





Нэгдүгээр бүлэг

ЭХЛЭЛ

A man with glasses and a beard, wearing a dark suit and tie, is seated in a large, ornate chair. He is holding an open book and appears to be reading. The setting is a library or study, with a bookshelf filled with books visible to the right. A large window with red curtains is behind him, and a chandelier hangs from the ceiling. The scene is rendered in a comic book style with bold lines and a color palette dominated by reds, yellows, and browns.

Миний ярих энэ түүх
олон мянган жилийн тэртээх
эртний номд өгүүлэгдсэн юм.
Уншигч танд хэлэх үг бүр
минь үнэн.

Энд гарах зүйлсийн
заримд нь итгэхэд хэцүү ч
үнэн ихэнхдээ зохиосон зүйлсээс
хачирхалтай санагддаг.




Эхэнд буюу дэлхий ертөнц, нар сар,
од гариг, гэрэл, цаг хугацаанаас өмнө, ертөнцийн
хамгийн анхны хүн бүтээгдэхээс ч өмнө Бурхан байсан
юм. Бурхан ямар ч эхлэл үүсэлгүйгээр ганцаар оршин
байсан хэдий ч уйтгарлаж гуньдаггүй байжээ. Бурхан
хэмжээ хязгаартай хүн шиг биш бөгөөд гурван бодгаль
байдлаар нэг Бурхан дотор зэрэгцэн
оршиж байдаг юм.

Бодгаль тус бүр адил тэнцүү,
адил мөнхийн бөгөөд мөн чанар, шинж
байдал, хүч чадал, үйл хэрэг, хүсэл
зоригийн хувьд нэг болой. Тэр Өөр
дотроо эв зохицолтой хайраар
харилцан байдаг юм.

Гэвч Бурхан амьдралаасаа
бусадтай хуваалцахыг хүсжээ.
Тиймээс Тэрээр анд нөхөдтэй
болохыг хүссэн юм.



Библид* Бурхан олон тооны тэнгэрлэг биетийг Өөрийнхөө сэнтийг тойруулан талархал магтаал өргүүлэхээр бүтээсэн хэмээн өгүүлсэн байдаг. Гэтэл Люсифер гэгч нэгэн тэнгэр элч тэдгээр тэнгэрлэг биетүүдийн гуравны нэгийг удирдан эсэргүүцэл гаргажээ. Бурхан тэднийг тэнгэрээс хөөн зайлуулсан бөгөөд Люсиферын нэр Сатан болж өөрчлөгдсөн юм.



Гэвч энд өгүүлэх түүх бол тэдний тухай түүх биш билээ.

Харин энэ бол Бурхан хүн төрөлхтөнтэй ажиллаж буй түүх болой.


*Та 321-р хуудаснаас Библи хэмээх номын тухай өгүүлсэн товч тайлбарын талаар үзээрэй. Сатаны талаарх илүү тодорхой мэдээллийг Исаиа 14:12-14, 45:18; Езекиел 28:13-19; Матай 25:41; Лук 10:18; Илчлэлт 12:4, 20:2-с үз.

Эхэнд Бурхан тэнгэр газрыг
бүтээжээ. Газар дэлхий хоосон
харанхуй, хэлбэр дүрсгүй байсан
бөгөөд Бүтээгч усны мандал
дээгүүр элэн хальж байлаа.



Гэнэтхэн Бурхан харанхуй уруу
ийнхүү ярьж эхэлжээ...

"Гэрэл бий бологтун!"





Ойролцоогоор
МЭӨ 4004 он. -
Эхлэл 1:2-3

Энэ бүхэн орчин үеийн хүмүүсийн боддог шиг болоогүй юм. Бүтээгч хувьслын онолыг ашиглаагүй ээ. Харин Бурхан бүх зүйлийг зөвхөн үгээрээ хэлж оршин тогтнодог болгож бүтээсэн юм. Жирийн зургаан өдөр буюу 24 цагтай зургаан өдрийн дотор Бурхан ургамал ногоо ургаж, мал амьтан үржиж энэ дэлхийг дүүргэхээр бүтээсэн аж.

Зургаа дахь өдөр муу сүнснүүдийг харж байхад Бурхан газрын хөрс шорооноос нэгэн шинэ бүтээлийг бүтээсэн юм.




Тэрхүү шавар биет уруу Бурхан Өөрийн амьсгалаар үлээхэд хүн амин сүнстэй болжээ. Ийнхүү хүн амьд амьтдаас дээгүүр байдлаар Бурханы дүр төрхөөр бүтээгдэн бий болжээ.

Бурхан тэрхүү шинэ бүтээлээ Хүн хэмээгээд Адам гэдэг нэр өгчээ.




Бурхан Өөрийн бүтээсэн бүгдийг хараад "Нэн сайн болжээ" гэж хэлжээ.

Өдөр бүр Бурхан Адамтай
ярьдаг байсан бөгөөд бүх зүйл
тун гайхамшигтай байлаа. Бурхан
бүх амьтдыг Адамын өмнө нэр
өгүүлэхээр авчирчээ. Амьтан
бүрийг өмнүүрээ өнгөрөхөд
тэдэнтэй адил ижил хос өөрт нь
байхгүй байгааг ухаарчээ.




Тэгээд Бурхан
ийнхүү хэлжээ...

Адамд туслах
ханийг Би бүтээнэ ээ.



Бурхан Адамыг гүн нойронд автуулаад хажуунаас нь нэгэн хавиргыг авав. Мөнөөх хавиргаараа Бурхан Адамыг хайрлан түүнд туслах үзэсгэлэнт эмэгтэйг бүтээж өгчээ.

Бурхан Адамыг сэрээгээд нөгөө эмэгтэйгээ авчирж өгөв. Бурхан тэдэнд үр хүүхэд төрүүлэн дэлхий ертөнцийг дүүргээрэй гэв. Адам үзэсгэлэнт шинэ эхнэрээ "Ева" хэмээн нэрлэв.



Энэ бол миний яс махны тасархай.

Сатан буюу бузар нэгэн харж байлаа.


Хэдийгээр тэр хоёр хувцасгүй нүцгэн байсан боловч эгээ л хүүхэд шиг ямар байгаагаа огт мэдэхгүй байлаа.

Цэцэрлэг дотор тэд маш аз жаргалтай байлаа. Тэнд ямар ч гэм нүгэл, өлсөх цангах явдал байхгүй байсан төдийгүй хэт халуун, хэт хүйтэн ч гэж байгаагүй юм.


Та нар цэцэрлэг дэх бүх модноос жимс идэж болно. Харин цэцэрлэгийн голд байгаа ганц модноос л идэж болохгүй шүү. Хэрэв та нар идвэл идсэн өдрөө л үхэх болно.



Сатан Бурханыг үзэн ядаж байсан учраас хийж байгаа ажлыг нь устгахыг хүсжээ. Гэхдээ харин Еватай ямар нэгэн аргаар ярих хэрэгтэй байсан тул нэгэн сайхан бүтээлийн дотор орж амаар нь ярьлаа.



Бурхан чамд цэцэрлэгийн ямар ч модноос идэж болохгүй гэж хэлсэн үү?



Бурхан бид нарыг энэ модноос бусад бүх модноос жимс идэж болно гэсэн. Гэхдээ харин энэ модонд хүрэх л юм бол бид нар үхнэ.

Ха! Та нар үхэхгүй ээ. Харин идэх юм бол бурхад шиг л болно доо. Та нар бид нар шиг болж, гэгээрч сайн муу гэж юу болохыг мэддэг болно.



Гоё харагдаад
байна л даа. Идэхэд ч дажгүй
хоол болох юм шиг байна.
Идчихвэл намайг ухаантай болгоно
доо. Даанч Бурхан битгий
идээрэй гэсэн л дээ.

Ева Бурханы үгэнд
оролгүй жимсийг идлээ.




Нэгэнтээ оройтжээ. Ева
хууртсанаа сая л ухаарав. Ингэж
жимс идсэн нь сайн мууг мэддэг
болгосон ч түүнийг бузар муу нь
ялан дийлжээ.

Ева жимснээс авч, нөхөртөө
өгөөд идүүлэхээр ятгав.



Хараач, би
үхээгүй л байгаа биз дээ.
Идчих, тэгвэл чи над шиг
ухаантай болно шүү.

Эхлэл 3:1-6; Илчлэлт 20:2




Тэд гэгээрч, нүцгэн
байгаагаа мэдээд
ичицгээв.

Бид чинь
юу хийчихнэ
энэ вэ?

Бид нар Бурханы үгэнд
ороогүй байна шүү дээ. Бурхан
одоохон ирнэ дээ. Хоёулаа
нүцгэн байгаагаа нууя.


Ха,
ха, ха. Одоо Тэр та
нарыг ална даа! Намайг
яасныг нь хараач.



Адам чи
хаа байна
аа?

Би Таныг дууг
сонссон л доо.
Гэхдээ би нүцгэн
байгаа болохоороо
айгаад байна.

Хэн чамд нүцгэн байгааг
чинь хэлээв? Чи Миний
үгэнд оролгүй хориотой
жимснээс идчихээ юу?



Таны
надад өгсөн эмэгтэй
л надаар ийм юм
хийлгэчихлээ.

A woman with long dark hair, wearing a green dress made of leaves, stands in a forest. She is pointing her right hand towards a large, white, scaly dragon-like creature with a long tail and wings. The dragon is standing on a yellowish ground. The background shows trees and a bright sky. A speech bubble is positioned above the dragon, and a larger speech bubble is at the bottom of the page.

Ссссссссс...

Могой л намайг
хуурчихлаа. Тэр л намайг үхэхгүй,
харин Тантай адилхан болно гээд
байсан юм. Харин би одоо Тантай адилхан
биш байна. Надад аймшигтай
муухай санагдаж байна.

Тэгээд Бурхан
могойг харааж
ингэж хэлэв...



Чи ийм юм хийсэн
учраас Би чамайг
элгээрээ мөлхдөг болголоо.
Чи үргэлж амаараа шороо
үмхэж явах болно.

Би чиний үр удмыг
эмэгтэйн үр удамтай
дайсан болголоо. Чиний
үр эмэгтэйн үрийн
өсгийг гэмтээнэ харин
эмэгтэйн үр чиний
толгойг бяцална.



Ирээдүйд болох тэмцлийг Би энд тунхаглаж байна. Эмэгтэйн үр Сатаныг ялах цаг ирэх болно. Тэр хүн, хүн төрөлхтнийг Бурханд буцаан авчирж, тэднийг гэм нүгэл ба үхлийн хараалаас чөлөөлөх болно.

Эхлэл 3:13-15



Бурхан Люсиферыг элч нарынх нь хамт тэр дор нь устгаж болох байсан ч тэгэлгүй үлдээсэн нь хүн төрөлхтнийг шалгахын тулд байсан юм. Хүмүүс Бурханыг дагах уу эсвэл Сатаныг даган цуг эсэргүүцэх үү?

Бурхан хүн төрөлхтнийг
ийн хараажээ...




Адам чи
эхнэрийнхээ нөлөөнд
автаж үгэнд нь орон Миний
үгийг дагаагүй тул Би газар
шороог хараан жимс ногоо
ургуулахаасаа илүү өргөс,
зангуу ургадаг болголоо. Тэгэхээр
чи газар шороог хүнс ургуулдаг
болгохын тулд хамаг хүчээрээ
зүтгэн ажиллах болно.

Чи насан туршдаа буюу үхэх
өдрөө хүртэл уй гашуутайгаар
хөлсөө урсган ажиллаад, чамайг
бүтээсэн тэр хөрс шороонд
буцан очих болно.

Бурханы хэлснээр Адам, Ева хоёр үхэх болж байна. Харин Бурхан тэднийг алахын оронд амьтан алаад арьсаар нь хувцас хийн өгөв.





Бурхан
биднийг алсангүй шүү
дээ! Бид амьд хэвээрээ
байна!

Бурхан
бидний оронд
амьтан алсан
байна!

Ямар ч гэм буруугүй амьтад
тэдний оронд үхсэн учраас тэр
өдөр Адам, Ева хоёр үхсэнгүй
үлджээ. Гэхдээ үхлийн шийтгэл
тэдний дээр тавигдсан учир
эцэстээ тэд үхэх л болно. Үхэл
бол гэм нүглийн шийтгэл мөн.


Адам, Ева хоёр нүгэлтнүүд болсон учраас Бурхан тэднийг үзэсгэлэнт цэцэрлэгээсээ гаргав. Ингэснээр тэд амийн модноос жимс идэн үүрд гэм нүгэлтэйгээ үлдэхгүй болох юм.



Бурхан цэцэрлэгийн хаалган дээр Херуб хэмээгдэх тусгай тэнгэр элчийг байлгаж амийн модонд хэнийг ч ойртуулахгүйгээр мануулж байлаа. Яваандаа цэцэрлэг ч устаж үгүй болон модыг тэндээс зайлуулсан юм. Нэгэн өдөр тэрхүү модыг буцаан энэ дэлхий дээр авчрах болно. Харин энэ тухай дараа өгүүлэх болно.



Адам, Ева хоёр өнөр олон хүүхэдтэй болжээ. Сүүлдээ тэдний охид, хөвгүүд хоорондоо гэрлэн олон хүүхэдтэй боллоо.



Тэдний ууган хүү Каин жимс ногоо ургуулдаг тариаланч болжээ. Харин удаах хүү Абел нь мал амьтан өсгөн малчин болсон юм. Энэ хоёрын аль нэг нь Бурханы амласан Сатаныг устгах хөвгүүн болох юм болов уу?



Каин, Абел хоёр хоёулаа Бурханы тухай мөн цэцэрлэгт юу болсныг ч хүртэл мэдэж байлаа. Харин Бурхан урьдынх шигээ хүнтэй мөр зэрэгцэн алхаж, ярьж хөөрөхөө больсон байв. Адамын дуулгаваргүй байдлаас болж үр удам нь бас өөрөө Бурханаас тусгаарлагдан салсан юм. Бурхангүй амьдрал хүнд хэцүү байлаа.



Бурхан минь, би
чинь нүгэлт хүн билээ.
Би энэ хургыг өөрийн
үхлийн төлөөс болгон
алаад Танд өргөж
байна.

Нэгэн өдөр Адамын хоёр хүү
Бурханыг дээдлэн мөргөхөөр
шийджээ. Эцэг нь тэдэнд цэцэрлэг
дотор Бурхан амьтан алсан тухай
ярьсан учраас итгэлээрээ Абел
амьтан нядлаад Бурханд өргөв.

Каин өөртөө байгаагаас хамгийн сайныг нь шилэн авчраад өргөсөн боловч тэр нь цусан өргөл биш байлаа. Каин өөрийнх нь гэм нүгэл Бурханыг хэрхэн гомдоодгийг мэдээгүй юм.



Бурхан минь,
би чинь нүгэлт хүн
билээ. Би энэ хургыг
өөрийн үхлийн төлөөс
болгон алаад Танд
өргөж байна.

Энэ хоёр хүний нэг нь амлагдсан
аврагч болох юм болов уу?

Эхлэл 4:1-4; Ром 3:23; Еврей 11:4



Кайн аа, үгүй ээ.

Кайны өргөл цусгүй байсан учраас Бурхан хүлээн авсангүй.

Бурхан Абелыг ч өргөлийг нь ч таашаав. Бурхан гэм зэмгүй хурганы цус урсахыг хараад Абелын нүглийг уучлан өршөөжээ.



Бурхан Каинд “Чи хийх ёстойгоо л хийсэн бол би чамайг таашаах байлаа. Бас дүү Абелаа чи захиран удирдаж тэр чиний удирдлага хяналтад байх байсан юм.”

Чи өөрийгөө юу гэж бодоод байгаа юм бэ? Миний жимс ногоо тэр муу цустай хурганаас чинь илүү үнэтэй. Хэн чамайг тэгтлээ онцгой болгоод байгаа юм бэ?

Ах минь ээ, цусан өргөл өргөх цаг байж л байна шүү дээ.






Миний
хувьд одоо
боллоо!
Хангалттай!

ТУГ!!

Абел үхэв. Харин Каин дүүгээ алсан нүглээ нуун далдлах гэж оролдов.

Гэсэн хэдий ч Каин бузар үйлдлээ Бурханаас нууж чадаагүй юм. Бурхан бүгдийг харж мэдэж байлаа.



Каин, дүү чинь хаа байна?

Би яаж мэддэг юм бэ? Би дүүгээ харж байх ёстой болж байна уу?

Дүүгийн чинь цус газар байж л байна. Тэр цус Надад чиний бузар хэргийг илчилж байна.

Бурхан бүхнийг мэддэг юм. Тэр бүхнийг үргэлж харж ажиглаж байдаг. Юу ч Бурханаас нуугдаж чадахгүй ээ. Каин Абелыг яасныг Бурхан мэдэж байлаа. Бурхан Каиныг хараав. Тэгээд Каин эхнэрээ аваад цөл уруу зайлан одов. Каин хийсэн нүглээсээ болж ихэд зовон шаналж байлаа.



Каин амлагдсан аврагч болж чадсангүй. Харин ч өөрт нь аврагч хэрэгтэй боллоо.

Хүн анхлан бүтээгдсэний дараа төрөлтийг гажигтай болгодог мутантын генүүд үүсээгүй байсан бөгөөд харин ийм генүүд үүссэнээс хойш Бурхан ойрын төрлийн хамаатнуудыг хоорондоо гэрлэхийг хориглосон ажээ.

Авралыг авчрах Бурханы амласан хүү юу болов? Адам, Ева хоёр дахин нэг хүүтэй болсон бөгөөд түүнийг Сет гэдэг байв. Мөн түүнээс гадна олон охид, хөвгүүд Адам, Ева хоёроос төржээ.




Каины
алсан хүүгийн
минь оронд
Бурхан надад
өөр хүү
өглөө.

Эхлэл 4:9-16, 5:4; Үйлс 17:24-26

Сет хүү төрүүлж түүнээс нь хүү төрж цаашид олон хөвгүүд төрсөн боловч гэмийг зайлуулж үхлийг ялан дийлэх хүү төрөөгүй л байлаа. Түүнээс хойш удалгүй дэлхий дээр хот суурин, тосгод бий болон олшров.





Шинэ үе удмууд үүсэн,
хүмүүс өсөн олшрох
тусам гэм нүгэл улам
нэмэгдэж байв. Хүмүүс
завхайрч, балмад хэрцгий
болж байлаа. Тэдний
бодол санаа бүр бузар
заваан болжээ. Хэн ч гэм
зэмгүй зөв шударга
амьдарч чадсангүй. Адам
нэг нүгэл үйлдсэн бол
хүмүүс зүсэн бүрийн
нүгэл хилэнц үйлдэж
байлаа.

Бурхан ийнхүү айлдав.
“Би газар дэлхий дээр хүнийг
бүтээсэндээ харамсаж байна. Би
энэ дэлхий дээрх амьтай болгоныг
устган үгүй хийнэ” Бурханы хаант
улсад хорсон хилэгнэдэг Сатан
Бурхан бүхнийг устгаж байгааг
хараад баярлан хөөрөх болно.

Анхны хүнээс хойш даруй
есөн үе (1,400 жил) өнгөрсөн
байлаа. Харин дэлхий ертөнц
гэм нүглээр дүүрчээ.


Хүмүүсийн нэг нь нөгөөгөө
зарцлан боолчлох болов.

Бурханыг хайрлан, Түүнийг
дуулгавартай дагах гэр бүл
ер нь гарах болов уу?

Эхлэл 6:5-6; Ром 5:12



Ойролцоогоор МЭӨ 2500 он



Харин ганц хүн л дандаа зөвийг үйлдэж шударга амьдардаг байлаа. Бурхан бүх хүмүүсийг устгахаар шийдсэн ч ганц энэ хүнийг таалан нигүүлсэж гэр бүлийнх нь хамтаар устган хороохгүй байхаар шийдэв.




Ноа,
Би дэлхий дээр
бүхэлд нь
асар их үер ус
буулгах болно.
Амьсгалтай бүхэн
үхэж үрэгдэнэ. Чи
гэр бүл, өөрийгөө
болон амьтдаа
аврахын тулд
нэг том онгоц
хийгтүн.

Энэ
дэлхий дээр байдаг
амьтан бүрээс эр, эм нэг хосыг
өөрсөдтэйгээ хамт онгоцонд
авч ор. Идэхийг зөвшөөрөгдсөн
амьтдаас долоог авах хэрэгтэй.
Би чамд тэр онгоцыг хэрхэн
барихыг зааж өгнө. Мөн үерт
юу бэлтгэх хэрэгтэйг чинь ч
хэлж өгнө.

Ноа тэр Сатаны үйлийг устгах мөнөөх аврагч болж чадах болов уу? Ноа Бурханыг дагах уу эсвэл бас л алдах юм болов уу?



Идэх хоол хүнснээс гадна дэлхий дээрх амьсгалдаг амьд амьтан бүрээс нэг хосыг багтааж чадахаар том байлгахын тулд онгоц ямар хэмжээтэй байх ёстойг нь Бурхан Ноад хэлж өгөв.



Болох их үерт бүх хүмүүс
устаж үгүй болно гэдэг
Ноад тун харамсалтай
байлаа. Тийм болохоор
Ноа хүмүүсийг гэм нүгэл
үйлдэхээ болихыг байнга
сануулж байв.

Би та нарт сүүлийн удаа
хэлье. Бурхан дэлхийг их
үерээр устгах гэж байна. Та
нар надад итгэж онгоцыг
хийлцээч.

Хайрын
Бурхан яаж
хүүхдүүдээ
устгах юм
бэ?

Хөгшин
зөнөг!

Нүглээс л болж тэр.
Та нар гэм нүгэл үйлдэхээ
больж бие биенээ хайрлан
шударга байх хэрэгтэй.


Онгоцыг хийж дуусгахад буюу 120 жилийн дараа Бурхан амьтдыг Ноа уруу дэлхийн зах хязгаараас авчирлаа.

Хараач,
дахиад өөр
амьтад ирж байна. Яг
л хүн дуудсан юм шиг
өөрсдөө ирээд байх
юм.

Зарим
нь ямар хачин
харагддаг юм бэ.
Ийм амьтад байдаг
гэж ерөөсөө бодоогүй
юм байна. Бурхан үер
буулгана гэж Ноагийн
яриад байгаа юм
болох юм болов
уу?

Яаж тийм
юм байх юм бэ?
Дэлхийг бүхэлд нь
бүрхэж гүйцэх тийм
их усыг хаанаас
ирүүлэх гээ вэ?





Одоо
ч бараг зайгүй
боллоо.

Эд
сүүлчийнх
нь шүү.

Ноа
цаг нь боллоо. Одоо
гэрийнхнээ аваад амьтдын
хамт онгоцондоо ор. Гэм
нүглээсээ ухраагүй болгоны
хувьд тун удахгүй дэндүү
оройтсон байх болно.

Бурхан усан онгоцны хаалгыг хаав. Нэг долоо хоног өнгөрөхөд юу ч болоогүй л байлаа.


Ха,
ха, Хараач
энэ тэнэгүүдийг!
Мангар том онгоцон
дотор бөөн амьтадтай
чихэлдээд хув хуурай
газар далай уснаас
хол хаагдчихаад
сууж байдаг.

Харин
тийм ээ. Өдийд
лав арслангууд
тэднийг залгичихсан
байлгүй.

Тэр
дотор долоо хоног
болж байна шүү дээ!




Гэтэл долоо дахь өдөр бороо орж эхлэв. Газрын гүнд хуримтлагдсан байсан ус ч гадаргуу дээр оргилон гарч ирлээ.



Ийм юм ер үзэж байгаагүй юм байна. Бурхан хүн бүрийг нүглийнх нь төлөө устгана гэж тэр завин дотор байгаа солиотой амьтдын яриад байсан нь үнэн юм биш биз дээ?

Битгий хөгийн юм яриад байгаач. Бурхан чинь хайр шүү дээ. Яаж ганцхан хүн зөв байгаад шүтлэгт удирдагчид маань бүгдээрээ буруу байдаг юм бэ?


Үүнээс өмнө ер бороо орж байсангүй. Цаг агаар үргэлж сайхан байсан бөгөөд шүүдэр хөрсийг чийгшүүлж өгдөг байлаа. Урьд өмнө борооны тухай дуулж мэдсэн, үзэж харсан хэн ч байгаагүй тул хүмүүс Ноаг тэнгэрээс бороо орно гэж ярьж байдаг солиотой амьтан гэж бодож байлаа. Харин Ноа Бурханы хэлсэн үгэнд итгэсэн юм.



Ноагийн
үгийг би сонсдог л
байж. Би ямар тэнэг
байгаа вэ!

Бурхан
минь ээ, нялх
үрийг минь
авраач!

Ойролцоогоор МЭӨ 2348 он



Хүмүүс Ноагийн
ярьж байсныг үнэн байжээ
гэж ухаарах тэр үед бүх
зүйл хэдийн оройтсон
байлаа.

Дөчин өдөр дөчин шөнө бороо орж
дэлхийн уул толгод бүр далдлагджээ.
Ноагийн онгоцон дотор байгаагаас
бусад амьсгалтай бүхэн үхэж
үрэгдэв. Тэд онгоцноос гарах хүртэл
бараг жил гаруй хугацаа орно.



Ус
татарч энэ
онгоцноос гарах
болбол би ёстой их
баярлахсан.

Эцэст нь Ноа нэгэн тагтааг гарган нисгэхэд мөнөөх тагтаа амандаа модны мөчир зуун буцаж ирсэн нь хаа нэгтээ газар мод ургаж эхэлсний тэмдэг байлаа. Дараа дахин нөгөө тагтаагаа явуулахад эргэн ирсэнгүй нь амьдрах тухтай газар олсон хэрэг байжээ.

Нэг их удсангүй усан онгоц
Арарат хэмээх уулын орой
дээр зогслоо. Ямар ч гэм
нүгэлгүй шинэ газар дэлхий
дээр бүгд буун ирлээ.



Ноа тахилын ширээ өрж Бурханд амьтнаар тахил өргөв. Ноа зөв шударга нэгэн байсан хэдий ч зүрх сэтгэлд нь гэм нүгэл байсаар л байлаа. Тэрхүү цусан өргөл Ноа ба түүний гэр бүлийнхний амь насны оронд Бурханд өргөгдсөн юм.



Өргөлийн амьтад нь үерт үхэх ёстой байсан боловч Бурханы нигүүлслээр аврагдсан найман хүнийг төлөөлж байсан юм. Энэ зүйл цэцэрлэг дотор Бурхан амьтад алан Адам, Ева хоёрт хувцас хийж өмсгөсөнтэй адил зүйл байв.

Би
та нарт солонгыг
сануулга болгон өгч
байна. Би үүнээс хойш газар
дэлхийг хэзээ ч усаар дахин
устгахгүй. Та нар олон хүүхэд
төрүүлж дэлхий даяар
тархан суурьшиж дахин
дүүргэх ёстой.



Би амьтдыг хүнээс айдаг болгоно. Та нар алив амьд амьтан, газрын хөрсөн дээр хөдөлж хөлхөгч бүрийг ургамал ногоог иддэгийн адил идэж болно. Харин та нар ямар ч амьтны цусыг идэж болохгүй. Хэнийг ч бүү ал.



Хэрэв
хэн нэг нь хүн алсан бол уг хүн өөр хүнд алагдах болно. Хэрэв хэн нэг нь өрөөл бусдын цусыг урсгавал уг хүний цусыг өөр нэгэн урсгаж хийсэн хэргийг нь төлүүлэх болно. Учир нь хүний амь цусандаа байдаг юм.




Ноа цэцэрлэгч болж, усан үзэм тарьж ургуулжээ. Газар дэлхий дээр дөрөвхөн гэр бүл байсан тул жаахан уйтгартай байлаа. Удалгүй Ноагийн хүүхдүүд үр хүүхдүүд төрүүлж өнөр өтгөн болцгоов.



Ноа жимсийг саванд хийж тавиад хэдэн долоо хонуулахад тэр нь исэж дарс болон уухад сонин болгодгийг олж илрүүлжээ. Ноа тэр дарсандаа тун дуртай болсон учир заримдаа ажлаа ч хийхээ болив. Тэгээд тэр ямар ч ухаангүй болон дороо унадаг байлаа. Энэ байдал нь Бурханы дургүйг хүргэдэг зүйлсийг хийхэд хүргэжээ.



Нэгэн өдөр Ноа маш их согтож хамаг хувцсаа тайчаад нүцгэн хэвтэж байлаа. Хүү Хам нь аавынхаа ичгүүрт байдлыг харсан боловч энэ нь түүнд таалагджээ. Тэгээд ах дүү нартаа аавыгаа харснаа шоолон ярьжээ.



Ноаг
сэрэхэд
хөвгүүд нь
Хамын юу
хийснийг
хэлэв.

Чиний
хүү Канаан,
тэрний үр удам
ах Шемийн чинь
удамд зарцлагдан
боолчлогдох
болно доо.

Олон жилийн дараа мөнөөх эш
үзүүллэг биеллээ олов. Канаанчууд
яваандаа Палестинд суурьшин
иудейчүүдэд боолчлогдох болсон юм.

Адам, Ева хоёр

Сет

Абел

Каин

Энэ найман хүнээс бусад бүх хүнийг Бурхан устгав.



Европ

Иафет

Турк

Шем

Ази

Хам

Египет

Африк

Ноа гэр бүлийнхнийхээ хамтаар Бурханы нүдэнд тааллыг олжээ.

Иафет баруун ба хойд зүгт явж тэндээ суурьшин өсч үржжээ. Шем зүүн зүгт явж Ази тивд суурьшжээ. Хам урд зүгт явж, зүүн өмнөд Ази болон Африк тивд оршин суув. Хүү Канагийнх нь үр удам одоогийн Палестины нутагт суурьжээ. Ийнхүү газар дэлхий дахин хүнээр дүүрчээ.

Ойролцоогоор МЭӨ 2247 он

Ноагийн хүү Хам нь Куш нэртэй хүүтэй байсан бөгөөд Куш Нимрод гэдэг хүүтэй болжээ. Нимрод бүх дэлхийд алдар цуутай агуу их анчин болжээ. Нимрод Бурханыг дагахаас татгалзаж Бабел хэмээх газар өөрийн зохиосон хуурамч шашныг эхлүүлжээ.


Бабелын хүмүүс Бурханы тушааснаар газар оронд тархаж дэлхийг дахин хүнээр дүүргэхийг хүсээгүй тул хамтран цуглараад мөргөлийн төв болгохоор өндөр цамхаг барьж эхлэв.





Харин мөргөн шүтээд
байгаа нь тэднийг
бүтээсэн Бүтээгч биш
байлаа. Сатан тэднээр
өөрсдөд нь зориулан
мод, чулуу, төмрөөр
бурхад бүтээлгэв.

Тэднийг газар дэлхийгээр тархан суурьшихаас татгалзсанд нь Бурхан уурлан хилэгнэж хэл яриаг нь ойлгохооргүй болгон будлиулжээ.



ᠡᠳᠡ ᠲᠡᠭᠦ ᠳᠡᠯᠬᠢᠶᠢᠭᠡᠭᠡᠷ ᠲᠠᠷᠬᠠᠨ
ᠰᠤᠭᠤᠷᠢᠰᠢᠬᠠᠰᠤ ᠲᠠᠲᠠᠭᠠᠯᠵᠢᠰᠠᠨᠳᠠ ᠨᠢ
ᠪᠤᠷᠬᠠᠨ ᠤᠷᠯᠠᠨ ᠬᠢᠯᠡᠭᠨᠡᠵᠢ ᠬᠡᠯ ᠶᠠᠷᠢᠶᠠᠭ ᠨᠢ
ᠣᠶᠢᠯᠭᠣᠬᠣᠣᠷᠭᠤᠢ ᠪᠣᠯᠭᠠᠨ ᠪᠤᠳᠯᠢᠭᠤᠯᠵᠡᠭᠡ.

ᠪᠠᠷᠢᠯᠭᠠᠴᠢᠳᠢ ᠡ᠋᠋᠋ ᠬᠣᠣᠷᠠᠨᠳᠣ᠋᠋
ᠣᠶᠢᠯᠭᠣᠯᠴᠣᠬᠣ᠋᠋ ᠪᠠᠶᠢᠰᠠᠨ ᠲᠤᠯ ᠴᠠᠠᠰᠢ
ᠤᠷᠭᠡᠯᠵᠢᠯᠦᠭᠦᠯᠡᠨ ᠠᠵᠢᠯᠯᠠᠵᠢ
ᠴᠠᠳᠠᠬᠦᠭᠦᠳᠤ ᠬᠦᠷᠴᠡᠭᠡ.

Барилгачид өөр хоорондоо ойлголцохоо байсан тул цааш үргэлжлүүлэн ажиллаж чадахгүйд хүрчээ.



Ижил хэлээр ярьдаг болгон нэгэн зүгт явцгаав. Нэг хэсэг нь дэлхийн хязгаар нутагт одож, өөр нэг хэсэг нь харин хөлөг онгоцоор ус далайг гатлан арлын зүг хөдлөв. Зарим нь хойд зүгийн хүйтэн газар очиж, үлдсэн зарим нь харин өмнө зүгийн халуун цөл газруудад нүүн суурьшив. Ийнхүү газар дэлхийг дахин хүнээр дүүргэ гэсэн Бурханы тушаал биелэгджээ.



Газар дэлхий хүнээр
дүүрэхэд нүгэл хилэнц
ч бас дахин өсөж
нэмэгдлээ. Хүмүүс хуурамч
шүтээнүүдэд мөргөн
сөгдөж амьд агуу Бурханаа
ор тас мартаx нь тэр.

Ойролцоогоор МЭӨ 2247 он
- Эхлэл 10:6-10, 11:1-9



Хоёрдугаар бүлэг

АБРАХАМ

Хөшөө баримлуудыг жинхэнэ бурхад гэж итгэдэггүй ганц л хүн байсан бөгөөд нэрийг нь Абрахам гэдэг байлаа. Бурхан бол жинхэнэ Бүтээгч учраас хуурамч шүтээнээр дамжуулан хүндлэгдэх боломжгүй гэж Абрахам мэдэж байсан юм.



Бурхан түүнд ингэж хэлэв. "Абрахам чи энэ хуурамч шүтээнээр дүүрэн хотоос яв. Чи төрөл садан, төрсөн нутгаа орхиод эндээс хөдлөгтүн. Би Өөрөө чамд хаашаа очихыг чинь зааж өгнө. Би чамайг агуу их үндэстний эцэг болгоно. Би чамайг ерөөсөн болгоныг ерөөж, чамайг хараасан болгоныг хараана. Чамаар дамжин бүх дэлхий ерөөгдөх болно."



Абрахам нүгэл ба үхлийг устгах амлагдсан нэгэн болох юм болов уу?

Ойролцоогоор МЭӨ 1921 он



Ингэж хэлсэн дуу хоолой Бурханы дуу мөн гэж Абрахам итгэж байсан тул хаашаа явж байгаагаа тааж мэдээгүй ч Бурханы үгийг даган хөдөлжээ. Харин тэр хуурамч шүтээн шүтэх явдлыг ардаа орхиод амьд Бурханыг дагаж яваагаа л мэдэж байв. Энэ л Абрахамд хангалттай байлаа. Абрахам ач дүү Лотоо дагуулан явжээ.

Абрахамын аян зам түүнийг
Хамын хүүгийн оршин суурьшсан
Канаан нутагт авчиржээ. Өнөөдөр
энэ газрыг Палестин гэдэг. Тэр
газар Бурхан ингэж айлджээ:



Абрахам
аа, энэ газрын нэг захаас
нөгөө захыг хүртэл яв. Би Канаан
нутгийг чиний ирэх үе удамд өгөх
болно. Би чамайг тоолж барахааргүй
олон хүүхэдтэй болгоно. Тэд шороо
тоос шиг олон болтлоо өсч үржинэ.



Сараи,
Бурхан чамайг
энэ олон жилийн
дараа хүүхэдтэй
болно гэж надад
хэллээ.

Бурхан
чамайг болно
л гэсэн дээ.

Чи
намайг хүүхэдтэй
болж чаддаггүйг
мэднэ шүү дээ. Тэгээд
ч одоо хүүхэд төрүүлэх
нас ч өнгөрчээ. Би яаж
хүүхэдтэй болдог
юм бэ?

Абрахам уг нутгаар аялан явахдаа үе үе зогсож Бурханд цусан тахил өргөж байлаа.

Өөрийгөө үхвэл зохилтой гэмтэн гэдгээ мэдэж байсан тул Абрахам яг л Абелын адил итгэлээрээ өргөл өргөж байсан юм.

Өргөлийн хурга хэдий Абрахамын нүглийг зайлуулж чадахгүй ч Бурхан итгэлийг нь харахдаа гэм нүглийг нь далдалж байлаа.






Арван
жилийн
дараа

Абрахам
аа, Бурхан намайг
хүүхдийг чинь төрүүлнэ
гэсэн гэж хэлээгүй билүү? Одоо
би 75- тай харин чи 85-тай болжээ.
Хоёул өтөлж, хүүхэд ч алга.
Удахгүй чи ч хүүхэдтэй байж
чадахаа болих нь. Бурханыг
сонссон чинь баталгаатай
юм уу даа?

Бурхан
надтай яг л ярьсан юм
даа. Харин яахаараа ингэж
удаан хүлээлгэж байгааг нь л
ойлгохгүй байна. Надад хэлэхдээ
намайг агуу их үндэстний өвөг болно
гэсэн. Гэтэл одоо надад өвгөрч
хөгширсөн бие, үр хүүхэд тээж
чадахгүй өтөлсөн эхнэр, өчнөөн
их хонин сүргээс өөр юм
алга.





Абрахам бүү ай. Би
бол чиний бамбай,
чиний агуу шагнал


Үр хүүхэдгүй
надад ямар
шагнал өгөх билээ
дээ?

Сарай та хоёр
хүүхэдтэй
болно.



Абрахам аа хүрч ирээд
оддыг хар даа. Чи тоолж
чадах уу? Чиний үр хүүхэд яг
энэ одод шиг тоолж
барахааргүй олон болно.

Таны
хэлснээр болно
гэж би итгэж
байна аа.



Чи нэгэнтээ Надад итгэж байгаа учраас итгэлийг чинь зөв шударгад тооцлоо. Үр удам чинь хүний газар харийнхан болж сууна гэдгийг сайтар мэдэж ав. Тэр газраа 400 жил боолчлогдон дарлагдсаны дараа Би уг үндэстнийг шийтгэж үр хүүхдүүд чинь тэндээс арвин их эд баялагтай гарч явах болно. Тэгээд тэд эндээ эргэн ирж энэ газарт оршин сууна,

Эхлэл 15:1-6, 13-14



Хүүхдийн талаарх нөгөө амлалт юу болов оо? Би өдрөөс өдөрт өтөлж хөгширч байна. Чи ч өөрөө удахгүй үртэй байх боломжгүй боллоо шүү дээ. Абрахам, би чамд хэзээ ч хүүхэд гаргаж өгч чадахгүй.

Энэ
газрын заншлаар
зарц бүсгүй маань
надад хүүхэд гаргаж
өгч болно шүү
дээ.



Абрахам
чи энэ боломжийг
хүүхэдтэй болох эцсийн
арга гэж бодохгүй байна уу?
Оройтчихоогүй байгаа дээрээ
чи энэ хүүхнийг авч хүүхэд
гаргуул. Тэр чиний үр болно.
Тэгээд ч энэ чинь Бурханы
хүсэл. Өөрөөр чи яаж агуу
их үндэстний өвөг
болдог юм бэ?





Энэ л
ганц арга
мөн.

Абрахам Бурханд залбирсангүй.
Харин Бурханы амлалтыг умартаж
эхнэрийнхээ үгийг дагажээ.

Эхлэл 16:1-4


Хэдэн сарын
дараа

Би
Абрахамын
хүүхдийг гаргах
гэж байна.



Хагар Абрахамын хүүхдийг
тээж байгаагаа мэдээд бардам
дээрэнгүй болж Сараиг дорд
үзэх болжээ. Сарай ч атаархан
уурлах болов.


Сарай Хагарт хатуу ширүүн хандаж ажлаар дарах болжээ. Бурхан хэзээ ч хүнийг хоёр эхнэртэй байлгах юмуу татвар эмээр дамжуулан хүүхэдтэй болгох санаагүй байсан юм.



Чи
наад усаа зөөж
дуусчихаад түлээ
хагалаарай.

Хагар оргохоор
төлөвлөжээ.


Хагар Сараигаас зайлан цөл уруу зугтаав. Ядарч туйлдаад явах тэнхээгүй болж муужран уналаа. Бурхан Хагарын зовлонг хараад ийн хэлжээ.



Хагар аа, буцаад яв. Сараигийн үгэнд ор. Чи хүүтэй болж түүнийгээ Ишмаел буюу "Бурхан сонсдог" гэж нэрлэнэ.



Хүүгээс чинь
тоолохооргүй
олон хүүхэд төрөх болно.
Ишмаел зэрлэг хатуу хүн болж
хүн болгонтой тэмцэнэ. Хүн
болгон мөн Ишмаелтай тэмцэх
болно. Тэр бас ах дүүстэйгээ
ойрхон амьдардаг
болох юм.



Хагар гэртээ буцаж ирсэн
бөгөөд хүү ч төржээ.

Хүү нэгэнтээ
Абрахамын үр мөн
учраас олон үндэстний
эцэг болно гэж Бурхан
надад хэлсэн.

Хожим нь Ишмаел бүх араб
үндэстний эцэг болсон юм.

Эхлэл 16:4-16

Ишмаелыг төрөхөд Абрахам 86 настай байсан юм. Ишмаелыг төрснөөс хойш тун удалгүй Абрахам хүүхэд төрүүлэх үр боловсруулж чадахаа больжээ. Ишмаел Бурханы Абрахамд амласан тэр хүү мөн үү? Гэтэл Бурхан Абрахамд хүүхэд Сарай тэр хоёрын дундаас төрнө гэсэн шүү дээ.




Хэрвээ Абрахам, Сарай хоёр хүүхэд гаргаж чадахааргүй болтлоо өтөлсөн юм бол Бурхан амлалтаа хэрхэн биелүүлэх билээ?

Абрахамыг 99 настай байхад Ишмаел арван гурван нас хүрсэн бөгөөд тэр үед Бурхан дахин ярьжээ.

Абрахам, Би бол Төгс хүчит Бурхан. Миний хэлсэн болгоныг хий. Харин нүгэл бүү үйлд. Өмнө Би чамд хэлснийхээ дагуу үр хүүхдийг чинь өнөр өтгөн болгоно. Тэгээд чи олон үндэстний эцэг болох юм. Би урьдаар чамтай гэрээгээ байгуулаад дараагаар нь бас үр удамтай чинь байгуулна.



Би чиний хүүхдүүдэд Канаан нутгийг үүрдийн эзэмшил болгон өгнө. Олон үндэстний тэргүүн болох Миний амласан тэр хүүг Сарай хэвлийдээ тээж төрүүлэх болно.



Ха ха яаж тийм юм байдаг юм бэ? Би одоо 99 настай Сарай 89-тэй. Бие махбод минь өтөлж өмхрөөд үхсэн хүнийхээс ялгаагүй болсон. Бид одоо хүүхэдтэй болно гэж байхгүй. Ишмаелыг л тэр амласан хүүхдээ болгож өгөөч.

Үгүй, анхнаасаа л Би хэлж байсан. Сарай та хоёр дундаасаа өөрсдийнхөө хүүхдийг төрүүлнэ. Амласан ерөөл Ишмаелаар биш тэр хүүхдээр дамжих юм. Нэг жилийн дараа Сарай эрэгтэй хүүхэд төрүүлэх болно.



Тэгж болох юм уу?.....Болно!
Хүмүүний биеийг бүтээсэн Бурхан
мэдээж өтөлсөн хоёр хөгшний
үхширсэн биесийг хүүхэд төрүүлэх
болгож чадалгүй яах вэ. Мэдээж
Бурхан үүнийг хийж чадна!





Хэдхэн өдрийн дараа гурван хүн цөлийн тэртээгээс айсуй яваа нь үзэгдэв. Тэд их холоос яваа мэт харагдахгүй ч бас нутгийн хүмүүс биш бололтой. Тэд эрч хүчтэй, итгэл зоригтой, залуу халуун харагдаж байлаа.

Тэдний дөхөн ирэхийг харсаар атал тэд нэг л ондоо байгааг нь Абрахам мэдэж байсан ч харин тэрхүү зочид нь энэ дэлхийнх бус гэдгийг мэдээгүй юм.




Тэдний хоёр нь шударга тэнгэр элч нар байсан бөгөөд харин гурав дахь нь Бурхан өөрөө байв. Ийнхүү элчийн дүрээр ирсэн нь Абрахамтай ярих боломжтой байхын тулд байсан юм. Абрахам тэдэнтэй уулзахаар угтан очлоо.



Абрахам
аа, эхнэр Сарай
чинь хүүтэй
болно.

Ха- ха- ха

Би ийм хөгшин
болсон байдаг.
Абрахам бол бүр надаас ч
хөгширсөн. Би дахиад яаж
энэ жаргалыг амсах билээ?



Бурхан өөрт нь хүүхэдтэй болно гэж хэлж байхад Сарай яагаад инээгээд байгаа юм бэ?


Би инээгээгүй ээ.

Чи үнэндээ инээсэн шүү дээ. Чи итгэсэнгүй. Бурханд дэндүү хэцүү юм гэж бий юу? Чамайг хүүхэд олох яг тэр тохиромжтой үед би дахин ирнэ. Тэгээд чи хүүхэдтэй болно.




Би одоо хийх гэж байгаа юмаа Абрахамд хэлэх үү? Тэр чинь олон хүүхдийн эцэг болох гэж байгаа хүн шүү дээ. Үр ачдаа миний үгэнд дуулгавартай бай гэж сургаг.

Тийм ээ тэр мэдэх хэрэгтэй.




Содом,
Гоморрагийн
нүгэл хилэнц асар их
болжээ. Би энэ хоёр
хотын амин сүнстэй
болгоныг устгана.
Эрэгтэй эмэгтэй хүмүүс,
хүүхдүүдийг хүртэл
өршөөхгүй.

Миний ач
дүү Лот гэр
бүлтэйгээ тэнд
амьдардаг
шүү дээ!



Шударга зөв хүнийг бузар муу хүнтэй хамт устгана гэж үү? Ийм юм хийх нь Танаас хол байг. Хотод шударга зөв тавин хүн байвал яах вэ? Тэдгээр тавин хүнийг аврахын тулд та хотыг устгахгүй үлдээхгүй юү? Бүх хүнийг Шүүгч зөв шударгыг үйлдэхийг нь би мэдэж байна.

Би тавин шударга хүн олбол хотыг устгахгүй.



Бурхантай ингэж ярих
зохисгүй өчүүхэн өт хорхой билээ, би.
Гэхдээ хэрэв дөчин таван шударга зөв хүн
байвал яах вэ? Таван хүн дутснаас нь болоод
хотыг устгах уу?

45 хүн
байвал Би устгахгүй
ээ.

Дөчин
шударга зөв хүн
байвал Би устгахгүй
ээ.

Зөвхөн дөчин
хүн олдвол яах
вэ?




Надад
битгий
уурлаарай. Гуч
байвал яах вэ?

Гучин хүний
төлөө Би
устгахгүй ээ.

Тэр бузар
хотыг
Би хорин шударга
хүний төлөө
устгахгүй.

Хорин
хүн байвал
яах вэ?



Надад үнэхээр битгий уурлаарай. Би сүүлчийн удаа л Танаас асууя. Хотод зөвхөн арван шударга хүн байвал Та хотыг бас л устгах уу?

Үгүй ээ.
Хэрэв Би арван шударга хүн олбол хотыг устгахгүй.

Хэрэв Та арван шударга хүн олохгүй бол миний ач дүү Лотод урьдчилан сануулаарай.


Би өнөө шөнө тэднийд очно.

Хоёр элч тэр оройдоо хотод
орж Лотынх уруу явлаа.




Бүр буруугаараа
эргэчихсэн юм
байна. Бодсоноос ч
шал дор юм.

Би одоо л яагаад
Бурхан том жижиг,
мал адгуусгүй бүгдийг
нь устгах гээд байгааг
ойлголоо.



Харийн хүмүүс
ээ. Та нар шөнө
гадаа гудамжинд байж
болохгүй. Аюултай.
Наашаа манайд
ороод хоно.

Хөөе! Эд
чинь дажгүй
гоё залуучууд
юм гээч. Очиж
нөгөөдүүлдээ
хэлье байз.



Лот, наадуулаа гаргаад ир. Бид нар наадуултай чинь унтмаар байна!


Цаашаа явцгаа. Та нар тийм бузар юм хийж болохгүй.

Энэ муу өөрийгөө хэн гэж бодоод байгаа юм бэ. Нэг их төгс ариун амьтан? Хоёр нүүртэн.

Хаалгыг чинь эвдлээ шүү. Эвгүй л юм болно доо муу цагаач аа.

Ёстой зэвүүн амьтан!

Бид нар охидуудыг чинь авмааргүй байна. Бидэнд тэр гоё залуучууд чинь хэрэгтэй байна!




Эзэн Бурхан та
нарыг хараагүй
болгог!

Би
харахгүй байна! Юу
болчихов оо!

Яагаад
харанхуй
болчихов?


Тэд хаа
байна?

Ямар их
хүч гэж
энэ вэ?



Та нар маргааш өглөө хотоос гарах хэрэгтэй. Хэлэх хүмүүстээ хэл. Бурхан зөв шударга учраас ийм нүглийг удаан тэвчиж чадахгүй.

Маргааш Бурхан энэ газарт тэнгэрээс галаар бороо оруулна. Содом, Гоморрагийн бүх хүн үхнэ.



Хурдал, гал
одоохон буулаа
шүү. Хэн ч зугтааж
чадахгүй.

Бурхан
шатаж байгаа хотыг
эргэж харж болохгүй
гэсэн шүү.



Битгий
эргэж
хар!

Эээээээ!



Аав аа, яана аа!
Ээж Бурханы үгэнд
орсонгүй. Давс
болчихлоо шүү дээ.

Битгий
хараарай!
Гүйгээд
байгаарай!


Тэр өдөр Содом, Гоморрагийн амьд амьсгалтай бүхэн устаж үгүй боллоо. Бурхан зөв шударга учраас гэм нүглийг үзэн яддаг юм. Ялангуяа зүй бусаар явалдагсдыг буюу эр нь эртэйгээ, эм нь эмтэйгээ хавьтахыг үзэж чаддаггүй юм. Хүүхдийг бузар мууд уруу татах юунаас ч илүү жигшүүртэй хэрэг. Бурхан дэлхий ертөнцийг усаар дахин устгахгүй байхаар амласан бол галаар устгахгүй гэж хэлээгүй билээ.



Дараагийн удаа Тэр галаар устган сөнөөх болно. Ямар ч нүглийн шийтгэл бол үхэл юм. Үхэл нь хоёр янз бөгөөд тэдгээр нь бие махбодын үхэл ба галтай нуурт хаягдах мөнхийн үхэл хоёр юм. Бурханы нигүүлслээр Лот Бурханы шийтгэлээс аврагдаж чадсан байна. Лотын эхнэр Бурханд бүрэн итгээгүй юм. Бурхан битгий эргэж хар гэж сануулсан нь санаандгүй хэлсэн зүйл биш байжээ.



Аливаа нүглийн шийтгэл нь ямар ч өршөөлгүй үхэл л байх ёстой.




Бурхан чамд өршөөл нигүүлслээ үзүүлсэнд би үнэхээр баярлаж байна. Лот чи тэр хотод үхэж болох байлаа шүү. Бурхан нүгэл хилэнцийг үзэн яддаг юм шүү дээ. Чи тийм хүмүүсээс хол байх хэрэгтэй дээ.

Эхнэрийн чинь талаар бид нар үнэхээр харамсаж байна. Одоо тэгээд яах гэж байна даа?

Ямар нэг байдлаар аргаа олох л байх даа.

Лот цааш хоёр охиноо дагуулаад явжээ. Харин Бурхан Абрахамыг ивээж, ерөөсөөр байлаа.


Бурхан Сарайг хүүхэдтэй болно гэж амласан байлаа. Абрахам, Сарай хоёрын хооронд бүр мартаж орхисон байсан хүсэл нь сэргэж эхлэв.



Абрахам аа, чи чинь юу болчихоо вэ? Над уруу ингэж... хараагүй удсан байна шүү.



Энэ үнэхээр гайхамшиг
байлаа! Удалгүй хүн
болгон Сараиг хүүхэд
тээж байгааг мэджээ!




Бурханы хэлснээр
бид хүүгээ Исаак* гэж
нэрлэнэ ээ. Хүү маань
агуу их үндэстний эцэг
болох юм.

Тэгэлгүй яахав.
Анх Бурхан намайг
хүүхэд гаргана гэсэн нь
миний инээдийг хүргэж билээ.
Яаж ийм хөгширсөн хойноо
хүүхэд гаргаад тэрнийгөө
хөхүүлж сууна гэж итгэх билээ
дээ. Бүр яг өөрөөсөө унасан
хүүхдийг шүү.

Бурхан амлалтаа
биелүүллээ. Тэр
хэзээд биелүүлдэг.

Хагараас гарсан Абрахамын хүү Ишмаел саятөрсөн нялх хүүхдийг үзэн ядаж байв.



Энэ муу тэнэг намайг шоолоод байгаа юм даа. Ер нь энэ муу египетийг би Исаактайгаа нэг дор байлгахгүй ээ.

Зарц хүүхнийг хүүтэй нь явуул.
Амлагдсан хүү Исаактай минь эд ямар
ч хөрөнгө хувь хуваалцахгүй шүү.



Бурхан Абрахамтай ярин ингэж хэлжээ.
"Сараигийн хэлдэг зөв. Хагарыг
Ишмаелтай нь явуул. Ишмаел Исаактай
өв хөрөнгө хуваалцахгүй. Харин чи
үүнээс болж битгий шаналаарай. Би
тэднийг харж хандана. . .

...Ишмаел бас чиний хүү учраас Би түүнээс агуу үндэстнийг бий болгоно. Гэхдээ харин Сатаныг дарах амлагдсан аврагч Ишмаелаас биш Исаакаар дамжин төрөх юм."




Ишмаел өсөж томроод бүх араб үндэстний эцэг болсон байхад Исаак харин иудей хүмүүсийн эцэг болсон ажээ. Арабчууд ба иудейчүүд эцэг нэгтэй ах дүүс юм.

Чи бол
гайхамшгаар бүтсэн хүүхэд.
Чи энэ ертөнцийг гэм
нүглээс нь аврах уу?



Абрахам хүү Исаака аминаасаа
илүү хайрласан бөгөөд хаа ч
явсан салдаггүй байв.




Аав аа, та яагаад энэ хөөрхөн хургануудыг алаад өрсөн чулуун дээр шатаагаад байдаг юм бэ?

Тэнгэр газрын их Эзэн Бурхан цэвэр ариун билээ, хүү минь. Над шиг нүгэлт хүнтэй зүйрлэхгүй цэвэр юм шүү дээ. Анхны хүн Адам Бурханд дуулгаваргүй хандснаас хойш хүн төрөлхтөн бүгдээрээ гэм нүгэлтэй болсон юм даа.

Бурхан Адамд нүгэл үйлдвэл үхнэ гэж хэлсэн юм. Харин Адамыг нүгэл үйлдсэний дараа Бурхан амьтан алаад арьсаар нь Адам, Евагийн ичгүүрийг далдалсан юм.


Миний хурга алаад Бурханд өргөөд байгаа нь гэм нүгэлтэйгээ ойлгосны илэрхийлэл бөгөөд өөрийнхөө оронд гэм зэмгүй хургыг үхүүлэн өргөж байгаа юм аа, хүү минь.

Исаак эрүүл чийрэг
болон өсөж эцгийнхээ
Бурхан Эзэнд итгэж
найдаж сурчээ.
Абрахам хүүгээ ихэд
хайрлан ямагт цугтаа
явж өргөл өргөж
мөргөн хүндэлдэг
байлаа. Хургыг алаад,
тахилын ширээн
дээр тавьж, шатаадаг
байлаа.



Абрахам Би чамайг
цорын, ганц хайртай
хүү Исаакаа аваад надад
шатаалт тахил болгон
өргөхийг хүсэж байна.






Бурхан минь
Та надаас яаж ийм юм
хийхийг асууж байна аа?
Та ийм юм хийдэггүй биз дээ.
Харийн шашинтнууд хүнээр тахил
өргөдөг шүү дээ! Та хүү Исаакаас
минь агуу үндэстэн гаргана гэж
хэлсэн биш билүү. Би хүүгээ
алчихвал амлалт тань
биелэхгүй биз дээ.




... гэхдээ Та бол
Бурхан. Би
ойлгохгүй байгаа
ч үгийг тань дагая.




Гурван өдөр
явж байж хүрэх
учраас бид долоо
хоногийн дараа
ирэх байх.

Сайн
яваарай. Би та
хоёрынхоо төлөө
залбирна аа.

A comic book illustration showing a man with a beard and a white blindfold being led by a man in a blue tunic. The man in blue has a sword on his back and is holding a lantern. They are in a rocky, mountainous landscape. A speech bubble is on the left, and another is at the bottom.


Аав
аа, хоёулаа мод
түлээ авчраад, та ч
тахилын ширээгээ
засчихлаа. Харин
өргөл маань хаа
байгаа юм бэ?

Исаак чи миний
ярьсныг санаж байна уу? Бурхан
надад хэлж, ээж бид хоёрыг чинь
энэ их өтөлсөн хойно хүүхэдтэй
болгосон гэж. Тэгээд... Бурхан
надтай дахиад ярьсан юмаа.




Аав аа, бид нар өргөлийг
шатаах мод авчирсан.
Харин өргөл нь хаана
байгаа юм бэ?

Исаак хүү минь, Бурхан
надтай ярьж, ээж бид хоёрыг нь
нас өтөлсөн хойно хүүхэдтэй болгоно
гэж хэлснийг би чамд ярьж байсныг
санаж байна уу? Бурхан надтай
дахин ярьсан юм.




Энэ удаа
надад чамайг
шатаалт тахил
болгон өргө
гэлээ.

Намайг уу?
Аав аа, та чинь
үнэнээсээ ярьж
байна уу?



Та надад, Бурхан намайг өв залгамжлагч болгон агуу их үндэстний эцэг болгож, хүүхдүүдийг маань тэнгэрийн оддоос ч олон байх болно гэсэн гэж хэлээгүй бил үү? Би одоо үхчихвэл Бурханы амлалт юу болох вэ?

Бурхан амласан л бол тэрнийгээ биелүүлдэг гэж аав нь сурсан юм. Эзэн чамайг агуу их үндэстний эцэг болно гэж хэлсэн л бол чи үхсэн ч болдгоороо болно.



Би
үхчихвэл
яаж тийм юм
болох юм
бэ?

Мэдэхгүй ээ
хүү минь. Чамайг
үхлээс амилуулахгүй
л юм бол болохгүй л
дээ.

Аав аа, яасан ч
Бурханыг дагах
ёстой байх аа.


Абрахам хэдий
Бурханы үгийг
дагаж байгаага
мэдэж байсан ч
шатаалт тахилыг
ёс журмын дагуу
бэлтгэж байхдаа
гар нь салгалж
зүрх нь шаналж
байсан нь
тодорхой.



Абрахам хүүгийнхээ хөл, гарыг хүлээд тахилын
ширээн дээр тавив. Дараагийн алхам нь хүүгийнхээ
хоолойд хутга хүргэх явдал байлаа.

Бурханд өргөсөн итгэлийн
залбиралтайгаар Абрахам
хутгаа аван гараа далайлаа.
Гараа доошлуулан хутгыг
дүрэхээр завдах тэр агшинд
тэнгэрээс дуу гарч:




A comic book panel featuring a close-up of a hand gripping a sword hilt. The hand is rendered in shades of brown and tan, with detailed shading to show muscle and texture. The sword hilt is wrapped in a blue material. In the background, the face of a man with a thick, grey beard and a turban is visible, looking towards the viewer with a serious expression. The background is filled with diagonal hatching lines. A yellow speech bubble is positioned in the upper right quadrant of the panel.

Абрахам!
Абрахам! Хүүд
бүү хүр.




Цорын ганц
хүүгээ өргөхөөс
татгалзалгүй үгийг минь
дагажбайгаа тул Надад
найдан итгэдгийг чинь
мэдлээ.

Абрахамыг толгойгоо
өргөн хартал нэгэн хуц
бутанд орооцолдчихсон
байгаа харагдав.



Аав аа
хараач,
Бурхан
миний оронд
хуц өгсөн
байна!


Абрахам чи ганц
хүүгээ Надаас
харамлалгүй
үгийг минь дагасан
тул Би чамайг
ерөөж үр хүүхдийг
чинь тэнгэрийн од
адил олон болгоно.
Хүүхдүүд чинь
энэ газарт нутаглаж
дайснуудаа устган
сөнөөнө.
Чамаас төрөх
хүүхдээр дэлхийн
бүх үндэстнүүд
ерөөгдөх болно.



Аав
аа, Эзэн яг таныг
хэлсэн шиг энэрэнгүй
Бурхан байна шүү!

Абрахам Ишмаел, Исаак гэсэн нэртэй хоёр хүүтэй
байлаа. Исаак бол Абрахамд амласан амлалтаа
биелүүлэхээр Бурханы сонгосон хүү юм. Исаак Иаков
гэдэг хүүтэй байлаа. Хожим Иаковын нэр Израиль
болжээ. Иаков 12 хүүтэй байсан бөгөөд тэд нэгэн
цагт гэр бүлээ аваад Египетэд суурьшиж, яваандаа
тэр газраа боолчлогдох болсон юм (МЭӨ 1706 он).






Иаковын арван
хоёр хүү хожим нь
Израилийн арван
хоёр овог болсон юм.

Ишмаел мөн арван хоёр
хөвүүнтэй байсан бөгөөд
тэд арабчууд болсон аж.

Ишмаел

Абрахам

Исаак (МЭӨ 1896)
Иаков
(МЭӨ 1836)



Гуравдугаар
бүлэг

MOSE

МЭӨ 1875 он

Газар нутагт өлсгөлөн болж Абрахамын ач хүү Иаков арван хоёр хүүгээ гэр бүл, боолуудтай ньаван Египет уруу очиж амьдарчээ. Египетэд тэд шороо тоос шиг олон болтлоо үржиж олшров.

Нэр нь Израиль болж өөрчлөгдсөн Иаковын хүүхдүүд египетчүүдээс тоогоор олон болж өсчээ.






Египетийн хаан Фараон Иаковын үр хүүхдүүдийг боолчлон, тоосго цохиулах хүнд хүчир ажилд зүтгүүлдэг болжээ. Египетэд 300 гаруйжил боолчогдсоны эцэст тэд Абрахам ба эцгүүдэд ньамласан Бурханы амлалтыг ор тас мартсан байлаа.

Бурхан Абрахамд хүүхдүүд нь харийн нутагт очиж боолчлогдоно гэдгийг хэлсэн байсан юм. Мөн түүнчлэн 400 жилийн дараа Бурхан тэрхүү үндэстнийг шүүн шийтгэж, израильчуудыг амласан газраа буцаан авчрахаа ч бас амласан байлаа.




Миний хэлж байгаа үнэн шүү! Фараон бид нарыг дэндүү олон болохоос айгаад байгаа гэсэн. Тэгээд л Фараон бүх нялх хүүхдүүдийг алаад байгаа юм. Египетчүүд өөрсдөө залхуу, сул дорой, харин манай эрчүүд хүнд хүчир ажил хийсээр байгаад хүч бярттай болчихсон болохоор айгаад байгаа гэсэн.




Тэд нар хүүхдийг маань алж чадахгүй. Бурхан хүүг минь хамгаална.

Хн! Бурхан хүчирхэг Фараоны эсрэг юу хийж чадах юм бэ?



Болиоч ээ,
миний хүүг
битгий шидээч!
Болиоч ээ!


Фараон израильчуудыг хэтэрхий олон болохоос айж байсан учраас шинээр төрсөн бүстэй хүүхдүүдийг хөнөөж байлаа.



Гэхдээ ээж ээ,
айл хөршийнхөн бас
цэргүүд манай дүүг
хаана байна гэвэл юу
гэж хэлэх
юм бэ?

Чи тэдэнд
үнэнийг л
хэлээрэй.
Цэргүүдээр
шидүүлэхгүйн
тулд ээж
ньөөрөө ус уруу
шидчихсэн
гэхгүй юу.

Ойролцоогоор МЭӨ 1525 он



Ээж ээ
та ус орохгүй
гэж бодож
байна уу?

Давирхайдчихсан
болохоор хөвөх
байх аа.

Би дүүгээ
дахиад харах
болов уу? Өө муу
египетчүүд!

Бурхан хүүг
минь хамгаална аа. Чи
ойрхон дагаад хараад
байгаарай.

Фараоны охин усанд
орохоор гол уруу ирэв.




Хараач! Тэр
сагснаас уйлах чимээ
гараад байна!

Еврей
хүүхдүү-
дийн нэг
байх аа.

Хөөх ямар
хөөрхөн
юм бэ?


Өлсөж
байгаа
байх даа.





Хөхүүлчих
хүн олбол би энэ
хүүхдийг өөртөө
авмаар байна
аа.

Тэнд нэг
еврей хүүхэд
байна. Тэр охин
хөхүүлчих хүн
мэдэж магадгүй
шүү.

A comic book panel featuring two women. In the foreground, a woman with long dark hair and a black patterned headscarf looks towards the right with a slight smile. In the background, another woman with dark hair and a headband with a flower looks forward. The background is a bright blue sky with a sun and palm trees. A speech bubble is positioned in the upper right.


Би яваад хөхүүлчих хүн хайгаад ирье. Хүүхдээ гол уруу шидүүлчихсэн нэг эмэгтэйг би мэднэ. Тэр эмэгтэй одоо ч сүүтэй байгаа байх аа.



Бичинь юу хийчих вэ? Хүүгээ дахиад харахгүй бол яанаа? Бурхан хүнийг харж хайхардаг юм уу?

Чамд яах ч арга байгаагүй ээ. Чи үүрд нууж чадахгүй байсан шүү дээ. Эрт орой хэзээ нэгэн цагт цэргүүд олоод л хүүгий чиньалчих байсан. Чи зүгээр Бурханд найдсан хэвээрээ л бай.

Ээж ээ,
Ээж ээ!



Ээж ээ, Фараоны охин
усанд орох гэж гол уруу ирээд
манай дүүг олоод авчихсан. Өөрөө
хүүхдээ болгоод авах гэнэ ээ. Тэгээд
хөхүүлчих хүн хайж байна! Одоо
наашаа ирж байгаа шүү!


Ээ мөнхийн
Бурхан Та ерөөгдөх
болтугай!



Би таныг
хүүхдээ алдсаныг
сонслоо. Би ёстой
их харамсаж байна.
Би энэ хүүхдийг
голоос олсон юм аа.
Та энэ хүүхдийг
хөхүүлээд өгвөл би
мөнгө төлнө
шүү.

Хөхнөөсөө
гарахаар ньби өөрөө ирж
ордонд аваачаад Египетийн
фараон болгож өсгөнө. Бид
нар Мосе гэж нэр өгнө.


Мосег өсөж томроход ээж ньөвөг дээдсийнх
ньжинхэнэ Бурхан Эзэнийг таниулж өсгөсөн
юм. Энэ бяцхан хүүгийн төлөө Бурханд
тусгай нэгэн төлөвлөгөө байлаа.



Бяцхан
хан хүү минь
үсрээрэй.
Ордон уруу
явцгаая.

Эд нар хэр
хурдан давхидаг
юм бэ?

Мосег хөхүүлж
өсгөсөнд баярлалаа. Их
эрүүл харагдаж байна шүү.
Хүч чадалтай чинээлэг
нэгэн болж өснө дөө.



Мосе Фараоны охины өргөмөл хүү болж, Египетэд агуу хүн болон өсжээ. Хувьзаяа нь түүнийг хүч чадалтай, баян чинээлэг болгосон ч харин угсаа гарлаа тэр хэзээ ч мартаагүй юм.






Мосе би
чамд хэлж байна. Бидний
өвөг дээдэс Абрахам, Исаак,
Иаковын Бурхан Абрахам эцэгт
мааньур удам ньхарийн газар үржиж
олширно гэж хэлсэн юм. Тэгээд
одоо бид энд байж байна!

Тийм
ээ, Бурхан
бас Абрахамд
биднийг тэр
газраа 400 жил
дарлагдан зовно
гэж хэлсэн юм.
Одоогоор 359
жил болчихоод
байна. 41 жил
л хүлээх
үлдлээ.



Наадах чиньгайхалтай
л юм байна. Гэхдээ Фараон хэзээ
ч зарц боолуудаа тэгж амархан
явуулахгүй дээ. Тэгээд бүр эд
баялагтайгаар шүү. Тэгэхээр арга
байж л таараа. Харин яаж дахин
41 жил хүлээх болж байна аа?

Цааш нь Абрахамд
хэлэхдээ бидэнд үйлдсэн бузар
үйл болгоных нь төлөө Бурхан Өөрөө
тэр үндэстнийг шийтгэж, тэндээс арвин
их баялагтайгаар гаргаж өвөг дээдэст
миньөгсөн тэр газартаа буцаан
авчирна гэж амласан юм.




Еврейчүүд эздийнхээ гарт дарлагдан зовжээ. Тэд шавар намаг дотор тоосго хийдэг байлаа. Мосе тэдний ингэж зовохыг тэсч чадахгүй байсан тул ямар нэгэн арга хэмжээ авахаар шийдэв.

Үхтлээ
нүдүүлэхээ-
сээ өмнө бушуухан
босооч!

Муу
заваан гахай,
босооч чи!

Эбэр ээ,
босоорой.



Нэг өдөр Мосе өөрийнх нь хүмүүсийн нэгийг египет хүн тарчлаан зодож байхтай таарчээ.

Чөлөөлөх цаг болжээ. Энэ зовлон дуусах болсон.



ТАС!

Одоо
боллоо!

Мосе мөнөөх египет хүнийг
алаад булчихав. Гэвч энэ
явдлыг өөр нэг хүн хараад
Фараонд мэдэгдсэн байлаа.



Зогс, чи
хүн алсныхаа
төлөө шүүгдэх
ёстой!

Мосе
байна шүү
дээ.

Ээ Бурхан
минь! Би юу
хийчих вэ?

Ойролцоогоор МЭӨ 1491 он

Мосе Египетийг орхин цөл уруу зугтаав. Ямар ч найз нөхөд, ах дүү хамаатан садангүй орьганцаараа болсон байлаа. Тэр өөрийгөө ч аварч чадаагүй юм.



Мосе олон өдөр
алхав. Эцэстээ
эцэж ядраад
цаашаа явах
тэнхээгүй болж
хоньчдын нэгэн
хотонд иржээ.

Хараач!
Нэг хүн байна!

Бараг
үхчихсэн юм шиг
харагдаж байна. Ус
аваад ир!

Египет хүн
байна!



Мидианчуудын дунд Мосе шинэ амьдрал эхлүүлжээ. Тэр цөлийн амьралаас суралцаж, тэндээ гэрлэж хоньчин болов. Дөчин жил ч өнгөрч Египет нутаг түүний хувьд алс холын дурсамж болсон байлаа. Өөрийнхөө хүмүүсийг дахин харна гэж найдахаа больжээ.



Үнэхээр хачин юм аа!
Энэ мод яаж гал авалцсан
юм бол оо? Тэгсэн мөртлөө
яагаад шатахгүй байгаа юм
бол? Асаад л асаад л
байх юм.





Мосе, гутлаа тайл.
Чи ариун газар зогсож
байна. Би чиний өвөг дээдэс
Абрахам, Исаак, Иаковын
Бурхан байна.

Би Египетэд байгаа
ард түмнийхээ зовохыг харж
залбирахыг ньсонслоо. Тэднийг
дарлалаас ньчөлөөлөх цаг
болжээ. Тэгээд тэднийг эцгүүдэд
ньМиний амласан газар нутагт
эргүүлэн авчирна.

Би чамайг Фараон
уруу явуулж ард түмнээ
боолчлолоос чөлөөлүүлнэ. Чи
Фараонд манай хүмүүсийг чөлөөл гэж
хэлэхэд тэр татгалзана. Тэгэхэд ньБи
Египетэд хүч чадлаа үзүүлнэ. Харин
үүний дараа л тэр явуулах болно.



Таны
намайг явуулсан
гэдэгт тэд итгэхгүй
шүү дээ. Харин хөх
инээд нь хүрэх
байх даа.





Таягаа
газар хая.

Юу? Таягаа
юу?



Үхлийн
хорт могой
болчихлоо
шүү дээ!



Могойг
сүүлнээс нь
бариад ав.



A close-up illustration of a hand in a yellow sleeve with a ruffled cuff, firmly grasping the hilt of a sword. The sword's blade is visible, extending horizontally across the frame. The background is a solid light brown color. A white speech bubble with a black outline is positioned in the upper left quadrant, containing Mongolian text.

Энэ
чинь эргээд
миний таяг
болчихлоо!

Египет уруу яв. Би
чамд юу хэлэх юу
хийхийг чиньзааж
өгнө. Ах Аарон
чиньчамд тусална.



МЭӨ 1445 он

Одоо дөчин
жил өнгөрчихөөд
байнаа. Миний
өнгөрсөн явдлыг
мэдэх хүмүүс одоо
бүгд үхээ биз. Хэн ч
намайг танихгүй.
Бурханы

хүмүүсийг
Фараон хэзээ л
явуулна тэр
хүртэл байна.

Чи Египет уруу буцаж
явах гээд байдаг Амийг чиньав ах
гэж хайгаад байгаа хүмүүсийг чи
яах гэж байгаа юм бэ?

Чи тэгээд
хэр удаан явах
юм бэ?





Бүх ахмадуудыг
цуглуул! Чөлөөлөгдөх
цаг болжээ!

Тэд нар
хэн бэ?

Энэ чинь Леви
овгийн Аарон байх шив дээ.
Тэр нөгөөдөх нь манайхан шиг
л харагдаж байгаа ч боол
биш байна.




Израилийн
ахмадууд аа
наашаа дөхөөд
зогс.

Наян жилийн
өмнө Фараон бүстэй
хүүхдүүдийг хороож
эхэлсэн их хядлагын
жил Мосе төрсөн юм. Эх
нь түүнийг сагсанд хийж
гол дотор тавин нуусан юм.
Бурханы хамгаалалтаар
Фараоны охин түүнийг
голоос олж Мосег египет
хүн болгон өсгөж
билээ.



Дөчин жилийн өмнө Мосе египет хүн болж ноёрхон захирснаас өөрийнхөнтэйгөө нийлээд зовъё гэж шийдсэн юм. Тэгээд өөрийнхөө замаар биднийг аврах гэж оролдоод бүтэлгүйтсэн. Өнгөрсөн дөчин жил Бурханы эцгүүдэд миньамлас ан тэр газар цөлд амьдарч байгаад иржээ. Харин саяхан Бурхан түүнтэй ярьж биднийг Фараоны гараас хэрхэн аврах арга замыг зааж өгсөн байна! Одоо Мосе та нарт Фараоныг биднийг явуулж чөлөөлөхөд ашиглах тэмдгүүдийг үзүүлэх гэж байна.



Абрахамын Бурхан
шатаж байгаа бутан дотроос
надтай ярьж намайг эцгүүдэд минь
амласан тэр газар уруу та нарыг
удирдан дагуулна гэсэн юм.
Энэ тэмдэг ньбайна.



Хөөх! Саваа
нь могой
болчихлоо.

Бүү
айцгаа.



Энийг
хараарай.



Бурхан
бидэн уруу
чөлөөлөгчийг
явуулжээ.

Энэ ч
Фараонд
нэг үзүүлээд
өгнө дөө.

Одоо бид
нар Фараон
уруу явлаа!

Энэ чинь
гайхамшиг
байна!

Абрахамын
Бурхан
минь!

Дөчин

жилийн өмнө эндээс
явснаас миньхойш юу
ч өөрчлөгдөөгүй байна
шүү. Зөвхөн миний юу
хэлээрэй гэснийг л
хэлээрэй.




Израилийн
Бурхан Мосетэй ярьсан
байна. Бурхан хүмүүсийг
цөл уруу гурван өдөр
явуулж тахил өргүүлж,
мөргөл үйлдүүл гэж
хэлүүлсэн байна.



Ха! Израилийн
Бурхан гэнэ ээ? Ха ха ха ха ха, Би та
нарын Бурханыг мэдэхгүй юм байна.
Ямар Бурхан болоод би үгийг ньдагах
ёстой болж байна аа? Хөгийн юм.
Би боолуудаа гурван өдөр цөл уруу
явуулахгүй ээ.

Би чамайг манай хүмүүсийг хутган үймүүлж ажлыг ньхийхийг болиулж байгааг сонссон. Тэгээд одоо бүр миний мэдэхгүй Бурханд мөргөхөөр гурван өдөр явмаар байна гэнэ ээ. Тэгвэл би тэд нарын ажлын нормыг улам их болгоно доо!




Одооноос эхлээд тэд нар тоосго хийх сүрлээ өөрсдөө бэлтгэг. Одоо эндээс зайлж ирсэн газар уруугаа далд ор.

Та нар
зоригийг ньх
арж байна уу?



Ёстой инээдтэй
юм. Энд яг л Бурханы
дуу хоолой юм шиг
эрэмгий ороод ирдэг
байна шүү.



Хийж гүйцэтгээд ирсэн юм чиньт эгээд бидний ажлыг хоёр дахин нэмчихлээ гэж хэлэх гээд байна уу? Чөлөөлөлт гэнэ ээ. Тэгээд бас Бурханыг өөрийгөө илгээсэн гэж бодоод байгаа шүү.


Энэ өөрийгөө хэн гэж бодоод байгаа юм бэ?

Бид нар үүний зальм эхэд хууртсандаа итгэж чадахгүй байна.

Хоосон мөрөөдөгч!

Та нарт хангалттай хийх
ажил байхгүй байна гэнэ ээ. Явж
Бурхандаа мөргөмөөр байна уу?
Бид нар та нарыг зүгээр суухгүй
байхыг сургаад өгнө өө.





Иавэ минь
ээ, би Таны нэрээр
ирж ярьсан байтал
бүр дордчихлоо. Та
намайг яах гэж нааш
нь ирүүлсэн
юм бэ?


Би бол
Иавэ, та нарын
эцгүүдийн
Бурхан. Би
өөрийн ард түмэн
Израилийн зовлонг
харж орилохыг
ньсонсон.

Абрахамд
амласан амлалтаа биелүүлж ард
түмнийг нь Канаан нутагт аваачих
цаг болжээ. Мосе чи тэднийг
дагуулна.



Би сайн ярьж
чадахгүй шүү дээ.
Фараон намайг
сонсохгүй ээ.

Аарон хэлэх, ярих
ажлыг нь
хийнэ. Харин чи зүгээр Намайг
сонсож юу хэлэхийг нь түүнд
дамжуул. Эхэндээ Фараон чамайг
сонсохгүй. Гэхдээ египетчүүд
намайг цорын ганц үнэн Бурхан
гэж ойлгох хүртэл Би түүнд агуу
тэмдгүүдийг үзүүлнэ.



Ха, ха чи энд
дахиад яах гээд
хүрээд ирэв?

Иавэ "Миний
хүмүүсийг явуул"
гэж хэллээ.



Иавэ ярьсны тэмдэг энэ байна.

Ха-ха-ха.

Энэ чиньзүгээр
илбэ шид л байна
шүү дээ. Наадах
чиньнамайг ер
айлгахгүй байна.
Манай илбэчдийг
дуудаад ир.

Тэр үүнийг
гаргуун хийлээ
шүү. Яг жинхэнэ
юм шиг харагдаж
байна гээч.

Хаана ингэж
сурсан юм бол?

Бушуул, хурдлаарай.
Савааг могой болгодог ид
шидийн юмаа аваад ир.




Манай могойн бурхан
Несерт чамд илүү олон
тоосго хийгээтэх гэж
хэлүүллээ. Ха, ха, ха!



Мосе, одоо
бүгдээрээ яах вэ? Бид
нар яг тэнэг амьтад шиг
харагдаж байна даа.




A comic panel showing the lower legs and feet of several people in traditional attire. The ground is sandy and populated by several snakes, some of which are coiled and hissing. A speech bubble is positioned in the upper center of the panel.


Хараау!
Тэр могой нь
бид нарынхтай
тулалдах гээд
байна.



Тэрнийх
манай нэг
могойг идэж
байна!



Нөгөөдөх
чиньм анай могойг
бүр залгичихлаа
шүү дээ!



Дахиад бас
нэгийг идэх гээд
байна гэж надад битгий
хэлж үзээрэй дээ! Манай
могойн бурхан Несерт
уурлана даа.



Ёстой
итгэмээргүй юм!
Тэрний могой бид
нарынхыг бүгдийг
нь идчихлээ шүү
дээ!

Яаж ийм
юм байдаг
байна аа.



Иавэ бол бүх
бүтээлийн Бурхан.
Тэр "Миний хүмүүсийг
явуул" гэж байна.

Яаж хийгээд
байгааг чиньм эдэхгүй
юм. Гэхдээ нэг шоуны
төлбөрт сая боолоо
өгөхгүй шүү.
ОДОО ЭНДЭЭС ЗАЙЛ!



Египетээс гарсан нь 7:13 "Гэсэн
ч Фараоны зүрх хатуурч, ЭЗЭНий
айлдсанчлан тэднийг сонссонгүй."



Иавэ яагаад
биднийг Фараоны
илбэчид хийчихэж чадах
тэмдгийг үзүүлүүлэхээр
явуулсан юм бол? Тэнд
биднийг хэсэг хугацаанд
тэнэгүүд л болгож
харууллаа шүү дээ.

Мэдэхгүй
юм даа. Гэхдээ Бурхан надад
Фараоны зүрхийг хатууруулна гэж
хэлсэн л дээ. Миний саваа тэдний
гэрийн могойнуудыг идэхэд ямар
их уурласныг ньхарсан уу?

Би Иавэтэй ярих
газар олох хэрэгтэй
байна. Цааш яахыгаа
би мэдэхгүй байна.

Бурхан дахин
Мосетэй уулзаж
юу хийхийг
ньхэлж өгөв.
Египетчүүд
Мосег шоолон
доромжилжээ.
Фараон дарлахаа
улам л
чангаруулснаас
өөрийнх нь хүмүүс
Мосег эсэргүүцэх
болов. Мосе юу ч
ойлгохгүй байсан
хэрнээ Бурханд
итгэж үгийг
ньдагаж байлаа.




Иавэ ингэж хэлж байна.
“Чи миний хүмүүсийг
явуулахаас татгалзсан тул
Би үнэн Бурхан болохоо
Египетийн бүх усыг цус
болгож харуулна”



Энэ чинь харин
гайхалтай юм
байна. Яаж
ингэж чадав аа?

Манай
илбэчдийг аваад
ир. Нил мөрний
бурхан үүнийг
зогсоож чадна.



Харж байна
уу? Манай илбэчид
ч хийж чадаж байгаа
биз дээ? Би чиний илбэ
шидэд хууртахгүй
шүү.



Би
амьдралдаа ийм юм
огт үзээгүй юм
байна. Бүр горхи шанд,
нуур цөөрөм хүртэл
цус болчихлоо. Тэр
Бурханыхаа нэрийг хэн
гэчихэв ээ?


Тэдний хэлж
байхыг ер дуулаагүй юм байна.
Ямар ялгаа байна аа? Бид ч гэсэн
хэдэн мянган бурхадтай шүү дээ.
Нил мөрний бурхан хилэгнэж
байгаа байх даа.



Ганц
Бурхан гэнэ ээ?
Инээдтэй юм.

Тэр Мосе
гэгч өөрийнхөө
Бурханыг цорын ганц
бурхан гээд байсан
шүү.


Усыг цус болгосноос хойш долоо
хоногийн дараа Мосе Египет дээр
Бурханы шийтгэлийг дахин авчрав.



Гол ус асар их
мэлхий бий
болгог.

Үмхийрсэн цустай
уснаас үй олон
мэлхий гарч иржээ.






Манай гэр
мэлхийгээр
дүүрчихлээ.

Бүх Египет
мэлхийгээр
дүүрчихлээ. Бурхан
шүтээнүүд хилэгнэж
байна!

Манай тахилчид
хааччихав аа?
Тэд юу ч хийж
чаддаггүй юм уу?






Тэд нар
яагаад мэлхий нэмж
хийгээд байгаа юм бэ?
Тэр Мосе гэгчийн өгсөн
хангалттай биш байна
уу? Одоо Фараон бас
нэмээд байдаг.


Фараон
хараарай. Илбэчид
бид ч гэсэн мэлхий
хийж чадна шүү.

Яагаад тэдний хүссэнийх
ньдагуу тэр цөл уруу нь явуулж
болдоггүй юм бэ? Бид одоо
цааш тэсэхээ болилоо



Мосег
дууд. Намайг
ярилцмаар байна
гэж хэл.

За эзэнтээн,
таны хэлснээр
хийе.



Иавэгаас мэлхийнүүдийг
аваач гэж гуй. Тэгэх юм бол
би хүмүүсийг чиньяв уулж
тахил өргүүлүүлнэ.

Мэлхийнүүдийг
хэзээ устгамаар байна.
Цагаа хэлбэл тэр цагт
чиньт эд үхнэ.

Маргааш
өглөө.


Өөрийн чиньх элснээр
болог. Мөн Иавэ Бурхантай
адил бурхан байхгүй
гэдгийг бүгд мэдтүгэй.

Өөрийнх
ньх элсэн
цагт бүх
мэлхийнүүд
үхсэн байхыг
Фараон үзээд
зүрхээ дахин
хатууруулж,
еврейчүүдийг
явуулахаас
татгалзав.

Манай газар
нутгийг мэлхийгээр
дүүргэдэг ямар бурхан
гээч вэ тэр Иавэ чинь?

Ямар нэгэн
бурхан хийсэн гэж
чи яагаад бодоод
байгаа юм бэ? Зүгээр
л байгалийн үзэгдэл
ч юм бил үү.





Тэгвэл тэр Мосе
ийм юм болно гэж урьдаас яаж
мэдсэн юм бэ? Бас яаж тэдний
үхэх цагийг ягтавмэдсэн юм бэ?

Хөөе,
дуугүй амаа хамхиад
хүрздээч. Ерөөсөө
дуусахаа байлаа.

Иавэ Мосед ийн хэлжээ. "Ааронд ингэж хэл. Гараа сунгаад газрын тоос шороог цо .хь Тэгвэл газрын шороо бөөс болж Египетийн нутгаар дүүрэн тархана."



Египетийн шороо
тоос тэр чигээрээ
бөөс болов.





Бөөс хийж чадахгүй гэдэг чиньюу гэсэн үг вэ? Хүмүүс түүний Бурханыг манайхаас илүү хүчтэй гэж бодно шүү дээ! Та нарын хийж чаддаг юм бол зөвхөн хоосон илбэ шид.

Гэхдээ эзэнтээн, энэ бол ганцхан Бурханыг л хийж чадах ажил. Тэр хоёрын хийгээд байгаа юмыг ямар ч хүн хийж чадахгүй. Бидний хүч хүрэхгүй байна.

Үүнийг байгалийн аргаар тайлбарлах бодитой арга зам байж л таараа. Гэхдээ одоо үүнээс илүү тэсэж чадахгүй нь. Мосед үг дамжуул. Бурхандаа бөөснүүдийг зайлуулбал еврейчүүдийг явуулж мөргүүлнэ гэж хэл.





Бөөснүүд алга
болсон ч би боолуудыг
явуулж чадахгүй нь.
Үүнээс илүү тэдний
бурхан юу хийж чаддаг
юм бэ?




Бурхан
Мосетэй ярьжээ. Тэгээд
ингэж хэлж байна. "Би
Египетийн дээр асар их
ялааг явуулна. Гэр орон
чиньялаагаар дүүрнэ. Гэхдээ
энэ удаа Би еврейчүүдийг
египетчүүдээс ялгана.

"Миний
ард түмний дунд
ямар ч ялаа байхгүй.
Үүгээр та нар намайг
бүх ертөнцийн Бурхан
гэдгийг мэдэх
болно!"

Аав аа, манай
тахилчид яагаад
энэ хүнийг болиулж
чадахгүй байгаа
юм бэ? Тэдний хүч
яачихсан юм бэ?




Би ямар ч
шашин шүтлэг
мэддэггүй. Би ажил
төрлөө хийгээд л
явж байдаг хүн.



Яг хэлснээр
ньеврөйчүүдийн
дунд ямар ч ялаа алга
байна! Энэ яг л тэдний
Бурханы ажил байх
шүү.


Мосег
олоод ир.



Явж тэр
Бурхандаа тахилаа өргө.
Гэхдээ харин Египетийн
нутгаас гарах ёсгүй шүү!

Бид дор
хаяж гурван
өдрийн газар явах
ёстой.


Би та нарыг явж
болно гэлээ шүү дээ.
Харин холдож болохгүй шүү.
Одоо тэр Бурхантайгаа ярьж
энэ үмхий ялаануудыг
зайлуул гэж хэл.



Египетэд
ганц ч ялаа
үлдсэнгүй шүү. Энэ
ч ёстой гайхамшиг
байна даа.

Амаа тат. Чи тэр
хоосон чалчигчдад
итгээд эхэлж байгаа
юм шиг сонстоод
байна шүү.

Фараон дахиад л зүрхээ
хатууруулж хүмүүсийг
явуулахаас татгалзлаа.



Бурхан өөр
гамшиг Египет
уруу явууллаа.


Тэдний бүх
үхэр, хоньямаа,
тэмээ, морьдод
өвчин тусгаж
үхүүлэв. Харин
еврейчүүдийн
мал сүрэгт энэ
өвчин хүрэлгүй
үлджээ.

Манай мал
сүрэг үхээд дууслаа.
Харин танайх эрүүл
тарган цатгалан байна.
Үүнийг юугаар
тайлбарлах вэ?

Мосе бид нарт өвөг
дээдсийн маань Бурхан
бид нарыг танай хүнд
дарлалаас чөлөөлнө гэж
хэлсэн. Гэхдээ би жирийн
л нэг малчин хүн, нарийн
ширийн юмыг нь мэдэхгүй.



Манай тахилчид
бурхаддаа тахил өргөж
байгаа. Манай ариун бух
уурлан хилэгнэж, энэ
явдлыг эцэс болгоно.




Египетийн
бурхад хаачаа
вэ? Тэдэнд хүч чадал
байхгүй юм уу?

Фараонд одоо
нэгэнтээ оройтжээ гэж
хэл. Манай ариун бухнууд
бүгд үхчихжээ. Манай
бурхад өөрсдийгөө энэ
еврейчүүдийн Бурханаас
хамгаалж чадаагүйг мэдээд
хүн ард уурлана даа.

Гэвч Фараон зүрхээ
улам хатууруулсан
байлаа.

Бурхан дахин Мосетэй
ярьж хотын дээр үнс цац,
египетчүүд яр шарханд
баригдана гэв.




Бурхан "Та нар
миний ард түмнийг
явуулаагүй учраас Би та нар
болоод мал сүргийн чинь дээр
бохир яр шархыг илгээж
байна" гэж хэлж байна.

Өө яана аа,
дахиад тийм юм
бүү хийгээч!

Илбэчдийг дуудаад ир. Тэднийг
бүх хүчээ нэгтгэ гэж хэл. Бурхдад
өргөл өргө. Үүнийг эцэс болго.





Дээд эзэнтэн
минь, та намайг
дуудаа юу?

Чи бас?
Энэ Мосегийн
Бурханы эсрэг
хүч чамд алга
уу?



Ямар ч хүчгүй заль
мэхтэнгүүд эндээс зайл. Та нар
гараараа дохиж хүмүүсийг хуурдаг. Би
та нарыг хууран мэхлэгчид гэдгийг
мэдэж байсан юм. Та нарын бурхан
шүтээнүүд хаа байна?

Өглөө эртлэн босоод Фараоны өмнө очоод ингэж хэл. "Еврейчүүдийн Бурхан ингэж хэлж байна. Миний хүмүүсийг явуул. Дараагийн гамшгаар бүр дордоно. Энэ зүйл та нарын олныг чиньүхүүлэх гай авчирна. Үүгээр та нар надтай адилхан бурхан хаа ч байхгүй гэдгийг ойлгох болно.

Чи өөрөө мэдэхгүй ч Би чамайг Фараон болгосон юм. Миний хүмүүсийг явуулахаас татгалзаж зүрхээ хатууруулсныг чиньби мэдэж байсныг чи өөрөө харна.



Зөрүү байдал чиньнам айг
хүч чадлаа харуулж, ард түмнийг минь
дарласан хүнд дарамтын чиньэср эг
шүүлтийг Египетийн дээр авчрах
боломжийг олгож байна. Чи өөрийн
хүслийг илүүд тавьж, Миний хүслийг
биелүүлэхээс эсэргүүцэн татгалзаж
байгаа тул

...маргааш яг энэ
цагт дэлхийд урьд
өмнө хэзээ
ч болж байгаагүй
гал, мөндрөөр
бороо оруулна."



"Бүх хүмүүст хун
малаа дотор байлга
гэж сануулж байна
гэж хэл, учир ньгадаа
байгаа болгон үхэх
юм."





Иавэгийн
хэлснээр
бологтун.




Яаж гал,
мөс холилдсон
ийм юм байж болдог
байна аа?

Хүчит
бурхан Сет
минь, биднийгээ
авраач!

ААААА!


Сануулгыг хүлээн аваагүй
гадаа байсан болгон үхэв.




Ааваа, тэр Мосегэдэгхүн
энийг яаж хийгээд байгаа
юм бэ? Тэдний Бурхан
нь салхи шуурганы эзэн
Сетээс хүчтэй юм уу?

Мосе
бидэнд
цорын
ганц Бурхан
байдаг, тэгээд
энэ еврейчүүд
тэр Бурханы
хүүхдүүд гэж
хэлээд
байгаа юм.

Тэдний Бурханыг хэн ч,
бүр еврейчүүд өөрсдөө ч
хараагүй юм. Тэдний тэр зүгээр
л сүнс гэж хэлээд байгаа Бурхан
нь Фараонаар еврейчүүдийг цөл уруу
явж мөргөхийг нь зөвшөөрүүлэх гэж
оролдоод байгаа юм.



Ээ салхи
шуурганы аугаа эзэн Сет
миньээ, танаас энэ муухай
шуургыг зогсоогооч гэж гуйж
байна. Та тэр Мосегийн үл
үзэгдэгч бурхдаас илүү хүч
чадалтай шүү дээ.




Энэ чиньбид нар
уруу ойртохгүй зөвхөн
египетчүүд дээр л
буугаад байна даа.

Аав аа, би
айгаад байна.
Гал, мөс хоёр бид
нар дээр ч буух
уу?

Тэгэхгүй ээ,
хүү минь. Египетчүүд
үгийг нь сонсохгүй
болохоор Иавэ тэднийг
шийтгэж байгаа юм аа.
Тэдний салхи шуурганы
бурхан Сет өөрсдөд
ньтусалж чадахгүй, хүчгүй
гэдгийг ньхаруулж
байгаа юм.

Ямар
аймаар юм бэ.



Би Иавэгийн өмнө нүгэл үйлджээ. Еврейчүүдийн Бурхан шударга, харин миний хүмүүс, бид нар өөрсдөө бузар муу юм байна. Иавэгаас гал, мөсийг зогсоо гэж хэл, тэгвэл би хүмүүсийг тэр даруйд нь явууллаа

Би хотоос гарч тэнгэр уруу гараа өргөнгүүт гамшиг зогсоно. Үүгээр чи газар дэлхий Иавэгийнх гэдгийг мэдэх боловч хэлсэн үгэндээ хүрэхгүй ээ. Чи Бурханаас эмээх арай л болоогүй байна.

Фараон шуурга намдсаныг харангуутаа дахин нүгэл үйлдэж зүрхээ хатууруулав. Тэр хүмүүсийг явуулсангүй ээ.




Бурхан дахин өөр гамшиг явуулав.
Тоо томшгүй олон царцаа гарч
ирэн шуурга сүйтгэлгүй үлдээсэн
ногоон ургамал болгоныг идэж
орхив. Тэр царцаанууд байр
байшингуудыг сүйтгэн орж ирлээ.

Ээж ээ,
ээж ээ!

ИИИЙЙ

Тэрийг
алчлаа!



Ургамал
ногооны бурхан Гээб ээ, тариа
ногоонд мааньеврейчүүдийн
Бурханы хийгээд байгаа юмыг
харж байгаа биз дээ?


Осирис
оо, өнөөдөр
хүч чадлаа
үзүүлээч.

Фараон Мосег
дуудаж ирүүлээд
хүмүүсийг явуулахаа
амласан боловч
Бурхан царцаануудыг
зайлуулангуут зүрхээ
дахин хатууруулж,
боолуудыг явуулахаас
татгалзжээ.

Бурхан Египетийг түнэр харанхуйгаар хучив. Гурван өдрийн турш ямар ч үүлтэй харанхуй шөнөөс ч тас харанхуй байлаа. Гэсэн хэдий ч еврейчүүдийн гэрт тийм харанхуй байгаагүй юм.



Би чамайг өмнө нь алчихаж болох байсан боловч тэгээгүй юм. Ингэх нь манай бурхад танайхны эсрэг тэмцэх хүчгүй гэж харуулахад хүрэх байлаа.



Миний нүднээс
далд ор. Би чиний царайг
дахин хэзээ ч хармааргүй
байна, харах боллоо гэхэд
тэр өдрөө чи үхэх болно.


Та ганц удаа үнэн
ярилаа. Бид дахин бие
биенээ хэзээ ч харахгүй
ээ.




Нарны агуу бурхан
Раа минь, биднийгээ
сонсооч. Та гурван өдөр
биднээсээ нуугдлаа. Та
энэ еврейчүүдийн Бурханыг
дийлэхгүй юм гэж үү?

Одоо хангалттай! Сүүлчийн гамшиг.
Фараон одоо бид нарыг Египетээс явахад
баярлах болно оо. Өнөө шөнө, шөнө дундын
алдад устгагч Египетийн дээгүүр өнгөрнө. Айл
бүрийн ууган хүү үхэх болно. Бурхан өнөө
шөнө гэм нүглийг шийтгэх болно.

Тэгвэл манай
ууган хүүхдүүд
ях вэ? Тэд бас
үхэх юм уу?






Итгэх хүн бүрт,
тэр ч бүү хэл египетчүүдэд
хүртэл Бурхан аврагдах боломж
олгож байгаа юм. Одоо явж эр
хурга эсвэл эр ямаа алж цусыг
ньөнөө орой хаалганыхаа хоёр
хатавч, тотгонд түрх.

Иавэ ингэж хэлж байна. Өнөө шөнө
Намайг газар нутаг дээгүүр бүх ууган
хөвгүүдийг алахаар өнгөрөхөд танай
хаалганы гадна талд цус харагдвал Би
дээгүүр ньөнгөрч ууган хүүхэд
чиньүхэхгүй. Шөнө гэрээсээ гаралгүй,
алсан хурганыхаа махыг ид.




Одоо явж египет
эздийнхээ гэрт очиж
тэдний үнэ цэнтэй алт,
мөнгөн эрдэнэсийг зээлд.
Бурхан тэдний зүрх сэтгэлийг
хөндсөн учраас тэд та нарт
татгалзахгүй арвин ихээр
өгөх болно.

Юмаа боож баглаад маргааш
өглөө хөдлөхөд бэлэн байцгаа. Та
нэр энэ газар дахин ирэхгүй. Египетийг
үүрд орхих цаг болсон байна. Энэ бол та
нарын амьдралын эхлэл болох анхны
өдөр юм.



Аав аа, энэ
чинь манай ганц
хурга шүү дээ. Зүгээр
л улаан будаг ч юмуу
аль эсвэл өөр нэг юм
хэрэглэж болдоггүй
юм уу?

Хүү минь, Бурхан
хурга алаад цусыг
ньхаалганыхаа хүрээнд
түрх гэсэн. Тийм учраас бид
яг хэлснээр ньхийх ёстой
юм. Өөрт нь итгэхгүй байгаа
хүмүүсийг хэрхэн шүүж
байгааг ньчи харж байгаа
биз дээ. Энэ хурга чамайг
үхлээс хамгаалж байгаа
юм шүү дээ.

A comic book panel featuring a woman with dark, curly hair and a headscarf. She is wearing a brown, textured tunic. She is holding a dead, light-colored animal, possibly a rabbit or a small dog, in her hands. The animal's mouth is open, and it appears to be dead. The background is a solid orange color. There are two speech bubbles: one on the left containing Mongolian text and one on the right containing Russian text. The style is a classic comic book illustration with bold lines and flat colors.


Тэгээд
энэ хурга миний
төлөө үхэж байгаа
юм уу?

Бас миний төлөө.
Би бас ууган хүү
байгаа юм.



Байшингийн чиньд
ээгүүр гарахад хаалган
дээр чиньцус харагдвал та
нарыг Өөрт ньитгэс эн
байна гэж ойлгоод
байшин дотроос хэнийг
чиньч алахгүй гэж Иавэ
хэлсэн юм.


Ээж ээ аав
яагаад хаалгаа
цусаар будаад
байгаа юм бэ?



Та нар
яагаад хурга
алж цусыг нь
хаалган дээрээ
түрхээгүй юм
бэ?

Хэ хэ та нар тэр
хий юманд итгээд байгаа
юм уу? Хаалган дээрх
өчүүхэн цус яаж үхлийг
зогсоож чадах юм бэ? Манай
хүү ерөөсөө айхгүй байгаа.
Мангар юм уу чи?

Юу гэж айх юм бэ? Чи намайг
хулчгар амьтан гэж бодоод байна уу? Шашин
чиньдоройчуу дынх байхгүй юу. Сайн бурхан лав
хүмүүсийг жоохон цус хаалган дээрээ түрхээгүйгээс
ньбо лоод алахгүй дэг. Энийг чинь
сонсоогүй хүмүүс яах юм бэ?

A comic book illustration showing a man with a beard and long hair, wearing a yellow robe, reading a scroll. He is standing and pointing towards a group of people seated at a table. The group includes a young boy, a man, and a woman. The table has a plate of food, a cup, and a small stove. The background shows a window with curtains.

Аав аа, өнөө
шөнө бусад шөнөөс
юугаараа ялгаатай
юм бэ?


Өнөө шөнө Бурхан
өөртөө итгээгүй бүх хүний
ууган хүүг ньалуулахаар
устгагчийг явуулах юм. Харин
хаалган дээр цус харагдах юм бол
тэр айлын дээгүүр өнгөрнө.

Энэ бол бидний өдөр
хоногуудын эхлэл юм аа, хүү минь. Жил
бүрийн энэ цагт бид Дээгүүр өнгөрсний баярыг
тэмдэглэж Бурхан биднийг Фараоны гараас
хэрхэн чөлөөлснийг санан дурсах юм.




Аав аа,
энэ хашхирааныг
сонсооч! Нөгөө устгагч
энд ирчихсэн байх аа!

Битгий айцгаа.
Бид Бурханы үгийг дагасан. Цус
хаалганы хүрээнд түрхэгдсэн
байгаа. Бид нар бас хурганы
махыг идэж байна.



Хүү минь үхчихлээ!Ээ
Бурхан минь, ямар нэг юм
хийгээч. Мосег дуудаач!



ЭЭЭЭЭ!

ҮГҮЙ
ЭЭ!

Үгүй ээ,
Бурхан минь
миний хүүг
биш ээ!

Ээ яанаа. Одоо нэгэнт
оройтжээ. Бид чамд сануулсан боловч чи
итгэхээс татгалзсан шүү дээ. Өнөө шөнө олон
хүн үхсэнд би үнэхээр харамсаж байна.

Устгагчийг тэр
шөнө хотын дээгүүр
өнгөрөхөд олон
мянгаараа үхжээ. Харин
итгэж хурганы цусыг
хаалган дээрээ түрхсэн
болгон амьд үлдсэн юм.



Манай
хүү
үхчихлээ!

Хурдлаарай,
Мосег энд даруйхан
авчир.




Юу.....?

Тэр чинь
айлын ууган
ньшүү дээ!



Фараон Мосег дуудуулжээ.

Гэвч Фараон Мосег эгцлэн
харж чадсангүй.



Би
нүгэл үйлджээ.
Чи энэ Египетээс
еврейчүүдээ бүгдийг
ньаваад гарч үз.
Чиний Бурхан Иавэг
би аргалж чадахгүй
юм байна. Явахаасаа
өмнө намайг
ерөөгөөрэй.



Бурхан эцгүүдэд нямласан ёсоор тэд Египетэд дөрвөн зуун жил болсны дараа тэндээс явжээ. Египетчүүд еврейчүүдэд алт, мөнгөн эдлэл, хоол хүнс зэрэг хүссэн болгоныг өргөж даахынх ньхэрээр өгчээ. Тэр өдөр бол шинэ үндэстэн болсны анхны өдөр байсан бөгөөд еврей үндэстний хувьд баяр баясгалантай мөч байлаа.

Хүүхэд, эмэгтэйчүүдээс
гадна 600,000 эрэгтэй
Египетийг орхин, амласан
газар уруу хөдөлсөн юм.



Бурхан тэднийг өдөр ньүүлээр
шөнө ньга лан баганаар удирдан
дагуулсан юм. Үүл тэдэнд сүүдэр
болж гал тэдэнд гэрэл болж байлаа.



Дөрөвдүгээр
бүлэг

ЕГИПТЕТЭЭС
ГАРСАН НЬ



Еврейчүүд явсаар уулархаг газарт
хүрч Улаан тэнгист тулан иржээ.
Тэндээ буудаллаж тэр их усыг хэрхэн
гатлахаа хоорондоо хэлэлцэв.




Тэрэгнүүдийг бэлтгэ. Еврейчүүдийн хойноос хөө. Бүгдийг ньал эсвэл буцаан авчир.

Фараон хүүгийнхээ хойноос гашуудаж дуусаад урьд өмнө хэзээ ч уурлаж байгаагүйгээрээ уурлан шатжээ. Яагаад тэр боолуудаа явуулчихдаг билээ?



Мэдлээ гүйцэтгэе, Эрхэм хаантан!





Хараач,
Египетийн цэргүүд
ирж явна! Бид энэ эзгүй
газар урхинд оржээ!


Мосе энд бид нарыг
үхүүлэхээр авчиржээ.
Бурхан ч мартсан энэ газар
алагдсанаас боол чигээрээ
үлдсэн нь дээр байсан юм.



Хажуу талд уул, өмнө маань ус. Бид ч бүр занганд оржээ.

Одоо Бурхан ч биднийг аврах аргагүй болсон.

Яах ч аргагүй болсон еврейчүүдийг харсан египетчүүд өөрсдөд нь Мосегийн учруулсан гай зовлонг санаж тэднийг юу ч үгүй устгахад бэлэн байлаа.



Байгаа газраа
зогс. Бурхан биднийг
гайхамшигтай аргаар
аврах болно.

Бурхан Фараоны
зүрхийг дахин нэг удаа
хатууруулжээ. Өнөөдрөөс
хойшта нар Египетийн
цэргийг дахин хэзээ ч
харахгүй.




Египетчүүд юу юугүй еврейчүүдийг гүйцэн ирэхийн даваан дээр тэнгэрээс гэнэт галан багана буун ирж тэдний замыг хаав. Тэр шөнө еврейчүүд гэрэлд харин египетчүүд түнэр харанхуй дотор байлаа.

Мосег тэнгисийн зүг таягаа
өргөхөд тэнгэрээс их салхи
гарч тэнгисийн дээрээс
үлээхэд тэнгис заагдан
ёроолынх нь хуурай газар
ил гарав.



Энэ бол ёстой агуу
гайхамшиг байсан юм.
Израилийн хүүхдүүд
тэнгисийн ёроол
дахь хуурай газраар
тэнгисийг туулан гарлаа.

Ирээдүйд тэд тэнгис дундуур зам
гаргасан Бурханы тухай дуулцгаана.
Иавэ гэдэг нэртэй ганц Бурхан
байдгийг хүн бүр мэдэх болно.



Энэ чинь Египетэд
бидний үзсэн болгоныг
гүйцэх юм байна.

Төөх, Манай Бурхан
бүхнээс агуу Бурхан
юм байна. Бид нар
чинь тэнгисийн голд
байна шүү дээ.



Жоаш! Чи чинь
солиороогүй
биз? Наанаасаа
холд! Чи сэлж
чадахгүй шүү дээ!




Би энэ хөөрхөн
загасанд зүгээр хүрээд
л үзчих гэсэн юм.

Еврейчүүдийг тэнгисээр яг гарч дуусч байхад нь Бурхан египетчүүдийг хоргоож байсан галан ханаа авав. Тэд тэнгисийг хуваагдсан байгааг хараагүй учраас еврейчүүдийн хойноос нэхэн хөөлөө.




Дайраад!
Еврейчүүдийг
алаад
байгаарай!



Өнөөдөр та
нар Иавэгийн хүч
чадлыг үзлээ.

Хараач, ус
буцаад нийлж байна. Тэд
нар одоо бүгдээрээ живлээ.



Египетийн бүх цэрэг
тэнгисийн усанд живж үхжээ.
Тэдний мод, чулуун бурхад
өөрсдийг нь аварч чадсангүй.

Хараач тэдний
цогцсыг. Тэнгис
египетчүүдийн
цогцсоор
дүүрчихлээ.



Иавэ ч үнэхээр
цорын ганц
Эзэн Бурхан юм аа.
Ийм юм хийж чадах өөр
ямар ч Бурхан байхгүй
шүү. Энэ өдрийг бид үүрд
санан дурсана даа.

Тэр өдөр еврей үр удам Египетийн
сөнөсөн


цэргийн арми, ус далайг ардаа орхиод үүл
Моше хоёрыг даган эзгүй цөлийн зүг
хөдөллөө. Тэд Египетээс авч гарсан хоол
хүнсээ тэр болтол идсээр л явсан юм.



Хэдэн өдрийн аяны дараа тэднийг дагуулж
байсан үүл хэдэн хурдгийн дэргэд зогсчээ.

Еврейчүүд тэнд хоол хүнсээ дуустал
буудаллав. Цаашид хоол хүнс олох ямар ч
арга байсангүй. Найдвар тасарч байгаа мэт
харагдаж байлаа.

Ерөөсөө Египетэд үлдсэн бол үүнээс дээр байх байсан юм. Зарц боол ч гэсэн хангалттай идэх юмтай байсан юм. Одоо бол юу ч алга.




Харин тийм ээ, энд чи биднийг өлсгөж алах гэж авчраа юу?




Намайг сонс. Та нар миний эсрэг бишх арин дагаж яваа Бурханыхаа эсрэг гомдоллож байна шүү.

Иавэ тэнгэрээс талхаар бороо оруулна гэж хэллээ. Өглөө болгон та нар газар талхаар хучигдсан байхыг олж үзнэ. Зөвхөн түүж аваад идэх л та нарын хийх ажилюм.



Мосе юу гээд
хэлчих вэ? Бид яаж
идэх юм олох юм бэ?
Хүүхдүүд маань
харангадаж байна.

Иавэ тэнгэрээс
өглөө болгон талхаар...
бороо оруулах гэж
байна гэнэ ээ.



Одоо ч нар мандах цаг болж байна даа. Мосегийн хэлснээр газар дээр талх байна гэж чи итгэж байна уу?

Байхгүй бол харангадах л болох нь дээ.


Чи ер нь тэнгэрээс талхаар бороо ордог гэж дуулсан уу?

Үгүй ээ, гэхдээ бас тэнгис дундуур зам гардаг ч гэж дуулж байгаагүй юм байна. Мосегийн энэ Бурхан бол ертөнцийг Бүтээгч байж таарна. Тэгэхээр Түүнд тэнгэрээс талх оруулна гэдэг тийм их хэцүү юм бишбайхаа. Цаг болсон байна. Наашир гарч харъя.



Яг хэлснээр нь
тэнгэрийн талх
байна шүү.

Бид чинь
яахаараа эргэлздэг
байна аа?



Хараач! Газар
сайгүй байна.

Хөөх, ямар гоё
амттай юм бэ? Яг
зөгийн бал шиг
амттай юм байна.

Үнэхээр л Иавэ бол
Бурхан харин Мосе бол
эшзүүлэгч нь юм
байна.

Хээр цөл газар байх бүхий л хугацаанд нь Бурхан тэднийг тэнгэр элчийн хүнс болох тэнгэрийн талхаар хоолложээ.




Үүл тэдний хуаран дээр тогтон зогсоход еврейчүүд булгийн усны дэргэд буудаллаж, тэнгэрийн талхаар хооллож, харин нүүж эхлэхэд нь майхан саваа ачааллан хойноос нь даган хязгаарүй цөлөөр явдаг байлаа.

Харин одоо
тэдний уух ус
дуусчээ.

За яахав тэр
бидэнд талх өгдөг
юм байж харин
одоо цангааж алах
нь ээ.

Одоохон ус олохгүй
бол бяцхан охин минь
үхлээ шүү дээ.





Бид Египетэд үлдэх ёстой
байсан юм. Нэг л өдөр хамаг мал
амьтан маань үхэж дуусаад дараагаар нь
хүүхдүүд маань үхэж эхлэх болох нь.
Толгойг чинь том чулуугаар бяц цохих
нь зүйтэй юм байна.

Бурхан
бид нартай
байна уу үгүй
юү?

Би явж
Иавэтэй
яръя.



Бурхан Мосед
юу хийхийг нь
хэлж өгөв.

Нааширж
Иавэгийн хүч чадлыг
үзэгтүн. Та нар Түүнд
итгэхгүй ээ. Та нар
уурлаж гонгинож л
чадна.

Тэр та нарт талх
өгсөн одоо энэ нүцгэн
хаднаас ус гаргаж өгөх
гэж байна.





TAC!

AAAAA!

Ус яг гол
шиг урсчээ.






Үүл дахин нүүж эхлэхэд еврейчүүд ачаалан хөдөлж, цөлд үүлийг дагасаар Синаи нэртэй уулын зүг хөдөллөө.

Мосе тэнд Бурханд залбирахад
Бурхан түүнтэй дахин ярив.

Тэдэнд, Египетэд Миний
юу хийж, яаж өөрсдийг
ньчөлөөлснийг бас хэрхэн
хооллож, хаднаас хүртэл
ус гарган ундаалуулсныг
миньсануулан хэл.






Хэрэв тэд
тушаалуудыг
минь сахивал
Миний онцгойлсон
ард түмэн болж
энэ дэлхийн улс
үндэстнүүдээс
дээгүүрт тавигдах
болно
гэж хэл.

Тэд Намайг
дагавал тахилчдын
хаант улсынхан
болох юм.

Мосе уулнаас бууж ирэн хүмүүст Бурханы ярьсан болгоныг хэлэв.




Бид дагана
аа. Бурханы хэлсэн
болгоныг бид
биелүүлнэ.

Тэгвэл явж хувцас биеэ
угаагтун. Бурханд хүндэтгэл мөргөл
үйлдэхэд өөрсдийгөө бэлтгэцгээ.
Гурван өдрийн дараа Бурхан та
нартай уулзана.

Бурханы тушаасны дагуу гурав дахь өдөр нь ард түмэн уулын хормойд Бурханы ярихыг хүлээн цугларчээ. Уулын оройд нэгэн ер бусын үүл бууж...




Мосе уул өөд
гараад ир.



Мосе, Би бол та нарыг
Египетийн нутгаас гаргаж
авсан Иавэ Бурхан байна. Чи доошоо
буухдаа уулын хормойгоор хүрээ
гортиг тат.

Хүмүүсээс нэг
нь л ууланд хүрэх юм
бол тэр хүн үхнэ шүү. Би
чамд арван тушаал өгнө.
Чи түүнийг хүмүүст
хэлэх ёстой юм.



Чамд Надаас өөр бурхан
байж болохгүй.

Мөргөн хүндлэхээр ямар ч
хэлбэр дүртэй юм хийж
болохгүй.

Миний нэрийг
хүндлэлгүйгээр дэмий
хоосон дуудаж болохгүй.
Долоо хоногийн долоо дахь
өдөр Намайг хүндлэхэд
зориулагдсан байх ёстой.
Эцэг эхээ хүндэл.

Хүн бүү ал.

Гэрлэсэн ханиасаа
өөр хэнтэй ч бэлгийн
хавьтал бүү үйлд
Хулгай бүү хий.
Бусдын эсрэг худал бүү
гэрчил.

Бусдын аливаа
юманд бүү шунахайр.

Мосе уулнаас бууж ирээд
Израилийн далан удирдагчийг
цуглуулж Бурханы арван
тушаалыг хэлж өгөв.


Бид үүнийг
хийх болно.

Сайн тушаалууд
байна шүү.

Танарындаланхүндтайхамтуул
өөдгарна.Бурханнадтайуулзсаншигээта
нартайбасуулзахюм.Танарөөрсдөөүзэцгээ.
ГэхдэээхлээдбиБурханыхэлсэнтушаалууд
ыг номдбичиххэрэгтэйбайна.

Мосе Бурханы хэлсэн болгоныг маш
болгоомжтойгоор бичиж авав.
Бурханы Сүнс Мосег алдаа
гаргуулахгүйн тулд тусалж байлаа.



A man with a beard and curly hair, wearing a yellow robe, stands on the left side of the frame. He is holding a large, open scroll with both hands and looking towards a large crowd of people on the right. The crowd consists of men and women in traditional, simple clothing, some wearing head coverings. The background shows a landscape with mountains and a tent-like structure. The scene is set outdoors under a bright sky.

Мосе хуулийн
үг үсгүүдийг
бичиж дуусаад
хүмүүсийг
цуглуулж
Бурханы үгийг
уншиж өглөө.

Бурханы хэлсэн
болгон машс айн
байна. Бид эдгээрийг
сахин биелүүлнэ.

Ийнхүү Израилийн ард түмэн
Бурхантай гэрээ байгуулжээ.
Бурхан тэднийг ерөөн, шинэ
амьдрал өгч, дайснуудынх
нь гараас чөлөөлж байх юм.
Харин израильчууд Бурханы
тушаалуудыг сахин биелүүлж,
шударга зөв амьдрах ёстой байлаа.


Бурхан цусан тахил өргөөд цусыг нь хүмүүс дээр цац хэмээн Мосед тушаажээ.



Бүгд үхэх ёстой нүгэлтнүүд байсан юм. Тэр бүү хэл Мосе, Аарон нар ч тийм л нүгэлтнүүд байлаа. Харин Бурхан энэрэнгүй Бурхан учраас гарах арга замыг зааж өгчээ.



Гэм зэмгүй хургыг алаад цусыг нь ард түмний дээр цацаж үхвэл зохилтой гэм нүглийг нь халхалж байгаа юм. Үхэх шаардлагагүй байсан хурга үхэх ёстой байсан үй олон хүний оронд үхжээ.




Одоо та нарын гэм нүгэл арчигдсан. Та нараас далан хүн надтай цуг уул өөд гарч, та бүхэн Бурханы сүр жавхланг үзэх болно.



Израилийн далан
ахлагч Мосег даган
Бурханы өөртэй нь
ярьсан уул уруу явлаа.

Гэнэт, Бурханы сэнтий
тэдний өмнө харагдлаа.



Бурханы
сүр жавхлан!

Далан ахлагчийг харж байхад
Мосе уул өөд гарч гялалзан
байх Бурханы сүр жавхлан
дотор харагдахгүй болов.

Ямар
үзэсгэлэнтэй
юм бэ!


Мөн сүр
жавхлантайяа.

Бурхантай нүүр
нүүрээрээ ярьдаг
Мосе шиг ямар ч хүн
байхгүй юм.

Мосе, Надад хүндлэн
мөргөх асрыг хүмүүсээр чи
баруул. Тэр дотор тахил
өргөж байх тахилын
ширээ байх бөгөөд үеийн
үед ахлах тахилч нар Надтай
жилд нэг удаа орж уулзаж
байх ариун
газар бас барь.

Асрыг яг яаж хийхийг би та
нарт зааж өгнө. Левийн овог
Миний тахилч нар болно.
Харин Аарон хөвгүүдийнхээ
хамт ахлах тахилч нар болох
юм. Тэд ард түмэнд ёс горимыг
заах бөгөөд хүмүүс гэм нүгэл
үйлдэхэд өргөл өргөж
байх юм.






Хэдэн долоо
хоногийн өмнө л Мосе уулын
орой дээрх гал уруу орж алга
болсон. Одоо ч үхээ байлгүй
дээ.

Харин тийм
ээ, бид энэ цөл
газар үүрд суугаад
байж болохгүй
байх аа.

Мосе биднийг
удирдсан шиг
бидэнд нэг бурхан
хэрэгтэй
юм бишүү.

Бүгдээрээ
бурхандаа
зориулж алтан
дүр бүтээцгээе.



Мосе одоо
үхсэн. Аарон бидэнд
зориулж алтан бурхан,
биднийг буцаагаад Египет
уруу дагуулна.

Алтнуудаа
өгцгөө.

Өөрсдийнхөө гараар тэр тэнэгүүд
бухын дүрс баримал бүтээгээд
түүнийгээ бурхан гэж нэрлэв.
Сатан нүгэл үйлдэхээсээ өмнө
анх бухын дүртэй байжээ. Хэдий
хүмүүс үүнийг нь мэдээгүй ч
Сатан өөрийгөө хүндлүүлэхээр
тэднийг удирджээ.



Аарон хүмүүсийн хүслийг дагаж алтан бурхан
барихад нь туслав.




Аарон үнэхээр тэнэг юм хийсэн юм.
Хийсэн юм нь бурхан бишбайсныг
мэдэж байсан ч хүмүүсээс тэр айж байв.



Та нарыг
Египетийн нутгаас
гаргасан бурхан
чинь энэ байна.
Маргаашбид агуу их
тахил өргөж Иавэг
хүндэтгэн мөргөнө.

Бурхан аль хэдийнэ тэдэнд мөргөж
шүтэхийн тулд ямар нэгэн дүрс бүү
хий хэмээн тушаасан байсан боловч тэд
өөрсдийнхөө бодол төсөөллийг дагажээ.



Хүмүүс хөөрөн бүжиглэж
бүр нүцэглэсэн байв. Тэд
ууж согтон завхайрчээ.
Бурхан тэднийг устгаж
Диавол ба түүний элч
нарт бэлтгэсэн халуун
гал уруу чулуудахад ч
бэлэн байлаа.

Бурхан Мосед ийн хэлжээ "Одоо доошоо
буу. Хүмүүс бузар муухай нүгэл үйлдэж
байна. Тэд өөрсдийгөө нүцэглэж бузар
шүтээний өмнө бүжиглэж байна. Би
тэднийг бүгдийг нь устгах ёстой. Тэдний
зүрх хатуу аж. Тэд шударга зөвөөр амьдарч
чадахгүй юм байна."




Хүмүүс Бурханыг умартан өөрсдөдөө бурхан шүтээн хийсэнд Мосе маш их уурлаж байлаа.

Та
нар Бурханы
тушаалуудыг зөрчиж
байна!




Мосе тушаалуудыг бичсэн
чулуун хавтангуудыг
унагаан бутлав.



Иавэгээс өөр
ямар ч бурхан байж
болохгүй гэж хэлээгүй
билүү? Гараараа хийсэн
баримал дүрс чинь та
нарыг бүтээгч байж
чадах уу?

Мосе мөнөөх алтан
тугалыг бут цохин нунтаг
болтол нь үйрүүлж орхив.




Хэрэв та нар
Иавэгийн талд
байгаа бол наашаа миний хажууд
ирж зогс. Харин Египетийн
бурхдын талд байгаа бол зогсож
байгаа газраа үлдэгтүн.

Хэдийгээр хэлбэр
дүрс байхгүй ч би Улаан
тангисийг хоёр хуваасан
Бурханыг дагана.

Бид
Абрахам, Исаак,
Иаковын Бурханыг
дагана аа.



Нүглийн шийтгэл
бол үхэл. Иавэ надад
тэд нарыг үхэх ёстой гэсэн.
Одоо сэлмээ аваад элдвийн
хэлбэр дүрстэй шүтээнд
мөргөгчдийг алагтун.



Тэр өдөр нийт
хуурамч бурхад
шүтэгч, завхайрагч
3000 хүн алагджээ.


ЦАВЧИХ
ЧИМЭЭ!

Болъё
оо!


Өршөөгөөч!

Мосе уул өөд буцан
гарахад Бурхан арван
хуулийг хоёр чулуун
хавтан дээр дахин
бичиж өгчээ. Мосе
уулнаас бууж ирээд
хүмүүст Бурханы
тушаалуудыг
үзүүлэхэд тэд даган
биелүүлэхээр хүлээн
авав.






Бурхан та нарыг хатуу
зүрхтэй зөрүүд хүмүүс байна
гэж хэлсэн шүү. Та нарыг гэм нүгэл
үйлдэхэд Бурхан бүгдийг чинь устгана
гэсэн юм. Харин би та нарын төлөө
залбирсан учраас Бурхан гэм нүглийг
чинь хойштавих гэж байна. Иавэ бол
үнэхээр уучлан өршөөгч Бурхан
юм даа.



Бурхан асрыг барих журам зааврыг өгчээ.
Хэрвээ бид хэлсэн зааврынх нь дагуу барьж чадвал
Бурхан өөрөө энд бидэнтэй уулзаж байх юм. Хүмүүс бид
нэгэнт нүгэлтнүүд учраас Өөрт нь хүрч болох арга замыг
Бурхан өөрөө л бидэнд зааж өгчээ.


Левичүүд өдөр бүр цусаар тахил өргөж байх
юм. Жил бүрийн нэг өдөр гэрээний авдар дээр
цус түрхэх болно. Бурхан авдар дээрх цусыг
хараад Египетэд үйлдсэн шигээ бидний нүглийг
цайруулж бид үхэхгүй. Энэ бол Бурханы
уучлалын арга зам билээ.

Асар баригдаж дуусаад тахилч нар өдөр тутмын өргөлүүдийг өргөж эхлэв. Бурхан малын цусаар тахил өргөж байгаа хүмүүсийн итгэлийг хараад нүглийг нь уучилжээ.



Хүмүүс цөлд амьдарч байгаадаа дургүйцэж байсан учраас байнга л гомдоллож байлаа.

Тэдний итгэлгүй гомдож гоншгоносон байдал Бурханыг өөрсдийнх нь дээр шийтгэл авчрахад хүргэжээ.



Иий! Хараач.
Могой... зөндөө их
байна!

Бурхан тэдний хуаран уруу мах цусанд дурласан машолон хорт могой оруулжээ. Бурхан өршөөн уучилдаг ч гэм нүгэл үүрд үргэлжлэхийг зөвшөөрөөгүй юм.



Удалгүй хуаран хорт могойгоор дүүрэв.




Бурхан миньээ,
бидэнд туслаач!

Могойнууд шөнөөр бүр
майхан саванд нь ч орж иржээ.

сссссссссссс





Надад
туслаарай. Би
хазуулчихлаа.



Авраарай!

Яанаа, Жоаб

Ээжээ!



Эцэг эхийнхээ гэм нүглээс
болж хүүхдүүд хүртэл
зовон тарчилж байлаа.


Хуарангаар нэг уйлан орилох, гашуудан шаналах дуу сонстож байлаа. Гэм нүглийн шийтгэл үнэхээр аймшигтай ажээ.

Ийм юм хуарангаар нэг тарж хором, хормоор гаарч байна. Аль хэдийнэ биднээс зөндөө олон маань үхчихлээ.

Мосег олох хэрэгтэй байна. Энэ яах аргагүй Бурханы хийж байгаа ажил байна. Бурхан л хүмүүсийн гэм нүгэлд хорсон хилэгнэж байна даа.


ТАС!





Чи Бурхантай
ярих ёстой. Бид
ийм шийтгэл авах нь
зүйтэй л дээ. Гэхдээ
Бурханыг өршөөлөө
үзүүлээч гэж
гуйгаач.

Хүмүүс хэзээ
Бурхан гэм нүглийг
үзэж чаддаггүй гэдгийг
сурах юм бэ? Тэд
Бурханы тушаалуудыг
сахиж ариун үндэстэн
болох ёстой шүү дээ.


A man with curly hair, wearing a brown robe, is shown in a deep bow, his hands clasped together in a prayerful gesture. The background is a dark blue with diagonal lines, suggesting a dramatic or somber setting.

Бурхан минь ээ,
Өөрийнхөө хүмүүст
өршөөл үзүүлээч!
Тэдний нүглийг
уучлаач.

Яв. Хүмүүсийг хазаад
байгаа могойнууд шиг
хүрэл могой хий. Хийсэн
могойгоо бүх хүмүүст
харагдахаар газар өндөр шонд
өлгө. Тэгээд хүмүүсийг өлгөөтэй
байгаа хүрэл могой уруу
харахад л тэр дороо шууд
эдгэрнэ гэж хэл.


Бурхан арга зааж өглөө.
Тэр хүрэл могой уруу хар
тэгээд л та нар эдгэрнэ.





Тэр үхэх
нь ээ.

Хараарай!
Бурхан арга зааж
өгчхөөд байна.
Зүгээр нүдээ нээгээд
хараач. Хараад
сэргээч!




Энэ чинь
гайхамшиг
байна!

Бүгдээрээ
өөр хүмүүст
хэлэх ёстой.

Надад л лав
тусалсан! Би
хүмүүст хэлнэ ээ.

Түүнийг
хар,
тэгвэл амьд
үлдэнэ!





Нөхөөр, чи яагаад
бүтэхгүй юм ярьж хүнээр
тоглоом тохуу хийгээд
байна аа?

Бусад
хүмүүс хараад
эдгэрээд байгаа
юм аа.

Үхэж байгааг минь
харахгүй байна уу? Тийм
тэнэг юм ярьж яаж чадаж
байна аа чи?



Үхчихлээ.


Уучлаарай,
тэр өөрөө даанч
итгэсэнгүй л дээ.

Тэр их бардам хүн
байсан юм аа.

Хүмүүс Бурханы хүч чадлыг
дахин нэг удаа ийн үзжээ.
Хуаран могойнуудаас
холдон нүүж амьдрал
эргээд хэвэндээ орлоо.



Гэвч хүмүүс Бурханы
тушаалуудыг дагахдаа
алдаж өөрсдийнхөө арга
замаар явсаар л байв.




Израилийн үр удам үүлийг даган явж байлаа. Бурхан тэднийг тэнгэрээс манна оруулан хооллож уух усаар хангаж байв.

Бурхан тэднийг амласан газартаа шууд дагуулан очиж болох байсан ч тэд тушаалуудад нь дуулгаваргүй хандсан учир тэднийг эзгүй цөлөөр дөчин жил тэнүүчлүүлжээ.

Мосе чи ганцаараа л Бурхантай хамгийн ойрхон байдаг гэж бодоод байна уу Бид нар ч гэсэн чамтай адилхан ариун хүмүүс.


Үнэндээ бол бүх чуулган ариун шүү. Одоо бидний дунд нэг ч нүгэлтэн үлдээгүй. Тэгээд Бурхан ч бидний дунд оршин байна. Аарон та хоёр эргэн тойронгүй явж юу хийхийг маань зааж өөрсдийгөө бидний шүүгч болгохын хэрэггүй. Бид ч та нар шиг шүүчхэж чадна.




Харин тийм ээ. Ер нь Бурхан биднийг аахар шаахар зүйлээс болж алж хороогоод л цөлөөр ингэж тэнэж явахаас би бүр залхаж байна.

Тийм ээ. Энэ Мосегийн буруу. Тэрний хэмжүүр дэндүү өндөр юм.

Мосе асарт орж
Бурханаас яахыг асуув.





Бурхан ингэж хэллээ. " Левийн хөвгүүд ээ та нар өөрсөд дээрээ дэндүү их хариуцлага авч байна. Та нар Бурханы томилоогүй хүмүүсийг тахилчид болгож байна."

Маргааш ЭЗЭН бид бүгдийн хоорондхыг шүүнэ. Тэр үед бид хэн нь Бурханы тахилчид, хэн нь ариун, хэн нь ариун бус болохыг мэдэх болно. Маргаашбойпр ууддаа гал хийгээд ирээрэй.

A stylized illustration in shades of brown and tan. The scene depicts a busy outdoor market or gathering. In the background, several large, white, tent-like structures are pitched. A large crowd of people, dressed in simple, traditional-looking clothing, is scattered across the open ground. Some individuals are carrying items, possibly goods or tools. In the foreground, two figures stand near a stone pillar. One figure is holding a long staff or pole, while the other has their arms raised in a gesture of greeting or announcement. The overall style is reminiscent of a woodcut or a graphic print.

Маргаашөдөр нь

Өөрсдийгөө ариун
болгон зарлаж тахилч болон
хүмүүсийг удирдах хүсэлтэй
хүмүүс ээ ойртоод зогс.

Бурхан өнөөдөр бид нартай
уулзаж Өөрөө сонгоно. Бид
Түүний алдар, сүр жавхланг
үзэх болно.



Өөрсдийгөө
энэ бузар хүмүүсээс
хол байлга. Эд нарыг би
хормын дараа устгах гэж
байна.



Тэдний
майхнуудаас холд.
Хэнийг нь ч өөрсдөдөө
бүү ойртуул тэгэхгүй
бол та нар
цуг үхнэ шүү.



Энэ бол сорилт. Хэрвээ энэ хүмүүс жам ёсоороо үхвэл та нар намайг хуурамч эшзүүлэгч бөгөөд Бурхан надаар дамжуулан ярьдаггүй гэж мэдээрэй.



Харин өнөөдөр та нар урьд хожид үзэж байгаагүй шинэ юм үзэж газар онгойн эдгээр хүмүүсийг эд зүйлийнх нь хамтаар тамын нүх уруу залгин одвол та нар эднийг Бурханы эсрэг, мөн намайг Түүний эшзүүлэгч гэдгийн эсрэг тэрслэн нүгэл үйлдснийг нь мэдэх болно.



Тас!!

хххххх!


Туслаарай

Иииийий

Ээээээ!




Тахилч болох гэсэн бүх хүн
Диавол ба түүний бузар элч нарт
зориулан бэлтгэгдсэн тамын гал
уруу амьдаараа унан залгигдав.



Тэд нарын
хүрэл бойпруудыг
цуглуулан авч,
тахилын ширээний
бүрээс хий.

Авдрын энэ хүрэл
бүрээсийг харах бүрдээ та нар,
хүмүүс Бурханы тушаалуудыг үл
ойшоон өөрсдийгөө тахилч нар
болгох гэсэн энэ өдрийг санаж
байх болно.


Тэр өдөр бол
Израилийн үр
удмынхны хэзээ ч
мартахааргүй өдөр
байлаа. Бурхан
Мосег эш үзүүлэгчээ
гэдгийг, мөн
зөвхөн Өөрийнх нь
томилсон хүмүүс л
тахилч нар болох
ёстой гэдгийг
маштодорхой
үзүүлжээ.




Бурханы
алдар бидний дээр
байж Тэр бидэнд
тэнгэрээс талх өгч
байна.

Бурханы алдар асрын дээгүүр байнга оршиж хүмүүс ч Мосег дуулгавартайяа даган дөчин жилийн туршцөлөөр хөндлөн гулдгүй явсан юм.

Бурхан тэнгэрээс талхаар бороо оруулж хаднаас ус гарган хангасаар л байлаа. Тэднийг шөнө нь галан баганаар хүрээлж өдөр нь үүлээр дагуулж байв. Тэд ч аянд дасан зохицож Бурханы тушаалуудыг дагаж сурсан юм.



Тахилч нар асарт орж өдөр
бүрийн тахилыг Мосегийн
тушаасан ёсоор өргөдөг байв.



Цөлд дөчин жил хэрэн тэнэсний эцэст хүмүүс бүгдээрээ амласан газар уруу орохоор зэхэж байхад нь Бурхан Мосег уул өөд дууджээ. Тэндээ Мосе Бурхантай сүүлчийн удаа яриад эцэст нь газар унан чимээгүйхэн өөд болжээ.



Удсан ч үгүй сүнс нь Бурханы
оршихуйд үтэр түргэн явж очив.
Тэрээр Бурханы Абрахамд
амласан газарт өөрийн хүмүүс
дээрээ эргэн ирэх эцсийн өдөр
хүртэл тэнд байх юм.


Иавэ Абрахамыг дуудаж эх нутаг элгэн саднаа орхиод өгөхөөр амлан буй газар уруу нь яв гэж хэлснээс хойшбараг 500 жил өнгөрчээ.



Хүү Исаакаас нь агуу үндэстэн бий болгоно хэмээн Абрахам, Сараид амласан Бурханы амлалт биелэгдэв. Хожим нэр нь Израиль болж өөрчлөгдсөн Иаковын арван хоёр хүү арван хоёр овог буюу олон түмэн хүн болж өсчээ.



Тэд боолчлогдож, цөлөөр
Мосетэй тэнэж, Бурханаас
хуулийг хүлээн авсны эцэст сая
л Амласан газарт орж ирлээ.
Цөлийн замд Мосегийн дэргэд
үргэлж даган харсаар явсан
залуу хөвгүүн Израилийн ард
түмнийг удирдахад суралцжээ.



Тэр хөвгүүн
өсөж томроод агуу
дайчин Иошуа болсон байна.

Мосег Бурхан дээр очсоны дараа
Абрахамд амласан газар уруу
хүмүүсийг дагуулан удирдахаар
Иошуа Бурханаар томилогджээ.



Дөрвөн зуун жил харийн нутагт харийнхан
болж сууна, харин үүний дараа өвөг дээдэст
нь амласан тэр нутагт эргэн ирнэ гэсэн
амлалтыг хүмүүс санаж байлаа. Бурхан
хэлсэн үгээ биелүүлсэн нь энэ билээ.

Иордан голыг гаталсан тэр өдөр тэнгэрээс манна орохоо зогсож уг нутгийн шинэхэн хүнсийг хүмүүс зооглох болов.

Нөхөр минь, Бурханы өгсөн энэ газар ёстой гайхамшигтай юм аа.


Тийм ээ. Энэ газар бол хүүхдүүдийг ариун, амар тайван амьдрахад сургаж, өсгөн хүмүүжүүлэхэд тохиромжтой сайхан газар байна.





Тавдугаар
бүлэг

ЭШ
ҮЗҮҮЛЭГЧИД




Баал эзэн
минь ээ, гэм зэмгүй
энэ хүүхдийг бид танд
өргөж байна. Хүүхдийн
цус таны уур хилэнг
зөөллөх болтугай.

Би амин
сүнснийхээ
нүглийн төлөөсөнд
нялх хүүхдээ өгч
байна.

Израильчуудын нүүдэллэн орж ирсэн
Палестин нутгийн оршин суугчид
үнэхээр бузар муухай хүмүүс байлаа. Тэд
израильчуудаас өөр хэлээр ярьдаг байсан
бөгөөд тэднийг канаанчууд гэдэг байв.
Канаанчууд амьд хүнээр тахил өргөж мод,
чулуу, алт, хүрэл, мөнгөөр хийсэн хиймэл
шүтээнүүдэд мөргөдөг байжээ.

Бурхан тэдэн уруу эш үзүүлэгчид, тахилч нарыг илгээж гэмшиж эргэ гэж хэлсэн боловч гэмшсэнгүй нүглээ үйлдсээр л байжээ. Бурхан Ноагийн үеийнхэн, Содом, Гоморра хотынхныг устгасан шигээ удахгүй канаанчуудыг устгах болно.




Нэг л өдөр бид нар ч ахлах тахилч болж өргөл, тахил өргөдөг болно доо.

Харахад аймшигтай ч ингэх ёстойгоос хойш яах вэ дээ. Сайныг хийвэл сайнаа хүлээн авч, мууг хийвэл муугаа хүлээн авах юм даа.



Амлагдсан газар амьдарч байсан хуурамч шүтлэгтнүүд Израилийн үр удмыг газар нутагтаа оруулахгүйн тулд эсэргүүцэн тулалдаж байсан боловч Бурхан израильчуудад тэднийг ялан дийлэх хүч чадал өгч байсан юм.



Чи яаж энэ
ариун дуганд орж
ирж зүрхлэв!

Чи сая хамгийн
сүүлчийнхээ
хүүхдийг аллаа.

Цуст тулаан дуусч еврейчүүд
дайснаа даран, өмнөө байгаа
газар нутгийг эзэмших боллоо.
Иошуа ард түмэнд хандан ярив.

Бидний дээд
өвөг Абрахам шүтээн
шүтэгч хүмүүсийг
ардаа орхин гарч
ирсэн юм. Бурхан
түүнтэй ярьж, түүнийг
агуу үндэстэн
болгохоо амласан
билээ.





Бурхан бас

Өөрийнх нь ард түмэн Египет нутагт очиж, тэндээ дөрвөн зуун жил болоод, Өөрөө тэднийг тэндээс гарган авч, та нарын одоо зогсож байгаа яг энэ газар авчирна гэж хэлсэн. Одоо харин бид нар 500 гаруй жилийн дараа энэ газар байж байна. Ингэж Бурхан Абрахамд амласнаа биелүүлсэн юм. Одоо явж үлдсэн газар нутгийг эзэгнэн суурьш. Та нараас өмнө амьдарч байсан нүгэлтнүүдийн жишээг бүү дагагтун. Эс бөгөөс Бурхан тэднийг үл өршөөсөн шигээ та нарыг ч өршөөхгүй шүү.

Шинэ нутагтаа тэд амар тайван амьдарч байлаа. Хүн болгон өөрийн гэсэн газартай болж идэх уух юмаар элбэг хангалуун байсан юм. Бурхан тэднийг бусад бүх ард түмнээс дээгүүрт тавин ерөөжээ.



Хоол чинь болчихлоо.

За энэ чулууг зайлуулчхаад л очлоо.

Бурханы амласны дагуу еврейчүүд өсөж үржин газар нутгийг дүүргэжээ. Хот суурингууд нь шударга зөв явдлаар дүүрэн байлаа.



Дүү минь чамд амар амгалан орштугай. Өнөөдөр загас ямар байна даа?


Байдгаараа л, далайгаас дөнгөж авчирсан шинээрээ байгаа шүү.



Иавэ дайснуудыг
чинь дарсан боловч
энэ газар хиймэл шүтээн
шүтэх явдал байсаар л байна.
Өнөөдөр та нар хэнд үйлчлэхээ
сонго. Газар нутагт нь байгаа
энэ хүмүүсийн хуурамч
шүтээнүүдийг үү, аль эсвэл
Абрахамын Бурханыг уу? Би
болон манай гэрийнхэн
бүгдээрээ ЭЗЭНд
үйлчилнэ.


Бид ЭЗЭНийг
орхин өөр бурхдад
үйлчлэх явдал биднээс
хол байг Агуу их хүч
чадлаараа Иавэ биднийг
Египетийн боолчлолоос
чөлөөлж цөлөөр дагуулан
хамгаалсаар ирсэн
билээ.

Бид ЭЗЭНд
үйлчлэхээ
амлаж байна.



ЭЗЭН бас бидний
өмнөөс энэ газар байсан бүх
хүмүүсийг, бүр аморичуудыг
хүртэл хөөн зайлуулсан билээ.
Тийм учраас ЭЗЭН бол бидний
Бурхан учраас бид бас
Түүнд үйлчилнэ.

Бурхан бол
ариун бөгөөд хардаж
харамладаг Бурхан шүү.
Хэрэв та нар Түүнийг орхиж,
хуурамч шүтээнүүдийг дагавал
Тэр бас та нараас нүүр буруулж
зовлон зүдгүүр авчран,
устган сөнөөнө.




Та нар ЭЗЭНийг сонгосон
учраас өөрсдөө өөрсдийнхөө гэрч
нар боллоо шүү.

Тийм ээ,
бид гэрч нар.

Өнөөдөр та нар
Бурхантай гэрээ
байгуулсныг
би номд бичнэ.


Бид Мосег бүх зүйл
дээр дагаж байсан шигээ чамайг бас
дагах болно. Мосетэй байсан шигээ ЭЗЭН Бурхан
чамтай хамт байх болтугай. Бурханы тушаалуудыг
дагахаас эсэргүүцсэн хүн болгон үхэх болно.

Шүүгчид ард түмнийг удирдаж, тэд Бурхантай харилцан, Мосегийн бичсэн үгсийг уншиж таниулдаг байлаа. Тэдгээр шүүгчид ард түмэнд Бурханы хуулиудыг тайлбарлаж Бурханыг дагаж амьдрахад дагуулан сургадаг байв.



Хүн мөргөсөн
бухын талаар
Бурханы хуулинд юу
гэж бичсэн байна?

Бухын эзэн
учруулсан хохирлыг
төлөх ёстой гэж Мосе
хэлсэн байна. Бас бухыг
алах ёстой юм байна.



Хэсэг хугацаанд хүмүүс
Моше, Иошуа нараар
дамжуулан хийсэн
Бурханы гайхамшгуудыг
санаж байлаа. Израильчууд
Египетийн боолчлолоос
чөлөөлөгдсөндөө баярлан
талархаж байсан юм. Тэд
Иавэ Бурханд үйлчлэн
заавар тушаалынх нь
дагуу өргөл, тахилуудыг
өргөдөг байв.

Аав аа, тахилч
нар яагаад манай
хургыг алах гэж байгаа
юм бэ? Өвөг дээдсийг
маань Египетэд байхад
болсон шиг устгагч
дээгүүр өнгөрөх гэж
байгаа юм уу?

Үгүй ээ хүү минь
устгагч ирэхгүй. Харин энэ
хурганы цус гэм нүглийг
маань далдалж Бурханы
нүдэнд биднийг хүлээн
зөвшөөрүүлэх юм.

Бурханд мөргөж
хүндэтгэн,
тушаалуудыг нь
дагахаа Иошуд
амласан боловч
бүх хүн бүгдээрээ
Иавэг хүндлэн
дээдэлсэнгүй.




Гайхамшгууд үйлдэгдэхээ болиход
хүмүүсийн дараагийн үе удам амьд
Бурханыг мартан, амьгүй дүрснүүдийн
өмнө сөгдөн мөргөдөг болжээ. Тэд бас
өөрсдийнхөө өвөг дээдсийг шүтэх болов.

Иошуагийн сануулсан ёсоор
Бурхан израильчуудыг
устгуулахаар харийн
дайснуудыг явуулав.

Болиоч
ээ! Баал минь
авраарай!

Яааа!






Бурханы шүүлт ард түмний дээр
буухад тэд Бурханы тушаалуудыг
санаж гэм нүглээ гэмшин улайв.

Иавэ Эзэн минь,
бидний нүглийг
уучилж амар
тайвныг тогтоогооч.

Хүмүүс гэм нүглээ хүлээн
зөвшөөрөхөд Бурхан тэднийг уучлан
газар нутгийг нь сэргээж өгөв.

Ард түмэн Бурханыг
эрэн хайдаг, Түүний
номоор хүмүүсийг
удирдан дагуулах
шүүгчдийг даган
явахаас залхаж,
өөрсдийгөө захирах
хаантай болохоор
шийджээ.



Газар чинь хаант
улсын ашиг тусын төлөө
хураагдлаа Охиноо энд
орхиод яв. Бид харж
хандана.

Хаантай болох нь
Бурханыг өөрсдийнхөө
удирдагч байхыг голж
байгаа хэрэг хэмээн
шүүгч, эш үзүүлэгч
Самуел ард түмэнд
болгоомжлуулсан
боловч тэд итгэлээр
алхахыг хүссэнгүй.

Саул хаан тэднийг
дарлан мөнгө хөрөнгийг
нь хураан авч,
хөвгүүдийг нь зарцалж
охидыг ашиглав.





Саул хаан хөгшрөхөд муу сүнс ирж зовоон тавгуйтүүлдэг байжээ.

Нэг өдөр тэрээр өөрт нь ятга тоглож өгч байсан Давид хэмээх залуу хөвгүүнийг жадлахаар завджээ.

Саул улам ихээр гэм нүгэл үйлдэх болов. Бүх хүмүүст атаархаж, бас айдаст автах болов. Муу сүнснүүд түүнд хүч чадал, мөнгө хөрөнгө өгнө хэмээн амлах боловч зөвхөн сэтгэл сүнсийг нь зовоон шаналгах зүйлүүдийг л авчирдаг байлаа.

Саул амьд
Бурханыг
огоорон
мартаж
мэргэч
төлөгчид
итгэх болов.

Надад
харанхуй
харагдаж байна. Сайн
юм болохгүй нь ээ. Та
тулаанд үрэгдэж өөр
хүн суудлыг тань авах
юм байна.

Саул дайнд алагдаж,
сүнс нь тамд хаягджээ.



Бурхан Саулын оронд нэгэн залууг хаан болгожээ. Тэр бол Бурханд хайртай, тушаалуудыг нь даган биелүүлдэг, мөн урьд Саулын алахаар завдсан тэр хоньчин хөвгүүн байсан юм.

Эзэн бол миний хоньчин, надад дутах зүйл нэг ч үгүй. Тэр намайг ногоон бэлчээрт хэвтүүлж, дөлгөөн усны дэргэдүүр хөтөлдөг. Тэр миний сэтгэлийг сэргээдэг.

Давид бол Бурханаар хайрлагдсан шударга зөв хүн байлаа. Тэгвэл Давид хүн төрөлхтнийг нүгэл ба үхлээс нь чөлөөлөх нэгэн юм болов уу? Давид амлагдсан нэгэн болж чадах уу?

Давид ийнхүү бичжээ.

Хорон муу хүний
зөвлөгөөг дагадаггүй
Нүгэлтнүүдийн зам дээр ч
зогсдоггүй Басамжлагчдын
суудалд ч суудаггүй хүн
ерөөлтэй еэ! Харин тэрээр
ЭЗЭНий хуульд баярлаж. . .



...Түүний хуулийг
өдөр шөнөгүй тунгаан
бясалгадаг Тэрээр урсгал
усны дэргэд тарьсан
мод адил билээ Тэр
мод цагтаа үр жимсээ
ургуулдаг бөгөөд
Навчис нь ч хатдаггүй
Тэр хүний үйлс бүхэн нь
өлзийтэй. . .



...Хорон муу хүмүүс
бол тийм биш
Харин тэд салхинд
хийсдэг тарианы хальс
мэт Тийм учраас хорон
муу хүн шийтгэлд
Нүгэлтнүүд ч зөв
шударга хүний
цуглаанд зогсож
чадахгүй Зөв шударга
хүний замыг ЭЗЭН
мэддэг Харин хорон
муу хүний зам сөнөх
болно.

Саулыг алагдсаны дараа Давид хаан болж, Израилийг Бурханыг хүндлэн дээдэлдэг, үг тушаалыг нь сахин биелүүлдэг болгон удирджээ.

Энэ эмэгтэйн газрыг буцаан өг. Цаашид энэ эмэгтэй татвар төлөхгүй гэдгийг мэдэж ав.

Давидын удирдлага дор Израиль үндэстэн хөгжин дэвжиж, зөв шударгаар аж төрөх болжээ.



Бурхан Давидтай ярин ирээдүйд
болох олон зүйлийг хэлж өгчээ.
Давид тэдгээр зөгнөлүүдийг Дуулал
номд бичсэн юм. Тэдгээрийн олонх
нь хэдийнэ биелэгджээ.




Тэр таны хүмүүсийг шударга
зөвөөр Таны үгээгүйчүүдийг
шударга ёсоор шүүх
болтугай Тэрээр ард
түмний зүдрэгсдийг зөвтгөн
Гачигдагсдын хүүхдүүдийг
аварч дарлагчийг сөнөөх
болтугай Түүний өдрүүдэд
зөв шударга хүн цэцэглэг
Сарыг үгүй болтол амар
тайван ч арвин ихээр байг
Тэрээр далайгаас далай
хүртэл, Мөрнөөс газрын
хязгаар хүртэл захирах
болтугай Бүх хаад түүний
өмнө сөгдөж. . .



Давид шударга зөв хүн байсан ч нүгэл үйлдсэн учраас амлагдсан Аврагч биш ажээ. Харин тэрээр ирэх Аврагчийн тухай ийнхүү бичжээ.

... Бүх үндэстнүүд түүний өмнө зарагдах болтугай. Тэр тэдний амийг дарамт ба хүчирхийллээс аварч тэр амьдрах болно. Тэд түүний төлөө үргэлж залбирах болтугай Тэд түүнийг өдөржин ерөөх болтугай Түүний нэр мөнхөд байх болтугай Түүний нэр нар гэрэлтэх мэт байх болтугай Хүмүүс түүгээр ерөөгдөж Бүх үндэстэн түүнийг ерөөгдсөн гэж дуудагтун (Дуулал 72)

Бурхан Давидад ингэж хэлэв. Чамайг нас барсны дараа би чиний хаанчлалыг хүүд чинь өгнө. Тэр Намайг хүндлэн дээдлэх өргөөг барих бөгөөд Би түүний хаанчлалыг мөнхөд байлгана гэжээ.




Давидыг таалал төгссөний дараа түүний хүү Соломон хаан болжээ (МЭӨ 971). Цөлд хэрэглэж байсан хуучин асрын оронд Бурханаас Давидад өгсөн зааврын дагуу Соломон өргөөг барив (МЭӨ 966).

Энэ үед
Израилийн
ард түмэн урьд
өмнө хэзээ ч
байгаагүйгээрээ
хөгжин дэвжжээ.
Бурхан тэднийг
энэ газарт авчран
ерөөнө гэсэн
амлалтаа үнэхээр
биелүүлсэн юм.



Харин Бурханы
амласан ганц л амлалт
биелэгдээгүй байгаа нь
Диаволын ажлыг устгах
Аврагчийн тухай амлалт
байлаа. Хүмүүс гэм нүглээ
үйлдсээр, малын цус
тэдний нүглийг цайруулан
өргөгдсөөр л байлаа.
Гэсэн ч хүмүүс аврагч ирэн
тэдний гэм нүглийг үүрд
арилгах өдрийг хүртэл
Бурхан гэм нүглийг нь
цагаатгах арга зааж өгсөнд
талархаж байсан юм.

Хүмүүс Ариун бичээсийг сонсохоор
өргөөнд ирдэг байлаа. Ялангуяа
тэд ирэх Аврагчийн тухай эш
үзүүллэгийг баярлан сонсдог байв.



ЭЗЭН Давидад Өөрийн эргэн
буцахгүй үнэнийг тангараглахдаа
"Чиний биеийн үр жимснээс Би
чиний сэнтийнд зална."
(Дуулал 132:11)

Давид ирэх аврагчийн талаар
олон зүйлийг бичжээ.

ЭЗЭН миний Эзэнд
Би чиний дайснуудыг хөлийн
чинь гишгүүр болгох хүртэл
Миний баруун гар талд суу"
гэдэг. (Дуулал 110:1)

Бурхан, Таны сэнтий мөнхийн
мөнхөд болой. Шударга
ёсны очирт таяг бол Таны
хаанчлалынх юм
Та зөв шударгыг хайрлаж
хорон мууг үзэн ядсан.
Тиймээс Бурхан, Таны Бурхан
Таныг Баяр баяслын тосоор
анд нөхдийн чинь дээр залж
тосолсон.
(Дуулал 45:6-7)

Ирэх Аврагчийн талаарх
өөр эш үзүүллэгүүд

Би мөн түүнийг ууган хүү Газар дэлхийн
хаадаас хамгийн дээд хаан болгоно.

(Дуулал 89:26-27)

Бурхан минь ээ, би Таны Хүслийг
гүйцэлдүүлэхдээ баярладаг юм Таны
Хууль миний зүрхэнд бий.

(Дуулал 40:8)

Би сургаалт зүйрлэл ярин амаа
нээнэ Би эртний нууц үгсийг дуулна.

(Дуулал 78:2)

Давид ирэх Мессиагийн талаар
маш сонин зүйл бичжээ:

Намайг ус шиг асгасан бөгөөд
Миний бүх яс мултарсан. Миний
зүрх лааны тос адил юм. Тэр нь
миний дотор хайлсан. Миний
хүч шаазангийн хэлтэрхий шиг
хатаж, Миний хэл түүшиндээ
наалдсан. Та намайг үхлийн
шороонд тавьдаг. Учир нь намайг
ноход хүрээлжээ. Бүлэг хорон
санаатнууд намайг бүсэлжээ. Тэд
миний гар, хөлийг нэвт хатгасан.

Би бүх ясаа тоолж чадна. Тэд
харж, над уруу гөлрөн ширтдэг.

Тэд миний гадуур хувцсыг
хоорондоо хувааж, Миний дотуур
хувцасны төлөө шоддог. (Дуулал
22:14-18)

Соломоны хаанчлал урт удаан элбэг баян байсан боловч таалал төгссөнийх нь дараа хаанчлалын хойд хэсэг тасран хуваагдаж Иеробоам нэртэй муу хүнийг хаана болгожээ (МЭӨ 975).

Энэ бол та нарыг Египетээс гаргаж авсан Бурхан байна. Харин эд нар бол түүний тахилч нар юм.

Тэгвэл Мосегийн өгсөн хуулиуд Иерусалемд барьсан Бурханы өргөөг яах вэ?




Хойд хаанчлал Иерусалем дахь Эзэний өргөөнөөс алс хол байсан тул өөрсдөө алтан тугалын дүрстэй шүтээнээр дүүрсэн мөргөлийн газар барьжээ.

Бурханд хүрэх олон арга байдаг юм. Зарим нь түүнийг Иавэ, зарим нь Аллах, зарим нь Хемош харин бид Түүнийг Баал гэж дууддаг юм.

Бурханаас эш үзүүлэгч нартаа өгсөн Ариун Бичээсийг яах болж байна вэ? Бичээст бид нарыг өөр ямар ч бурхадтай байж болохгүй гэж тушаасан биз дээ? Тэнд бас зөвхөн ганцхан л Бурхан байдаг бөгөөд Түүнд хүрэх ганц л зам бий гэдэг шүү дээ.





Бурханыг
чи тийм ахархан
бодолтой гэж
бодоо юу?

Би дахиж иймэрхүү
юм сонсмооргүй байна шүү.
Баалын шүтлэг бол
энэ нутгийн албан ёсны
шашин. Түүнийг шүтээгүй
хүн үхэх болно шүү.



Баал эзэн
минь ээ! Бидний
өчүүхэн гараас
энэхүү өргөлийг
хүлээн авна уу.

Тахилч нар бухын дүрсийг хуурамч шүтээнийхээ хэлбэр болгон сонгохдоо нүгэлт херуб Люциферын дүрсийг сонгосноо мэдэхгүй байлаа. Тиймд хүмүүс бузар нэгнийг тахин шүтэж байсан бөгөөд Бурханы явуулахаар төлөвлөж байгаа аврагчийн амлалтаас хүмүүсийг холдуулж байгаадаа Дявол баярлаж байлаа.




Тэнгэрийн Хатан
хаан, Бурханы Эх та магтагдах
болтугай. Бидний залбирлыг
сонсож бидний нүглийг уучлаач.



Чи
энэ ариун газар юу
хийж яваа юм бэ?

Та нарын салан холдсон Иавэ
Бурханы нэр дээр ярьж байна. Эзэний
үгийг сонсогтун. Давидын гэрээс хүү
төрнө. Түүний удмаас чөлөөлөгч ирнэ.
Түүний нэрийг Иосиа гэж нэрлэх бөгөөд
тэр энэ ширээн дээр Баалын тахилч
нарыг шатаах болно.



Чи яаж ингэж ярьж
зүрхлэв? Бурхдаас өөр
хэн ч ирээдүйг хэлж
чаддаггүй юм.

Эзэний үгээр
би ярьж байна. Яг энэ
тахилч нарын ясыг Иосиа
энэ ширээн дээр тавин
шатаах болно.



Бурханы нэрээр ярьж байгааг
минь мэдүүлж Эзэн чамд тэмдэг
өгөх болно. Чухамхүү энэ өдөр
энэ тэнэг шүтээнүүдийг тавьсан
тэр ширээ голоороо хуваагдаж, дээр
нь байгаа үнс асгарна.

Ха, ха, ха! Энэ муу шүтлэгтэй
илжигний орилохыг дуулав уу?
Өөрөө л зөв, бусад хүмүүс буруу
юм гэнэ ээ!




Бариад ав!
Ал наадхыгаа. Бусдын
шүтлэг бишрэлийн
талаар энэ муу яаж
ингэж чалчиж чадна
вэ?

Миний гар
хатчихлаа! Иавэ
намайг шийтгэчихлээ.
Намайг эдгээгээч гэж
залбираач.





Бурхан Эзэн минь
өнөөдөр Өөрийгөө
таниулаач. Хааны
гарыг эдгээж өгөөч.



Энэ чинь
ёстой гайхамшиг
байна! Бурхан
миний гарыг
эдгээчихлээ!




ТАС!

ИЙЙЙ!

ТАР НЯР!


Юу гээч
энэ вэ!

Иавэ, ийм
хурдан уу?



Чи үнэхээр Бурханы
хүн юм аа! Баалын нэг ч эш үзүүлэгч ийм юм хийж
байгаагүй билээ. Надтай хамт яв. Хоёулаа юм идэж
ууж тэнхээ оръё. Тэгээд өнөөдөр чамайг Бурханд
гайхамшигтайгаар үйлчилсний чинь төлөө шагнаж
хүндэлье.

Гэхдээ чи тахилч нарын
яс ширээн дээр шатна гэсэн биз дээ.
Гэтэл хэнийг ч үхээгүй байхад тахилын
ширээгүй болчихлоо шүү дээ.




Тэр манай шашныг
үгүй хийчихлээ. Юу ч
үлдсэнгүй ээ.

Үгүй ээ, би цуг явж
чадахгүй. Бурхан намайг
Израильд байхдаа юу ч идэж ууж
болохгүй ирсэн замаараа ч буцаж
болохгүй гэсэн юм.

Тэр чинь
миний үг биш
Бурханы үг
байсан.

Бурханы тушаасан ёсоор эш үзүүлэгч өөр замаар буцан явжээ. Юу ч идэж уулгүй хоёр хоносон болохоор ихэд өлсөж цангасан байлаа. Тэр өдөр алтан тугалд мөргөхөөр ирсэн хоёр залуу хөвгүүн эш үзүүлэгчийг хаашаа ямар замаар явахыг нь даган харж байв.






Аав аа,
ба өөрөө хараагүй бол ер
итгэхгүй байх байлаа. Яг л
Израилийн эртний эш үзүүлэгч
нар шиг байсан шүү!

Хурдал! Илжиг
эмээллээдэх! Би
тэрнийг олж уулзах
хэрэгтэй байна!

Аав аа, тэр
хүний хэлсэн
нь үнэн юм болов
уу? Иавэ л цорын ганц
амьд Бурхан юм уу?
Бид нарын шүтээнүүд
зүгээр л нэг мод
чулуунууд юм уу?



Иавэгийн эш үзүүлэгчийг модны дор сууж байхад нь мөнөөх хүн олж очжээ. Тэр хүн, хүч чадал бүхий энэ эш үзүүлэгчтэй уулзахыг хүссэн ажээ. Нэгэн цагт энэ хүн Бурханы эш үзүүлэгч байсан бөгөөд хаанчлал хуваагдахад нутгийнхаа хуурамч шүтээн шүтэгчдийг даган явжээ. "Бүх л шашин адилхан байлгүй дээ" гэж тэр өөрийгөө зөвтгөсөн байж.




Чи нөгөөх Иудагаас ирсэн Бурханы хүн мөн биз дээ? Чи их ядарсан харагдаж байна шүү. Надтай хамт манайд оч. Би чамд хоол унд хийж өгье.

Би чадахгүй ээ. Бурхан намайг энэ нутагт идэж ууж болохгүй гэсэн.

Бурхандаа талархъя, би бүр аягүй цангаж байлаа шүү.

Би яг чам шиг эш үзүүлэгч байгааг харахгүй байна уу? Өнөө өглөө Иавэгийн тэнгэр элч надад чамайг өнөөдөр гэртээ авчраад хоол унд өг гэсэн юм аа.



За сайхан
хоол байлаа.
Харин одоо
би Иуда уруу
явахгүй бол
болохгүй.

Иавэ ингэж хэллээ: "Чи Иавэ Бурханы тушаалыг дагалгүй энэ газар идэж уусан учраас яс чинь Иуда нутагтаа гэрийнхнийхээ булшинд тавигдахгүй".

Аав аа та чинь эш
үзүүлээд байна шүү дээ.
Бурхан бас таньтай ярьсан
юм уу?

Тэглээ
хүү минь. Олон
жилийн дараа
анх удаагаа
ингэлээ.




Харин тийм
ээ, надаас л
боллоо.

Та тэгээд
энэ хүнийг үхнэ
гэж байгаа юм
үү?

Бурхан хэлсэн үгэндээ заавал хүрдэг гэдгийг мэдэж байсан учраас эш үзүүлэгч тэдний гэрээс сэтгэл нь маш их шаналан гарч явлаа. Үхнэ гэдгээ мэдэж байсан ч харин ийм хурдан, бас ийм байдлаар болно гэж бодоогүй ажээ.





Энэ чинь нөгөө
Иудагаас ирсэн
эш үзүүлэгч
байна!

Бүр
хачирхалтай нь
арслан, илжиг хоёр
биеийг нь хамгаалж
байна уу гэлтэй
хамтдаа байж
байдаг.

Би ийм юм
ер үзээгүй юм
байна. Арслан
тэрнийг алчихаад
идэхгүй сууж
байх юм.

Мөнөөх хуурамч эш үзүүлэгч Бурханы хүний биеийг авч яван Баалын эш үзүүлэгчдийн дунд байдаг өөрийнхөө булшинд оршуулжээ. Уг газар нь устгагдсан тахилын ширээний ойролцоо байлаа.

Бурхан түүнийг дуулгаваргүйгээс нь болж хороожээ. Гэвч түүний эш үзүүлэгчүүд бүгд биелэгдэх нь дамжиггүй.

Бурханы хүн оршуулагдаж бүгдэд мартагдсан хэдий ч цөөхөн хүн санаж байлаа. Тахилын ширээг буцааж барьсан бөгөөд бараг гурван зуун жилийн дараа ч Баалыг шүтэгчид ашигласаар л байв. Гэсэн хэдий ч Бурханы хүний хэлснээр тэдний ясыг тахилын ширээн дээр тавьж шатаагаагүй л байлаа.



Гурван зуун жилийн дараа Иосиа гэдэг нэртэй хаан Иудагийн хаан ширээнд заларчээ (МЭӨ 640 он). Хаан Бурханы өргөөнөөс Библийн нэг хуулбарыг олов. Улс үндэстнээрээ амьд Бурханыг мартан, хуурамч шүтээнүүдийн хойноос даган явсныг мэдээд Иосиа маш тавгүйрхэж бүх ахлагчид, эш үзүүлэгчид, тахилчид мөн Иерусалемын бүх оршин суугчдыг хуран цугларч Эзэний үгийг уншихыг сонс хэмээн тушаажээ.



Хүмүүс гэм нүглээсээ ичиж номын үгийг дагахаа хүлээн зөвшөөрөв.



Ариун
Эх минь биднийгээ
авраач!

Хүмүүс Бурханы
хуулиудыг дагаж нутагтаа
байгаа бүх шүтээнийг
устгажээ. Тэд нар сар од
гариг, тэнгэрийн Хатанд
утлага уугиулж байсан
бүх тахилчийг алж устгав.

Мосегөөр дамжуулан өгсөн
Бурханы хууль ижил хүйстэнтэйгээ
явалдагсдын үйл ажиллагааг
хориглосон байсан тул бүх тийм
хүн газар нутгаас зайлуулагдав.


Тэвчээргүй муу
тэнэгүүд.



Тэд бас нутаг орноосоо бүх
төрлийн сүнс дуудагч, мэргэ
төлөгчийг хөөн зайлуулжээ.



Наадхынхаа
болор бөмбөгийг
хагалаад гэрийг
шатаа.



Тэд тахилын бүх ширээ, бүх хуурамч шүтээнийг хэмхэлж моднуудыг тайрч бүгдийг нь үртэс болтол нь нунтаглав.

Гурван зуун жилийн өмнө мөнөөх эш үзүүлэгч Хойд хаанчлалын анхны хаан Иеробоамтай уулзаж байсан мөргөлийн тэр өндөрлөг дээр Иосиа очив.

Цорын ганц Бурхан байдаг бөгөөд Түүнийг ямар ч хэлбэр дүрсээр дамжуулан шүтдэггүй юм. Эдгээр хуурамч тахилчид хүмүүсийг Иавэ Бурханаас холдуулсан байна.



Чи үхэх
ёстой.

Тахилын ширээ дахин
нэг удаа хуваагдан
унаж үнс нь цацагдав.

Бүх хуурамч тахилч
алагдаж бүгдийг нь нурсан
тахилын ширээний үнсэн
дээр шатаажээ.



Уг газрын ойролцоо хуурамч
тахилчдын булш байдаг байв.
Хүмүүсийг тэдний булшинд
мөргүүлэхээс сэргийлж
Иосиа тэднийг ухаан гаргуулж
тахилын ширээн дээр шатаав.



Бүх
ясыг
шатаа.

Бурханы хүний хэлсний дагуу 300 жилийн настай эш үзүүлэгч ийнхүү биелжээ.


Тэгвэл түүний яснуудыг тусад нь орхи. Бусдыг нь шатаа. Бурханаас бид ерөөл авъя гэвэл шүтээн шүтэх энэ явдал төгсгөл болох ёстой

Та болгооно уу, харин энэ бол гурван зуу орчим жилийн өмнө Иудагаас ирж яг өнөөдрийн энэ өдрийг зөгнөн хэлсэн Бурханы хүний булш байгаа юм аа. Энэ эш үзүүлэгч нь Иосиа хэмээх нэртэй хүн буюу таныг ирж, яг өнөөдрийн таны хийснийг хийнэ гэж зөгнөсөн юм.

Хөрс шорооноос
талх тариа ургуулагч,
ертөнцийн их хаан, Бурхан
Эзэн минь ээ, Та ерөөгдөх
болтугай!

Ингэж шүтээн шүтсэн завхрал
арилж Иосиа хааны зарлигаар
Египетийн газар нутгаас
өвөг дээдсийг нь гаргаж энэ
газрыг өгсөн Иавэ Эзэнийг
дурсан бүх хүмүүс Дээгүүр
өнгөрөх баярыг тэмдэглэжээ.





Аав аа, энэ
өдөр бусад өдрөөс
юугаараа ялгаатай
юм бэ?

Тэгээд эцэг нь хүүхдүүддээ хэрхэн Бурхан израильчуудыг Египетийн боолчлолоос чөлөөлж Хууль ба Асрыг өгсөн эртний түүхийг ярьж өгчээ. Бас тэдэнд хаалганы тотгон дээрх цус, устгагч тэнгэр элчээс Израилийн ууган хөвгүүдийг аварсан түүхийг ч ярьж өгөв. Энэ бол урьд хожид болж байгаагүй хамгийн гайхалтай Дээгүүр өнгөрөх баяр байсан юм.



Зургадугаар
бүлэг


ЕЛИА



Израилийн хойд хаанчлалын сэнтийд нэгэн нүгэлт хүн гарч ирсэн нь хаан Ахаб байсан юм (МЭӨ 918 он). Ахаб Самари нутагт Зидоны ойролцоо амьдарч байлаа. Тэрээр Баалын тахилч нарын нэгнийх нь охин Иезебелтэй гэрлэжээ.



Иезебел шашин шүтлэгээрээ нэрд гарсан нэгэн байв. Иезебел Израилийн Бурханыг үл тоомсорлож, газар нутагт Баалыг тахин шүтэхийг шаардаж байлаа.



Иавэгийн бүх эш
үзүүлэгчдийг олж
устга. Баал манай
бурхан болно.

Хаанд Обадиа нэртэй
Иавэг хүндлэн мөргөдөг
нэгэн зарц байв.

Бурханы
эш үзүүлэгчдийг олж,
тэдэнд заавал сануулах
хэрэгтэй.

Обадиа зуун эш үзүүлэгчийг агуйд
нуугаад, хоол унд зөөж өгдөг байв.





Елиа гэдэг
Бурханы нэгэн эш
үзүүлэгч л харин
нуугдаж үлдэхийг
хүсээгүй юм.



Хаан Ахаб аа, та өвөг дээдсийнхээ Бурханыг умартаж эхнэр Иезебелээ даган бузар мууг үйлдэж байгаа тул "Намайг дахин тушаахаас нааш Израильд бороо орохгүй, шүүдэр ч буухгүй" гэж Иавэ хэллээ.


Ха, Ха! За за чи тэгэхээр өөрийгөө эш үзүүлэгч гэж байгаа юм биз дээ? Тэгвэл надад мянган эш үзүүлэгч байдаг юм даа. Тэдний хэн нь ч ган гачгийн талаар юм яриагүй шүү. Сүүлийн хэдэн жил хангалттай бороо орсон. Чи муу зальхай шүтлэгтэн одоо замаас зайл.

Ган болж өлсгөлөн улам ширүүсэхэд хүмүүс өлсөж, харангадаж эхлэв. Хуурамч эш үзүүлэгчид Баал уруу орилон хашхиравч Баал юу ч хариулж чадахгүй байлаа. Цаашдаа дусал бороо, дусал сүүдэр ч үгүйгээр ган гачиг үргэлжилжээ. Бурхан Елиаг нэгэн бэлэвсэн эмэгтэйн гэр уруу явуулж өөрийг нь гэртээ байлган ган дуустал хооллож, ундал гэж хэл гэжээ.



Чи
надад ус
өгч, идэх
жаахан талх
авчирж
өгөөч.

Танд үнэнээ хэлэхэд одоо надад хоёр жижигхэн талх хийх л гурил үлдсэн. Би түүгээрээ өөртөө болон хүүхдээ талх барьж идчихээд хэвтээд үхье дээ гэж бодож байлаа. Найдвар ч тасарлаа. Бурхан биднийг нүглээс маань болоод шийтгэж байна.




Бүү ай. Бурхан
чамайг харж
хандана аа.

Чи яриад байсан талхаа
бариад эхлээд надад авчирж өг.
Дараа нь л чи хүүтэйгээ идэж болно.
Израилийн Бурхан Иавэ ингэж хэллээ.
"Израильд Бурхан бороо оруултал
гурилтай хул аяга, тостой сав
чинь хоосрохгүй".

Үнэхээр үнэн
байна. Хул аяганд
маань гурил, саванд
маань тос үлдсэн
байна шүү!






Бүгдийг
нь дуустал гаргаж
чадахгүй юм байна!
Тасрахгүй гоожоод
л байна.


Энэ бол
ёстой гайхамшиг!
Бурхан үнэхээр
сайн юм аа.

Дараагийн хоёр жил нь тэр
гурав ганц хул аяга гурилаар
хооллосоор л байлаа.

Нэгэн өдөр Елиа мөнөөх
эмэгтэйн гэр дэх өрөөндөө
иртэл хүү нь үхсэн байхыг үзэв.



Хүү маань
халуурч байгаад
өнгөрчихлөө!



Би таныг яаж гомдоосон юм бэ? Бурхан хүүг минь хороох шалтгаан болсон нүглүүдийг минь та сануулан тоочихоор ирээ юү?


Израильд
Бурхан байгаа
хэвээрээ шүү.

Иавэ Эзэн минь ээ,
энэ хүүгийн сүнсийг
биенд нь буцаан
оруулаач.





Бурхан Елиагийн
залбирлыг сонсоод,
хүүгийн сүнсийг амьгүй
болсон биенд нь буцаан
оруулжээ.




Абрахам, Исаак,
Иаковын Бурхан
Эзэн минь ээ, Тандаа
баярлалаа. Та
л ганцаараа Бурхан.

Би Израильд
Бурхан байгаа
гэж хэлсэн
биз дээ.

Миний хүү!

Өлсгөлөн гурван жил үргэлжилжээ.
Хүмүүс өлсөж харангадаж байсан ч
хуурамч бурхан Баалд мөргөсөөр л байв.




Баал яагаад
биднийг сонсож
бороо оруулахгүй
байна аа.

Баал чих
муутай бурхан юм
байлгүй дээ. Чихгүй л
юм шиг байна даа.

Иезебел, Ахав нар өлсгөлөн болсонд
Елиаг буруутгаж байв. Тэд Елиаг
бариулахаар цэргүүдийг улс даяараа тэр
ч бүү хэл зэргэлдээх улс орнуудаар ч
явуулжээ. Тэд түүнийг тааралдсан газраа
шууд ал гэж тушааж байв.



Елиаг нааш нь
гаргаад ир Та нар
түүнийг нууж
байгаа бол цуг
алагдана шүү.



Ахаб аа чи
намайг хайгаад
байна уу?

Чи Израилийг
өлсгөлөнгөөр
зовоогоод байгаа
хүн мөн үү?

Чи өөрөө л хуурамч
шүтээнүүдээрээ
Израилийг зовоож байгаа
хүн дээ. Тэгвэл Иавэ, Баал
хоёрын дунд нэг тэмцээн
зарлачихъя л даа. 850 эш
үзүүлэгчээ аваад Кармел
уулан дээр хүрээд ир.

Юу гэнэ ээ. Тэмцээн
гэв үү. Сонирхолтой л
юм байна. За тэгвэл тэнд
чинь уулзъя.




Хэдэн өдрийн дараа
Кармел уулан дээр.

Та нар хэр удаан хоёр санаатай явах юм бэ? Зөвхөн ганц л Бурхан байгаа. Хэрвээ Иавэ Бурхан юм бол ганцхан Түүнийг л хүндэл. Харин Баал бурхан юм бол тэрэндээ мөргө. Та нар одоо шийд.

Баалын эш үзүүлэгч та нарыг би тэмцээнд уриалж байна. Хэн нь жинхэнэ Бурхан болохыг харцгаая.

Тэгье. Бурхдын хоорондох тэмцээн. Бид нар яах ёстой вэ?




Та нар
Баалдаа залбир.
Би Иавэд залбирна.
Тахилын ширээ уруу
гал явуулсан Бурхан
нь жинхэнэ Бурхан
болж бид нар зөвхөн
түүнийг л дээдэлнэ.
Та нар нэгэнт надаас
олуулаа тул та нар
эхэл.

Та нар Баалдаа тахилын
ширээ өр. Би ч Иавэд нэгийг засъя.
Бүгдээрээ ширээн дээр мод тавиад
өргөх тахилаа дээр нь тавина. Гэхдээ
дор нь гал асаахгүй шүү.




Ээ Баал минь,
өнөөдөр биднийгээ
сонсооч. Бид таны
агуу нэрд энэ тахилыг
зориулж байна.




Ээ агуу
сүр жавхланта Баал
эзэн минь ээ.

Тэнгэрийн
Хатан минь,
өнөөдөр ирж
Баалд туслаач.



Баал бурхан юм бол тэр чинь та нарыг анхаарахгүй л байна даа. Цаадах чинь яриад та нарыг дуулахгүй байгаа юм болов уу. Эсвэл нэг тийшээ юманд явчихсан байх. Аль эсвэл унтаж байгаа байх шүү.

Чи муу
заваан гахай. Чи бид
нараас дээрдэхгүй.



За яг шүү! Унтчихсан
байна. Та нар дахиад
жаахан чанга хашхираад
сэрээгээч.

Бууж өгөхгүй шүү
эрчүүд ээ. Ерөөсөө
бүгдээрээ биеэ огтолцгооё.
Баалд таалагдаж магадгүй.

Баалын эш үзүүлэгчид бүр
цөхрөнгөө бараад өөрсдийгөө
газар шидэн, биеэ зүсэн
огтолж, Баалдаа сонсгох гэж
орилж хашхирч байлаа.




Аааааааа!

Иийй

Би цусаа
танд өргөж байна.
Баал аа биднийгээ
сонсооч! Гал явуулаач!
Нэрээ хамгаалаач!

Яаааиий





Ха, ха! Та нар өөрсдийгөө
хараач! Та нар есөн цагийн турш ямар
ч хариу өгөхгүй байгаа бурхныг дуудаж
хашхирлаа. Хэрвээ тэр чинь үнэхээр л
бурхан байсан юм бол энэ завшааныг
ашиглаад батлах л байлаа шүү дээ.

Одоо миний ээлж.
Наашаа ирээд миний
юу хийхийг ойрхноос хар.

Баал аа, та
яагаад хариу
өгөхгүй байгаа
юм бэ?




Энэ одоо
яагаад ийм
гүнзгий нүх
ухаад байгаа
юм бэ?

Зүгээр л
харанхуй болохыг
хүлээж аргалах гэж
байгаа юм.

Чи хэзээ
залбирч эхлэх
гээд байгаа
юм бэ? Энэ
чинь нүх ухах
тэмцээн биш
шүү!

Яваад дөрвөн
боошиг ус авчраад
өргөл, мод хоёр
дээр асгаад орхи.


Ус аа?
Норгочихвол
асахгүй шүү
дээ.



Энэ эш
үзүүлэгч ёстой
солиотой байх аа.
Энэ хүн хэзээ ч нар
жаргахыг үзэхгүй
юм байна.

Хангалттай
биш байна.
Дахиад дөрвөн
боошиг ус
хийчих.

Нээрээ
ухаанаа алдчихсан
юм биш биз дээ?
Хаан ийм хүнийг яаж
тэвчдэг байна аа?



Ха Ха. Амьд Бурханд дэндүү хэцүү юм гэж байна уу? Дахиад дөрвөн боошиг ус хий. Та нар Израильд Бурхан байдгийг харах болно. Гэхдээ харин Баал гэдэггүй юм шүү.

Ахаб энэнийх нь төлөө толгойг нь авна даа.



Хойшоо
болцгоо.

Хойшоо.

Арагшаа
ухарцгаа.




Иавэ, Абрахам, Исаак, Иаковын
Бурхан өнөөдөр Та өөрийгөө ганц үнэн
Бурхан гэдгийг, бас намайг өөрийнхөө
зарц гэдгийг, мөн Та тэдний зүрхийг өөр
уруугаа эргүүлсэн гэдгийг мэдүүлээд
өгөөч.



ААААААА!

ТАР НЯР!

ИЙЙЙ!




Абрахамын
Бурхаан!

Хуйхалагдмаар
халуун байна
шүү!

Тэнгэрийн
гал!

Туслаач!



Абрахам,
Исаакийн Бурхан
галаар хариу өгч
байна.


Бүр чулуу
шороог хүртэл
шатаачихсан
байна!

Ямар ч
хэлбэр дүрсгүй
мөртөө ийм
юм хийж чаддаг
ямар гээчийн
бурхан бэ?



Өршөөгөөч!

Мосе бидэнд зөвхөн Иавэ
Бурханыг л хүндлэн дээдлэх
ёстой гэж тушаасан биз дээ. Өөр
бурханд шүтэн мөргөвөл
Израилийн ямар аавын хүү байх
нь хамаагүй үхлийн ял авна гэж
Мосе тушаасан юм.



Тэднийг
ал! Найман зуун
тавиуланг нь ал!

Бид нар
мэдээгүй
шүү дээ.

Бүгдийг
нь яг одоо
илдээр устга!

Баалын эш үзүүлэгчид
бүгд алагдав.

Хаан та ууж, идчихээд гэр
өөд яаравчил. Би их хурын
чимээ сонсож байна.




Гурван жил хагасын өмнө Елиа Ахабд өөрийг нь дахин тушаахаас нааш Израильд бороо орохгүй гэж хэлсэн юм. Баалын эш үзүүлэгчдийг устгаад, хүмүүс жинхэнэ Бурханыг дахин хүндлэн дээдлэх болж Елиа ч бороо орохыг тушаажээ.



Их бороо голуудыг үерлүүлж хүмүүсийн харих замд саад болж болзошгүй байсан тул тэд гэр уруугаа яаравчлах хэрэгтэй байлаа.

Елиад Бурхан хүч өгсөн тул сүйх тэрэгний өмнө орон хорин бээрийн газар дахь хааны ордон уруу гүйжээ.



За, чи
Елиаг цааш нь
харуулсан биз
дээ? Баал бороо
оруулахыг би
харж байна.

Үгүй ээ
хонгор минь. Елиа
гадаа байгаа. Кармел
уулаас манай сүйх
тэрэгний өмнө орж
гүйсээр байгаад
хүрээд ирсэн.

Ёстой хөгийн юм.
Ямар ч хүн сүйх тэрэгний өмнө
ороод тийм хол гүйж чадахгүй шүү
дээ. Баалын тахилчид хаа байна?
Орох бороог бүгдээрээ тэмдэглэх
юм биш үү?




Би бүгдийг
нь алуулчихсан.
Тэд нэр чинь худалч,
хууран мэхлэгчид
байсан байна лээ
шүү.



Юу, ясан гэнээ? Муу эргүү чинь! Чи тэр Елиаг л алах ёстой байсан юм биш үү?

Гэхдээ тэрний Бурхан
л галаар хариулсан шүү
дээ. Тэр жинхэнэ гайхамшиг
байсан. Манай тахилч нар
ямар ч хүчгүй юм байна лээ.
Хүмүүс бүгдээрээ Иавэ уруу
эргэчихсэн.





Гэхдээ
хайрт минь, би
өөр яах байсан
юм бэ? Би

Чи
миний тахилч
нарыг алчихсан
байна.

Муу тэнэг!




Баалын хилэнгээс
Елиаг ямар ч гайхамшиг
хамгаалахгүй ээ.

Хэрвээ би энэнийх
нь төлөө Елиаг алж
чадахгүй юм бол бурхад
надад ч адилхан бүр
тэрнээс ч дор юм хийх
болтугай.

Би
зугтаахгүй бол
болохгүй нь.



Елиа Бурханд найдахыг
мартаад өөрөө өөрийнхөө
амийг аврахаар зугтаажээ.




Өө Бурхан минь, би
хэр чадлаараа л хичээлээ.
Иезебел намайг олохоос өмнө
одоо намайг үхүүлээч.

Би өөрөөсөө ичиж байна.
Танд найдаж чадсангүй. Би нүгэлт
өвөг дээдсээсээ ямар ч дээрдэх
юмгүй хүн. Зүгээр л намайг
үхүүлчих.




Елиа дөчин өдрийн турш
цөлд агуйд нуугджээ. Тэрээр
Мосегийн арван тушаалыг
хүлээн авсан Синай уулан
дээр иржээ. Тэнд Бурхан
түүнтэй ярьсан юм.



Елиа чи наанаа
юу хийж байгаа
юм бэ?

Надаас
бусаднь Таны
хуулиудыг мартчихсан.
Таны бүх эш үзүүлэгчид
алагдчихлаа. Би л
ганцаараа үлдээд Таныг
хүндлэн дээдэлж байна.
Тэд миний амийг нэхэн
хөөж байна.

Уулан дээр
Эзэний өмнө
очиж зогс.



Елиаг Эзэний өмнө
босож зогсоход хүчит
салхи салхилсан
боловч Бурхан тэр
салхин дотор байсангүй.

Дараа нь газар
хөдлөхөд ч Бурхан бас
л тэр дунд байсангүй.

Эцэст нь тэнгэрээс
гал буужээ. Гал дунд
ч Бурхан байсангүй.

Дээрх зүйлүүд бол Бурхан өөрийгөө
Иезебелтэй зүйрлэхээргүй аймаар шүү
гэж Елиад үзүүлэх гэсэн хэрэг байлаа.


Салхи, газар хөдлөлт зогсож гал унтрахад Елиа Бурханыг аядуу, намуухан хоолойгоор ярихыг сонсов. Дахиад л Елиагаас өмнө нь асуусан асуултаа асуув:

Елиа чи наанаа юу хийж байгаа юм бэ?

Елиа юу ч сурсангүй. Өөрийгөө өрөвдсөн хэвээр байсан тул өмнөхөөрөө л бас хариулжээ.

Бүгдээрээ л надаас бусад нь Таны хуулиудыг мартчихсан шүү дээ. Бүх эш үзүүлэгч алагдчихсан. Би л ганцаараа үлдэж Таныг хүндлэн дээдэлж байна, тэд миний амийг нэхэж байна.





За тийм байж. Чи ингэж бодож байгаа бол явж очоод Елишаг өөрийнхөө оронд миний эш үзүүлэгч болгон тосло.

Чи л мэдэхгүй байгаа болохоос биш Израильд 7,000 хүн Баалын хөшөөнд мөргөөгүй, хөлийг нь үнсээгүй байгаа шүү. Одоо өөрийнхөө замаар яв. Ахабын гэрийнхэн бүгд үхэх гэж байна.



Елиа Елишаг үхэр
хөллөн газар
хагалаж байхтай
тааралдаж, түүнийг
тослон эш үзүүлэгч
болгожээ.

Эзэн чамайг
өөрийнхөө эш
үзүүлэгч болно гэж
хэллээ.

Би үхрүүдээ
Эзэнд тахил болгон
өргөчихөөд таныг
шууд дагая.

Ахабын ордны яг хажууд
Наботын усан үзмийн
талбай байдаг байв.
Ахаб талбайн сайхныг
байнга цонхоороо
алмайран харж өөрийнх
нь байсан ч болоосой
гэж шунахайран боддог
байжээ. Ингэж бодох
тусам тэр талбайг авах
гэсэн шунал нь улам
бадардаг байлаа. Хуульд
"Чи шунаж болохгүй" гэж
хэлсэн байдаг ч Ахаб
Иавэг ер тоогоогүй юм.



Ахаб их мөнгөтэй
байсан тул мөнөөх
талбайг худалдан
авахаар шийджээ.


Усан үзмийн
талбайгаа надад
зарчих. Энэ чинь яг
манай гэрийн хажууд
ч юм байна. Би чамд
өөр газар наадхаас
чинь илүү дээрийг
олоод өгье.

Бурхан ийм юмыг
зөвшөөрдөггүй юм.



Энэ талбай манай удмын
өвөг дээдсийн эзэмшилд 500
гаруй жил болж байгаа юм.
Хуульд гэр бүлийнхээ эзэмшлийг
өөр бүлийн хүнд зарж болохгүй
гэж тушаасан байдаг биз дээ.





Хайрт минь
надад хэлээч. Чи
яагаад юу ч идэхгүй
байгаа юм бэ? Яагаад
ингээд гуниглаад
байгаа юм?

Набот
надад үзмийн
талбайгаа
зарахгүй гээд
байгаа юм аа.




Чи чинь хаан
биз дээ. Чамд өөртөө
таалагдах бүхнийг хийх
эрх мэдэл бий. Чи аз жаргалынхаа
замд нэг муу дорд цэцэрлэгч
хөндөлд хийг бүү зөвшөөр.
Би тэр талбайг чинь
чамд авч өгнө.



Ажлаа дуусахаар
чинь нэмж төлнө өө.
Одоо амаа хамхи.
Тэгэхгүй бол нэмж
өгөхгүй шүү.

Мосегийн хуульд: “Чи хөршийнхөө эсрэг хуурамч мэдүүлэг өгч болохгүй” гэж хэлсэн байдаг.





Тэнд
байна. Тэр
мөн байна.

Тийм.
Тэр этгээд
хааныг үхэх
ёстой гэж
байсан.

Бас тэгээд
Бурхан хааныг
эзэмдүүлэхээр
чөтгөр явуулсан
гэж хэлсэн.

Тэгвэл
тэр үхэх ёстой
юм байна


Тэд Наботыг авч
яваад алжээ.




Хайрт минь,
тэрийг хараач.
Одоо чи үзмийн
талбайгаа ав даа. Энэ
хорвоо дээр чинь харгис
хатуу л байхгүй бол
урагшаа ахихгүй шүү.
Хүчтэй нь үлддэг
юм.

Хачин сайхан
байгаа биз. Би
л энийг эзэмших
хувьтай юм чинь.

Иезебел өөрийнхөө бурхан Баалыг харах
нүдгүй гэж мэддэг байлаа. Харин тэнгэрт
байдаг Бурхан бол хүний бүх үйлдлийг харж
чаддаг бөгөөд харснаа хэзээ ч мартдаггүй юм.




Елиа, Ахаб
Наботын усан
үзмийн талбайг
авахаар явлаа. Явж
очоод түүнтэй тэнд
уулз. Миний үгийг
дамжуул.




Ахаб аа, Бурхан
надад чамайг гэмгүй
хүнийг алж эд хөрөнгийг нь
авлаа гэж хэлж байна. Үүний
чинь төлөө, бас бусад бүх гэм
нүглийн чинь төлөө Наботын
цусыг ноход долоосон газар
чиний ч цусыг бас долоох
болно доо.

Миний дайсан
намайг олоод
ирэв үү?




Чи
Бурханаас
нуугдаж
чадахгүй.
Чи сүнсээ эд
хөрөнгөөр
сольсон хойно
Бурхан чиний
гэр дээр бузар
мууг авчрах
болно.

Чи Бурханы уурыг
хүргэжээ. Ноход
Иезебелийг гэрийн
чинь хананы дэргэд
иднэ. Танайхнаас хотод
үхэгсэд нь нохдын хоол
болж, хээр үхэгсэд нь
шувуудын хоол болно.
Хэн ч хүндэтгэлтэйгээр
оршуулагдахгүй.




Энэ бол
Эзэний үг.
Тиймд бүгд
биелэгдэх
болно.

Болиоч гуйя.
Би Иавэд тахил
өргөж эхэлье.



Елиагийн
хэлсэн болгон
биелэгдэнэ дээ.


Ахаб Иавэд өргөл
өргөж эхэлсэн ч
цэвэр сэтгэлээр
Түүнийг дагаагүй юм.



Хэсэг хугацааны дараа
хуурамч эш үзүүлэгчид
Ахабыг дайнд явахыг
зөвлөжээ.

Явж Рамот-
Гилеадад тулалд.
Бурхан танд
ялалтыг өгнө.

Эш үзүүлэгчид
бүгд зөвшөөрч
байгаа юу?



Ахаб Хаантаан, Иавэ надтай ярьсан.
Таныг Рамот Гилеадад очоод тулалдаанд
алагдана гэсэн.

Микаиаг
тоох хэрэггүй ээ. Энэ
л ганцаараа Иавэгийн
эш үзүүлэгч биш. 400 эш
үзүүлэгч бид бүгдээрээ
таныг Рамот-Гилиадаас
олз омог ихтэй ирнэ гээд
байгааг болгоогтун.

Би Микаиаг
үзэн яддаг. Тэр дандаа эсрэг
юм ярьж байдаг юм.


Ахаб хаан, та Бурханы
нүдэнд бузар мууг үйлдсэн. Та мөнгө авч
үйлчилдэг хуурамч эш үзүүлэгчидтэй
зөвлөлдөж байна. Тэд худал
хуурмагийг зааж сургадаг.



Би Бурханыг сэнтийдээ залран, тэнгэрийн бүх элч нар Түүнийг хүрээлэн байхыг харсан. Бурхан "Нэгэнтээ Елиа, Ахадд үхнэ гээд хэлчихсэн болохоор янз бүрийн аюул ослоос хол байх гэж ихэд хичээж байна. Түүнийг тулаанд явуулахаар ятгах хэрэгтэй байна. Хэн Ахабыг Рамот-Гидеадад алуулахын тулд тулаанд явуулахаар ятгах вэ?" гэж асуув.


Нэг нь нэг юм хэлэхэд нөгөөдөх нь өөр юм санал болгож байв. Ярилцсаны эцэст нэг тэнгэр элч урагш алхаад ингэж хэлсэн:






Хэрэгжүүлчихэж
болохоор нэг санал
надад байна. Би доошоо
бууж очоод бүх хуурамч
эш үзүүлэгчдийн аманд
худалч сүнс болоод
орчихъё. Би тэдэнд Ахаб
тулаанд явах ёстой
гээд хэлчихнэ.

Наадах чинь сайн
санал байна. Тэд нар Ахабд
тулалдаанаас ялалт авчирна гэж
зөгнөнө. Гэхдээ харин тэрнийг
тулааны талбарт очингуут нь би
алуулчихъя. За яв!




Чи
Иавэгийн сүнс
намайг орхиод, харин
чамтай ярьсан гэж
бодоод байгаа юм уу?

ТАС!




Дотор өрөөнд
орж амиа хамгаалахаар
нуугдахдаа чи хэнд нь
Иавэгийн сүнс байгааг
мэднэ дээ.

Энэ чинь юу
вэ? Дахин нэг эш
үзүүллэг үү? Ха!



Наадхыгаа шоронд хориод
намайг тулаанаас буцаж иртэл
үхүүлчихэлгүй зэлмүүр төдий
байлгаж бай. Ирээд бодийг
нь хөтөлье.

Хэрвээ та тулаанаас
амьд эргэж ирдэг юм
бол би хуурамч эш
үзүүлэгч болж үхвэл
зохино.




Та өөрийгөө
жирийн цэрэг хүн
болгон хувиргана
гэдэг чинь сайн санаа
байлаа шүү. Тэд таныг
хаан гэж ер
мэдэхгүй. Манайхан ч
сайн тулалдаж байна.
Таныг эргээд очихоор
нөгөө эш үзүүлэгчийн
царай ямар харагдах
бол гэхээс тэсэж
ядан байна шүү
би.

Тийм ээ. Энэ
хуяг намайг ямар ч
сумнаас хамгаална
даа.


Дайсны нэгэн цэрэг хэнийг ч
ониллолгүйгээр дайснаасаа нэгийг онож
магад гээд сумаа хөвчилж байгаад
агаарт өндөр гэгч нь харваж орхив.














ПАД!


Юу?

Аааа!



Түргэлээрэй.
Цус их алдаж
байна.

Тэсээрэй!



Хаан
үхсэнд би
их харамсаж
байна.

Сум хуягаар
хамгаалагдаагүй
ганцхан цэгийг олоод
оночихсон байгаа юм даа.
Үхэх цаг нь л үнэхээр
болсон байж дээ.

Өө
бурхан минь,
үгүй байлгүй
дээ!

Бид нарыг
буцан ирж зохих
ёсоор оршуултал
шарилыг нь Наботын
талбайд тавьчих.






Елиагийн хэлсэн ёсоор Ахабын цусыг Иезабелийн цонхны дор ноход долоож байв. Тэрээр гэрийнхнээсээ алагдсан нь анхных байсан бөгөөд бусад нь түүний араас алагдсан юм.

Ахабын сүйх тэрэгний цусыг угааж
дуусаад цэрэг ордонд орж ирэв.

Ахаб хаан хаа
байна? Ялалтаа
тэмдэглэж
байна уу?




A comic book panel featuring two characters. On the left, a man is shown in profile, wearing a white hooded cloak that covers his face, leaving only his eyes and a dark beard visible. He is looking towards the right. On the right, a man with a bald head and a full white beard is shown. He wears a golden crown and a green robe with gold trim. He has a surprised or concerned expression, with his hands raised near his face. The background is a bright yellow glow. Three speech bubbles contain Mongolian text.

Муу тэнэг! Чи Бурханы эш
үзүүлэгч биш байна. Чи бол
худалч! Иавэгийн эш үзүүлэгч
Микаиагийн хэлснээр Ахаб
үхсэн.

Тийм байж
таарахгүй ээ. Бүх
сайн эрчүүд санал нэг
байсан юм даа. Ахаб
ялах л ёстой.

Бүгд биш ээ. Чиний
алгадаад шоронд хийсэн Микаиа
тэгж хэлээгүй шүү. Хүмүүс энийг
дуулаад чиний толгойг авна даа.



Чи одоо
явж болно.
Ахаб үхсэн

Би мэдэж байсан юм
аа. Бурханы хэлснээр ямар ч
эргэлзээгүй ноход цусыг нь долоосон
биз дээ. Иезебел дараагийнх нь тэгээд
Ахабын гэсэн болгон тийм болно.
Бурхан тэгж хэлсэн юм.



Би нуугдахгүй
бол горьгүй нь.

Өө яана аа! Микаиа
хэнд нь Бурханы Сүнс байгааг
нуугдахаар дотор өрөөнд орохдоо
мэдэх болно гэсэн шүү дээ.



Ахабын хөвгүүд түүний оронд хаанчилж Иезебел хатан чигээрээ арван хоёр жил болно. Израиль ч хуурамч бурхдад мөргөсөн хэвээр Бурханы тушаалуудыг зөрчих юм.



Бурхан Ахабын гэрийн эсрэг ингэж хэлсэн юм. "Цаг нь болжээ. Ахабын гэрийн хүн бүр жаахан хүүхэд хүртэл алагдана. Хэн ч амьд үлдэхгүй. Иезебелийг ноход иднэ. Тэрний хойноос хэн ч гашуудахгүй, хэн ч оршуулахгүй."

Арван хоёр
жилийн дараа

Нүүрээ будъя,
тэгвэл Иехү жанжныг
тулаанаас ирэхэд тэрэнд
аятайхан харагдах
байх.



Энд
зогсож байя.
Тэд Намайг одоо
ч захирч байгаа
юм байна гэж
ойлгог.



Хэн
миний талд
байна?





Бид
таны талд,
жанжаан.

Тэгвэл
Иезебелийг
доош чулууд.

Та нар тэгж
болохгүй. Би
бол хатан.





Үхдэлийг
наанаа орхи.

Бурханы эш үзүүлэгчийн хэлснээр нөхрийнх нь цусыг долоосон яг тэр газар ноход Иезебелийн хүүрийг идэж цусыг нь долоожээ.





Ноход хүртэл маш их нүгэл үйлдсэн
бузар гарыг идсэнгүй орхив.

Эш үзүүлэгчийн
хэлснээр Ахабын
гэрийн бүх хүүхэд
нэг нь ч үлдэлгүй
хотынхонд
алагджээ


Хээр алагдагсад нь махчин шувуудад
идэгдэж хотод алагдагсад нь нохдын
идэш болов Оршуулах юу ч үлдсэнгүй.
Үнэхээр нүглийн төлөөс бол үхэл мөн.

Елиаг залбирахад эш
үзүүлэгч залуучууд
Елишад мэдээ
хүргэхээр иржээ.




Бурхан хэдэн эш
үзүүлэгч залуутай ярьсан
байна. Өнөөдөр чиний эзэн
Елиа тэнгэр өөд аваачигдах
гэж байгааг чи мэдсэн үү?

Тэгсэн. Бурхан бас
надад хэлсэн. Гэхдээ
чимээгүй бай. Дахиад
хэнд ч битгий хэлээрэй.



Елиша чи
энд үлд. Би Иерихо
уруу явах хэрэгтэй
байна.

Бурханы амьд буй
цагт би таныг өөрийнхөө
хараанаас салгахгүй. Би
таны явах газар явна.




Өнөөдөр чиний эзэн
Елиа тэнгэр өөд аваачигдах
гэж байгааг мэдсэн үү?

Тийм ээ, би мэднэ.
Одоо бид нарт битгий төвөг
болоод бай. Өөртөө л хадгал.
Би түүнийг хараанаасаа алдаж
болохгүй.



Чи энд Иериход
үлд. Би Иордан гол
тийш явах хэрэгтэй
байна.

Бурханы амьд буй
цагт, мөн таныг амьд буй
цагт би танаас холдохгүй.



Тэр эш
үзүүлэгч залуус
чи бид хоёрыг
дахиад дагаад
эхэллээ.

Хоёулаа
голыг яаж гатлах
юм бэ? Өнөөдөр
нэлээн нэмсэн
байна.

Хуурай
газраар.



Чи тэрийг харав уу? Ус хажуу тийш босоод тэр хоёр гарч байна.


Аа!



Тийм ээ. Яг Мосе шиг.

Би ийм юм харахын тулд юугаа ч өгөхөд бэлэн байх байсан.


Баалын эш үзүүлэгчид энийг харсан ч болоосой.



Салахаасаа
өмнө чи надаар юу
хийлгэмээр байна?

Чи хэцүү
юм асууж байна.
Гэхдээ намайг тэнгэр
өөд авагдахыг харж
чадвал хэлснээр
чинь болно.

Бурханы
Сүнсийг надад
өөртөө байснаас
хоёр дахин илүү
өгөөч.



Бурханы
сүйх тэрэг!

Бас хуй
салхи!

ХУРРРРРР

Галт сүйх тэрэг Елиаг
Елишагаас салгав.






Елиа хуй салхиар
тэнгэр өөд авагдав.


Тэгээд бүгд нам жим
болов. Елиа одоо
Бурханы оршихуйд оржээ.

Үлдсэн юм нь
түүний нөмрөг л байх
шив дээ. Энүүгээр тэр
усыг хоёр хуваасан юм
шүү дээ.






Елиагийн
Бурхан хаа
байна?



Елиагийн сүнс
Елишагийн дээр
байна!

ВУУТТ!

Хөөх, энэ
чинь ёстой
ер бусын өдөр
байна даа!



Елиша Елиагийн хийснээс хоёр дахин илүү гайхамшгийг үйлдэж, Бурханы өмнө итгэмжтэй амьдарч байлаа. Гэсэн хэдий ч хүмүүс хуурамч шүтээн мөргөлөөсөө бүрмөсөн эргээгүй юм.


Елиа
хаашаа явсан
юм бэ?

Явж олох
хэрэгтэй!

Ямар ч
хэрэг байхгүй.
Тэнгэр өөд
явчихсан юм
чинь.



Долдугаар
бүлэг
ХРИСТИЙН
ТУХАЙ ЭШ
ҮЗҮҮЛЛЭГҮҮД



Елишагаас хойш Бурхан Исаиа, Иеремиа, Амос гэх мэт олон эш үзүүлэгчийг гарган, хүмүүсийг гэм нүгэл, хуурамч шүтээн шүтэх явдлаас нь эргүүлэхээр дуудаж байсан юм. Бурхан тэр эш үзүүлэгчдээр дамжуулан ярьдаг байв. Мөн тэднээр ирээдүйн явдлуудын талаарх эш үзүүлэгчдийг бичүүлжээ.

Исаиа бол Уззиа, Иотам, Ахаз, Хезекиа хаадын үед амьдарч байсан эш үзүүлэгч юм (ойролцоогоор МЭӨ 760-700 он). Бурхан Исаиагаар дамжуулан ингэж хэлжээ. "Миний өсгөж, торниулсан хөвгүүд Миний эсрэг бослоо. Тэнэг үхэр хүртэл эзнээ таньдаг. Гэвч Израиль Намайг таньдаггүй. Нүгэлт үндэстэн, гэмд дарагдсан ард түмэн, хорлогчдын үр удам..."

“Та нар бузар мууг хажуу тийш тавьж дарлагсдыг чөлөөлж, эцэггүйчүүдийг хайрлаж, бэлэвснийг ханган тусалбал Би та нарыг сэргээж эдгээнэ. Харин та нар Над уруу эргэхгүй бол Би та нарыг илдээр устгана. Танай газар нутаг хоосрон эзгүйрч, хотууд чинь галд шатаагдана. Хөвгүүд чинь Вавилонд хүргэгдэж тайган болгуулж тэндхийн хааны ордонд үйлчлэн зарагдана.”





Иеремиа бол Иосиа, Иохиаким, Зедекиа хаадын үед (ойролцоогоор МЭӨ 630-590 он) амьдарч байсан эш үзүүлэгч юм. Тэр ингэж хэлжээ. " ЭЗЭН ингэж айлдаж байна. Үзэгтүн, Би та нарын өмнө амь ба үхлийн замыг тогтоодог. Энэ хотод суусан нэгэн илд, өлсгөлөн, тахлаар үхнэ. Харин гадагш гарч яван, та нарыг бүсэлж байгаа халдеичуудад бууж өгсөн нэгэн амьд үлдсэн ч Вавилонд очин зарцлагдана. Өөрийн нүүрийг энэ хотыг эсэргүүцэхээр чиглүүлэв гэж ЭЗЭН тунхаглаж байна. Энэ хот Вавилоны хааны гарт өгөгдөх бөгөөд тэрээр түүнийг галдан шатаана."



ЭЗЭН Амосоор
дамжуулан ийнхүү
айлджээ. "Би Өөрөө
сунгасан гар, хүчит
мутраар та нарын эсрэг
уурлан, хилэгнэн,
дургүйцэн тулалдана.
Би мөн
энэ хотын оршин
суугчдыг, хүн болон
араатан амьтдыг
ялгаагүй цохиж, тэд их
тахлаас болж үхнэ.

Тэгээд дараа нь Иудагийн хаан Зедекиа түүний зарц нар болон ард түмнийг буюу энэ хотод тахал, илд болон өлсгөлөнгөөс амьд үлдсэн хүмүүсийг хүртэл Би Вавилоны хаан Небухаднезарын гарт, тэдний дайснуудын гарт, мөн тэдний амийг эрэн хайгчдын гарт тушаана. Тэрээр тэднийг илдний ирээр цохино.

Тэрээр тэднийг амьд үлдээхгүй, өрөвдөх ч үгүй, энэрэх ч үгүй. Миний уур хилэн гал мэт асах бөгөөд хэн ч түүнийг унтрааж чадахгүй. Тэд та нарыг Вавилонд зарц боол болгож, мөн илдээр устгана. Вавилон уруу явсан хүмүүсээс олонх нь тэндээ үхэж оршуулагдана." Амос бол Уззиа, Иеробоам II хаадын үед амьдарч байсан эш үзүүлэгч юм (ойролцоогоор МЭӨ 765-750 он).



Бурхан Амосоор дамжуулан ингэж хэлжээ. "Танай эмэгтэйчүүд үнээ шиг өөрсдийгөө уух юмаар ханга гэж нөхрүүдээсээ хүсдэг. Та нар нөхрүүдээ удаан дарлахгүй. Та нар Вавилонд биендээ дэгээтэйгээр хүргэгдэн боолчлогдоно."



“Та нар үнэт тавилга дээр хажуулдаж тансаг хоол идэн таргалсан. Их дарс ууж хөгжимсонсдог. Та нар шударга үнэнийг газар гишгэж, ядуу зүдүүг дэвсэлж, зөвийг дарлаж, хээл хахууль авч, үгээгүйгээс шударга ёсыг булаан авдаг. Та нар усан үзэмтариалах боловч дайснууд чинь дарсыг нь ууна. Танай цэрэг арми устгагдаж та нар өөрсдөө харь газар боолчлогдоно.”

Бурхан айлдаж байна. "Би Бетелийн тахилын ширээнүүдийг устгаж танай өвлийн байшинг зуны байшинтай чинь цуг тастаж хаяна. Та нар ядуучуудыг дарлаж, хахууль авдаг бас үгээгүйчүүдийг нухчдаг. Би бороог зогсоож өлсгөлөн, тахал явуулсан боловч та нар гэмшээгүй. Та нар дахин усан үзэмт ариалавч тэрнээсээ уухгүй."




Ээж ээ, би өлсөөд байна.

МЭӨ 753 он


Хосеа бол Уззиа, Иотам, Ахаз хаадын үед амьдарч байсан эш үзүүлэгч юм (ойролцоогоор МЭӨ 785-725 он). Тэрээр ингэж эш үзүүлсэн юм: "Израиль илдэнд унах бөгөөд хүүхдүүд нь газар унаж, жирэмсэн эхчүүд нь дутуу төрнө".



"Бурхан түүний гэм нүглийг уучилж Израилийг чөлөөтэйгөөр хайрлах цаг ирнэ. Израиль сараана цэцэг шиг дахин дэлбээлнэ. Тэр чидун мод шиг ургаж Ливаны хуш шиг анхилна."



“Вавилоны дараа он жилүүд өнгөрөхөд та нар үндэстнүүдэд тараагдаж тэд та нарыг дарлан доромжилж, хөрөнгө хогшлыг чинь авна. Тэгээд та нарт амсхийх газар ч олдохгүй.”




Тэд хамаг юм
аваад явчихлаа. Бид
нарыг яагаад зүгээр
орхичиж болохгүй
байгаа юмбол?

Ээж ээ, бид
нар хаана амьдрах
гэж байгаа юмбэ?

Энэ уул нь
их үнэ хүрэх байсан
юм. Иудейчүүдийг
явуулна гэдэг яасан
дургүй хүргэсэн хэрэг
вэ. Тэд уул нь мөнгө
олоход их сайн
байсан юмсан.

Энд бүх
иудейчүүдийг гурван
өдрийн дотор нутгаасаа
гар гэсэн байна.



Тушаалын дагуу бүх
иудейчүүд нутгаасаа гарах бөгөөд
харин биедээ ямар ч эд зүйл авч явж
болохгүй гэсэн байна.

Би энэ үнээг
авах юмсан гэж
дандаа л хүсдэг
байж билээ.

Израиль үндэстэн Бурханы үгийг голон үл
ойшоосон учраас дэлхийн улс үндэстнүүдэд
тараагдах бөгөөд Бурхан эргүүлэн эцэг дээдсийнх
нь нутагт авчрахаас нааш тэд амар тайвныг үзэхгүй.

“Израилийн бүх газар нутаг эзгүйрэн хоосорч та нар Вавилоны хаанд далан жил зарагдана. Гэвч далан жилийн дараа би Вавилоныг гэмбуруугийнх нь улмаас шийтгэж үлдэгсдийг энэ газар авчран сэргээн засуулна.”




“Иерусалим хаягдаж хоцроод тал хөндий шиг хагалуулан тэгширнэ.”



Энэ эш үзүүлэг биелэгдсэн бөгөөд дайснууд нь үнэндээ Иерусалимыг газар хагалах шиг хагалсан юм. Гэсэн хэдий ч сүүлчийн өдрүүдэд Бурханы өргөө дахин баригдаж хүмүүс түүн уруу хөврөх болно.


МЭӨ 750-686 онуудад амьдарч байсан эш үзүүлэгч Мика ийнхүү зөгнөжээ:

“Олон үндэстнүүд ирцгээ!
ЭЗЭНий уул болон
Иаковын Бурханы өргөө
уруу явцгаая. Тийнхүү
Тэрээр бидэнд Өөрийн
замуудын тухай сургаж,
бид Түүний жимээр
алхах юмгэцгээнэ.
Учир нь Сионоос хууль
гарч, ЭЗЭНий үг ч
Иерусалимаас гарна.”



“Тэр олон ардын хоорондохыг шүүж, хүчирхэг, холын
үндэстнүүдэд зориулан шийдвэрийг гаргах болно.
Тэгээд тэд илдээ анжисны хошуу, жадаа хадуур болгон
давтана. . .

... Үндэстэн
үндэстнийхээ эсрэг илд
далайхгүй бөгөөд дахин
хэзээ ч тэд дайтахад
суралцахгүй. Өөрсдийг
нь айлгах ямар ч
хүнгүйгээр тэдний хүн
тус бүр нь өөрийн усан
үзмийн болон инжрийн
модны доор сууна.
Учир нь түмэн цэргийн
ЭЗЭНий амайлдав."



"Бид үүрд мөнх
өөрсдийн ЭЗЭНий
нэр дотор алхана.
ЭЗЭН тунхаглаж
байна: Тэр өдөр
Би Өөрийн тарсан
ард түмнийг
цуглуулж хүчит
үндэстэн болгоно.
ЭЗЭН Сион
ууланд тэднийг
эдүгээгээс
мөнхөд хүртэл
хаанчилна."

Иеремия ингэж
эш үзүүлжээ.



Далан жилийн дараа Вавилон хойд
зүгийн цэргүүдэд ялагдаж манай
үлдсэн хүмүүс нутагтаа буцан ирж хот,
Бурханы өргөө хоёрыг сэргээн барина.

Зедекиа хаан ЭЗЭНий
нүдэнд бузар
мууг үйлджээ. Тэр
үхэхгүй бөгөөд Вавилон
уруу ард түмнийхээ
хамт очиж амьдарна.
Гэхдээ тэр Вавилоныг
хэзээ ч харахгүй учир нь
түүний нүдийг сохолсон
байх юм. Вавилонд та
нар далан жил болно.

Шийтгэлийн хугацаа өнгөрсний дараа Бурхан тэдний гэмнүглийг уучилж, Иерусалимүеийн үед хүнээр дүүрэн цэцэглэх болно.

Энэ номыг Вавилон уруу авч яван тэнд хүмүүсийн өмнө уншиж өг. Эргэн ирэхээсээ өмнө тэд юуг туулах ёстойг нь ойлгуул.




Би Давидын сэнтийг сэргээхэд та нар эргэн ирж газар нутгаа эзэмших болно.



Езекиел ийн эш үзүүлжээ:
“Тэд үндэстнүүдийн дунд
тархах боловч эцэст нь
Бурхан тэднийг тараасан
шигээ буцаан авчрах юм.”



“Бурхан Абрахамд үр
удам нь газар нутгийг
үүрд эзэмшинэ гэж хэлсэн
учраас амлалтаасаа
Тэр няцахгүй. Гэсэн
хэдий ч хүмүүс нүгэл
үйлдэхэд Бурхан тэднийг
үндэстнүүдэд олзлуулж
тэр газраа тэд хуурамч
харийн бурхдад үйлчлэх
боловч эцэст нь Бурхан
эргүүлэн авчирна.”



“Египет мөн Вавилоноор шүүгдэж дөчин жилийн турш газар нутаг нь эзгүйрэн хоосорно. Вавилоноос буцаж ирснийхээ дараа тэд урьд байсан шигээ агуу болж хэзээ ч чадахгүй зөвхөн эцсийн цаг үеийг хүртэл оршин байх юм. Хожмын өдрүүдэд Египет, Ассири хоёр хамтран миний ард түмэн Израильтай нэгдэн гурвалсан энхийн гэрээ тогтооно, тэгэхэд нь Би тэднийг ерөөнө.”



“Филистчүүд устгагдаад дахин хэзээ ч сэргэхгүй. Түүнчлэн Ашдод, Екрон, Аммон гэж байхгүй болно. Едом ч бас эзгүйрэн хоосорно. Тир устаж мод чулуунууд нь далайд хаягдана. Тэр дахин хэзээ ч сэргэхгүй бөгөөд газар нь тэгширч мөлийгөөд чулуу шиг болж загасчдын тор тавьдаг талбар болно.”

“Харин Перс (Иран), Турк, Этиоп,
Ливан төгсгөлийн өдрүүдийг
хүртэл оршин байна. Бас
заримцаг үеүдэд тэд Израилийн
газар нутгийг эзлэхээр
санаархавч чадахгүй харин
Израилийн ууланд мөхөх юм.”



Библийн олон эш үзүүллэгүүд ямагт ямар ч зөрүүгүй таардаг. Эш үзүүллэгээр мөхөх тавилантай байсан хотууд, үндэстнүүд үнэхээр л тэгж төгссөн байдаг. Төгсгөлийг хүртэл оршин байна хэмээн хэлэгдсэн улс үндэстнүүд өнөөдөр ч бидний дунд байсаар байна.



МЭӨ 605 онд Израиль
вавилончуудад эзлэгдэн,
эш үзүүлэгчдийн зөгнөн
хэлсэн биелэгдсэн билээ.



Эзэн минь ээ, бид эцэг
өвгөдийнхөө гэм буруугаас
болж шийтгэгдэж байгаа билээ.
Эзэн минь, энэ харь газарт ч
гэсэн Таны хуулиудыг даган
биелүүлэхэд туслаач.




Таван мянга гаруй иудей хүн дайнд олзлогдон Вавилонд хүргэгдсэн юм. Тэд залуу, боловсролтой хүмүүсийг олзолж, хаант улсдаа ашиглах зорилгоор авчиржээ. Тэдний дунд Даниел гэдэг нэгэн залуу ирсэн байлаа. Тэрээр Бурханы тушаалуудыг ямагт сахин биелүүлж, Абрахамын Бурханд дуулгавартай амьдарч байсан ажээ.




Газар, тэнгэр,
дэлхий ертөнцийн
их Эзэн минь, Тандаа
бид талархаж байна. Та
газар шорооноос талх
тариаг ургуулдаг
билээ.

Даниел харь газар олзлогдогсдын нэг байсан боловч Бурхандаа итгэлтэй үнэнч хэвээр байхаар шийдсэн байлаа. Баривчлагсад нь Даниелын зөв сайн сэтгэлтэйг мэдээд Вавилоны ухаантан мэргэдийн дунд, тусгай албанд томилжээ.



Вавилоны хаан
Небухаднезар ер бусын
зүүд зүүдлээд сэржээ.

Энэ юу гэсэн үг юм
болов оо? Иймэрхүү зүүд
ирээдүйд болох зүйлийг
хэлж бурхдаас л ирдэг
байх даа.

A king with a long grey beard and a golden crown sits on a wooden throne. He wears a purple tunic with gold fringes. He is surrounded by several advisors in various colored robes (yellow, green, red) and head coverings. The setting is an ornate palace interior with a patterned floor and a large bird sculpture in the background.

Та нар бол
мэргэн хүмүүс. Бурхад
юу гэж байгааг та нар
мэддэг улс. Одоо намайг юу
зүүдэлснийг, бас энэ зүүд
ямар утгатай болохыг
хэлээд аль.

Та зүүдээ
хэлэхгүй юмбол
бид ямар утгатай
болохыг нь яаж
мэдэх билээ дээ.
Ийм юмыг бурхдаас
өөр хэн ч хийж
чадахгүй.



Би та нарыг
бүгдийг чинь мэхлэгчид
гэж мэдээд байсан юм аа.
Бурхад та нартай ярьдаггүй
юм байна. Та нар бүгдээрээ, гэр
бүлтэйгээ хамт алагдана Танай
орон гэрүүд овоолоотой
өтөг болно.


Уучлаарай Даниел аа.
Маргааш гэхэд чи Вавилоны бүх
мэргэчүүдтэй цуг хороогдох гэж
байна. Хаан өөрийнхөө тахилчдад
итгэхгүй байна.



Харин Иавэ Бурхан
хааны зүүдийг тайлалтай
нь хамт хэлж чадна аа. Би
ганцаараа залбирах хэрэгтэй
байна. Та нар хааныг ганц
өдөр аргалж чадах нь уу?


ЭЗЭН минь ээ,
Та л зөвхөн Бурхан,
энэ ертөнцийн Хаан
билээ. Та боолдоо
болох бүх зүйлүүдийг
харуулаач. Тань
шиг Бурхан хаа ч
байхгүй.





Хурдлаарай.
Намайг хаан
дээр дагуулаад
очооч!


Чи хааны зүүдийг
хэлж чадахгүй бол хаан
намайг байгаа газар
маань хорооно доо.



Хаантан
минь, тэнгэрийн
их Бурхан таныг бүх
хаадын хаан болгосон
билээ. Бурхан танд
төгсгөлийн өдрүүдэд
юу болохыг
харуулсан үзэгдэл
өгсөн байна.

Дэлхий ертөнцийг
бүтээгч, цорын ганц үнэн
Бурхан таныг зүүдийг боол
надад харуулсан.

Битгий цаг
үрээд бай. Чи миний
зүүдийг хэлж чадах
уу, үгүй юу?



Өө хаантаан,
та нэг агуу дүрсийг
үзсэн байна. Тэрхүү дүрс
нь танай хаант улсыг
болоод түүний араас гарах
гурван өөр хаанчлалыг
төлөөлж байна.


Үнэн байна! Би
хэнд ч хэлээгүй юм!
Чиний Бурхан бол
цорын ганц үнэн
бурхан байна.




Та бол тэр алтан толгой буюу бүх хаадын хаан. Таныг Иудаг эзлэхээс өмнө Бурхан биднийг гэм нүглүүдийн маань улмаас шийтгэж, хаанчлалыг танд өгнө гэж манай эш үзүүлэгчдэд хэлсэн билээ. Одоо таны хаанчлал алдарших болно.




Тэр мөнгөн цээж бол
өөр нэг хаанчлал буюу Mede,
Персийн хаанчлал юм. Таныг
таалал төгссөний дараа Вавилоныг
тэд эзлэн авч, та дэлхийг захирсан
шиг тэд захирах юм.

A character wearing ornate golden armor with a prominent circular emblem on the chest. The armor is highly detailed with various straps and buckles. The character's arms are also armored in gold.


Өө хаантаан. Алтан толгой, мөнгөн цээжний дараа та хүрэл хэвлийг харсан. Тэр хүрэл бол гурав дахь хаанчлал болох Грекийн хаанчлал юм. Энэ хаанчлал Персийн дараа гарах бөгөөд тэд түргэн, хэрцгий байх болно.


A man with dark hair and a headband is shown in profile, pointing his right index finger towards the foot of the armored character. The background is a simple green and brown ground.

Дөрөв дэх хаанчлал бусдаасаа өөр байна. Хоёр хөл нь төмрөөр хийгдсэн байх бөгөөд үндэстнүүдийг үйрмэг болгон гишгилнэ. Гэхдээ төмөр шавартай холилдсон байхыг та харсан. Төгсгөлдөө хаанчлал арван хэсэг болон хуваагдаж, сулран доройтно.



Дараа нь хаан та
нэгэн чулуу хүний гарын
оролцоогүйгээр уулнаас авагдахыг
харсан. Тэр чулуу уулнаас өнхөрч,
мөнөөх дүрсийг хөлөн дээр нь цохиход
бүхий л хаанчлал нэг мөчийн дотор
нуран унав.





Тэр чулуу
бол энэ
дэлхийд ирж
сүр жавхланта
хаанчлалаа
тогтоох Бурханы
Хүүг төлөөлж
буй юм.


Төгсгөлийн цаг ирэхэд
үхсэн бүх хүмүүс амилж
шүүлтийн өмнө зогсох болно.
Бузар мууг үйлдэж байсан хүмүүс
ичгүүр ба мөнхийн шийтгэлийг
хүлээн авна. Харин сайныг
үйлдэж байсан хүмүүс мөнх
амийг хүлээн авах юм.

Ямар ч эргэлзээгүй ярьсан болгон чинь Бурханаас ирсэн байна. Тиймбишсэн бол чиний зүүдийг иймдэлгэрэнгүй яаж мэдэх билээ. Би чамайг бүх мэргэн хүмүүсийн удирдагчаар томиллоо.




Даниел Вавилонд цааш 68 жил суужээ. Тэр олон зүүдийг тайлж ирээдүйн талаар олон зүйлийг урьдчилан хэлсэн байна. Яваандаа Небухаднезар хаан таалал төгсөж, хүү Белшазар нь түүний хаанчлалыг авчээ.

Нэгэн үдэш Белшазар найрлан согтууран байхад нь үл ойлгогдомгар гарч ирэн ханан дээр бичжээ. Даниел уг зүйлийг тайлбарлахаар дуудагдахад Бурхан түүнд энэ харь хэлийг тайлах ухаан өгчээ.



Өө хаантан, та Бурханы эсрэг нүгэл үйлджээ. Эш үзүүлэгчдийн зөгнөн хэлснээр өнөө шөнө таны хаанчлал унаж Меде, Персийн гарт очихнээ.




Эш үзүүлэгчдийн урьдчилан хэлснээр эдгээр дайснууд хот уруу ордог усны хоёр хаалгаар нууцаар нэвтрэн орж Вавилоныг булаан эзэлнэ гэсэн байна. Гэтэл Вавилончууд энэ бүхнийг ажиглах сөхөөгүй болтлоо согтсон байх юм. Вавилоны сүйрэл яг ийм замаар ирснийг түүх өгүүлдэг билээ.


Вавилоныг меде, персчүүд эзэлснээс хойш Даниел Библийн номуудын нэг болох Иеремиа эш үзүүлэгчийн бичсэн хуучин номыг олж нээжээ. Номыг уншиж байхдаа Даниелын олж мэдсэн гайхалтай зүйл бол Бурхан израильчуудыг Вавилонд зөвхөн 70 жил цөллөгдөнө гэж урьдаас хэлсэн явдал байлаа.



Түүний дараагаар үлдэж хоцорсон хүмүүс Иерусалимд эргэн ирж хотын хана хэрэм, Бурханы өргөөг сэргээн барих юм. Номыг цааш уншаад 200 жилийн өмнө эш үзүүлэгч Исаиа тэднийг нутагт нь буцаах тушаал өгөх Персийн хааныг нэрлэж байсныг хүртэл олж мэджээ.




Одоо түүнээс хойш
69 жил өнгөрчээ... Зөвхөн
ганц жил л үлдсэн байна. Энд
Бурханы зарц Дариус Түүний хүслийг
гүйцэлдүүлнэ гэж бичжээ. Тэр хаан
биднийг төрсөн нутагт маань буцаан
явуулахаар тушаах юм!



Бурхан Абрахамд амласныхаа дагуу энэ газар нутгийг бидний мөнхийн эзэмшил болгон өгсөн юм. Бурхан бидний өвөг дээдэст өөр бурхдад үйлчилбэл дайснуудынхаа гарт орно гэж анхааруулсан юм. Гэхдээ Тэр өөрийнхөө ард түмнийг хэзээ ч мартахгүй гэж бас амласан билээ. Бурхан хэлсэн үгэндээ хүрдэг учраас бид эргэн ирлээ. Бид одоо Бурханыг үгийг дагах ёстой.

Иудейчүүд
Вавилонд
олзлогдсноос
хойш 70 жилийн
дараа Бичээст
бичсэний дагуу
Дариус тэднийг
чөлөөлжээ.
Ингэж 52,000
хүн нутагтаа
эргэн ирж хотоо
сэргээн барьжээ.



Бүгдээрээ
зохион байгуулалтад
орж эхлээд хануудыг барьж
дараагаар нь Бурханы өргөөг
босгож эхэлье.

Абрахамын Эзэн
Бурхан минь, Та амласныхаа дагуу
биднийг буцаан авчирлаа. Өөрийн
тань замаар хэрхэн явахыг
бидэндээ зааж өгөөч.

Би цэвэр ус
олоод ирлээ. Одоо
ажлаа эхэлцгээе.

Даниел нас өндөр болсон байсан учраас бусадтайгаа цуг буцаж явсангүй. Тэрээр Вавилон дахь Меде-Персийн эзэнт гүрэнд хааны зөвлөхийн өндөр албан тушаалт ажлыг хийж гүйцэтгэсэн хэвээр байлаа. Бурхан түүнд ирээдүйд болох явдлуудын тухай хэд хэдэн үзэгдлийг үзүүлсний заримнь бүр төгсгөлийн өдрүүдийн тухай байсан юм. Нэгэн үзэгдэлдээ тэрээр төмөр биетэй араатныг харжээ. Тэнгэр элч түүнд уг үзэгдэл ямар утгатай болохыг хэлж өгчээ.





Бурхан чамд төгсгөлийн өдрүүдэд юу болохыг харуулж байна. Ирээдүйд гарах дөрвөн хаанчлалын тухай Бурхан Небухазнезарт харуулсан юм. Одоогоор хоёр нь гарчхаад байна. Меде-Персийн хаанчлалын дараа Грекийн хаанчлал ирнэ. Тэд гарч ирээд бүхнийг үлдэн хөөх боловч удалгүй дөрөв болон хуваагдаж өөрөө өөрсөдтэйгөө тулалдан зөвхөн хоёр нь л үлдэх юм. Үлдсэн хоёр нь удаан хугацаагаар хоорондоо тэмцэлдэж дөрөв дэх хаанчлал гарч ирэхэд эзлэгдэх бөгөөд тэрхүү дөрөв дэх хаанчлалыг уг төмөр араатан төлөөлж байгаа юм.



Дөрөв дэх хаанчлал ган төмөр мэт хатуу байх бөгөөд урьдын бүх хаанчлалуудаас илүү хүчтэй, илүү харгис байх болно. Тэд бүхнийг эзлэн авах боловч төгсгөлдөө арван улс болон хуваагдана. Улмаар тэдний дундаас нэгэн хүн энх тайвны тухай ярин гарч ирэх юм. Тэр хүн бол араатны толгойноос ургах хамгийн сүүлчийн эвэр юм.

Төгсгөлийн өдрүүдэд тэр хүн сайхан амлаж, энх тайвныг билэгдэх боловч зөвхөн устгаж булаан эзлэхийн тулд л тийнхүү амлах аж. Тэр бас Иудейн ариун өргөөг цэвэр бус болгон өргөл өргөхийг зогсоохын тулд жигшүүрт зүйлийг дотор нь тавих юм. Мөн бүх дэлхийд агуу зовлонгийн үе ирэх боловч зөв шударга хүмүүс үүнээс чөлөөлөгдөнө.

Даниел аа, Бурхан чамд хэзээ юу болохыг мэдүүлэхийг хүсч байна.


Өргөөг сэргээн бариулах тушаал

өгөгдснөөс хойш 483 жилийн дараа Мессиа [Тослогдсон нэгэн] алагдаж хүмүүсийн нүглийн төлөөсийг төлнө. Үүний дараагаар Бурханы өргөө дахин устгагдах болно.



Энэ эш үзүүлэлэг биелэгдэж Мессиа тослогдох юм. Тэр үед гэм нүглийн эвлэрүүлэл хийгдэж, мөнхийн зөвтгөл хүн дээр ирэх болно.

Даниелын бичиж үлдээсний
дагуу яг 483 дахь жилийн
төгсгөл дээр
Мессиа Иерусалимд өөрийн
ялалтаар орж ирсэн юм.



Бурхан Адам, Ева нарт
эмэгтэйн үр бузар нэгнийг
дарна гэж хэлсэн юм.
Бурхан Ноад Мессиа
Иафет, Хам нарын удмаас
биш Шемийн удмаас төрөх
болно гэж хэлжээ.

Мөн Абрахамд чөлөөлөгч хүү Исаакийнх нь үр удмаас ирнэ гэсэн байна. Харин Исаакт амлагдсан аврагч хүү Иаковоос нь гарна гээд, Иаковд болохоор Иудагийн удмаас ирэх юм гэжээ.

Бурхан амлагдсан Аврагчийн тухай олон тодорхой эш үзүүлэлтийг өөр өөр эш үзүүлэгчдэд өгсөн байна. Тэд аврагчийг мөнхөд оршин байсан гээд Иудагийн Бетлехем хотод онгон эмэгтэйгээс төрнө гэж хэлжээ. Тэр харахад маш эгэл дорой байх бөгөөд илжиг унан явна.

ЭЗЭН түүний дээр сүнсээ
байлгахад Тэр харь
үндэстнүүд дээр шүүлтээ
авчрах юм. Тэр бас харь
үндэстнүүдэд гэрэл болох
бөгөөд энэ дэлхийн бүх
хүнд авралыг авчирна.
Мессиа зовжшаналан
өөрийнхөө хүмүүст
гологдож гар, хөлөө
хатгуулна. Тэр нүцгэн
өлгөгдөж, анган цангахад
усны оронд тэд Түүнд цуу
өгөх юм. Тэр бас хулгайч
дээрэмчдийн дунд
алагдаж, харин баян хүний
булшинд оршуулагдана.

Даниелын эш үзүүллэгт
гарсан дөрөв дэх хаанчлал
яг түүний зөгнөн хэлснээр
гарч ирсэн
юм. МЭӨ 330 онд Грекийн
агуу их Александр хаан
долоон жил үргэлжилсэн
аян дайнаа
эхлүүлж, улс
үндэстнүүдийг эзлэн авсны
дотор Меде-Персийн эзэнт
гүрэн ч оржээ. Грекчүүд
МЭӨ 167 он хүртэл буюу
дөрөв дэх хаанчлал болох
Ромын эзэнт гүрнийг эзлэн
авах хүртэл хүчирхэг
байсан юм.

Небухаднезарын
зүүдэнд Ромтөм өр
хөлөөр үзэгдсэн
бөгөөд Даниелын
үзэгдэлд төмөр араатан
мэт харагдаж эш
үзүүлэгчдийн урьдаас
хэлсэн шиг хүч чадал,
хил хязгаараа тэлэн
нэмэгдүүлжээ. МЭӨ 5 онд
Ром Израилийг төмөр
нударгаар захирч байлаа.

500 жилийн дараа

Даниелын эш үзүүллэгээс хойш 500 гаруй жил өнгөрчээ. МЭӨ 6 онд ромчууд иудейчүүдийн шашин шүтлэгийг чөлөөтэй болгосон боловч татвар, татаасаар хүчтэй дарамталж байлаа. Бурханы өргөө дахин баригдаж иудейчүүдийн амьдралын гол төв нь болж байсан юм. Ихэнх хүмүүс ирэх Мессиагийн талаар мартсан боловч цөөхөн хүн Хуулийг сахин биелүүлж Христийн ирэхийг хүлээж байлаа. Тэрхүү цөөн хүний дунд Симеон хэмээх нэгэн хөгшин байжээ.

Тэрээр шударга ариун хүн байсан бөгөөд эш үзүүлэгчдийн өгүүлсэн тэр Нэгэнийг хүсэн хүлээсээр байв. Олон жил эш үзүүлэгчүүдийн талаар уншиж судалсан учраас цаг хугацаа тун их ойртсоныг мэдэж байлаа.

Нас нэгэнтээ ахисан болохоор удаан амьд явахгүй болсон ажээ. Анх Бурхан Евад өөрийнх нь үр Бузар нэгний ажил үйлсийг устгана гэж хэлснээс хойш 4,000 жил өнгөрчээ.

Одоо цаг нь болжээ.
350 гаруй эш үзүүлэг биелэгдэхэд бэлэн боллоо.




Наймдугаар
бүлэг

ШИНЭ
ГЭРЭЭ

Абрахам, Исаак, Иаковын
Бурхан миньээ, би Аврагчийг
удаан хүлээлээ. Одоо би удаан
амьд явахгүй биз дээ.

Чи удаан
амьдрахгүй нь үнэн,
гэхдээ нүд анихаасаа
өмнө Амлагдсан
нэгнийг харах болно.




Симеон чи
энд өдөр бүр л ирэх юм.
Бүх тахилч нар чам шиг ийм
итгэлтэй байсан ч болоосой.

Симеон Бичээсээс
уйгагүй хайсаар
Христийн талаарх
олон эш үзүүллэгийг
олж мэджээ.

Исаиа номд
байдаг Христийн талаарх эш
үзүүллэгийг та нар юу гэж үздэг
вэ? Онгон бүсгүй хүүхэд тээж хүү
төрүүлнэ гэж хэлсэн байна. Энэ л
тэгэхээр Евад хэлсэн эмэгтэйн үр
байх ёстой доо.


Тийм ээ, Исаиа
бас түүнийг Агуу хүчит Бурхан
гэж хэлэгдэнэ гэсэн байдаг
шүү. Гэхдээ эш үзүүллэгүүдийг
ойлгоход хэцүү байдаг юм аа.



Мика 5:2 дээр
хэлсний дагуу
Хүү ч бас Бурханы
адил мөнхийн байх
ёстой. Тэгтэл бас
Дуулал 45:6 дээрх эш
үзүүллэг Бурхан Өөрөө
хүүг бас Бурхан гэж
дууддагийг юу гэж
ойлгох вэ?

Цөөхөн хүн
чиний ярьж байгаатай
санал нийлдэг юм шүү. Тийм
болохоор чи хамаагүй олны
дунд ярьж болохгүй шүү.
Тэгэхгүй бол чамайг дор нь
чулуудаад алчих байх.

Чи харна аа. Намайг нүд
анихаас өмнө Мессиа яг энэ
өргөөнд ирнэ. Тэгэхээр ньби
Түүнийг харах юм.




Тэр хүн зөв
ярьж байгаа
байх шүү.

Чи хэн бэ? Чи
эдгээр зүйлүүдийн
талаар юу мэддэг
юм бэ?

Би та нарын яриаг хажуугаас
чиньчих тавин сонсохгүй байж чадсангүй.
Би ч бас Бичээсийг зөндөө судалсан. Даниел
500 жилийн өмнө Мессиагийн ирэх цагийн
тухай их сонирхолтой зүйлс хэлсэн
байдаг юм.

Хуулийн багш
нарын мэдэхгүй юуг
чи мэддэг юм бэ?





Манай аав хуулийн багш л даа.
Аав мааньнадад эш үзүүллэгүүдийг
тайлбарласан юм аа. Бурхан Даниелд
Иерусалимыг сэргээн барих тушаал
гарснаас хойш жилийн дараа Мессиа ирнэ
гэж хэлсэн байдаг.


Тэр тогтоол гарснаас хойш
жил болж байна. Харин одоо
тэгэхээр 34 жил үлдсэн
байна. Мессиа одоо ч бараг
гадаа гудманд алхаж явах
боломжтой болоод байна.

Гэхдээ арай
үгүй ээ. Ариун Сүнс
намайг үхэхээсээ
өмнө нярай Мессиаг
яг энэ өргөөн дотор
харна гэж хэлсэн юм
даа.

Та ийм
юмнуудыг яаж
мэддэг байна аа?

Чи харна,
хүү минь.

Амлагдсан Христийн
ирэхийг Симеон
хүлээсээр байлаа. Тэр
үед Захариа хэмээх
нэгэн тахилч Бурханы
өргөөнд залбирахаар
орж ирэв. Захариа
эхнэрийн хамт өтөлж
хөгширсөн байсан
бөгөөд ерөөс өөрийн
гэсэн үр хүүхэд
заяагаагүй юм.



Гэнэт нэгэн тэнгэр элч
тахилын ширээний
хажууд гарч ирэв!

Бүү ай. Чиний
залбирлыг Бурхан
сонссон. Эхнэр Елизабет
чиньхүүтэй болно, та нар
түүнийг Иохан хэмээн
нэрлэнэ.

Түүнийг төрөхөд
хүмүүс баярлан хөөрнө. Учир
ньтэрээр хүмүүсийг Мессиаг
ирэхэд бэлэн болгох юм. Тэр дарс,
согтууруулах ундаа ер хэрэглэхгүй
бөгөөд Елиагийн хүч, сүнсийг
ньхүлээн авна.

Таны хэлснийг үнэн гэдгийг би яаж мэдэх юм бэ? Эхнэр бид хоёр хоёулаа хүүхэдтэй болж чадахааргүй өтөлсөн улс. Тэгээд ч эхнэр мааньнасаараа л хүүсэр байсан.



Би бол Бурханы оршихуйд зогсож байдаг Габриел байна. Намайг чамд энэ зүйлсийг хэлүүлэхээр явуулсан юм. Чи тэмдэг хүсээ юу? Тэгвэл чи энэ бүхнийг биелэгдэх хүртэл юм ярьж чадахгүй болно.



Чи ярьдаг
болоод энэ тухай
хоорондоо ярилцах цаг
болоход би их баярлана
даа. Манайх ёстой чимээ
аниргүй байна. Чи ер нь
тэнгэр элч нартай тэгж
маргах хэрэггүй байсан
юм шүү дээ.

Захариа аа,
одоо ч итгэхэд бэрх байна аа.
Яг манай үндэстний эх Сараи шиг
Бурхан бидний залбирлыг сонсоод
намайг агуу эш үзүүлэгчийн эх
болгосон байна шүү дээ.

4,000 жилийн туршид эш үзүүлэгчид ирэх Мессиагийн талаар урьдаас зөгнөн хэлж байсан юм. 700 жилийн өмнө эш үзүүлэгч Исаиа ингэж хэлжээ: “Харагтун, онгон бүсгүй хүүхэдтэй болж хүү төрүүлэн түүнийгээ Иммануел буюу Бурхан бидэнтэй хамт гэж нэрлэнэ.”



Мариа Иосефтэй суухаар сүй тавьсан байлаа. Тэрээр ямар ч эр хүнтэй ойр дотно харилцаатай байгаагүй бөгөөд Мосегийн өгсөн хуулиудыг дуулгавартай дагадаг байв.

Гэнэт Мариад нэгэн
тэнгэр элч үзэгдэв!

Мариа, чи
Бурханы мэлмийд
тааллыг олжээ.
Чи хэвлийдээ
Бурханы Хүүг тээж
төрүүлнэ.

Би
ямар ч эр
хүнтэй ойртож
үзээгүй атал ийм
юм яаж байж
болох юм бэ?

Бурханы Ариун Сүнс
чамайг бүрхэнэ. Чиний хэвлийд
олдох тэр ариун ураг Бурханы Хүү
болох юм. Хүүсэр гэгддэг байсан
чиний үеэл Елизабет одоо хүүтэй
болсон. Одоо зургаан сартай
болж байна.




Би
Эзэний
шивэгчин билээ.
Өөрийнх
ньхүссэнээр
надад биелэгдэх
болтугай.

Би Бурханы Хүүгийн эх
болно. Иосеф надад итгэх
болов уу? Ойлгох болов уу?
Намайг жирэмсэн болсныг хараад
хүмүүс юу гэх бол оо? Аа нээрэн
Елизабет дээр очиж түүнтэй л
хамт байя даа.

A comic book illustration depicting the Visitation. On the left, a pregnant woman (Mary) stands in a blue robe and purple shawl, her hands clasped in prayer. On the right, another woman (Elizabeth) kneels in a similar blue and purple outfit, her hands raised in a gesture of awe or prayer. The background shows an interior setting with a wooden door and a window. Two speech bubbles contain text in Russian.

Елизабет!

Мариа, охин
минь!



Эмэгтэйчүүдийн дундаас ерөөлтэй ньчи мөн. Хэвлий дэх үр чинь ерөөлтэй еэ. Эзэний миньэх над дээр ирдэг би чинь хэн билээ? Мэндийн дууг чинь сонсонгуут хэвлий дэх үр минь баярлан тонгочиж байна.

Сэтгэл минь Эзэнийг дээдэлнэ. Сүнс миньч Аврагч Бурхандаа баясна. Энэ мөчөөс хойш бүх үеийнхэн намайг ерөөлтэйд тооцно. Учир ньхүчит Бурхан миний төлөө агуу үйлсийг хийсэн билээ.

Ядуу дорой биднийгээ Эзэн мааньдээш өргөжээ. Бурхан Эзэн маань Абрахам эцэгт маань амлахдаа л нигүүлсэл дотроо биднийгээ санажээ.

Мариа Елизабетийн хамт гурван сар орчим байжээ.


Елизабет
хүүгээ төрүүлэх
цаг болжээ.

Захариа хүү гарна
гэдэгт бүр эргэлзээхгүй
байна. Тэнгэр элч тэгж
хэлсэн гэнэ.

За за хүү
юм бол аавтай
ньадилхан Захариа
л гэж нэрлэх
байлгүй дээ.

Цаадах чинь
ирлээ. Өөрөөс
ньас ууя.





Тэнгэр элчид
итгээгүй болохоор
өөрийг нь хэлгүй
болгочихсон юм
гэнэ лээ.

Хүүдээ
хэн гэж нэр өгөх
гэж байгаа юм бэ?

Самбар
аваад ир
гэж байна.


Тэнгэр элч тэгж
тушаасан болохоор хүүгээ
Иохан гэж нэрлэнэ гэнэ ээ.

Удамд ньямар
ч Иохан гэдэг нэртэй
хүн байхгүй шүү дээ.



Үнэхээр хүү
гарсан шүү. Их
үсэрхэг хүүхэд
байна.






Эзэний хэлснээр
хүүгийн нэр бол Иохан. Энэ
хүүхэд манай израильүндэстэнд
Мессиаг танилцуулах болно.

Захариа
ярьж байна! Энэ олон
сарын дараа одоо л
ярьж байна!

Энэ чинь
чухамдаа нөгөө
ирнэ гэж эш
үзүүлэгдсэн Елиа
байж болох уу?

Энэ үеэр Иосеф Мариаг жирэмсэн болсныг мэджээ. Тэр хүүхэд өөрийнх ньбиш гэдгийг ч бас мэдэж байв.




Ээж ээ, би одоо ч итгэж чадахгүй байна. Мариагийн эргэн тойронд ямар ч эрхүн байгаагүй шүү дээ. Цаг үргэлж л гэрийнхнийхээ дунд байсан даа. Би тийм болгоогүй. Гэтэл гарцаагүй жирэмсэн болсон байгаа юм даа.




Ээ Иосеф
минь одоо
яах гэж
байна даа?

Би одоо түүнтэй
гэрлэхгүй ээ. Гэсэн ч бас
олонд мэдэгдмээргүй байна.
Түүнийг завхайрсан гээд чулуу
нүүлгэнэ шүү дээ. Зүгээр чив
чимээгүй л сүйгээ цуцалчихъя.



Эцгийг ньтэгээд
тэр өөрөө хэн гэж
байна?

Цаадах чинь
хүүхдийн эцгийг
Бурхан гээд байгаа
юм аа. Ямарчбодит
харилцаагүйгээр Ариун
Сүнсээр хэвлийг нь
үртэй болгосон гэж
яриад байгаа.



Юу гэнэ ээ.
Цаадах чинь
солиорчихоо
юу?

Мариа бас
хүүхдийг энэ
дэлхийн Аврагч
Бурханы Хүү
болно гэсэн.

Тийм хүүхэн ийм
юм ярина гэдэг чинь
Бурханыг доромжилсон
хэрэг. Би Мариагаас
альбо лох түрэгхэн,
сүр дуулиангүй холдох
хэрэгтэй байна.


Тэр үдэш Иосефыг унтаж
байхад нь тэнгэр элч үзэгдэв.



Давидын хүү Иосеф оо,
Мариаг эхнэрээ болгохоос бүү
эмээгтүн. Учир нь түүнд олдоод
байгаа нь Ариун Сүнснийх юм.
Түүнийг Хүү төрүүлэхэд чи
Түүнийг Есүс гэж нэрлэ. Учир
нь Тэр Өөрийн ард түмнийг
нүглээс нь аварна
гэж хэлэв.



Энэ бол
Исаиагийн эш үзүүлсэн
"Онгон бүсгүй хүүхэдтэй болж
Хүү төрүүлнэ. Тэгээд тэд
Түүнийг Иммануел орчуулбал
бидэнтэй хамт буй Бурхан
гэж нэрлэнэ" гэсэн
ньбилээ.




Мариа, чамд
итгэлгүй эргэлзэж
байсныг миньтөлөө
намайг уучлах уу?

Мэдэж байна аа. Энэ
бүхэн итгэхийн аргагүй
байгаа юм аа. Олон зууны
турш дахь, Израилийн олон
эмэгтэйчүүдийн дундаас Бурхан
намайг л сонгон Мессиаг
энэ дэлхийд мэндлүүлдэг
гайхмаар шүү!




Хүүхэд хэнтэй адилхан байх бол оо? Бурхан махан биеэр төрж байгаа юм болохоор төрөнгүүтээ л шууд ярьж эхлэх юм болов уу? Гарахдаа л уншиж чаддаг гарах байх даа?

Иосеф миньдээ, би яаж мэдэх вэ дээ. Бурхан л бүгдийг нь мэдэж байгаа. Хоёулаа зүгээр хүлээж л байхаас.




Чи бид хоёр
чинь хоёулаа
Давидын удмынх шүү
дээ. Эш үзүүлэгч нар
Мессиаг Давидын
удмаас гарна гэсэн
байдаг биз дээ.

Аа би бас өөр нэг юм саналаа.
Бурхан нээрээ Еден цэцэрлэгт эмэгтэйн үр могойн үрийн толгойг
няцална гэж амалсан шүү дээ. Одоо л ойлголоо! Энэ хүүхэд
чиньэрэгтэйн үр биш, зөвхөн эмэгтэйнх л юм байна шүү дээ. Хөөх!
Бурхан бүр эхнээсээ л энэ бүхнийг төлөвлөчихсөн юм байна.




Сонсогтун,
сонсогтун. Ромын эзэнт
хаан Цезарьөөрөө гарын
үсэг зурж гаргасан албан
тунхгийг сонсцгоо. Хүн амын
тооллого болох гэж байгаа
учраас Израилийн бүх хүн ард
төрсөн хотдоо очиж татвар
хураалтад бүртгүүлэгтүн.

Иосеф, Мариа нар
Галил аймгийн Назар
хотод амьдардаг
байлаа. Гэтэл хуучны
эш үзүүллэгт Мессиа
Иудейн Бетлехем
хотод төрнө гэсэн
байдаг юм (Мика
5:2). Төдөлгүй Мариа
хүүгээ буруу хотод
төрүүлэх болоод
байлаа. Тэд энэхүү эш
үзүүллэгийг мэдэхгүй
байсан бөгөөд тэгж
хол аялах шаардлага ч
байсангүй.




Иосеф оо, энэ
чиньтэгвэл чамайг
Бетлехем уруу яв гэсэн
үг байна шүү дээ. Чамайг
байхгүйд хүүхэд төрөх
ньдээ.

Намайг
байхгүй байвал хүмүүс
гайхах байлгүй дээ. Би
чамайг аваад явна аа.



Мариа, би
чамайг энэ хол
авч явдаггүй байжээ.
Ерөөсөө буцаад явсан
ндээр байх аа.


Үгүй ээ. Хүүхдийг
төрөхөд чи надтай цуг байх
ёстой. Чамаас өөр хэн ч
ойлгохгүй шүү дээ.

A man and a woman are walking through a rural landscape. The man is in the foreground, wearing a brown jacket and a red headscarf, leading a brown donkey. The woman is behind him, wearing a white and blue outfit and a red headscarf, carrying a large, round, woven basket on her back. The background shows a simple building and some trees.

Явжболжл
байвал бүгдээрээ
түргэлэхгүй бол
болохгүй нь. Хэзээ
язаагүй гарах ньшиг
байна.

Зуун жаран
километр газар
явахад долоохоног
гаруй явжээ.


Буудалд өрөө
олдох ньуу би
үзээд ирье.



Мариа, би эх
барихад туслах
хүн олчихлоо.

Буудалд
өрөө
алга уу?


Алга
аа, бүгд
дүүрчихжээ



Чи анхныхаа
хүүхдийг гаргаж
байгаа гэхэд ёстой
сайн байлаа шүү. Харин
малын хашаанд төрсөн
нъл жаахан тиймхэн
байна.

Тэрнийг
битгий тоо доо.
Нэг л өдөр хүү
мааньдэлхийг
захирах юм шүү
дээ!

Миний хувьд
танай хүүхэд жирийн л
нэг хүү харагдаж байна.




Юу?
Тэнгэр элч
байна шүү дээ!


Мянга
мянган тэнгэрлэг
дайчин!

Бүү айгтун.
Бүх хүмүүст дуулгах
сайн мэдээг та нарт
хэлүүлэхээр Бурхан
намайг илгээлээ. Өнөөдөр
Давидын хотод Иудейн
Мессиа Эзэн буюу Аврагч
та нарын төлөө төрлөө.

Дараах зүйл
та нарт тэмдэг
болог. Та нар
малын тэжээлийн
тэвшинд даавуунд
өлгийдүүлсэн нялх
хүүхэд хэвтэж
байхыг олно.



Дээд өндөрт
алдар нь Бурханд байх
болтугай! Бурхан хүмүүст
сайн сайхныг үйлдэхээр
энэ дэлхийд амар
тайвныг авчирлаа.



Саяын зүйлд итгэж чадаж байна уу? Тэнгэр элч нар бидэнд харагдлаа шүү дээ!

Эхнэртээ
хэлтэл
минь хүлээгээч!
минь хүлээгээч!

Чи
хэлэхийг нь
сонсоогүй юм уу?
Мессиа Израильд
төрчихөөд байна
шүү дээ

Би явж
хармаар байна.

Аврагч! Хүмүүст амар
тайвныг авчирлаа! Нялх
хөвгүүн гэнэ ээ? Явж
үзэцгээе!



Мессиа!

Та нарт төвөг
удсаныг минь хүлцэн
өршөөнө үү. Гэхдээ
тэнгэр элч бид нарыг
нааш ньирүүлс эн юм
аа.

Бурхан нялх
хөвгүүн болно
гэж хэн зүүдлэх вэ
дээ?

Мариа, Иосеф нар хуулийн дагуу шинэ төрсөн хүүхдийг тахилч нарт үзүүлж өргөл өргөх өдөр болсон байлаа.

Иосеф оо, хүү анх удаа Бурханы өргөөнд ирж байна. Есүсийг Христ гэж энд хэн ч мэдэхгүй шүү дээ.

Ер ньхэнд ч хэлэх хэрэггүй байх аа. Өөрийг ньөсөж том болохыг хүлээе.



Симеон
Бурханы өргөөн
дотор байлаа.

Тэр энд байна!
Бид чиньзөндөө
удаан хүлээсэн
юм шүү дээ.

Мариа
энэ хүн хэн
билээ?


Би мэдэхгүй.
Энд хэн ч биднийг
танихгүй шүү дээ.






Эзэн, Та Өөрийн үгийн дагуу
боол намайгаа амар тайван явуултугай.
Нүд миньч Таны авралыг харлаа. Та
үүнийг бүх ард түмний өмнө бэлтгэсэн
билээ. Энэ ньхарьүндэстнүүдэд илчлэлийн
гэрэл, Таны ард түмэн болох Израилийн
алдар ньболтой.

Гэхдээ та үүнийг
яаж мэдсэн юм бэ?




Намайг
сонс. Энэ хүүхэд
Израильд олныг босгож,
бас олныг унагана. Мөн
хүмүүс Түүний эсрэг
ярих болно.

Тийм ээ. Түүнд
тохиолдох явдлыг
хараад зүрх чинь эмтрэх
болно доо.



Хараач! Мессиа
байна! Өөрийнхөө
өргөөнд иржээ. Эш
үзүүлэгчдийн яриад
байсан Аврагч мөн
байна.

Энэ бол
Анна. Насаараа л
Аврагчийг ирнэ гэж
хүлээсэн хүн дээ.



Залуу миньэнэ, хүүхэд бол
дэлхийн Аврагч Христ юм шүү
дээ. Энэ хүүхэд Израилийг гэм
нүглээс ньаврах юм.


Тэр цагаас хойш Анна
золилтыг хүлээж байсан бүх
хүнд Түүний тухай ярьжээ.

Израилиас дорно зүгт орших улсуудад Бурханыг таньж мэдэхийн төлөө эртний бичээсүүдийг уншиж судалсан ухаант мэргэн хүмүүс байдаг байлаа. Тэд ирэх Мессиагийн тухай эш үзүүлэлгүүдийг мэддэг байв. Зүүд, үзэгдлээр дамжуулан Бурхан тэдэнд амлагдсан Нэгэн төрсөн болохыг илчлэн үзүүлжээ. Тэд израильүндэстний зүгт нэгэн онцгой од байхыг олж үзэв.



Бид зөндөө хол явчихлаа. Явж үзээгүй сонин газар байна. Олон долоо хоног явчихсан байна шүү:


Од зогсохгүй яваад л байх юм. Хэрхолявахнь вэ дагаад яваад л байхаас.



Херод хаантаан,
алс дорно зүгийн нэлээн чинээлэг
байрын гурван хүн ирчихээд байна.
Тэд хэлэхдээ Израилийн шинэ хаан
болох нялх хүүхдийг хайж явна
гэнэ ээ.

Тэр үед
израильчууд
Ромын хаант
улсын захиргаанд
байсан учраас
хаангүй байв.
Гэхдээ Ромоос
томилогдсон
Иудейн хаан Херод
Иерусалимд суудаг
байв. Мэргэн
хүмүүс шинэ төрсөн
хааны тухай асууж
сураглахын тулд
Херодыг хайжээ.

Нялх хүүхэд ээ? Хаан
гэв үү? Би хаан шүү дээ.
Нааш ньоруулаад ир. Тэгээд
бас ахлах тахилч, хуулийн
багш нарыг дуудаадах.



Та нар нялх
хааныг үзэхээр
ирсэн гэв үү? Та
нар тийм юм яаж
дуулж мэдээв?

Бид дорнодод
Түүний одыг харж
мөргөн хүндлэхээр
ирлээ.

Тэгээд
хаа байгаа
юм бэ?

Яг хаа
байгааг нь
мэдэхгүй байна.
Тэгээд л тан
дээр ирсэн
хэрэг.

Би эрдэмтэн мэргэдийг
цуглуулчихлаа. Тэд нар энэ
талаар юу мэдэж байна, очиж
уулзъя. Наашаа дотоод өрөөнд
ороод ирцгээ.




Энэ хүмүүс,
зон олны
авралын төлөө
ирэхээр зөгнөгдсөн
Иудейн хаанд
мөргөхөөр ирсэн
юм гэнэ. Та нарын
бичиг номд ийм
хааны тухай ямар
нэгэн юм хэлсэн
байдаг уу?

Тийм
ээ. Олон
эш үзүүлэгч
Түүний ирэх
талаар хэлсэн
байдаг. Гэхдээ
бид тиймэрхүү эш
үзүүллэгийг шууд
хүлээн авч итгэж
болохгүй
гэж боддог.

Та нарын
үзэл бодол
надад огт
хамаагүй. Харин
тэр эш үзүүллэгт
чухам юу гэж
байдаг ньл
чухал байна.


Тэгвэл эш
үзүүлэгч
Мика Мессиаг Иуда
овгийн Бетлехем
хотод төрнө гэсэн
байдаг юм даа.



Сонсогтун! Би ч бас
тэр хаанд мөргөмөөр
байна. Тэгэхээр та нар
хаа байгааг ньолонгуутаа
надад дуулгаарай.


Тэгэлгүй
яахав. Бид
олонгуутаа л танд
мэдэгдье.

Херод шинээр хаан төрснийг
дуулаад айж байсан учраас хүүхдийг
олонгуутаа хороохыг хүссэн ажээ.



Израилийн эш
үзүүлэгчдийн бичсэн ньбусдынхаас
ёстой ондоо юм аа. Тийм нарийн
тодорхой хэлсэн юмыг би урьд ер
үзэж байгаагүй юм байна.


Хуулийн багш
нар хүүхдийг хаана
төрөхийг тодорхой
мэдэж байдаг ёстой
сонин юм шүү.
Гэхдээ тэд өөрсдийн
эш үзүүлэгчдийн
үгийг хайхрахгүй
байх юм даа.



Хараач!
Зүүнтэйд
харагдаад байсан
нөгөө од байна
шүү дээ!

Энэ урьд
өмнө ер үзэж
байгаагүй онцгой
од шүү. Бусад
одтой адил алга
болохгүй, бас


Байгаа
байршлыг нь тэмдэглээд
авчих. Маргааш гурвуулаа
дагаад явъя.



Тэнд тэр байшингийн
дээр тогтчихлоо. Гэхдээ
энэ чиньбетлехем биш шүү
дээ! Зөндөө олон хоног
өнгөрчихсөн болохоор тэд
нүүчихсэн байх.

Нээрээ л
хачин од шүү.
Ер ньүүлэнд
ойрхон байгаа
байх шүү.


Олон ч
хоног явлаа одоо
ч бараг ирчих шиг
боллоо.



Бид та нарт төвөг болох гээгүй юм аа. Гэхдээ бид олон хоног явж энд ирлээ. Бид шинэ төрсөн хаанд мөргөн, хүндлэл үзүүлэх гэсэн юм.


Та нар яаж мэдээ вэ?

Бүх хүний төлөө бичигдсэн ариун бичээсийг бид нар уншсан юм аа. Танай эш үзүүлэгчид Түүний ирэхийг урьдаас хэлсэн байсан. Тэгтэл бас нэг од үзэгдэж, биднийг дагуулсаар энд авчирлаа. Тэр од одоо ч танай байшингийн дээр тогтсон байгаа.



Бид энэ
хорвоогийн Аврагчийг
хүндэтгэн даруу сэтгэлээр
өчүүхэн бэлэг авчирлаа.
Энэ Аврагч олныг зөвтгөл
уруу эргүүлэх юм.

Тэр шөнө Бурхан
мэргэн хүмүүстэй
зүүдэнд ньярьж хүүхэд
хаа байгааг Херодод
хэлэхгүй байхыг
анхааруулаад өөр
замаар яв хэмээжээ.
Түүнчлэн Бурхан
Иосефтой ярин Херод
хүүхдийг алахаар
хайх тул хүүгээ аваад
Египет уруу зугт гэж
хэлсэн байлаа.




Дорно зүгийн тэр
хүмүүс намайг хуурчихлаа.
Тэд өөр замаар буцсан байна.
Тэд хүүхдийг олсон учраас
энэ замаар явахаасаа
эмээсэн хэрэг.

Бетлехем уруу
цэргийн тусгай анги илгээж
хоёр нас хүрээгүй бүстэй
хүүхэд бүрийг алахыг тушаа.


Бетлехемийн энэ гашуудалтай
явдлын тухай олон жилийн
өмнө эш үзүүлэгчид
урьдчилан хэлсэн байжээ.





Иосеф, Мариа хоёр хүүхдийг
аваад Египет уруу явжээ. Мэргэн
хүмүүсийн өгсөн бэлэг тэдний аян
замын зардлыг хангаж, бас хоёр
жил тэнд амьдрахад тусалжээ.

Херодыг нас барсны дараа Есүсийг хоёр нас
хүрэхэд нь Бурхан тэднийг Израильуруу буцахыг
тушаав. Энэ ч бас "Би Хүүгээ Египетээс дуудав"
гэсэн Библийн эш үзүүллэгийн биелэлт болсон юм.



Тэднийг Египетээс буцан
ирэхэд ньт энгэр элч,
Иосефт нэгэн жижиг хот
болох Назарт очиж суугтун
гэж хэлжээ.

Энэ ч бас
Түүнийг
Назарынх гэж
нэрлэнэ гэсэн
эш үзүүллэгийн
биелэлт байлаа.

Миний таван
залуу өдөржингөө
ажиллах гэж
байна уу? Нааш ир,
хоолоо идэцгээ.

Есүс өөрийн эцэг
гэгдэх Иосефын
хамт мужааны ажил
хийдэг байлаа. Тэр
бие, сүнсээр өсөж
ухаантай нэгэн
болжээ.




Есүсийг арван хоёр настай байхад нь Иосеф гэрийнхнээ аваад Дээгүүр өнгөрөх баярыг тэмдэглэхээр Иерусалим уруу явжээ. Тэд нүглийн өргөлд зориулах хургаа бас авч явсан юм.

Есүс чи хургыг тахилчид аваачиж өг. Маргаашийн тахилаас өмнө тэд хургыг батлах ёстой юм. Бид нар хаа нэгтээ хоноглох газраа хайя.

Аав аа, би бас Есүстэй цуг Бурханы өргөө уруу явъя.

Өргөлөөс хэд хоногийн дараа.



Иосеф оо, би
Есүсийг эрээд эрээд
хаанаас ч олдоггүй.
Өнөөдөр тэрнийг хэн
ч хараагүй байна.

Бид нар
Иерусалимд л
орхисон байж таарах
ндээ.

Бид нарыг явах
гэж байсныг мэдсэн
л юм даа. Тэгээд л би
хамаатнуудын хэн нэгэнтэй
ньяваа юм байх гэж бодож
байсан юм.

Одоо буцаж яваад
олж ирэхгүй бол
болохгүй шүү.


Эш

үзүүлэгчид
Мессиаг Давидын
хүү гэдэг болохоор
та нар бүгдээрээ
зөвшөөрч байгаа
биз дээ? Давид бас
Мессиаг өөрийнхөө
Бурхан гэж үзэж
байсан учраас Эзэн
гэдэг байсныг
хүлээн зөвшөөрдөг
тийм үү? Тэгвэл
Мессиа Давидын хүү
мөртлөө яаж бас
Эзэн нь байж чадах
вэ? Хэрэв ...



Чи тийн
тайлбарлахдаа
болгоомжтой байхгүй
бол дүгнэлт нь Бурханыг
доромжилсон болж
магадгүй шүү.

Чи тэгэхээр өөрийнхөө
тайлбарыг зөв гэх гээд
байна уу? Ахлагч нар иймэрхүү
гүнзгий агуулгатай үнэнийг
илүү ойлгож мэдэхээр сурч
боловсорсон улс шүү.



Бичээс
нэг бол үнэн,
эсвэл худлаа. Бид
зөвхөн уламжлал,
ёсонд таарсанд
ньитгэх хэрэгтэй
болж байна уу?

Өө, тэр
энд
байна.

Ер ньүнэн
гүнзгий байна гэж
байх уу? Бичээс бидэнд
ойлгохоор өгөгдөөгүй
гэж үү?

Гэхдээ бүхнийг
яг байгаагаар ньойлгож
болохгүй. Талмудад ингэж
хэлсэн байдаг...




Есүс чамайг
бид хаа сайгүй
хайлаа. Чи яагаад
ингэж байгаа юм
бэ?

Энэ хүүхэд бид нартай
бараг хоёр хонож байна. Танай
хүү чиньэгэл биш хүүхэд
байна шүү.



Юунд та нар
намайг хаа сайгүй
хайгаа вэ? Аавынхаа
ажлыг хийж байх
ёстойг миньта нар
мэддэггүй юм уу?




Бичээсийг
ингэж сайн мэддэг ийм
бага хүүхдийг ер үзэж
байгаагүй юм байна.

"Аавынхаа
ажлыг хийх ёстой"
гэдэг чинь юу гэсэн үг
вэ? Хайгаад яваа хүн
аав ньбиш юм уу?

Есүс эцэг эхээ даган явж, тэднийхээ захиргаан дор байлаа. Тэрээр цааш мужааны ажлаа хийсээр байсан бөгөөд улам ухаажсаар эрийн цээнд хүрч байв.



Есүс үргэлж шударга зөв амьдарч, бусдын сайн сайхны төлөө явдаг байсан болохоор хүн болгоны тааллыг олж байлаа.




Бусад залуучууд гэм нүгэлд
унан алдаж байхад Есүс л
зүрх сэтгэлээсээ Бурханы
тушаалуудыг сахин
биелүүлж байсан юм.

Чи үргэлж
шударга байдаг
болохоор энэ Назарт
чамаас дээр мужаан алга.
Дахиад яг энэн шиг
зургаан ширхгийг
авъя.



Тэнгэрийн хаанчлал
ойрхон байгаа учраас та нар
бузар муугаа орхиж
Бурханыг дагагтун. Хэрвээ та
нар Мессиаг хүлээн авахаар
зүрх сэтгэлээ бэлтгэвэл би та
нарыг усаар баптисм
хүртээе.

Мариагаас зургаан
сарын өмнө Елизабет
хүү төрүүлснийг
санаж байна
уу? Хүмүүсийн
зүрх сэтгэлийг
Мессиагийн ирэхэд
бэлтгэх байсан учраас
Захариаг хүүдээ
Иохан гэдэг нэр
өгөөрэй гэж тэнгэр
элч хэлжээ. Энэ ч бас
таван зуугаад жилийн
өмнөөс хэд хэдэн эш
үзүүлэгчдээр зөгнөн
хэлэгдсэн байлаа.




Миний араас
ирэх Нэгэн надаас
илүү эрхэм билээ. Тэр
бол надаас урьд оршин
байсан юм. Тэр та нарыг
усаар биш харин Бурханы
өөрийнх нь Ариун Сүнсээр
баптисм хүртээх юм.
Оройтохоосоо өмнө
гэм нүглээсээ
салагтун.

Иохан оо бид
тэгээд юу хийх ёстой вэ?
Бурхан биднийг шударга
зөв байлгахын тулд юу
хүсдэг юм бэ?



Хэрэв чи хоёр
дээлтэй байгаад нэг ч
дээлгүй хүнтэй тааралдвал
нэг дээлээ түүнд өг. Чи
хоолтой байвал хоосон
нэгнийг хоолло.

Бүх хүний төлөө
шударга зөвийг
хайгтун.



Иохан, засаг төрд ажилладаг бид Бурханд таалагдахын тулд яах ёстой вэ? Би татварын байцаагч, харин энэ Набал бол гаалийн ажилтан л даа.

Хээл хахуульбүү авцгаа. Албан ажлаараа дамжуулан хэнээс ч хэрээс нь хэтэрсэн мөнгө төлбөр бүү шаард. Хийж буй бүх ажилдаа шударга, зөв хандагтун.

Би танай хүмүүсийн
нэг ч биш, бас танай
шашинтан ч биш. Гэхдээ би
бас Бурханд таашаагдмаар
байна. Би яах ёстой вэ?



Өөрийнхөө удирдлаган
дор захирагдагсдад бүү харгис
ширүүн ханд. Өөрийнхөө байр
суурийг ашиглан бусдаас эд хөрөнгө,
мөнгө төгрөг бүү ав, бас бүү хулгайл.
Өөртөө байгаад л сэтгэл хангалуун
амьдарч сур.



Миний араас
ирэгч ньнадаас
илүү эрхэм бөгөөд
би Түүний шаахайн
сурыг ч тайлах
зохисгүй билээ.
Хэрэв та нар гэмшиж
итгэвэл Тэр та нарт
Ариун Сүнсээр
баптисм хүртээнэ.

Хэрэв

та нар Түүнийг үл
тоомсорлож гэм нүгэл
дотроо амьдарвал Тэр
та нарыг мөнхийн
тамын гал уруу унагаах
болно. Одоо гэм нүгэл
үйлдэхээ больцгоо.




Би Мессиа биш ээ.

Мессиаг зарлан тунхаглаж байдаг чи хэн гээч вэ? Чи өөрийгөө хэн гэж хэлэх вэ?

Үгүй ээ. Харин Исаиагийн "Би бол Мессиагийн замыг бэлтгэж цөлд хашхирах нэгний дуу байна" гэж хэлсэн нь юм.


Чи Мосегийн яриад байсан, хүмүүсийг Бурхан уруу буцаан дагуулахаар ирэх тэр эш үзүүлэгч мөн үү?



Тэгвэл чи яагаад
манай шашны эрх мэдэлтнүүдийн
зөвшөөрөлгүйгээр энэ хүмүүст
баптисм хүртээгээд байдаг билээ?

Та нар бардам, сэхүүн
байдлынхаа гэм нүглийг авч
хаях хэрэгтэй. Моддын үндсэнд
сүх хэдийнээ зоогджээ. Хэрвээ
та нар зүрх сэтгэлээ өөрчлөхгүй
бол цавчигдан тамын галд
хаягдана шүү.

Би бол зөвхөн
Мессиагийн замыг
бэлтгэгч зарлага, харин
та нар бол хорт могойн
удам. Та нар иудейчүүд,
Абрахамын удам учраас
өөрсдийгөө Бурханы
хүүхдүүд гэж бодоод
байна уу?



Иохан, чи сая Мессиа
удахгүй ирнэ гэж хэллээ.
Хэзээ ирэхийг ньчи яаж
мэддэг юм бэ?

Бурханы элч надад
Эзэний Ариун Сүнс дээрээс
нь тагтаа мэт бууж ирэх нэгэн
бол Израилийн Мессиа буюу
дэлхийн Аврагч мөн гэж
хэлсэн юм.


Энэ цаг ирэхийг
ээж ньм эдэж байсан юм аа.
Тэнгэр элч Габриел намайг их
уй гашуу амсана гэсэн. Аав чинь,
гүй ээ дүү нарын чинь эцэг амьд
сэрүүн байж энэ бүхнийг үзсэн
болоосой гэж бодох юм.

Чи юу хийх
вэ, яаж эхлэх вэ?
Эхлээд Бурханы
өргөө уруу очих
үү?

Иохан хүмүүст заан сургаж эхэлснээс
хойш зургаан сар өнгөрөөд байлаа.
Есүс тэр үед гучин настай байв.



Би юу ч мэдэхгүй ээ.
Эцэг миньнадад мэдүүлнэ. Ямар
ч байсан эхлээд би Иохан уруу очиж
түүгээр баптисм хүртээлгүүлнэ.
Иохан олон хүнийг дахин
төрөлтөд бэлтгэсэн байгаа.



Чи над дээр
эргэж ирэх
үү?

Тэгэлгүй яахав дээ,
ээж минь. Би таныг яалаа
гэж орхих юм бэ. Гэхдээ л та
тууштай байх хэрэгтэй шүү.
Надад тохиолдох зүйлс танд
тийм амар байхгүй ээ.

Мессиаг ирэхэд бэлтгэгтүн.

Эцгүүд ээ та нар зүрх сэтгэлээ хүүхдүүд рүүгээ эргүүлэгтүн. Та нар ухаалаг байж, Бурханы хуулиудыг хүүхдүүддээ зааж сургахад хамаг хүч, цаг заваа зориул. Хичээл зүтгэлийг чиньхараад дуулгаваргүй зөрүүд хүүхдүүд чинь зүрх сэтгэлээ та нар уруу эргүүлж, танай гэр бүлүүд эдгээгдэх юм.



Мессиаг ирэхэд итгэн дагах зүрх сэтгэлийг та нар агуулж байгаа бол наашаа ирж гэмшлийн усан баптисм хийлгэгтүн. Харин Тэр ирээд та нарын гэм нүглийг уучилна.

Иохан надад
усан баптисм
хүртээнэ үү?

Та өөрөө надад
баптисм хүртээх нь
илүү зохилтой. Та бол
жинхэнэ зөв шударга
хүн.



Иохан, Би
Бурханы хуулиудыг
дагах ёстой. Эцэг
миньӨөрийнхөө
хүмүүст тушаасныг Би
бас хийх болно.








Тагтаа!
Би тэр
тагтааг харж
байна!




Та Мессиа
байна! Би яагаад
мэддэгүй байна
аа.



Энэ бол
Миний таалан
соёрхдог хайртай
Хүү минь.

Энэ бол бүх
дэлхийн гэм нүглийг
авч хаях Бурханы Хурга
байна.



Бурханы
Ариун
Нэгэн!

Христ!

Тэр
ирчихсэн
байна!

Хаанчлалаа
ТОГТООНО
доо!




Цаг нь болохоор тэгнэ. Харин одоо сорилтыг давах хэрэгтэй.

Тэр хаашаа явж байгаа юм бэ? Улс үндэстнээ одоо чөлөөлнө биз дээ?

Ямар сорилт?

Адам ба түүний бүх үр удмын унасан сорилт байгаа юм аа. Есүс харанхуйн жононтой уулзах ёстой юм.



Эцэг нь Хүү Есүстээ дөчин өдөр мацаг баригтун гэж хэлжээ. Тэр хугацаанд Есүс ямар ч төрлийн хоол, хүнс идээгүй юм. Бие махбод нь сулран доройтох тусам Сатан өлсөх хүслийг нь дагуулан Түүнийг Эцэгээс ньурвуулахыг оролдож байв.

Анхны хүн Адам Бурханд дуулгаваргүй хандаж өөрийнхөө байр суурийг алдсан юм. Есүс мөнхөд Бурхан байсан бөгөөд одоо харин махан биетэй хүн болон иржээ. Бусад бүх хүний алдсан тэрхүү уруу татлага сорилтыг Есүс давах болов уу?


Дөчин өдөр мацаг барьсны эцэст Есүс маш их өлсөж ядарсан байлаа. Бие махбод ньөөрөө өөрөөсөө хороотлоо өлсөж ядрахад, ядуу зүдүү идэх хоолгүй байхын зовлонг мэдэрч байсан юм. Мөн Есүс ганцаардан хаягдаж, өвчтэй зовлонтой байхын хэцүүг ч бас амсаж туулжээ.



Олон өдрийн турш Сатан Есүсийн бодол санаа уруу дайрч эргэлзээ, айдас төрүүлэхийг оролдож байв. Сорилт дуусах дөхөж Есүс эцсийн цэгтээ тултлаа эцэж ядарсныг Сатан мэдэж байсан болохоор хийдэггүй мэхээсээ хийж өөрийн биеэр хүртэл үзэгдэв.




Чи
Бурханы Хүү
юм чинь юм
идэх эрх Чамд
бий шүү дээ.




Сатан анхны хүн Адамыг уруу татаж хориотой зүйлийг идүүлсэн юм. Тэр одоо ч бас өлсөж, ядарсан Хүний Хүүг адил зүйлээр уруу татахыг оролдож байна.

Дөчин өдөр юу ч идэж уугаагүй хүний хувьд энэ бол үнэхээр том сорилт байсан юм.


A hand in a dark, flowing sleeve holds a glowing, reddish-brown stone. The background is a bright yellow, suggesting a sunset or sunrise. The hand is positioned in the center-right of the frame, with the stone held between the thumb and index finger. The stone has a textured, crystalline appearance. The overall style is that of a comic book illustration.

За энэ дээ,
энэ чулууг Чи
талх болгоод
хоосон ходоодоо
баярлуулж болно
шүү дээ.



Үгүй ээ, Би тэгэхгүй.
Бичээст хүн зөвхөн талхаар
бус, харин Бурханы амнаас гарах
үг бүрээр амьдарна гэж бичсэн
байдаг.

Тэгвэл нааш ир.
Би чамайг Бурханыг
дагаж болох газар уруу
аваачъя.



Бичээст бас
"Өөрийн Бурхан
Эзэнээ бүү сорь" гэж
бичсэн байдаг юм.

Хэрэв Чи эндээс үсэрвэл
тэнгэр элч нар хүрч ирээд Чамайг
бариад авна. Тэгвэл хүмүүс бүгдээрээ
Чамайг харж Мессиа хэмээн хүлээн
авна даа. Би ч мэдэж байна. Чи тэгэх
л гэж ирээ биз дээ

Чи өөрөө
Бичээсийг дурдлаа. Бичээст
тэнгэр элч нар Чамайг хөлөө чулуунд
цохиулахаас хамгаалан гар дээрээ
өргөн авч явна гэж хэлсэн байдаг.
Тэгвэл одоо тэдэнд хүч чадлаа
харуулах цаг болсон юм биш үү?



Чи дэлхийг
хайрлан түүнийг аврахаар
ирсэн болохоор одоо миний
үзүүлэх гэж байгаа юм яг Чамд
таалагдана.



За эндээс дэлхийн хамгийн дээд хаанчлалуудыг харж болно. Эд үнэхээр сүр жавхлантай байгаа биз? Адам захиргаанаас чиньгарснаас хойш би энэ дэлхийг захирах болсон билээ. Хүмүүс тэр эрхийг надад дахин дахин өгөөд байдаг юм даа. Эд бүгд минийх. Чи биш би энэ дэлхийн эзэн байгаа юм.

Гэхдээ... ганцхан болзолтойгоор бүгдийг нь чамд өгч болно шүү. Чи ганцхан удаа сөгдөж надад мөргөвөл би энэ дэлхийг захирах эрхээ өгч Чи үүнийг дотор ньбайгаа бүх хүнтэй ньхамт авч болно. За юу гэж бодож байна?



Бичээст

“Чи өөрийн Бурхан
Иавэдаа мөргөж,
зөвхөн Түүнд үйлчил”
гэж бичсэн байдаг юм.
Чи дийлсэнгүй. Одоо
эндээс зайл.

Сатан Христийн оршихуйгаас зугтан зайллаа.
Хүн төрөлхтний түүхэнд анх удаагаа л
Сатаны хуурч чадахгүй ганц хүн байсан юм.
Есүс сорилтыг амжилттай давжээ. Бурханы
бүрэн захиргаанд байж чадах ганцхан хүн л
одоо дэлхий ертөнц дээр байсан ньэнэ билээ.

Дөчин өдрийн
зовлон дууссан
хэдий ч Есүс цааш
явах тэнхээгүй
болсон байлаа.






Тэнгэр элч нар хоол, хүнс авчран Түүнд үйлчлэв. Бие нь тэнхрэн сэргэнгүүт Есүс Иоханы зааж сургаж байсан газар уруу буцан явжээ.



Есдүгээр
бүлэг

АНХНЫ ҮЙЛЧЛЭЛ




Харагтун,
бүх дэлхийн гэм
нүглийг авч хаях
Бурханы Хурга
ирж явна.

Энэ
Мессиа
байна!

Эш
үзүүлэгч
нарын яриад
байсан мөн
байна.


Тэр юу хийх
юм бэ?



Эзэн минь
ээ би таныг
орхихгүй ээ.


Есүсийг
дага.

Би чиний эзэн биш.
Би юу ч үгүй болтлоо доошлох ёстой, харин
Тэр бүх зүйл болон өсөх ёстой юм. Тэр үнэхээр
энэ дэлхийн Аврагч Мессиа шүү. Түүнийг л дага.



Эзэн, бид Таныг дагаж
таны шавь нар болъё. Та
хаана сууж байгаа вэ?

Наашаа
ирээд үз.



Филип ээ,
намайг дага.

Эзээн. Бид таныг
хүлээж байлаа. Гэхдээ
эхлээд би Натанаелыг
олох хэрэгтэй байна.


Тэр ч бас
Бурханы хуулиудыг
сахиж, Мессиаг
хүлээж байсан юм.



Натанаел хаа
байна?

Тэр талбай
дээр байгаа.
Яасан буруу юм
болоогүй биз?

Үгүй ээ, бүх
юм зүгээр.




Натанаел
аа чи хаана
байна аа?

Энд
байна аа
ах минь.


Натанаел аа, эш
үзүүлэгчид, Мосе нарын
яриад бичээд байсан
Түүнийг бид олсон шүү
дээ. Тэр бол Иосефын
хүү, Назарын Есүс.

Мессиа гэнэ ээ?

Чи тэгээд Өөртэй нь ярьсан юм уу? Гэхдээ Назарынх гэсэн үү? Назараас сайн юм ер гарч байгаагүй биз дээ. Мессиа яаж тийм хоцрогдсон, ядуу хоосон газраас ирдэг юм бэ? Тэр чинь Иудагийн Бетлехемд төрөх ёстой шүү дээ.



Чи өөрөө очоод уулз л даа. Иохан шалгаж үзсэн байна билээ. Андрей ч бас цуг байгаа.



Үнэхээр л цэвэр
сэтгэлтэй израиль хүн
байна даа.

Филип ээ
чи миний тухай
ямар нэгэн юм
ярьсан юм уу?


Юу ч
яриагүй
ээ.

Та намайг мэдэхгүй шүү дээ. Тэгээд яаж намайг цэвэр сэтгэлтэй гэж хэлж байна?

Филип чамайг дуудахаас өмнө чамайг тэр инжрийн модны дор сууж байхад чинь би харсан юмаа.

Та яаж намайг харсан юм бэ? Намайг хаана байсныг хэн ч мэдээгүй шүү дээ.





Та бол
үнэхээр Бурханы
Хүү, Израилийн
Хаан мөн байна.

Энэ чамайг гайхшируулав
уу? Чи үүнээс илүү олон
гайхамшгийг үзэх болно. Тэнгэрийн
хаалга нээгдэн тэнгэр элч нар миний
дээр өгсөж, уруудан байхыг чи харна.
Явцгаая, бидэнд хийх юм их байна.

Андрей бас Есүсийн тухай
ахдаа хэлэхээр явжээ.



Симон оо, бид нар
Иоханы яриад байсан
Мессиаг олчихлоо.

Нааш
ирээд хар.

Хэзээ? Хаана?
Ямар харагдаж байна? Өөр
хүмүүс дагаж байна уу?

Ионнагийн хүү
Симон оо, чи Петр гэж
дуудагдах болно.

Би завиа
гэрийнхэндээ
өгчихөөд таныг
дагая.





Удалгүй Есүс өөрийгөө дагаж, сургаалийг нь сонсож байсан авран хоёр хүнийг сонгов. Энэ хүмүүс Есүсийн арван хоёр дагалдагч гэж хэлэгдэх болсон юм. Тэд хот тосгод дамжин, хаанчлалын Сайн мэдээг тунхаглаж явлаа.



Есүс дагалдагчдынхаа хамт Сүмд залбирахаар очтол юм зарж байгаа хүмүүсээр дүүрсэн байлаа.

Сүмд мөнгөө өгөхөөс өмнө яахаараа би задлуулдаг байна аа. Чамайг харахад чи ч овоо ашиг олж байгаа хүн байна шүү.

Тахилч нар бүр завхарч гүйцжээ. Сүмд зарагдсан юм болгоноос өөрсдөдөө ашиг авдаг болсон байна.


Тахилч нар үүнийг зөвшөөрсөн юм шүү.





Юу хийгээд
байгаа юм бол оо? Тэр
байгаа газраа бараг цаг
шахам зогсоод юу ч
ярихгүй олсоор л нэг юм
сүлжээд байх юм.

Өнөөдөр ч овоо
орлого олчихлоо шүү.
Амьдрах гэж ажил хийж
байснаас хамаагүй ашигтай
байгаа юм даа.




Ташуур! Тэр
ташуур хийж байгаа
юм байна!




Миний Эцэгийн гэр
залбирлын өргөө байх
ёстой байтал та нар үүнийг
дээрэмчдийн үүр болгож
байна. Бүгдийг нь хуу
хамаад гарга. Яг одоо!

Тэрний эцгийн
гэр гэв үү! Өөрийгөө одоо
хэн гэж бодоод байна аа?
Мессиа юм уу?



Миний
Эцэгийн гэрийг
наймааны газар
болгохоо зогсоо.
Та нар бол
хулгайч нар.

ТАР НЯР!



Та нар хорт
могойн удмууд. Та
нар үгээгүй бэлэвсэн
эмэгтэйчүүдийг
хоосруулагчид.

Энэ
одоо хэн
юм бэ?

ӨөӨө ёоёо
ёо! ёо!

Tac!



ТАР НЯР! ТҮН ТАН!


Чи удаан
залбирч байгаа
дүр үзүүлдэг.

ТАС НЯС!

Та нар
айл хөршийнхнөө
хайрладаггүй харин
тэдний эд мөнгөнд
л дурладаг.




Дараагийн удаа
та нарын сүмд ирэх
чинь нүглээ илчилж
гэмшихийн тулд байх
болтугай.



Та нар
Мессиагийн тухай
Давидын хэлсэн
үгийг санаж байна
уу?

Бичээч нар
заахдаа Мессиа гэнэт
өөрийнхөө сүмд ирнэ гэж
байсныг чи санаж байгаа
биз дээ.

Харин
тийм ээ. "Таны
өргөөний төлөөх
хичээл зүтгэл
намайг эзэмдэж
байна, учир нь
тэд Таны үгийг
мартжээ"



Чи тэгэхээр Иоханы
яриад байдаг Назарын Есүс
юм биз дээ. Чи өнөөдөр бидэнд
ёстой их гай тарилаа даа. Чи
өнөөдөр бидэнд ямар тэмдэг
үзүүлэх юм бэ?

Намайг Мессиа
гэсэн баталгааг
та нар энэ сүмийг
нураахад харна.
Гурван өдрийн дотор
би үүнийг дахин
босгох юм.



Есүс сүм гэж өөрийнхөө биеийн тухай ярьсан боловч тэдэнд ойлгуулахгүйн тулд тайлбарлаж өгөөгүй ажээ.

Энэ сүмийг барихад 46 жил орсон юм. Гэтэл чи гурван өдрийн дотор барьчихна гэж бодоод байгаа юм уу? Тийм юм яаж байдаг юм бэ!

Чамайг дахиад ирдэг юм бол баривчлуулна шүү.

Есүс дагалдагч нарынхаа хамт Иерусалимаас гарч өөрийнхөө төрсөн нутаг Назарт иржээ.



Еэ ашгүй,
Есүс гэртээ ирлээ. Найз
нөхдөө бүгдийг нь аваад
ир. Би та нарт сайхан хоол
хийгээдэхье.

Ээж ээ,
бид нар энд нэг
их удахгүй ээ
Саббат өнгөртөл
л байх юм.

Манай хүн өөрийнхөө найзуудыг дагуулаад ирсэн байгаа учраас бид их баяртай байна. Тэдний тухай хачин сонин юм дуулаад байгаа билээ. Тэр тухай дараа илүү тодорхой сонсмоор байна.

Харин одоо Есүс чи өнөөдөр Бичээсээс унших хүндтэй үүргийг хүлээж байна.


Саббат өдөр Иудейн шашин мөргөлийн газар болсон синагогт очих нь Есүсийн заншил байсан тул тийш очжээ.



Есүс Исаиа номоос
Мессиагийн талаар
маш тодорхой хэлсэн
эш үзүүлэгийг уншив.



"Эзэний Сүнс Над дээр байна.
Учир нь сайн мэдээг ядууст дэлгэрүүл
гэж Тэр Намайг тосолсон юм. Тэр Намайг
илгээсэн нь олзлогдогсдод эрх чөлөөг
тунхаглах, сохруудад хараа оруулах,
дарамтанд байгсдыг чөлөөлөхийн сацуу
Эзэний тааламжит жилийг тунхаглахын
тулд болой."

A comic book panel featuring a man with a dark beard and a golden earring. He is looking intently at a large, blank scroll that occupies the lower half of the frame. His hands are visible, holding the scroll. A speech bubble is positioned to the left of the man's face, containing text in Mongolian. The background is a simple, light-colored wall.

Өнөөдөр энэ
эш үзүүллэг
биелэгджээ.

Доромжилж байна!

Чи зүгээр л
мужааны хүү
биз дээ.

За тайвширцгаа.
Бид одоо явлаа.

Түүнийг
чулуугаар
нүүлгэж ал.
Тэр өөрийгөө
Мессиа болгож
байна!




Есүс дагалдагчдынхаа хамт тэдний заримынх нь амьдардаг байсан, Галил нуурын дэргэдэх Капернаум хотод ирэв. Тэнд ч бас тэд синагогт явж орлоо.



Нэгэн эш үзүүлэгч Мессиа харь үндэстнүүдэд гэрэл болж, тэд ч түүнд итгэж найдна гэж хэлжээ. Сэтгэл зүрх нь цэвэр хүн жаргалтай юм, учир нь тэр хүн Бурханыг харах болно. Иудей, харь хүн хэн байх нь хамаагүй Бурхан өөр уруугаа ирэх хэнийг ч Өөрөөсөө түлхэхгүй.




Ариун
Нэгээн! Биднийг
зүгээр орхиоч!



Би таныг хэн
болохыг мэднэ.
Та бол Бурханы
Ариун Нэгэн.

Наадах чинь
муу сүнсэнд
эзэмдүүлсэн хүн.
Наадхаа эндээс
гарга.



Та биднийг
цагаас маань өмнө
хөнөөхөөр ирээ юу?
Биднийг зүгээр
орхиоч. Бид танд юу
хийсэн юм бэ?

Хэн энийг энд
оруулсан юм бэ?
Хараарай! Наадах
чинь аюултай
шүү.



Муу сүнснүүд ээ,
наад хүнээ дахин
тарчлаахаа больж
түүнээс гар гэж би
тушааж байна!



Чи наадхаа
яачихав аа?

Үхчихсэн
үү?

Мөнөөх хүн гэнэт хөл дээрээ босон зогсов.

Бурханыг
магтъя!

Муу
сүнснүүд зайлсан
байна. Одоо чи
чөлөөлөгдсөн. Замаараа
яв даа. Нүгэл дахин бүү
үйлдэгтүн.

Есүс муу сүнснүүдийг
захирах бүрэн эрхтэй юм
байна. Нөгөө хүн чинь зүгээр
болчихлоо.



Бид нар
одоо очлоо.

Петр гуай,
эхнэр
тань таныг гэртээ
хүрээд ир гэж
байна. Ээж нь
халуураад их
өвчтэй байгаа
гэнэ.



Өө Петр минь.
Халуун нь улам
ихсээд би бүр
айчихаад байж
байна.

Битгий ай.
Эзэн энд
байна.



Эгч минь
одоо бос доо
Өвчин чинь
арилчихлаа.



Ээж
босоод ирлээ
Эдгэрчихсэн
байна!

Өвчтэй байсан эмэгтэй
босоод, Есүс ба
түүний дагалдагч нарт
үйлчилж эхэлжээ.

Есүсийн эдгээсэн
тухай яриа тарж,
хүмүүс Есүс уруу
өвчтэй олон
хүнийг авчрав.


Эзээн, манай
аав намайг хүүхэд
байхаас л хөдөлгөөнгүй
болсон юм. Нуруун дээр нь
дүнз унаад гэмтчихсэн юм
аа. Хэрвээ та хийж чадах
юм бол туслаач дээ.

Босоод алх.





Бурханд
алдрыг
өргөө!




Би явж чадаж
байна! Ямар
гайхамшигтай
юм бэ!

Эзээн, охин
маань төрөхдөө л
хараагүй төрсөн
юм. Та эдгээж
туслаач?

Бичээст
"Хараагүй нь хараа орно"
гэж бичсэн байдагчлан
охин чинь одоо харна.






Аав аа,
ЭНЭ ЧИНЬ ТА
ЮУ?

Аав аа,
таныг ямаршуухан
харагддагийг ерөөсөө
мэддэггүй байж байгаад
харахад та миний
төсөөлснөөс ч илүү
сайхан байна.



A man with a beard, wearing a white tunic and a yellow shawl, stands on a raised platform in a city. He has his right hand on his chest and his left arm extended towards a crowd of people. The crowd consists of men and women in traditional Middle Eastern attire, including head coverings and robes. The background shows stone buildings and a cityscape.

Есүс дагалдагч
нарынхаа хамт баярын
үеэр Иерусалимд очиж,
сүмд зааж байлаа.

Урьд нь та нар
анд нөхдөө хайрлаад
харин дайснаа үзэн яд
гэж сонсож ирсэн. Харин
би та нарт дайснаа хүртэл
хайрлаж, тэдэнд сайныг
үйлдэгтүн хэмээн хэлж
байна.

Хүн та нарыг
хараавал
хариуд нь бүү хараа, харин
тэрний оронд тэдэн дээр
ивээл буухын төлөө залбир.
Хүний оронд өөрийгөө
тавьж хүмүүсийг өөртөө яаж
хандуулмаар байна тэр
байдлаарай бусдад ханд.

A man with a beard, wearing a white tunic and a yellow shawl, stands on a raised platform in a classical building with columns. He is gesturing with his right hand towards a crowd of people below. The crowd consists of men and women in traditional attire, including head coverings and robes. The scene is set in a well-lit, open-air environment.

Хүмүүс
чиний эсрэг муу
юм хийвэл чи тэр
хүмүүсийг уучлах
ёстой. Та нар цэвэр
зүрх сэтгэлтэй байвал
Бурханыг харах учраас
ерөөгдөх болно. Амар
тайвныг тогтоогч
хүн хэнээс ч илүү
ерөөгдөнө.

Нүдийг
нүдээр, шүдийг
шүдээр гэснийг
яах вэ?



Хүн чиний
нэг хацрыг алгадвал
нөгөө хацраа тавьж өг. Бүү
харгис хатуу байгтун. Айл
хөршийн чинь хүн хувцасгүй
байгаад өөрт чинь илүү байвал
түүнийгээ өг. Тэр хүн өлсөж
байвал хооллож ундал.
Тэнгэрлэг Эцэг чинь хараад
чамайг ерөөх болно.

Та нар хүн
бүү ал гэж заалгаж,
хэлүүлж ирсэн. Гэхдээ
би та нарт хэлж байна.
Хэрвээ та нар ах дүү
нартаа зөв шалтгаангүй
уурлавал Бурханы
шүүлтийг өөр дээрээ
авчрах аюул бий.



Та нар бүү
завхайр гэдгийг
сонсож дуулсан, гэхдээ би
та нарт хэлье. Хэрвээ чи
эмэгтэй хүнийг тачаалын
нүдээр харвал зүрхэндээ
түүнтэй аль хэдийн
завхайрсан хэрэг.





Шашны
удирдагчид гадна
талаасаа сайхан
харагдах боловч
дотроо тэд бузар
заваан юм.

Тэд бол гадна талыг нь цагаанаар
будсан булшнуудтай адил юм. Гаднаасаа
сайхан харагдах боловч дотроо бол үхсэн
хүний ясаар дүүрсэн юм. Та нар тэднээс
илүү шударга биш бол миний хаанчлалд
хэзээ ч орохгүй ээ.

A man with a dark beard and mustache, wearing a white tunic and a yellow shawl, is shown from the chest up. He is looking upwards and to the right, with his right hand raised towards his chest. The background is a simple, light-colored wall.

Мөхөлд
хүргэх зам
өргөн уужим
бөгөөд олон
хүн түүгээр
явдаг юм.


Би бол тэнгэрт орох
хаалга. Хэрэв та нар надаар
дамжин орвол мөнх амьтай
болно. Харин та нар өөр замаар
явбал гэм нүгэл дотроо үхэж
мөхөх болно.

Саббат өдөр
яагаад хүн эдгээгээд
байгаа юм бэ? Мосе биднийг
амралтын өдөр ажиллаж
болохгүй гэж тушаасан биш
бил үү?




Эцэг
маань намайг
ажлаа хийлгүүлэхээр
явуулсан юм. Би
Түүний хэлсэн
зүйлүүдийг л
хийдэг.

Чи өөрийгөө Бурхантай
адил болгож байна. Энэ бол
Бурханыг доромжилж байгаа
хэрэг. Үүнийхээ төлөө чи
үхлийн шийтгэл
авах ёстой!



Бүх хүн Эцэгт
мөргөж хүндэтгэхийн
адил Хүүд мөргөж
хүндэтгэх нь тэнгэрлэг
Эцэгийн маань ч хүсэл
мөн билээ.

Оршуулагдсан хүмүүс
хүртэл миний үгийг сонсож үхлээс
амилан, зарим нь мөнхийн амь уруу
харин зарим нь мөнхийн там уруу явах
цагчирэхюмшүү.



Энэ хүн бол
үнэхээр Мессиа байна.
Эхлээд гайхамшгуудыг
үйлдсэн. Харин одоо
ингэж зоригтой ярьж
байна.

Энэ хүн
шашны бусад
удирдагчдаас их өөр
юм. Эрх мэдэлтэй ярьж
байна шүү. Тэд нар
түүнийг хороочих вий
гэж л айж байна.


Би явж
эхнэртээ хэлэх
ёстой юм байна.



Эзээн, энд нэг фарисай ирээд тантай уулзах гээд хүлээж байна. Иудейчүүдийн удирдагч, нэлээн чухал хүн байгаа юм аа.


Яагаад шөнөөр ирж байгаа юм бол доо? Есүстэй ярьж байгаагаа харагдчихна гэж ичээд байгаа юм байх даа.

Би явж түүнтэй хувиараа уулзъя.



Чи дахин төрөхгүй л бол Бурханы хаанчлалыг үзэж чадахгүй шүү.

Эзээн, Иудейн удирдагчид бид таныг Бурханаас ирсэн багш гэж мэднэ. Учир нь Бурхантай л хамт байхгүй бол хэн ч таны үйлддэг гайхамшгуудыг үйлдэж чадахгүй билээ.



Та намайг
эхийнхээ хэвлийд
буцаж ороод хоёр дахь
удаагаа төр гэж хэлэх
гээд байна уу?

Үгүй ээ. Махан
биеэс төрсөн нь махан
бие, харин сүнснээс төрсөн
нь сүнс юм. Чи Бурханы
хаанчлалд орохын тулд
дээрээс төрөх ёстой.

Тэр дахин
төрөлт яаж болдог
вэ?




Мосе цөлд
могойг өндөрт
өргөсөн шиг Би
бас өргөгдөх
ёстой юм.

Миний ярьж байгаа
тэр сүнсний төрөлт бол
салхитай адил нууцлаг, харин
салхитай адил л бид мэдэрч амсдаг.
Бурханы хаанчлалд оръё гэвэл чи
дээрээс ийнхүү төрсөн байх ёстой.

Тэд Бурханы
эсрэг нүгэл
үйлдснээсээ болоод
могойд хатгуулж
үхэх гэж байсан юм.
Тэд тэр хүрэл могойг
хараад шууд эдгэрч
байсан.






Тийм ээ, өнөөдөр ч хүмүүс бүгдээрээ тэр нүглийн “хатгуураас” болж үхэж байна. Харин энэ удаа би бүх хүнд харагдахаар өргөгдөх болно. Цөл газар могойд хатгуулсан хүмүүс хүрэл могойг хараад эдгэрэн чөлөөлөгдөж байсан бол нүгэлд хатгуулсан хүмүүс надад итгэснээр эрх чөлөөг олно.



Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм. Түүнд итгэдэг хүн яллагдахгүй. Харин үл итгэдэг хүн аль хэдийн яллагдсан.



Тэгэхээр та
дахин төрөлт л зөвхөн
нүглийг эдгээнэ. Мөн Та өөрөө
чөлөөлөлтийг авчрахын тулд
модонд өлгөгдөнө гэж хэлэх
гээд байна уу?

Энэ дахин
төрөлт хэзээ
болох юм
бэ?

Бүгдэд
харагдахаар намайг
өргөгдсөний дараа
болох юм.

Самаричууд Иерусалим, Галил хоёрын хооронд нутагладаг байв. Иудейчүүд самаричуудыг сүнсний хувьд бохирдсон гэж үздэг байсан учраас тэдэнтэй холбогдох тэр ч бүү хэл хот тосгодоор нь дайран өнгөрөхөөс ч зайлсхийдэг байлаа. Нэгэн өдөр Есүс дагалдагч нартаа ийн хэлээд тэднийг гайхахад хүргэжээ:



Явцгаая, би Самариар дайрч явах хэрэгтэй байна.

Самари уруу явах нь Эцэгийн минь хүсэл.

Эзэн, тэд чинь цэвэр бус, бүдүүлэг харанхуй улс! Тэд бас ядуу, завхай хүмүүс.

Үдийн алдад тэд
хотын гаднах нэгэн
худаг дээр иржээ.

Та энд
ганцаараа
үлдэх юм
уу?


Та нар хот уруу
ороод мах аваад ир.
Та нарыг эргэж иртэл
чинь би худаг дээр
хүлээж байя:

Тийм ээ, би
Эцэгийнхээ
ажлыг хийх
ёстой.






Есүс өлсөж, цангаад ядарсан байлаа.
Тэр цаг эмэгтэйчүүд худаг дээр
ирдэг цаг биш байсан боловч нэгэн
самари эмэгтэй ус авахаар ирэв.



Ваарнаасаа надад
жаахан ус өгөөч.

Надад байгаа Бурханыг
бэлгийг, бас миний хэн болохыг
мэдэж байсан бол чи надаас гуйх
байсан даа. Тэгээд би чамд амьд
ус өгөх байсан юм.


Хн! Самари
эмэгтэй надаас иудей
хүн та яахаараа ус гуйж
байдаг билээ? Миний
мэдэхийн иудейчууд та нар
бидэнтэй ямар ч хамаагүй
биш билүү?



Та надад ус өгнө
гэнэ ээ? Танд ус утгах юу ч байхгүй.
Тэгээд ч худаг их гүн шүү дээ. Та
хаанаас тэр амьд усаа авах юм бэ?

Тэгвэл та надад
тэр амийн уснаасаа
өгөөч. Би дахиад хэзээ ч
цангахгүй болъё.


Чи энэ худгийн
уснаас уугаад дахиад
л цангана. Миний чамд
өгөх ус бол чиний
сүнсэнд мөнх амийн
булаг болох юм.



Яваад
нөхрөө дуудаад ир.
Би энэ усны тухай
хэлье.


Надад нөхөр
байхгүй.

Чи таван
нөхөртэй байсан.
Одоо хамт амьдарч
байгаа хүн чинь
чиний нөхөр биш.



Миний нууц
нүглийг хүртэл
мэдэж байдаг та
үнэхээр эш үзүүлэгч
байна.

Танай иудейчүүд
Иерусалимд мөргөл үйлддэг,
харин манай эцэг дээдэс энэ
ууландаа мөргөж ирсэн. Аль уул
нь мөргөл үйлдэхэд
зөв газар вэ?




Бурхан бол Сүнс.
Хүний гараар бүтээгдсэн
дугануудад Бурхан хүндэтгүүлж
мөргүүлдэггүй юм. Үнэнд итгэж,
сүнсээр мөргөдөг хүмүүсийг
Бурхан хайж байдаг.

Мессиа ирж,
үнэнийг бидэнд
илчилнэ гэдгийг
бид мэднэ.




Чи
Мессиатай
ярьж байна.



Би явж
нөхдөө олж,
тэдэнд бас
хэлье!

Есүс Самарид
хоёр хоног саатаж
хүмүүст нь Бурханы
Үгийг заажээ.



Нэг удаа Есүс дагалдагч нарынхаа хамт Галил нуур уруу харсан толгой дээр зогсож байв.

Ядуу, зүдүү хүмүүст тусламж өгөхдөө бусдад харагдахаар олны өмнө бүү өг.


Хэдэн мянган хүн сургаалыг нь сонсохоор хот тосгодоос ирсэн байлаа.

Бусдад гайхагдаж, магтагдахын тулд сүсэг бишрэлээ илэрхийлбэл тэнгэр дэх Бурханаас шагнал хүлээн авч чадахгүй юм. Тиймд зүүн гар чинь юу хийж байгааг баруун гар чинь бүү мэдэг.




Залбирахдаа
хоёр нүүрт
сүсэгтнүүдийн
адил олны нүдэнд
харагдахын тулд
нийтийн газар бүү
залбир.

Та нар шашны удирдагчид
шигээ нэг үгээ давтан бүү залбир. Тэд олон
нийтийн газар зогсон өөрсдийнхөө сүсгийг
харуулахын тулд тэгж залбирдаг юм.




Хамаг цаг, хүчээ баяжихад
бүү зориул. Баян хүмүүс бусдаас
илүү зовлонтой байдаг. Тэд эд
баялгаа юунаас ч илүү хайрлах тул
тэнгэрийн хаанчлалд ороход тэдэнд
их хэцүү байдаг юм.

Энэ дэлхий
дээр өөрсдөдөө эд
баялгийг бүү хураагтун,
харин тэнгэрийн эд
баялаг үүрд үлдэх тул
тэнд хураагтун. Та нар
мөнгө, Бурхан хоёрт зэрэг
үйлчилж чадахгүй. Эцэст
нь та нар нэгийг нь
хайрлаж, нөгөөг нь үзэн
ядах болно.




Эзэн одоо орой
болжээ. Энэ хүмүүс
бидэнтэй өдөржингөө цуг
байсан тул өлсөж байгаа
байх. Хамгийн наад захын
хот уруу очъё гэсэн ч их
хол байгаа.

Одоо эднийг
явуулаач, тэгээд
тэд явж хоол хүнс
худалдаж аваг.




Эзэн, та миний
өдрийн хоолыг ав. Ээж
маань надад таван талх,
хоёр загас бэлтгэж
өгсөн юм.



Бүх
хүмүүсийг
суулга. Бид
тэднийг
хооллоно.

Юугаар?



За, бид загас,
талхаар хооллох гэж
байгаа юм шиг байна
даа.

Арван
хоёр том сагс
зээлж олж ирээд
хоол тараахад
бэлтгээдэх.

Эзэн, тэр
чинь 5,000
хүн бүү хэл,
ганц хүнд ч
хүрэхгүй юм
байна шүү
дээ.




Хөрс
шорооноос талх
тариа ургуулдаг
ертөнцийн их
хаан, бидний
Бурхан Эзэн минь
Та ерөөгдөх
болтугай.



Тэр жаахан
идэх юмыг ийм
том сагс уруу хийгээд
байдаг нь яаж байгаа
нь тэр вэ?



Тэрийг
хар даа! Энэ их
хоол хүнс чинь
хаанаас гараад
ирэв ээ?




Бурханыг
магтъя!

Яг Мосе шиг...
Тэр бидэнд
тэнгэрээс талх
өгч байна.

Ээж маань
энэнд итгэхгүй
дээ!



Хүмүүс сагснаас талх,
загас аваад л байсан
мөртлөө дахин дахин
нэмэгдсээр байлаа.




Эзээн, хүмүүс
бүгдээрээ идчихээд
байхад сагснууд
дүүрэн хэвээрээ байна.
Бид нар саснуудыг
хоосолж чадахгүй
нь!

Та нар үлдэснийг
нь цуглуулчихаад нөгөө
дагалдагч нартайгаа цуг
завиа аваад нуурын цаад талд
гар. Би та нартай тэнд уулзъя.
Би одоо уулан дээр гарч
залбирах ёстой.

Есүс ганцаараа залбирахаар уул өөд
явлаа. Харин дагалдагч нар нь нуурын
нөгөө талд гарахаар завиндаа суув.




Есүс ер нь ганцаараа залбирахаар
эзгүй газар очдог байлаа.



Дагалдагч нарыг нуурын
гол дунд очиход хүчтэй
шуурга гарчээ. Тэд
живэхээс айж байлаа.

Би ийм аймаар
шуурга ер үзэж
байгаагүй юм
байна.

Цаашаа
бид яаж ч
чадахгүй
юм байна.



Бид нар
живэх нь
ээ!


Хараач! Усан дээр
нэг юм харагдаад
байна.



Чөтгөр
байна!

Чөтгөр
байна!

Нэг хүн усан
дээр алхаж явна.



Эзэн, Та хэрвээ
мөн юм бол өөрөө алхаж
байгаа шигээ намайг бас усан
дээр алхуулж Өөр дээрээ
очуулаач.

Петр ээ
Би байна.
Битгий ай.

Петр ээ
нааш хүрээд
ир.



Эзэн,
би очиж
явна.

Петр ээ,
болохгүй ээ!

Петр Есүс уруу
үнэхээр усан дээр
алхан очиж байлаа.



Петр том давалгаануудыг
хараад Есүсийг харж чадахгүй
болоод айж эхлэв.



Айснаасаа болоод
ИТГЭЛЭЭ алдан живж
ЭХЭЛЖЭЭ.



Эзээн, намайг
авраач!

Петр чи
Надад
эргэлзэж
эхэллээ.



Есүс Петрийн
хамт усан дээгүүр
алхсаар Петрийг
завин дээр буцаан
авчирлаа.


Петр чи
үнэхээр усан
дээр алхчихлаа
шүү дээ!





Намд
тогтуун
бол.

Есүс салхи, шуургыг зэмлэсэнд
намдаж тогтуун болов.



Ээ Эзэн,
би чинь нүгэлт
хүн шүү дээ.
Надаас хол
байгтун.

Та бол үнэхээр
Бурханы Хүү
байна шүү.

Миний
Эзэн бас
миний
Бурхан.

Израилийн
Христ
байна.




Дараа нь

Баярын өдрүүдэд хүн ихтэй байна. Хүмүүс нутгийн өнцөг булан бүрээс хүрэлцэн ирсний зарим нь бүр Ром, Египет зэрэг хол газраас ирсэн байлаа.

Доошоо бууж
усан сан уруу
очицгооё


Миний
мэдэхийн л энэ
хүн энд байнга
байдаг байсан.






Та бүрэн
бүтэн болмоор
байна уу?

Надад
туслах ямар ч хүн
байхгүй ээ.




Бос,
дэвсгэрээ
аваад яв.

Та Есүс мөн
биз дээ? Ба Таны
үйлдсэн
гайхамшгуудыг
дуулсан.



Ямар хатуу тоглоом бэ? Энэ хөөрхий хүн 38 жил хөлгүй байхад чинь.

Энэ манай ариун Саббат өдөр. Тэрэнд бидний амар амгаланг үймүүлэх эрх байхгүй шүү.



Энэ хүнийг зайлуулах
хөдөлгөөн өрнөж байгааг би
дуулсан. Дэндүү их анхаарал
татаад байгаа юм.

Энэ Есүс өөрийгөө
Мессиа гэж бодоод байгаа
юм биш биз дээ?

Харин
тийм ээ, өөрийгөө
гайхамшиг үйлдэж
чадна гэж хүмүүст бүр
итгүүлчихээд байгаа
юм.



Хөөе хөл нь!
Ургаад байна!




Нөгөө
хүн чинь
босоод
ирлээ!

Байж боломгүй
юм!



Бурхан магтагдах
болтугай! Энэ олон
жилийн дараа ийм юм
болох гэж!

Есүс бол
Мессиа мөн!



Чи яагаад
Саббат өдөр хүн
эдгээгээд байгаа
юм бэ?

Мосе
биднийг
Саббат өдөр
амраарай гэж
тушаасан шүү
дээ.

Нүх уруу унасан бухаа
татаж гаргах нь зөвшөөрөгддөг биз дээ.
Тэгвэл би Саббатаар хүн эдгээсэн нь
хуулийг зөрчиж байна уу?

Миний Эцэг
Саббат өдөр ажилладаг.
Би Түүний хийдгийг л
хийдэг.



Бариад ав
наадхаа! Наадхыг
чинь чулуугаар
нүүлгэж алах
ёстой.

Тэр Өөрийнхөө
эцгийг Бурхан гэж байна.
Тэр өөрийгөө Бурхантай
эн зэрэгцүүлж
байна.

Ал
наадахаа!




Саббатаар
өвчтөнийг эдгээлээ
гэж хүн алах гэж
байна уу?

Энэ хүн манай
хуулийн эсрэг
яриад байна.

Тэр хуулийн
эсрэг юу ч
яриагүй шүү
дээ.


Та нар юу
хэлэхийг нь л
сонс.



Намайг сонс. Энэ
гайхамшгийг үйлдснээс минь
болоод та нар гайхаж байна. Би үүнээс
илүү агуу гайхамшгуудыг үйлдэх болно.
Эцэг минь хүмүүсийг үхлээс амилуулдаг
тэр эрх мэдлээ надад өгсөн юм. Эцэг
минь надад энэ дэлхийг захирах бүрэн
эрх мэдлийг өгсөн.


Хэрэв та нар
Намайг хүндлэхгүй
юм бол Бурханыг ч хүндлэхгүй.
Үнэхээр би та нарт хэлье. Надад
итгэгч хүн намайг илгээсэн Нэгэнд ч
итгэж байгаа тул тэр хүн мөнх
амьтай болно.

Чи яаж
мөнх амь өгдөг
юм бэ?



Үхсэн хүн хүртэл миний
дууг сонсоод булшнаасаа
гарах цаг ирнэ. Сайныг
үйлдсэн хүмүүс мөнхийн
амьдрал уруу амилуулагдах
болно. Харин бузар мууг
үйлдсэн хүмүүс мөнхийн
зовлонгийн галтай нуурт
хаягдах юм.

Энэ чинь
доромжлол. Хэн ч
үхлээс хүнийг босгож
чадахгүй. Ганцхан
Бурхан л мөнх амь
өгч чадна.




Та нар надад
итгэдэггүй боловч
Иохан болон Бичээс миний
ирэхийг урьдаас хэлсэн юм.
Бичээсээс хайгаад үзэгтүн.
Тэнд олон эш үзүүллэг
миний тухай хэлсэн
байдаг.

Би та нарыг
Бурханы өмнө буруутгана
гэж бүү бод. Та нарын дагаж
чадахгүй байгаа Мосегийн
хуулиуд өөрсдийн чинь эсрэг
гэрчлэх болно.


Энэ чинь тэд нарын
алахаар төлөвлөөд байгаа
хүн байхгүй юу. Гэтэл одоо
ч их зоригтой ярьсаар байх
юм, тэд юу ч хийж чадахгүй
байна даа. Эрхэм дээдсүүд
энэ хүнийг үнэхээр Христ,
Израилийн Мессиа гэж
мэддэггүй юм уу?

Хуулийн
багш нар Мессиаг
хаанаас ирэхийг
мэдэхгүй гэж заадаг
юм. Харин энэ
хүнийг Галилын
мужааны хүү гэж
мэднэ шүү.



Чи сая Намайг хэн
болохыг бас хаанаас
ирснийг минь мэднэ гэлээ. Би
энэ дэлхийд Өөрөө ирээгүй юм.
Миний Эцэг Намайг илгээсэн
бөгөөд та нар Миний Эцэгийг
мэддэггүй. Харин би Эцэгээ
мэднэ. Тэр Намайг та нар
уруу илгээсэн юм.

Намайг яаж
сонсчихдог
байна аа?



Энэ хүн
бүх юмыг
мэддэг юм.

Энэ чинь тэгвэл
урьдаас зөгнөн хэлээд
байсан Мессиа
байна шүү дээ.


Мессиа энэ
хүний хийснээс илүү
гайхамшгуудыг хийнэ байх
гэж бодож байна уу?



Бушуухан
явж тэр доромжлогчийг
баривчил.

Энэ удаа
тэгж чадахгүй
шиг байна.

Хүмүүс Түүнд итгэж
эхлээд байна. Тэрнийг одоо
дуугүй болгох
хэрэгтэй.




Зөв шударгын төлөө
цангагчид ерөөлтэй. Учир
нь тэд цангаагаа тайлах
болно.

Цангаж байгаа
хүн байвал Над уруу ирж
уугтун. Ариун Сүнс түүний
дотор мөнхийн амь уруу
оргилох булгийн ус мэт
байх болно.

Амар тайвныг
тогтоогчид ерөөлтэй, учир
нь тэд Бурханы хүүхдүүд
гэж хэлэгдэнэ. Дайснуудаа
хайрлан, ивээж ерөөгтүн.

Энэ хүн
чинь хэрэгтэн
шиг ярьж байгаа
юм алга.

Хүмүүс түүнийг
4,000 жилийн эш
үзүүллэгийн хариулт
гээд байгаа юм.



Та нар түүнийг
бид нар уруу яагаад авчраагүй юм бэ?
Яг чиний өмнө зогсож байсан биз дээ.
Яагаад бариад аваагүй юм бэ?

Ямар ч хүн
ингэж ярьж
байгаагүй.

Энэ Хүн хайр
уучлалын тухай
ярих юм.


Ха, та нарыг бас
хуурчихаа юу? Боловсрол, мэдлэгтэй
удирдагчид, фарисайчуудаас түүнд
итгэсэн хүн байна уу? Энэ Есүс
гэгч үхэх ёстой.

Есүстэй шөнөөр ирж уулзан
ярилцаж байсан Никодем.



Манай хууль
өөрийнх нь хэлэх зүйлийг
сонсохоос өмнө тэр хүнийг
шийтгэдэггүй биз дээ?

Никодем чи бас Галилаас
ирсэн Тэрний дагалдагч нарын нэг
үү? Бичээсээс хайгаад үз. Мессиа
Галилаас гарч ирнэ гэж бичээгүй
байгаа шүү. Мессиа Иудагийн
Бетлехемээс гарах бөгөөд Давидын
хүү байх ёстой юм.




Тэр
худал яриагаараа
энгийн ард иргэдийг
хуураад байгаа юм.

Есүс юм
болгонд хариулт
өгч чадаад байгаа
юм даа.

Ерөөсөө
бүгдээрээ хамгийн шилдэг
сайн хуульчдаасаа явуулж
үгэн дээр нь унагаавал яадаг
юм бэ?



Би яг тийм
хуульчийг мэдэх юм
байна. Тэр бол жинхэнэ
шилдэг бөгөөд үл өршөөгч
хуульч байгаа юм.




Мөнөөх хуульч
Есүсийг
сорихоор ирэв.

Хуулинд
юу гэсэн
байдаг вэ?

Багш аа,
мөнх амийг
өвлөхийн тулд
яах ёстой вэ?

Ингэж хэлсэн
байдаг. Чи өөрийн Бурхан
Эзэнээ бүх зүрх сэтгэл, хүч
чадал, санаа бодлоороо хайрла.
Мөн хөршөө өөрийн адил
хайрла гэсэн байдаг.



Чи асуусан зүйлдээ
өөрөө хариулчихлаа. Хайр
бол хуулийг хэрэгжүүлж буй
явдал мөн. Чи хөршөө өөрийн
адил хайрлаж байвал
Бурханд таалагдана
гэсэн үг.

Тийм л дээ, гэхдээ хөрш
гэж аль нь вэ? Та бүх хүнийг
гээгүй биз дээ. Харийн
ромчуудыг хэлээгүй
биз дээ?

Би чамд
нэг түүх
арья.



Нэгэн хүн Иерихогоос
Иерусалим орохоор явж
байгаад дээрэмчдэд зодуулж
бүх юмаа тонуулан нүцгэрээд
үхлүүт хэвтэж байжээ.

Нэг тахилч
замын голд хэвтэх
түүнийг тойрон гараад
тусалсан ч үгүй цаашаа
яваад өгөв.

Түүнчлэн сүмд
үйлчлэхээр томилогдсон нэгэн
леви хүн мөнөөх шархадсан
хүний хажуугаар нь өнгөрөхдөө
зогтусан харснаа тусалсангүй
цааш явчихжээ.



Надад хайр
бий гэчихээд хайрлах үйлс
үзүүлэхгүй юм бол энэ нь яаж сайн
байх билээ. Хэрвээ та нар хөршөө
хайрлахгүй юм бол Бурханыг ч бас
хайрлахгүй байгаа хэрэг.

Иудейчүүдэд дорд үзэгдэн,
бузар гэж тооцогддог нэгэн самари
хүн бас түүгээр явж байв. Самари хүн зам
дээр хэвтэх мөнөөх шархдаж, нүцгэрсэн
хүнийг хараад иудей хүн байна хэмээн
бодож тооцоод байсангүй.



Самари
хүн түүнийг хараад
өрөвдөж туслахаар
саатав.




Самари хүн
мөнөөх хүний шархыг
цэвэрлээд боов. Тэр хүний хайр
үгэндээ биш үйлстээ байлаа.


Самари хүн
шархтай хүнийг
илжгэн дээрээ дамнаад
амрааж, тэнхрүүлэхийн
тулд буудал уруу авч
явав.



Одоо гайгүй ээ.
Би чамайг аваад явж
байна. Удахгүй орон
дээр хэвтэнэ ээ.



Би танд хоёр
долоо хоногийн
хоол, өрөөний мөнгийг
төлчихье. Тэгээд илүү
мөнгө гарвал буцахдаа
эргэж ирээд төлье.




Чи надаас миний
хөрш гэж хэн бэ гэж асуусан. Одоо тэгвэл
хэлээдэх. Энэ гурван хүний аль нь шархадсан
хүний хөрш вэ?

Мэдээж
тэр энэрэнгүй
сэтгэлтэй нь л
мөн дөө.

Гайхалтай!




Тэгвэл чи явж тэр самари хүний үйлдсэн шиг үйлд. Чи хөршөө хайрла.



Ээ муу тэнэг! Есүс
өөрийг нь урвуулчихаас
өмнө цаадхыгаа тэндээс
аваад ир.

Энэ чинь юу
гэдэг хачин сургаал
вэ? Хэрэгжүүлэх
боломжгүй юм. Зарим
хүмүүс хайр гэхээр юу ч
хийхгүй шүү дээ.



Та нар нөхрөө хайрлаж
дайснаа үзэн яд гэж заалгаж ирсэн.
Харин Би та нарт хэлье. Дайснаа хүртэл
хайрлаж өөрийг чинь хараасан хүнийг
ерөө. Өөрийг чинь үзэн ядсан хүнд сайн
сайхныг үйлд. Чамайг хавчин дарлаж,
дорд үзэн ашиглагч хүний төлөө
залбир.



Аравдугаар
бүлэг

ГАЙХАМШГУУД
БА СУРГААЛТ
ЗҮЙРЛЭЛҮҮД


Хаа нэгтээ газар...

Юуч
идсэнгүй олон
өдөр өнгөрлөө.

Чи харх, голио
царцаа идэж сурахгүй
л бол удахгүй үхнэ шүү.
Тэр л амьд үлдэх цорын
ганц арга байгаа юм.

Би үхье л
гэж бодож байна.
Ганцхан жилийн өмнө
хөрөнгө чинээтэй
бусдаар хүндлэгдсэн
хүн байлаа би. Одоо
намайг хар даа.

Одоо чи дахиж ер
хүндлэгдэхгүй. Хаягдаж
гадуурхагдсан, хулгана
яр өвчтөн.




Эхлээд ч би нэг
л өдөр эдгэрч сайн
болоод эхнэр хүүхдүүддээ
эргэж очно гэж найддаг
байлаа. Гэтэл би энд одоо
арван жил болж байна.
Эндээс эдгэрч сайжраад
буцаж олны дунд орсон
хүнийг би ер үзээгүй
юм байна.



Эхэндээ ч бас эхнэр
маань хүүхдүүдийг минь
авчраад холсноос надтай
ярьдаг байлаа. Одоо ч
ирэх нь бүр цөөрч байна.
Хүүхдүүд ч бас өсчихлөө.
Одоо тэд намайг харвал
бараг танихгүй биз дээ.
Ингэж байх чинь үхсэнээс
дор байх юм.


За за, өөрийгөө
өрөвдөхөө больж
үз. Хэн ч тоохгүй,
бүр Бурхан ч тоохгүй.
Явцгаая. Идэх юм
олдох нь уу, үзье.





Хоёулаа
өнөөдөр гол
замаар явъя. Хэн
нэг нь өрөвдөж ч
юуны магад.

Хэдүүлээ
цуг явъя арай
аюулгүй байх.

A stylized illustration of a group of people in a desert landscape. The scene is rendered in a limited color palette of yellow, brown, and blue. In the foreground, several figures are walking or running towards the right. They are wearing long, flowing robes and head coverings. The background shows rolling hills and a clear blue sky. A speech bubble is positioned in the upper center of the image, containing Mongolian text.

Замаар аяны
хэдэн хүн явааг
харлаа!



Хараач!
Дахиад нөгөө
баньд нар
байна.

Зайл, муу
заваан яртангууд. Хол
очиж үхэцгээ.

Муу өмхий
өтнүүд! Бурхан
та нарыг шийтгэж
байгаа юм.

Гүйгээрэй!
Гүйгээрэй!

Хол
байгаарай! Цэвэр
биш, бид нар бүгдээрээ
бузартсан шүү.

Эд хулгана
яртангууд байна.
Наадуулаа битгий өөртөө
ойртуулаарай. Чамд бас
халдана шүү.



Та нар
өршөөлөө хайрлана
уу? Бидэнд ганц үмх
ч болов юм өгч
хайрлаач?

Тэдэнд жаахан юм
өгчихөөч тэгвэл тэд
нар явах байх.



Холдоцгоо.
Та нар цэвэр
биш!



Хойшоо ухар
ухар. Бид нар
юмаа газар
тавьчихъя.

Наашаа ойртох
болоогүй шүү. Эхлээд би
эндээс холдоод орхиё.



Талх!

Хоол!

Надаа
үлдээгээрэй!

Битгий
бүгдийг
нь авчих!




Чи муу
гахай!

Энэ чинь
минийх!

Талх!
Талх!


Ээ Бурхан
минь!



Одоо тэндээс бүр олон хүн ирж явна.


Эд чинь бас бүгдээрээ эрчүүд байна.

Бүгдээрээ болгоом той байгаарай. Эд нар дэндүү олуулаа ж юм байна.



Тэр чинь Назарын
Есүс байна. Би Түүнийг
өмнө нэг удаа харж байсан
юм. Энэ өвчин тусахаасаа
өмнө юм шүү дээ. Энэ Есүс
чинь хүмүүсийг эдгээдэг
юм байхгүй юу.


Тэр Өөрийгөө
Бурханаас ирсэн гэдэг
юм. Тэгээд бас Өөрийгөө
Эцэгтэй нэг гэдэг юм байна
лээ. Би Түүнийг хараагүй,
суумгай хүмүүсийг эдгээж
байхыг нь харсан
юм байна.



Есүс ээ!
Бидэнд
туслаач!

Эзэн, эд
чинь хулгана
яр өвчтөнгүүд
байна.

Эд
нарыг битгий
ойртуулаарай.



Та нар надаар
юухийлгэ мээр
байгаа юм бэ?


Бидэнд
өршөөлөө
үзүүлж, биднийг
эдгээж өгөөч.

Та хүсвэл
намайг цэвэр
болгож чадна шүү
дээ.



Та надад хүрч
болохгүй шүү.

Зүгээрээ зүгээр.
Явж сүмд очоод өөрсдийгөө
тахилчид үзүүл. Тэр та нарыг
цэвэр болсныг үзээд гэр гэртээ
харьж өөрийнхөнтэйгөө
уулзахыг чинь зөвшөөрнө.



Бид нарыг
цэвэр болсон
гэх юм.


Бид нарыг сүмд
ойртож очихоос өмнө
хөөгөөд явуулчих
байлгүй.

Би лав
хэлснээр
нь явж
хийлээ.

Би ч бас
тэгнэ. Явцгаая.



Есүс бид
нарыг эдгэрсэн
гэсэн шүү дээ.




Би арай дээр
болоод байгаа юм
шиг байна.



Бид нар
өөрчлөгдөөд
байна!






Есүс
ингэчихсэн
байна! Чамайг
бүтэн болгожээ!

Миний
арьс
эдгэрчихэж!

Чи
муухай
харагдахаа
байчихаж!

Би явж
эхнэрээ
олох ёстой
юм байна!



Израилийн хаан, Бурханы
Хүү Та ерөөгдөх болтугай. Та намайг
дахин амьдралтай золгууллаа. Бурхан
бол энэрэнгүй, нигүүлсэнгүй юм
байна.


Арван хүн цэвэршээгүй
бил үү? Гэтэл ганц л ирж
талархаж байдаг. Тэгээд энэ
ганц нь иудей ч биш бүр
самари хүн шүү.

Нэгэн хүн Есүсээс олон хүн мөнхийн амьдралд орох уу гэж асуухад Есүс ингэж хариулжээ:

ETERNAL LIFE

Би та нарт хэлье. Мөнх амь уруу хөтлөх зам хэцүү бөгөөд нарийхан учир маш цөөхөн хүн түүнийг олно. Гэтэл харин мөхөл сүйрэлд хүргэх зам өргөн уужим бөгөөд мөнхийн там уруу явж буй хүмүүсээр дүүрэн байх юм.





Нарийхан замаар явах гэж хичээгтүн. Учир нь олон хүн амийг хайх боловч олж чадахгүй юм. Шүүлтийн өдөр ирэхэд олон хүн Бурханаас "Эзэн минь, би үнэхээр Таных. Би их шүтлэгтэй хүн байсан. Би мацаг барьж залбирдаг байсан. Бас би шашин номынхонд буян үйлдэж их дэмжлэг үзүүлдэг байсан. Би Таны нэрээр эш үзүүлж чөтгөрүүдийг хүртэл зайлуулдаг байсан" гэж гуйх болно.

Тэгэхэд нь Би тэдэнд "Би та нарыг ер танихгүй юм байна. Надаас холд. Та нар мөнхийн галд орохоор хараагдсан байна. Тэнд та нар шүдээ хавиран орилох болно" гэж хэлэх юм.

Энэ бол тэдний сүнс хэзээ ч үхэхгүй бас хэзээ ч гарч чадахгүй тийм газар юм. Тэдний зовлонгийн утаа үүрдийн үүрд суунаглан байх болно.

Есүс бас ийн ярьжээ.



Өдөр болгон
сайхан хувцас өмсөж
сайхан хоол иддэг байсан
нэгэн баян хүн байжээ.
Тэр хүн бузар муухай биш
харин давгүй сайн хүн байв.
Гэсэн хэдий ч ихэнхдээ
өөрийгөө л боддог
байсан юм.

Тэр
хүн мөнгө
төгрөгөө
арвижуулан
хурааж
өдрөөс
өдөрт
баяжсаар л
байжээ.

Энэ хоолны үлдэгдлийг
миний тавагнаас аваад тэр манай
хаалганы хажууд хэвтдэг гүйлгачинд
аваачаад өгчих. Би бол өрөвчхөн,
хүнийг хайрладаг хүн.




За эзэнтээн,
тэр танд
талархана даа.



Эзэн маань
чамд энэ
үйрмэгийг өгч
байна.

Бурхан Эзэн магтагдах
болтугай! Бурхан хүмүүсээ юмаар
дутаадаггүй. Би ийм их юм авах
зохистой хүн биш ээ. Эзэндээ
миний өмнөөс талархаарай.

Миний эд
баялаг асар их
болжээ. Тэгэхээр би
юмаа хураах илүү
том агуулах савтай
болох хэрэгтэй юм
байна даа.




Тэнэг
минь чи өнөө
шөнө үхэж сүнс
чинь нэхэгдэх гэж
байна.

"Нэг удаа үхэх нь
хүмүүст тогтоогдсон юм.
Харин тэрний дараа шүүлт
ирнэ"


АААА!

Баянхүнийгоршуулахааравч
явахдаамөнөөхгуйлгачинЛазар
басүхсэнбайхыгхүмүүсүзэв.



Энэ чинь өнөөх
гуйлгачин өвгөн Лазар
байна. Энэ бас өнгөрсөн шөнө
үхчихэж. Ямар сайхан тайван
харагдаж байна аа.


Лазарын цогцсыг тэргэн дээр тавиад, амьтдын сэгийг
хаяж шатаадаг газарт авчрав. Түүнийг оршуулсан ч
үгүй, бас хойноос нь гашуудсан хүн ч гарсангүй.



Гэтэл тэнгэр элч нар ирээд
Лазарыг тэнгэрийн улс
уруу аваад явчихав.

Төөх! Ямар
гоё юм бэ! Үхнэ
гэдэг чинь ийм сайхан
байна гэж бодоогүй
юм байна шүү!

Лазар дүү минь
гэртээ тавтай морил доо. Чи
одоо дахиад хэзээ ч өлсөхгүй,
чиний бие дахиад бас хэзээ ч
өвдөхгүй болсон. Нааш ир, бид нар
чамд ширээ засаад зэхчихсэн.



Маш сайн хүн байж билээ.
Заримдаа тэр өөрийнхөө хайртай
хүмүүст хатуу ширүүн мэт ханддаг
байсан ч бид түүнийг ямагт санан дурсах
болно. Тэр улс үндэстэндээ хайртай
байсан бөгөөд ажил хэрэгтээ үнэч
шударга байсан юм аа.

Тэр шагналаа
авахаар одлоо. Сүнс
нь мөнх амгалан
нойрсог доо.


Мөнөөх баян хүний
ажил явдал тун сайхан
болж, гоё гээчийн
булшинд оршуулжээ.
Түүний мөнгө хөрөнгөнд
дурласан олон хүн
өөрсдөдөө ямар өв
гэрээс үлдээсэн байгааг
сонирхохоор хүрэлцэн
ирсэн байлаа.

Гэтэл баян хүн нас
барангуутаа ёроолгүй гүн
ангал уруу унаж явчихав.






Туслаач!
Ээ Бурхан минь, хэн
нэгэн нь надад
туслаач! Би энд энэ
гал дотор байна!



Абрахам эцэг минь ээ, намайг энэрээч. Би Лазарыг тэнд байгааг харж байна. Хурууг нь ус уруу дүрүүлээд наашаа явуулж хэлийг минь норгуулаач. Би энэ гал дотор тарчилж байна.

Хүү минь, чаддаг бол би чамд туслалгүй яах вэ. Гэтэл бидний хоорондох асар том ангалын ёроолд галт нуур байна. Бид үүний дээгүүр гарч чам дээр очиж чадахгүй, чи ч бас наашаа ирж чадахгүй ээ.


Тэгвэл Лазарыг манай гэр уруу буцаан явуулж, миний таван дүүд хэлүүлээч. Тэд энэ аймшигт тамын газар ирэхгүй болох юм.



Тэдэнд
Мосе ба эш
үзүүлэгчдийн
бичээс байгаа. Тэд
өөрсдөө Бичээст
итгэг.

Гэхдээ тэр тэдэнд
хангалттай биш ээ.
Тэд үхлээс амилсан
гайхамшгийг үзвэл
итгэлгүй байдалдаа
гэмшиж магадгүй.

Хэрвээ тэд Бичээст итгэхгүй юм
бол хэн нэгнийг үхлээс амиллаа гээд
итгэхгүй биз дээ. Одоо чамд бүх юм оройтжээ.
Тэд өөрсдөө шийдэг дээ. Намайг уучлаарай.
Надад хийж чадах юм алга даа.



Хөөе, ханхар залуус аа. Та нар сайхан зугаацмаар байна уу? Миний үнэ хямдхан шүү.


Эзээн, наадахаа битгий тоо. Наадах шиг чинь юмнуудын хувьд аль хэдийн өнгөрсөн.



Ариун Бичээст
“Чи завхайрч болохгүй” гэж
хэлсэн байдаг юм шүү.


Хөөе. Би их
шүтлэгтэй
эмэгтэй шүү.
Би Бурханд
итгэдэг.

Муу чөтгөр
чамайг хуурчээ. Чиний
төгсгөл галтай нуураас
өөр юуч биш болох
гээд байна даа.



Чи найзынхаа
хэлэхийг сонсоо биз дээ.
Намайг өнгөрсөн хүн гэж.
Би хүүхэд байхаасаа эхлээд
эрчүүдтэй унтсан.

Бурханд дэндүү
оройтно гэж байдаггүй юм. Чи
Бурханыг эрж хайвал Тэр чамд олдоно.
Бурхан чиний нүглийг уучилж сүнсийг
чинь эдгээж өгнө.

A comic book panel featuring two characters. On the left, a man with long brown hair and a beard is shown in profile, looking towards the right. He is wearing a light blue garment. On the right, a woman with dark, curly hair is shown from the chest up, looking towards the man. She is wearing a green top and large, ornate gold earrings. A white speech bubble is positioned above her, containing text in Mongolian. The background is a solid orange color.

Миний сүнс
чөтгөрийнх болсон
л доо. Харин Бурхан
намайг чөлөөл...
чөлөөл... чө... ЧӨ...

АААА!

Дүүрэн
муу сүнс
шүгэлчихсэн
юм байна!


Холд
цаашаа!





ТЭЭЭЭЭЭ!

Сатан аа,
түүнээс
гар!



Би чамайг гар гэж
тушааж байна. Гараад
эргэж бүү ир.


Есүсийн тушаалаар долоон муу
сүнс түүнээс зайлан оджээ.



Тэд алга
болсон!

Та хэн
бэ?


Би Есүс
байна.



Чи нүгэл
үйлдэхээ больж,
Бурханыг хүндэлж
эхлэхгүй бол муу
сүнснүүд өөрсдөөсөө
ч долоон дор
сүнснүүдийг дагуулан
эргэж ирнэ шүү.

Би Бурханд
үйлчилмээр байна. Би
Таныг дагаж суралцмаар
байна.

Энэ
эмэгтэйд сая
юубо лчихов
оо?



Эзэн, би сая юуболсныг харлаа. Ёстой гайхамшигтай юм. Манай шашны зарим удирдагчид Магдалын Мариаг өдөр тоодоггүй мөртлөө шөнө болохоор ирээд байдаг юм шүү. Та сая түүнд шинэ амьдрал өглөө.


Бид нар очъё.

Та дагалдагч нартайгаа цуг манайд очиж хоол идэхгүй юу? Би энэ талаар нөхдөдөө илүү их яриулмаар байна.

Есүс ээ,
бидэнд хэлээч. Энэ
завхарсан нийгэмд
хүн яаж шударга, ариун
байж чадах вэ? Хуулийг
жаахан гуйвуулан зөрчиж
байхгүй бол бид чинь
харангадаж үхнэ биз
дээ?




Устаж үгүй болох юмны
төлөө бүү хөдөлмөрлө. Харин
мөнх үлдэх юмны төлөө л ажиллаж
хөдөлмөрлө. Өөрийнхөө төлөө хөрөнгө
зоорь хураах гэж бүү бод. Харин бусдад
яаж туслах билээ, яаж өгөх билээ
гэдгийг л бод.




Амь бол хоол,
хувцастай зүйрлэхгүй
агуу зүйл. Бурхан талд
ургах сараана цэцгийг
гоёдог юм бол та нарыг
ч бас хувцаслана
шүү дээ.

Хүн бүхэн
Бурханы өмнө зогсож,
биеэрээ үйлдсэн сайн, муу
аливаа болгоныхоо төлөө
шүүгдэх цаг ирнэ.



Шашны удирдагч нарын
үйлддэг шиг бүү үйлд, яагаад гэвэл
тэд зааснаасаа өөрийг үйлддэг юм.
Тэд яг гаднаа гяланцаг дотроо
паланцаг хүмүүс.

Шударга байдал
чинь тэд нарынхаас
дээрдэхгүй бол та нар
хэзээ ч хаанчлалд орж
чадахгүй.




За, Та чинь тэгэхээр
нүгэлтнүүдийг хүлээж
аваад цуг сууж хооллодог
юм биз дээ? Би тэр Магдалын
Мариаг энд бас нүгэлтнүүдийн
дунд байхыг харж байна. Ийм
муусайн юмнуудтай цуг сууж
хооллочихоод Өөрийгөө яаж
шударга зөв гэж хэлж
чадаж байна аа?

Би та нарт
Бурханы зүрх сэтгэлийг
тайлбарлаж чадах нэгэн
түүх ярьж өгье.



Нэгэн
хүн хоёр хүүтэй
байжээ. Бага хүү нь
зөрүүд дураараа байсан
учир бие махбодынхоо
хүслийг гүйцэлдүүлэн
амьдрахыг хүсжээ.

Аанхаан, энэ
чинь ямар
гоё түүх вэ.

A comic book illustration depicting a scene with a shepherd and a man. The shepherd, on the right, has a long white beard and wears a blue robe with a gold patterned sash. He holds a wooden staff. The man on the left has dark hair and a beard, wearing a brown tunic. In the background, a flock of sheep is grazing in a green field under a blue sky. A large tree trunk is visible on the right. A large inset of a man's face with a beard and long hair is in the top left corner.

Тэгээд хүү нь одоо л өв хөрөнгөө авъя гэж эцгээсээ шаардаж гэнэ.

Аав аа, та миний хувийг одоо өгчихвөл би хот уруу очиж амьдралаа хөөмөөр байна.

Гэхдээ хүү минь, надад байгаа болгон чинь чинийх шүү дээ. Би тийм ч их удаан наслахгүй. Чи л ахтайгаа бүгдийг нь өвлөж үлдэнэ. Чи тэгээд цаашдын амьдралдаа санаа зовох юмгүй байна биз дээ хүү минь. Манайд зөндөө их хонь, үхэр байна. Манай газар будаа тариагаар жил бүр л дүүрэн байдаг. Бас манайх зөндөө олон үйлчлэгч зарц нартай...

Гэхдээ л би явж хорвоо ертөнцтэй танилцмаар байна даг. Би ингэж хөдөө газар малтай ноцолдож, бүх насаараа зарц боол шиг амьдармааргүй байна. Насныхаа залууд наргиж цэнгэж үзмээр байна. Манай найзууд ч ...



Танай найзууд яахав дээ хэзээ ч ажил хийж үзээгүй улс. Тэд үргэлж аль морь хурдан, аль дарс амттай, аль хүүхэн сайхан байна гэж л боддог юм чинь.

Та амьдралын талаар юу мэддэг юм бэ? Та үргэлж л энэ хэдэн мал, газар хоёртойгоо зууралдаж байгаа юм чинь. Би яг одоо л хувиа авъя. Би хот орж өөрийнхөөрөө амьдарна хө.




Наадахдаа өг өг. Бид тэрэнтэй тэрэнгүй болно. Ер нь ч наадах чинь ямар хийх юмаа хийдэг биш.

Тэгээд эцэг нь бага хүүдээ оногдох өв хөрөнгийг нь өгчээ. Хүү ч ус далай гатлан явж их хотод очин аз жаргалаа эдлэхээр одов гэнэ.

Хэнчюу хийхийг маань заахгүй энэ чинь л ёстой амьдрал байна даа.






Бага хүү...

Хөөх, ёстой
миний төсөөлснөөс
ч лаг юм байна. Энэ олон хүн,
энэ лаг байшингууд. Бүх юм
л энд болж байдаг байх
даа.

Хөлслөх
сайхан байр
олно хө.



Их давгүй
харагдаж байна.
Би авна аа.

Ямар нэгэн юм
хэрэг болбол зүгээр
л дуудаарай. Бид өдөр,
шөнөгүй үйлчилдэг
юм.

Одоо
ч үүнээс илүү яахав
дээ. Маргааш гадагш
гарч хүн хартай
танилцана хө.




Хөөе, хөдөөний залууэнд юубайгаа болоод чи хүрээд ирээв? Нүүр нь ил гарчихвал дажгүй байрын залуу байна шүү.

Хөөе залуу.
Чи ямар нэгэн юм хиймээр байвал наад сахал үсээ хусаад арай аятайхан хувцаслачих.



Бүдүүлэг гуай.
Энэ шинэ хувцаснуудыг
өмсчихөөр тийм ч муухай
харагдахгүй байна шүү.





Чи бидэнтэй
хамт зооглож
байгаа нь юутай
сайхан бэ.

Тэр одоо
сахал үснээсээ
салчихаад сайхан
харагдаж байгаа
биз дээ?



Шинэ найзынхаа
төлөө тулгачихъя. Үргэлж
ая тух, аз жаргалыг эдэлж
явах болтугай.

... бас
хайр дурлал.

Үйлчлэгч ээ,
найзуудад маань
дахиад дарс.




Хоёулхнаа танай
өрөө уруу явъя л даа,
тэгэхгүй юм уу?



Гэрээсээ алс хол
газар залуу хөвгүүн
их хангалуун хэдэн сар
амьдарч гэнэ. Мөнгөө
дуустал их олон найзтай
байлаа.



Зугаа
цэнгэлийн хойноос
хөөцөлдөн тэнэглэсээр байтал
хамаг мөнгө нь барагдав.
Гэхдээ ч түүнд нэлээн хэдэн
чинээлэг найзууд байлаа.




Ямар ч мөнгө
байхгүй болсон гэдэг
чинь юу гэсэн үг вэ? Би
чамайг баян гэж бодоод
байсан шүү дээ.


Энд амьдрах чинь
аймшигтай үнэтэй байдаг юм байна.
Сүүлчийнхээ мөнгийг өнгөрсөн долоо
хоногт уралдааны бооцоонд тавиад
алдчихсан. Миний бооцоо тавьсан нөхөр
яг түрүүлнэ гэж бодсон чинь...

Чи тэгээд
хоосорчихсон гэсэн үг
үү? Чи нөгөө амлаад
байсан хувцсаа надад
яаж авч өгөх юм бэ?

Би танай
аавыг аж ахуйдаа
удирдлагын ямар нэгэн
ажилд намайг авах байх
гэж найдаж байсан шүү
дээ.

Ажил аа?





Би өөрийгөө
энэ балиар заваан
гахайнуудыг тэжээх
ажил хийж байна гэж
ёстой итгэмээргүй
юм.

Найз нөхөдтэй
боллоо гэж бодож
байсан юм сан. Гэтэл
одоо дуугардаг ч үгүй юм
байна. За яах вэ, гайгүй
сайн ажил олж хийгээд
буцаад дээшээ гарна
даа.

Гох

Гах

Гох



Чиний өвчтэй
зовлонтой байх надад
хамаа алга. Эндээс холдож
тэр гахайнуудаа малла.
Чамайг халчихаад өөр хүн
ажилд авчихна шүү. Одоо
эндээс зайл.

Тийм ээ
ноёнтоон, Уучлаарай.
Тэгэлгүй яах вэ...




Энэ ажил
үнэндээ тааруухан
хоол авчихаар ч үнэ
хүрэхгүй юм. Нөгөө миний
найз шиг юмнууд лаг хоол
идэж байгаа
байх даа.



Би чинь ямар
байдалд орчихоо вэ.
Би бүр өлсөж, ядарч, даарч
хөрч байна. Энэ гахайны хоолыг
идэхэд ч бэлэн байна. Манай аавын
зарц, үйлчлэгчид идэж чадахаасаа
ч илүү хоол ундтай байгаа даа. Би
зүгээрл... гэхдээтэгж хаяж явчихаад
яаж буцаж очих вэ дээ. Тэд нар
намайг тоохгүй байх даа.


Би
ямар тэнэг байсан
юм бэ. Хэрэв намайг яваад
очиход боол бол гэвэл яах вэ?
Би чинь ааваасаа авснаа бүгдийг
нь үрчихсэн хүн шүү дээ. Тэд л
намайг боолоо болгодог юм
бол боол болсон ч яах вэ
дээ.





Би
ерөөсөө
явна аа.

Тэнэг
амьтан! Ямар ч
мөнгөгүй юм
чинь чи мянган
бээр алхаж дээ.



Арваад өдөр
явсны эцэст
гэртээ дөхөн
ирэв гэнэ.

Бараг
хүрээд ирлээ.
Би ямар ч юм горьдох
эрхгүй хүн дээ. Ингэж л хэлье
дээ. " Аав аа, би нүгэл үйлдэж
таны хүү байх эрхгүй болсон
хүн. Намайг хөлсний зарц
нарынхаа нэг болгож аваач."

Чи тэр ирж яваа хүнийг харж байна уу? Миний нүд бүр урдных шигээ харахаа байчихаад байгаа юм. Алхаж явааг нь харахад удаан алга болсон хүүтэй минь адилхан харагдаад байх юм.



Тийм байна аа. Жаахан ахимаг бас нэлээн туранхай харагдаад байна. Гэхдээ яг таны хүү мөн юм шиг байна.




Миний
хүү!




Миний
хүү, миний хүү!
Чи гэртээ хүрээд
ирлээ шүү дээ!

Аав аа,
Би таны өмнө нүгэл
үйлдсэн...



... тэгээд би таны
хүү гэж дуудагдах
эрхгүй болсон...




Бид чамайг үхсэн
гэж бодож байсан
тэгтэл чи амьд байна.
Бид нар чамайг
бушуухан угааж
арчаадахъя.


Чи ийм байдалтай гэрт
орж болохгүй. Зарц нар маань чамд
хамгийн сайн хувцас, гутал аваад ирэг.
Бөгж чинь алга болчихож. Чамд чинь бөгж
хэрэгтэй юм байна шүү дээ. Миний алга
болчихсон хүү олдчихлоо.



Хамгийн тарган
бяруу нядлаад найр
хийхэд бэлд. Хүмүүсийг
урь, баярлаж хөөрөх
учиртай сайхан өдөр
тул бүгдээрээ баяр
тэмдэглэнэ ээ.



Энэ гайхамшигтай
үйл явдалд оролцохоор
хүрэлцэн ирж баяр хөөрийг
минь хуваалцаж байгаа та
бүхэндээ баярлалаа. Энэ бол
миний амьдралын хамгийн аз
жаргалтай мөч юм аа.



Том ах нь хэдэн өдөр юманд явсан байлаа. Гэртээ эргэж ирэхэд нь найр наадам болж байв.

Энэ сонсогдоод байгаа дуу хөгжим, бүжиг наадам чинь юувэ?

Дүү чинь ёстой нэг өрөвдмөөр амьтан гэртээ эргэж ирээд. Бүр турж ядарсан, ядуу хоосон хүн ирсэн. Тэгээд аав чинь дүүг чинь ирлээ гээд баяр наадам болж байна. Бушуухан ороорой.

Би наад тэнэглэлд чинь оролцохгүй. Тэр чинь гэм нүгэл, гутамшиг шившиг дүүрэн амьдралаар амьдарч яваад ирсэн хүн.

Зарц нь орж аавд хүүгийнх нь хэлснийг хэлтэл түүнтэй ярилцахаар аав нь гарч ирэв.

Би удаан гэгч нь түүнийг эрж хайж байсан юм. Тэгээд хүүгээ үүрд алдчихлаа гэж бодож байлаа. Сүүлдээ цөхөрч найдлага тасрах гэж байтал өөрөө хүрээд ирдэг байна. Энэ их ивээлд итгэж байна уу? Бурхан үнэхээр сайн юм аа!




Яахаараа тэр муу нүгэлтэнтэй цуг хөөрч баярлаад байгаад тань итгэхэд бэрх байна. Би тийм юманд оролцохгүй ээ.



Сайхан л түүх
байна. Гэхдээ та биднийг
том хүүтэй адил гэх гээд
байна уу даа?


Сонсох чихтэй
нь сонсогтун.

A comic book panel depicting a scene with several men. In the foreground, a man with a beard and a purple hat looks towards the right with a serious expression. In the background, a man in a yellow robe is being escorted by a man in a green robe. Another man in a purple hat is visible in the lower right foreground.

Энэ хүн үнэхээр
аюултай хүн байна. Бүх
хүн Тэрнийг хайрлаж
байна.

Тэр тэдэнд
найдвар өгөөд
байгаа юм.


Тийм ч гэсэн тэр чинь хоосон найдвар.
Ямар хүн нүгэлтэй хүнд мөнх амийг амлаж чаддаг
байна аа? Тэр үхэх ёстой. Бүгдийг нь дууд. Өнөө
шөнө бүгдээрээ ахлах тахилчийнд уулзацгаая.



Нааш ир. Бүгдээрээ Галил уруу буцан явж хэсэг амарцгаая. Намайг баривчлах цаг тун дөхөж байна. Тэд намайг доромжилж, дараа нь цовдолно. Гэхдээ би гурав дахь өдөр нь үхлээс амилна.

“Үхлээс амилна” гэдэг чинь юугэс эн үг вэ?

Ёстой мэдэх юм алга. Аягүй л бол сургаалт зүйрлэл л байх.



Эзэн, яаралтай юм боллоо! Марта намайг Таныг олоод ирээч гэлээ. Ах Лазар нь үхлүүт өвчтэй байна. Тэр чинь Таныг сайн найз шүү дээ. Одоо түргэхэн явбал өнгөрөхөөс өмнө очиж амжих байх. Бид нар мэдэж байна. Та л түүнийг эдгээж чадна.


Мариа, Марта хоёрт намайг очно гэж хэл. Бас энэ өвчин бол үхлийн төлөө биш, Бурханыг алдаршуулахын төлөө юм гээд хэлчихээрэй.

Лазар өвдчихөж. Бүгдээрээ хурдалъя!

Хоёр өдрийн дараа

Эзэн, бидний анд
Лазар үхлүүт өвдлөө
гэж дуулдаад хоёр өдөр
өнгөрчихлөө. Бид нар очих
гэсээр байтал бас дахиад
хоёр өдөр болно. Одоо
явахгүй юм уу?


Маргааш
явна аа. Та нар
Бурханы алдрыг
үзэх болно.



Эзэн, одоо дөрөв
хоног хэтэрчихээд
байна. Тусалж амжих
юм болов уу?

Лазар одоо
үхсэн. Бурханы
алдрыг тар нар
үзэж итгэх учраас та
нарын төлөө Би тэнд
байгаагүйдээ баяртай
байна.

Үхсэн?
Лазар үхсэн
гэнэ ээ?




Есүс
дагалдагчдынхаа
хамт гадаа хаалган
дээр байна.

Үгүй ээ!

Иинийй!

Тэд нарыг намайг хүлээж бай
гээд хэлчих. Энэ олон фарисайчууд,
тахилч нарыг энд байхад тэд нар энд
орж ирэх нь аюултай. Эд нар одоо ч
Түүнийг алахаар хайж байгаа.

Хөөрхий муу
Лазар минь!



Эзэн, Та энд байсан бол ах маань
үхэхгүй л байх байсан юм даа.
Гэхдээ Та одоо гуйсан ч Бурхан
Таны хүссэн болгоныг хийж өгнө
шүү дээ.


Ах
чинь үхлээс
амилна.

Энэ ертөнцийн
төгсгөлд амилалтын
өдөр эргэн амилахыг
нь ч мэдэж л байна
л даа.



Би бол амь
бөгөөд амилалт
юм.

Надад
итгэдэг хүн үхэвч
эргэн амилах болно.
Амьд байгаа надад
итгэдэг хүмүүс хэзээ
ч үхэхгүй. Чи үүнд
итгэж байна уу?

A close-up comic book illustration of a woman with a blue headscarf. She has a surprised or reverent expression, looking upwards and to the right. Her right hand is raised, palm facing forward, in a gesture of awe or testimony. A white speech bubble with a black border is positioned to her right, containing Mongolian text. The background is a simple blue sky with some dark, horizontal brushstrokes.

Тийм ээ
Эзэн. Таныг энэ
дэлхийд ирнэ гэж эш
үзүүллэгээр хэлэгдсэн
Бурханы Хүү Мессиа
гэдэгт би итгэдэг.

Марта Есүстэй ярьсныхаа
дараа Мариаг авчруулахаар
зарцаа явуулжээ.

Ииииййй.



Нааш ир.
Мариа булш уруу
очиж гашуудан
уйлахаар явчихлаа.




Эзэн
Та энд байсан бол
ах маань үхэхгүй
байсан шүү дээ.

Та нар
түүнийг хаана
тавьсан бэ?




Бидэндээ
ёстой их
үгүүлэгдэж
байна даа.



Хараач Есүс
Лазарт үнэхээр
хайртай байжээ.

Хараагүй хүмүүст
хараа оруулаад байсан
хүн өөрийнхөө анд нөхрийг
үхүүлэхгүй байж болоогүй
л юм байх даа.





Чулууг
өнхрүүл
дээ.

Би чамд Надад
итгэвэл Бурханы алдрыг
харна гэж хэлээгүй бил
үү? Чулууг зайлуул.

Гэхдээ Эзэн минь.
Одоо үмхийрчихээ
байлгүй дээ. Өнгөрөөд
дөрөв хоночихлоо
шүү дээ.

Эцэг минь ээ,
Та намайг сонсдогт баярлалаа.
Би Өөрийнхөө төлөө залбираагүй
ээ. Яагаад гэвэл Та Намайг үргэлж
сонсдог билээ. Харин Би яг одоо энд
хараад зогсож байгаа хүмүүс Таныг
Намайг илгээсэн гэдэгт итгээсэй
гэсэндээ залбирч байна. Аав аа, Та
Өөрийгөө алдаршуулаач.






Лазар аа,
гараад ир.


Энэ удаа ч
ёстой арай
дэндлээ.

Тэглээ.
Одоо л харин
нэг Өөрийнхөө
тэнэгийг
харууллаа даа.



Яагаад ингэж
байгаа юм бэ? Бие нь
аль хэдийн муудчихсан
биз дээ.

Энэ олон хүний
нүдэн дээр Өөрийгөө өртэй
болгож байхад ч харин бидний
хувьд Өөрт нь үхэх ял оноохоор
барьж авахад амархан
боллоо доо.




Юу?
Ёстой
итгэмээр
гүй юм.

Байж
боломгүй
юм.



Бурханд алдар
нь байг!

ХҮҮҮЕЭЭЭ!

A comic book panel featuring two women. The woman on the left is wearing a yellow headscarf and has a wide-eyed, open-mouthed expression of surprise or joy. The woman on the right is wearing a blue headscarf and has a similar expression, with her hands clasped near her chest. The background is a simple light blue gradient.

Мариа! Есүс
амилуулчихлаа!
Амилуулчихлаа
шүү дээ.

Амилчихсан!
Дөрвөн өдрийн
дараа ах маань
амилчихлаа.

Үхээд дөрөв
хоносныхоо
дараа Лазар
булшнаасаа хөл,
гар нь даавуугаар
ороолгоостой
гарч ирэв.

Боолтыг
нь тайлаад
явуул!

Бурханаас өөр
хэн ийм юм
хийж чадах вэ?




Энэ их үймээн
шуугиан чинь юу
вэ? Энэ ороолт
даавууг аваадахаач.

Чи дөрвөн
хоног үхсэн
байсан шүү
дээ.

Эзэн минь
Тантай дахиад
уулзах сайхан байна
шүү. Намайг буцаан
авчирсныг Та л
хийсэн байх даа.





Лазар ах
минь бид нар
таныг зөндөө
санасан шүү.

Би өлсөж байна.
Энэ гашуудагсдыг
явуулчихаад юм
идэцгээе.


Бидний Эзэн
Бурхан ерөөгдөх
болтугай.

Харсан юмандаа чи итгэж байна уу? Тэгж хуурчих ямар ч арга байгаагүй л юм даа. Би бүр оршуулахаас нь өмнө харсан юм чинь. Ямар ч эргэлзээгүй, яахын аргагүй үхчихсэн л байсан юм даа.



Иеурсалимынхан үүнийг сонсоод Тэрнийг хаан болгоно доо. Бушуухан нэг арга бодохгүй бол болохгүй нь.


Бүгдээрээ Фарисайчууд, бичээчдэд бушуухан очиж хэлье.



Энэ Есүс өнөөдөр
ёстой том мэхэллээ. Саяын
явдлыг харсан хүмүүс хүртэл
Түүнийг үнэхээр л үхсэн хүнийг
амилуулчихсан гээд итгэчихлээ
шүү дээ.


Үүнийг яаж
хийсэн нь хамаа алга.
Зогсоохгүй л бол хамаг
хүмүүсийн сэтгэл зүрхийг
бүр эзэмдэж гүйцлээ.

Дахиад нэг л
үймээн самуун гарвал ромчууд
бидний эрх мэдлийг аваад
хаячихна даа. Тэд бидэнд амгалан
тайван байдлыг хамгаалах үүрэг
өгсөн юм байгаа юм.



Гэхдээ Есүс
хэзээ ч хэрцгий балмад юм
хийж байгаагүй, бас ромчуудын
эсрэг юм ярьдаггүй шүү дээ.

Гэхдээ Есүс хэзээ ч
хэрцгий балмад юм хийж
байгаагүй, бас ромчуудын
эсрэг юм ярьдаггүй
шүү дээ.



Тэрнийг
зайлуулах
хэрэгтэй. Тэр
Өөрийгөө үхлээс
босгож чадахгүй
ээ.

Үүнийг удааж
болохгүй. Манай
шашны нэр хүндийг
юуч үгүй унагаахаас
нь өмнө дуусгая.


Ромчууд
бидний эсрэг
ямар нэг хийхээс
нь өмнө хөдөлье.

Тэд Намайг үгүйсгэж
алахаар хуйвалдаж байна. Намайг өөрсдийнх
нь авралын төлөө ирснийг ойлгосонгүй дээ.
Намайг явсны дараа ромчууд тэдний хайрлаад
байгаа сүмийг устгана. Нэг чулуу нөгөө дээрээ
давхарлан үлдэхгүйгээр товрог болгоно.




Намайг хайрладаг хүмүүс шорон гянданд хаягдах цаг ирнэ. Надад хайртайгийн чинь төлөө л та нарыг бүх үндэстэн үзэн ядна. Та нарын зарим чинь тэдний гарт үрэгдэнэ. Зарим чинь гэр орноосоо цөлөгдөж, ажиллаж хөдөлмөрлөх эрхгүй болно. Дайн дажин, гай гамшиг, газар хөдлөлт, өвчин тахал, өлсгөлөн зовлон тохиолдоход бүү гайхагтун. Гэхдээ эдгээр зүйлстэй цуг төгсгөл ирэхгүй.






Эдгээр зүйл бол
ирэх зовлонгийн зөвхөн
эхлэл нь юм. Иерусалим
харийнханд эзлэгдэж тэдний
цаг үе хүртэл байна. Хэн нэг
нь та нарт Намайг ирсэн байна.
Ийшээ очиж, эсвэл тийшээ
очиж Надтай уулз гэвэл тэдэнд
бүү итгэ. Ирээдүйд хуурамчаар
Намайг орлох эсвэл
хуурамчаар Миний өмнөөс
ярих олон хүн гарна.




Харин Би буцан
ирэхдээ аянга цахилгаан
цахилах мэт ирнэ. Нүд
болгон Намайг харна. Үхэгсэд
амилуулагдаж Би газар дэлхий
дээр ноёрхлоо тогтооно. Гэхдээ
үүнээс өмнө энэ дэлхийд
урьд хожид болоогүй их
зовлонгийн үе болох юм.



Эзэн, Марта
намайг Таныг олоод
ир гэж явууллаа. Таныг
дагалдагч нарынхаа хамт
гэртээ урьж байна. Танд
цаашид Иерусалимд байх
аюултай болсон байна.
Та манай эзнийг үхлээс
амилуулсанд зарим хүмүүс
дургүй байгаа юм. Та явж
бидэнтэй цуг жаахан
байхгүй юу?


Бид дуртайяа танайд
очно. Өөрийнхөө зовлонг
ирэхээс өмнө тэдэн дээр
сүүлчийн удаа бас очмоор
байна.

A comic book illustration showing Jesus, a man with a beard wearing a purple robe, standing in front of a stone building with a wooden door. He is gesturing towards a group of people. To his left, two women in green and blue robes stand together. In the foreground, a group of men in various robes are seen from behind, looking towards Jesus. The scene is set outdoors with a large tree on the right and some foliage on the left.

Энэ чинь
Есүс дагалдагч
нарынхаа хамт ирж
байна шүү дээ.


Эзэн, манай гэр
бол Танай л гэр гэсэн
үг шүү. Наашаа орж
ирж тухлаач.

Лазар минь, чи урьдахаасаа
хамаагүй дээр болсон харагдаж
байна шүү. Булшин дээр чинь
очсоноос гэрт чинь ирнэ гэдэг
шал өөр байна шүү мэдээж.




Бид зоог
бэлдчихлээ. Зочдыг
ч урьчихсан байгаа.

Эзэн Та
бол үнэхээр амь
бөгөөд амилалт
юм аа.



Эзэн, би
баттай эх сурвалжаас
иудейчүүд Таныг хүчээр
баруулаад алуулахаар
шийдчихсэн байгааг
олж дууллаа.

Би ертөнцийн төлөө
амиа өгөхөөр энэ ертөнцөд
ирсэн юм аа. Би баригдаж,
цовдлогдох боловч гурав
дахь өдрөө үхлээс эргэн
амилах болно.




Та бол амь
ба амилалт мөн. Танд
итгэгч хүн хэзээ ч
үхэхгүй.

Мариа чи наад
муутгадаггүй үнэрт
тосоороо юухийгээд
байгаа юм бэ?





Миний
Эзэн, Та бол амь
ба амилалт мөн.
Та хэдий үхлээ ч
эргэн амилна.



Мариа наад үнэртэн
чинь нэг хүний жилийн
цалинтай тэнцэнэ шүү дээ.
Яагаад наадхаа дэмий үрээд
байгаа юм бэ?


Мариа Эзэнийг
тосолж байна
шүү дээ.

Үүнийг чинь
зараад мөнгийг нь
ядууст өгч болох
байсан юм.

Мариа Есүсийн
хөлийг үсээрээ
арчлаа.



Мариаг орхи
доо. Тэр болох
гэж буй оршуулгын
минь төлөө ингэж
байгаа юм.



Оршуулга
гэж юуяриад
байгаа юм
бол оо?

Есүс Өөрийгөө
цовдлогдоно гэж яриад
байсан. Гэхдээ яг жинхэнээсээ
цовдлуулж үхэх тухай
яриагүй байлгүй дээ.

Би та нарт хэлье.
Сайн хоньчин сүргийнхээ
төлөө амиа өгдөг юм. Би
баривчлагдан, цовдлогдож,
оршуулагдаад гурав дахь
өдрөө эргэн амилна.



Мариа миний
биеийг оршуулгад бэлтгэж байна.
Миний цаг иржээ. Миний алдаршуулагдах
тэр цаг болсон байна. Нааш ирцгээ.
Бүгдээрээ одоо бүх юм болох Иерусалим
уруу явах ёстой.



Эзэн, бүх
Иерусалимынхан
Таны ирэхийг
хүлээж байна!

Яваад миний
унах илжгийг олоод ир.
Бүгдээрээ эцсийн удаа
Иерусалим орцгооё.



Эзээн, олон мянган хүн Иерусалимд ирэхийг тань хүлээж байна. Тэд Таныг хаан болгох гэж байгаа юм.


Би баривчлагдан, цовдлогдоод гурав дахь өдрөө үхлээс амилна.



Иудейн
Хаан
мандтугай.

Эзний
нэрээр ирэгч нь
ерөөлтэй еэ.


Давидын
Хүү магтагдах
болтугай.



Израилийн
Хаанд зам
тавьж өгөгтүн.

Бурханд
магтаал нь
очих болтугай.

Амлагдсан
аугаа
чөлөөлөгч.




Хүмүүс
Түүнийг бүр Иудейн
хаан гэж байх шив
дээ!

Тэд Түүнийг
амлагдсан нэгэн болох
Мессиа гэж бодоод
байгаа юм.


Тэр яагаад сүм
уруу ирж байгаа юм бол?
Өөрийнх нь амь насанд
аюултай болсон гэдгийг
мэдэж л баймаар юм.

Давидын
Хүү минь ээ,
биднийгээ
чөлөөлөөч.



Тэд Бурханы
өргөөг доромжилсоор
л байна даа. Залбирлын
гэр гэхээсээ илүү
худалдаа наймааны
зах шиглболждээ.

Тандлгэж
их сайн хямдхан үнээр өгнө шүү.
Өргөлд аль хэдийнэ батлагдчихсан
юм шүү.

A detailed illustration of a bustling ancient marketplace. In the upper left, a man in a green tunic weighs goods on a scale. To his right, a man in a brown robe is seen from behind, carrying a large basket on his head. In the center, a man in a purple robe stands near a counter where a man in a white tunic is handling coins. To the right, a man in a blue robe stands near a table with several large earthenware jars. In the foreground, a man in a white tunic is being held back by a man in a green tunic. The scene is filled with various items like baskets, jars, and coins, suggesting a busy day of commerce.

Өө уучлаарай.
Өөр ханшаар авах гээд
байгаа юм бол өөр хүн
дээр оч. Би чамд ханшаа
хэлчихсэн.

Есүс дахиад л
сүмийг дээрэмчин,
тонуулчдаас цэвэрлэв.

Энэ бараа
таваараа миний Эцгийн
гэрээс гарга. Та нар бол
хулгайч, дээрэмчид.

Та нар бол энд
залбирахаар ирэгсдийн
мөнгийг тонож байгаа
хүмүүс. Хөрөнгө, мөнгө
чинь та нартай цуг там
уруу тонилох болтугай.



ТАР НЯР!

Хараач!




Миний
Эцэгийн гэрийг
дээрэмчдийн үүр
бүү болгоцгоо.

Tac!

**ТҮН
ТАН!**


Чи өөрийгөө хэн
гэж бодоод байгаа
юм бэ?

Ямар
эрх мэдлээр чи
ингээд байгаа
юм бэ?



Эзээн, тахилчид, фарисайчууд
бид нарыг тагнуулахаар туршуул
явуулчихсан байна. Дээгүүр өнгөрөх
баяраас өмнө Таныг шоронд хорино гэсэн
яриа яваад байна. Дээгүүр өнгөрөх баяр
чинь одоохон хэдхэн хоногийн дараа
болох гэж байгаа шүү дээ.

Иерусалимд тийм сүр
дуулиантай орж ирчихээд сүмийг
цэвэрлэнэ гэдэг чинь ямар утгатай
болохыг мэдэж байна уу?




Би та нарт
Өөрийгөө тэдний гарт
орон зовж, цовдлогдоод
гурван өдрийн дараа
үхлээс амилна гэж
хэлсэн биз дээ.

Би та нарт Өөрийгөө тэдний
гарт орон зовж, цовдлогдоод гурван
өдрийн дараа үхлээс амилна гэж
хэлсэн биз дээ.

Дээгүүр өнгөрөх
баяраас өмнө л зогсоох хэрэгтэй
байна. Дагалдагч нарынх нь дунд
манай туршуул байгаа.

Би та нарт анхааруулж байна. Намайг явсны дараа тэд та нарыг шорон гянданд хорьж, тамлан зовоож, бүр заримыг чинь алах болно. Тэгэхэд та нар тэдэнд Миний хайр, хүч чадлыг гэрчлэх юм. Тэд та нарыг шүүхэд аваачихад Би та нарын аманд үгээ өгнө.


Хүүхдүүд нь эцэг эхийнхээ эсрэг гэрчилж, эцэг эх нь хүүхдүүдийнхээ эсрэг хандана. Та нар Намайг мэддэг учраас бусдад үзэн ядагдана. Маш олон хуурамч эш үзүүлэгч миний нэрээр гарч ирнэ. Ариун Сүнс та нартай цуг байх болно.



Эзэн, Таныг эргэж ирэх болон дэлхийн төгсгөл ирэхэд ямар ямар тэмдгүүд бий болох юм бэ?




Хэн нэгэн хүн та нарт Намайг төдийд, өдийд ирнэ гэх юмуу эсвэл тийм ийм газар ирнэ гэвэл тэдэнд бүү итгэгтүн. Миний ирэх нь гэрлийн хурдаар мэт гэнэт байх юм. Надад итгэлтэй байгтун. Тэгвэл та нар нүгэлтнүүдийн дээр буух шийтгэлээс аврагдана. Миний ирэх цаг мөчид бэлэн байхын тулд хянуур байгтун.



Ноагийн өдрүүдэд ямар байсанчлан Миний ирэх нь ч тийм байх юм. Хүмүүс зав чөлөөгүй зугаа цэнгэл хөөцөлдөж, үер болж өөрсдийг нь урсган авч явах хүртэл юуч мэдээгүй юм. Хулгайч шөнөөр гэтэх мэт Би гэнэт ирнэ.


Хоёр хүн талбайд ажиллаж байхад нэг нь Надтай уулзахаар авагдаж, харин нөгөө нь зовохоор үлдэх юм.

Хоёр хүн гурил тээрэмдэж байхад нэг нь авагдаж, нөгөө нь үлдэнэ. Та нарыг мэдээгүй байхад Би ирэх тул бэлэн байхын тулд болгоомжтой ажиглаж байгтун.



Эзэн, би хот
орж хүнтэй уулзах
хэрэгтэй учраас
явлаа. Дараа ирнэ.

Иудас минь
явж хүссэнээ хий.



Үнэ мөнгө
чинь зөв байвал би
Есүсийг та нарын гарт
барьж өгнө

Иудас
чи чинь тэдний
дагалдагч нарын
нэг биз дээ?


Тийм л дээ. Би гурван
жил Түүнтэй явлаа. Одоо бүр
залхаж байна Шал солиотой юм
ярьдаг юм. Би мөнгийг нь
ашигладаг байсан юм.

Миний
алдаршуулагдах
цаг болжээ. Буудайн
үр газар унаж үхэхгүй
бол ганц чигээрээ л
үлдэнэ. Харин унаж
үхвэл олон тариан
түрүү болон үржих
юм.




Одоо Миний сүнс зовон шаналж байна. Яадаг юм билээ. "Эцэг минь намайг энэ цаг мөчөөс авраач"? Үгүй ээ, энэ л хэргийн төлөө Би энэ дэлхийд ирээ биз дээ.





Эцэг минь,
Та Өөрийнхөө нэрийг
алдаршуулаарай.



Би Өөрийнхөө
нэрийг аль хэдийнэ
алдаршуулсан, одоо ч бас
дахин алдаршуулах
болно.

Яг тэнгэр
дуугарах шиг
чанга байсан
шүү.


Бурхан
Түүнтэй ярилаа!

Тэнгэр
элч Түүнтэй
ярьсан!

Тэр дуу бол Миний
төлөө биш та нарын төлөө
байсан юм. Одоо энэ ертөнцийн
жонон Сатаны ялагдах цаг ирлээ.
Би загалмай дээр өргөгдөхдөө
олон хүнийг Өөртөө
ойртуулах юм.

Эш үзүүлэгчид
Мессиаг мөнх амьдарна
гэж хэлсэн байдгийг бид
мэднэ. Гэтэл та өөрийгөө
үхнэ гэж хэллээ. Тэгвэл
хэн Мессиа болж
байна аа?





Одоо тун богинохон цаг хугацаанд та нарт гэрэл байна даа. Гэрэл байгаа дээр та нар Түүнд итгэгтүн. Тэгвэл та нар бас Бурханы хөвгүүд болж болох юм.

Надад бол солиотой сонсдож байна.




Намайг
болоод Үгийг минь
үл тоож байгаа хүн
Бурханыг бас үл тоож
байгаа хэрэг.
Би бол хорвоогийн гэрэл.
Хэрвээ та нар Надад
итгэвэл харанхуйгаас
тусгаарлагдаж мөнхийн
амьтай болох юм.



Арван
нэгдүгээр
бүлэг

ДЭЭГҮҮР
ӨНГӨРӨХ БАЯР
БА ХРИСТИЙН
ЗОВЛОН



Явж
Дээгүүр
өнгөрөх баяраар
идэх зоогийг
бэлтгээрэй.

Би загалмайн
зовлонг амсахаасаа
өмнө энэ зоогийг та нартай
идэх хүсэлтэй байна. Бурханы
хаанчлал энэ дэлхийд иртэл
дахин Би та нартай үүнийг
идэхгүй юм. Тэр үед та нар
Надтай хамт Миний ширээнээс
хооллож Израилийн арван
хоёр овгийг захирахаар
сэнтийнүүдэд залрах юм.

Ирээдүйд ийм зүйл
болоход та нарыг итгүүлэхийн
тулд Би нэгэн зүйлийг та нарт
хэлье. Бичээсийн Дуулал 41:9 -д
"Миний талхнаас идэж байсан дотно
найз минь ч Миний эсрэг өсгийгөө
өргөсөн" гэж хэлсэн байдаг. Та нарт
хэлье, Надтай цуг гараа ширээн дээр
тавиад сууж байгаа та нарын нэг
чинь Надаас урвана.

Тийм юм
бүү байг!



Хийх нь
тодорхой болсон
ч тэр хүн бүү тийм
юм хийгээсэй.



Эзээн, тэр чинь
би юм уу? Би л лав
Танаас уравмааргүй
байна.

Эзэн тэр
чинь би биш
биз дээ?

Эзээн,
Би Танаас хэзээ ч
урвахгүй.





Талхаа аяганд
дүрж байгаа хүн бол
тэр хүн мөн.



Бид нар
бүгдээрээ л
талхаа аяганд
дүрсэн шүү
дээ.

Иохан Есүсээс хэн Өөрөөс нь
урвахыг шивэгнэн асуухад Есүс
хариуд нь "Би талхаа дүрээд
өгч байгаа хүн юм аа" гэв.



Эзээн, энэ чинь
би юм уу?


Чи өөрөө
хэлчихлээ.

Есүс талхаа дүрээд
Иудаcт өгөв.




Чи хийх гээд
байгаа юмаа
түргэн хий.





Иудас
хааша явж
байгаа юм
бэ?


Цаадах чинь мөнгө
барьдаг болохоор Эзэн нэг тийшээ хурдан
яв гэсэн, бодвол ядууст тусламжийн юм
авч өгөх гэж байгаа юм байлгүй.



Одоо Би
алдаршуулагдах болно.
Бяцхан хүүхдүүд минь
одоо Би та нартай удаан
хамт байхгүй ээ.


Та нар Миний очих
газар очиж чадахгүй. Би та
нарт бие биенээ хайрла гэсэн
шинэ тушаал өгч байна. Та нар
бие биенээ хайрлаж байвал
түүгээр чинь хүмүүс та нарыг
Миний дагалдагч гэж таних
болно.

Зехариа энэ цагийг ингэж
зөгнөн хэлсэн байна. "Би хоньчинг
цохиход хонин сүрэг тарж алга
болно" гэжээ. Би үхлээс амилсныхаа
дараа та нараас урьтаж Галил уруу
очно. Өнөө шөнө та нар бүгдээрээ
намайг үгүйсгэнэ.



Бусад нь
бүгдээрээ Таныг
үгүйсгэлээ гэхэд би
л хэзээ ч тэгэхгүй.


Петр ээ
азарган тахиа хоёр
донгодохоос өмнө чи
надаас гурван удаа
урвана даа.



Би Танаас урвахын
оронд Тантай цуг үхсэн
минь дээр.

Би л лав
Танаас урвана
гэж байхгүй.

Тэд намайг Танаас
урватал тамлана
гэж байхгүй.



Бичээст тодорхой байгаа юм аа. Та нар бүгд л урвана. Эш үзүүлэгч Исаиа миний талаар ингэж хэлсэн юм. "Тэр яг нүгэлтэн шиг шийтгэгдэнэ" гэжээ.

Петр чи дахин Надад итгэж найддаг болсныхоо дараа ах дүүсээ итгэлээр зоригжуулаарай.




Газар
шорооноос талх
тариа ургуулагч
ертөнцийн их Хаан
бидний Бурхан Эзэн
минь, Та ерөөгдөх
болтугай.

Энэ талх
та нарын төлөө
өргөгдөж буй биеийг
минь төлөөлнө. Та
нар Дээгүүр өнгөрөх
баярыг тэмдэглэх
бүрдээ Намайг
дурсан санаарай.



Бие минь та
нарын төлөө
эмтэрнэ.



Үүнийг
авч бүгдийг
нь идэгтүн.




Энэ аяга та
нарын нүглийг цайруулахаар
урсах, миний цусаар тогтоох
шинэ гэрээний төлөөлөл юм.



Бие биендээ
дамжуулж бүгдийг
нь уугтун. Өөрийнхөө
хаанчлалд дахин та нартай
хамт уух хүртлээ Би усан
үзмийн дарс уухгүй.

Ирээдүйд та нар Миний
үхлийг дурсан Намайг эргэж
иртэл үүнийг хийж байх юм.






Миний ярьсан зүйлээс
болж битгий айж тэвд. Миний
Эцэгийн гэрт орд харш олон
бий. Би явж та нарт орон байр
бэлтгэн эргэж ирээд та нарыг
Өөрийн байгаа газар
авч явна.



Гэхдээ Эзэн
минь бид Таны хаашаа
явж байгааг мэдэхгүй
шүү дээ. Тэгэхээр Тан
уруу очихоо бид нар яаж
мэдэхюмбэ?




Би Өөрөө зам, үнэн, амь
учраас та нар замыг мэднэ. Надаар
дамжихгүйгээр ямар ч хүн Бурханд очиж
чадахгүй. Хэрвээ та нар Намайг мэддэг
бол Эцэгийг ч гэсэн мэднэ гэсэн үг. Бас
Түүнийг харсан билээ.



Эзэн Та бидэнд
Эцэгээ үзүүлээч тэгвэл
бидний санаа амарна даа.

Филип ээ чи Надтай ийм
удаан цуг байчихаад одоо
болтол Намайг мэдэхгүй гэж үү?
Хэрвээ чи Намайг харсан л бол
Эцэгийг минь бас харсан шүү дээ.
Эцэг бид хоёр нэг юм.



Би та нарыг дангаар
чинь орхихгүй ээ, эргэж ирнэ.
Ертөнц Намайг дахин харахгүй.
Гэхдээ харин Би та нарт Ариун
Сүнсийг явуулахад Тэр та нарын
дотор байж та нарыг тайвшруулна.
Тэр та нарын дотор байж, та
нарыг үнэн уруу дагуулна.

Хэрвээ та нар Намайг хайрлаж
байвал тушаалуудыг минь
биелүүл. Дэлхий та нараас булаан
авч чадахгүй тийм амар
тайвныг Би та нарт өгнө.



Та нар Надад хайртай
л бол Эцэгтээ эргэн очих гэж
байгаад минь баярлана даа.
Эдгээр зүйлийг болохоос нь
өмнө хэлж байгаагийн минь
учир гэвэл биелэгдэхийг нь
хараад та нарыг итгээсэй гэсэн
дээ юм шүү.


Босоцгоо, бүгдээрээ
магтан дуулчхаад ц эцэрлэгт
очиж залбирцгаая.



Есүс арван нэгэн
дагалдагчийнхаа хамт
сүүлчийн магтууг дуулав.

Миний
араас чимээгүй яв.
Одоо нууц газраа
очиж залбирцгаая.





Тун удахгүй Би баригдаж та нараас явна. Гэхдээ эргээд бас тун удахгүй та нартай уулзана. Ингэж хэлж байгаад минь битгий гуниглаарай.

Хэдий та нар минь уйлах боловч удахгүй та нарын гуниг зовлон агуу баяр хөөр болон хувирна. Би Эцэгээсээ ирсэн болохоор удахгүй Түүн уруу буцан очих гэж байна.

Та одоо маш тодорхой ярьж байгаа болохоор бид итгэж байна.

Одоо л та нар итгэж байна уу? Тун удахгүй та нар Намайг орхиод тарж одно доо. Би жаахан хол очиж залбирчхаад ирье. Эндээ байж бай.

Аав аа цаг болжээ. Би Таны өгсөн ажлыг хийгээд дуусгачихлаа. Дэлхий ертөнцийг бүтээхээс өмнө Тантай хамт байхад минь байсан тэр алдраараа Намайг алдаршуулаач, Эцэг минь. Би тэдэнд Таны тухай зааж сургасан учраас тэд үгийг минь хүлээн авсан билээ. Би өөрсдийнх нь нүглийн үнэнийг хэлсэн учраас ертөнц Намайг үзэн ядсан шигээ дагалдагчдыг минь бас үзэн ядна. Тэд одоо энэ ертөнцийнх бус болсон. Би Танаас тэднийг энэ ертөнцөөс аваач гэж гуйж байгаа юм биш харин тэднийг минь бузар муу нэгнээс хамгаалаач гэж гуйж байна.



Тэдний гэрчлэл үйлчлэлээр дамжин итгэх бүх хүний төлөө Би бас залбиран гуйж байна. Би Тантай цуг байдаг шиг тэр хүмүүс Надтай хамт байгаасай гэж хүсч байна. Аав аа, Таны Намайг хайрласан хайр тэдний дотор, би ч бас тэдний дотор байх болтугай.



Миний сүнс
туйлын их шаналж
байна. Бүр үхтлээ
шаналж байна.




Аав аа, боломжтой
бол миний уух ёстой энэ уур
хилэнгийн аягыг надаас холдуулаач.
Гэхдээ Би өөрийнхөө хүслийг биш
Таны хүслийг гүйцэлдүүлмээр байна.
Би уух ётой л бол ууя Аав минь.

Есүс энэ дэлхийд нүглийг үүрэгч болон ирсэн юм. Тэр цаг болоход Есүс загалмайн ичгүүрийг авч, бүх цаг үеийн хүмүүсийн нүглийн төлөө нүгэл болсон гэсэн утгатай юм.



Аав аа
болдог бол энэ
аягыг надаас
зайлуулаач.



Гэхдээ Миний
хүслээр биш
Таны хүслээр
болог.


Есүсийн хөлс
цусан дусал
болж байв.



Гэнэт нэгэн тэнгэр
элч гарч ирэн
Есүст үйлчлэв.

Ариун Нэгэн, Таны зовох
цаг иржээ. Гэхдээ Эцэг Тантай хамт
байгаа шүү. Маргааш ертөнцийн нүглийг
Өөр дээрээ авахад тань тэнгэрийн бүх
дайчид харж байх болно.


Дэлхийг бүтээхэд
тань бид хамт байсан шиг дэлхийг
чөлөөлөхөд тань бас хамт байна аа.




Маргааш Сатан
ялагдаж нүглийн өр
төлөгдөнө.

Аврахам болон тэнгэр
дэх үй олон хүмүүс Таныг ирэхийг
хүлээж байгаа. Тэд дайснуудын тань
өмнө Танд ширээ засаж бэлтгэсэн
байгаа. Аяга тань дүүрэн бялхаж байна.
Сайн сайхан хийгээд энэрэл нигүүлсэл
Таныг баттайяа дагаж байдаг. Та
Эзэний гэрт үүрд оршин байх
болно.

Бос доо.
Тамын хүү Иудас
Танаас урвахаар
ирж явна.



Аав аа,
энэ хэргийн төлөө
л Бидэлхийд ирсэн
билээ.




Та нар нойронд
автжээ. Намайг ганц цаг харж
чадахгүй байна уу? Босоцгоо. Би
нүгэлтнүүдийн гарт өгөгдөж
байна.



Эзэн, Тантай энд
уулздаг их сайн байна.
Гэхдээ яанаа тэд
намайг дагачихсан
юм аа.

Иудас чи Намайг
үнсэнгээ урваж
байна уу?






Иудас! Муу
балиар
урвагч!


Эсэргүүцвэл
тэднийг
бүгдийг нь
хороо.

Больцгоо!
Та нар хэнийг
хайгаав?



Назарын
Есүсийг.

Тэр чинь
Би байна.



Болгоомжтой!
Наадах чинь
их хүчтэй юм!

Цэргүүд Есүсээс
айсандаа арагшаагаа
ханаран унацгаав.




Тэр байна.
Юунаас нь айгаад
байгаа юм бэ?
Бариад аваач!

Чи Эзэнийг
минь барьж
авахгүй шүү!



ШШХХ!

Яааиййе!



Болъ! Энд цус урсгах хэрэггүй. Петрээ сэлмээ хуйнд нь буцааж хий. Би хэрвээ хүсвэл 10,000 тэнгэр элчийг дуудахад тэд надад туслахаар ирнэ. Энэ бол харанхуйн цаг үе.

Чихийг
минь тас
хяргачихлаа!

Та нар гэмт
хэрэгтнийг барихтай адил
Намайг барихаар илд шийдэм агсан
ирэв үү? Би та нартай цуг сүмд байгаад
л байсан биз дээ. Тэгэхэд яагаад
бариагүй юм бэ? Яагаад тэгээгүйг чинь
Би хэлье. Бичээс биелэгдэхийн тулд
л тэгээгүй юм.






Бурхан
минь надад
туслаач!




За, шинэ юм
шиг болчихлоо.



Та нар Намайг
хүсээ юү? Бид та нарыг
ер эсэргүүцэхгүй ээ.
Намайг аваад тэднийг
явуул.




Гайхамшигтай!
Чихийг минь
эдгээчихлээ! Чихийг
минь эдгээчихлээ!



Наадуулаа
зогсоо! Бүгдийг
нь барь! Нэгийг ч
битгий явуул!

Явцгаая.

Дагалдагчид
бүгдээрээ харанхуйд
тарж алга болов.



Явсхий, явсхий.
Цаадуул чинь хүмүүсийг
мэдэхээс өмнө энэ хэргийг
дуусга гэсэн юм.


Цэргүүд Есүсийг тахилчид
ба гэрчүүдийн цуглараад
байгаа газар авчрав.

Эд надад чамайг
өөрийгөө Мессиа болгож,
бас Бурханыг Эцэгээ гэж
хэлдэг гэлээ. Чи бас өөрийгөө
энэ ертөнцийнх биш гэдэг
гэнэ. Чи тэгээд хаанаас
ирсэн юм бэ?

Би синагогуудад бас
сүмд заадаг л байсан шүү дээ.
Би ерөөсөө нууцаар заагаагүй.
Та яагаад надаас асуугаад байгаа
юм бэ? Надаас сонсож, сурсан
хүмүүсээс асуу. Тэд Миний юу
хэлснийг мэдэж байгаа.



TYC!




Чи ахлах
тахилчтай ингэж
ярьдаг юм уу.

Хэрвээ Би бузар
мууг ярьсан бол тэр
муугий маань гэрчлээдэх.
Гэтэл хэрэв би сайныг
ярьсан бол яагаад чи
Намайг цохидог бил
ээ?

Энэ хүний
эсрэг гэрчүүдийг
оруулаад ир.






Энэ нэг удаа сүмийг
устгаад гурван өдрийн дотор гараа
оролцуулахгүйгээр барина гэж
ярьж байсан.

Үгүй ээ.
Ингэж хэлсэн юм.
Хэрвээ хэн нэгэн
хүн сүмийг нураавал
буцааж барина гэсэн
юм.

Та нар тэнд байгаагүй юм
байна. Би ингэж хэлэхийг нь
сонссон юм байна. Сүм нурах тухай
ярьж байхдаа өөр уруугаа заагаад
байсан юм. Миний бодлоор бол
өөрийнхөө биеийг алагдах тухай
ярьсан байх.




Шал хөгийн юм. Гурван өдрийн дараа яаж өөрийнхөө биеийг буцааж босгох юм бэ?

Мэдэхгүй юм байна. Яаж сүмийг гурван өдрийн дотор барих гэсэн юм бол?


Тэд өөрийг
чинь буруутгаж байгааг
сонсохгүй байна уу? Чи
өөрөө хариулахгүй юм
уу?



Есүс юу ч
дуугарсангүй.




Наад тэнэг
чинь хариулахгүй
юм байна.



Амьд Бурханаар
би тушааж байна. Чи амьд
Бурханы хүү Христ мөн
эсэхээ хэлээдэх.

Би Бурханы Хүү мөн.
Та нар Намайг баруун талын
хүндэт суудалд суухыг, мөн тэнгэрийн
үүлс хөлөглөн энэ дэлхийд буцан
ирэхийг харах болно.



Бидэнд дахиад өөр гэрч хэрэггүй ээ. Бид өөрсдийн чихээр ч сонслоо. Тэр Өөрийгөө Бурханы Хүү болгож байна. Энэ бол доромжлол.

Наадхынхаа нүдийг боочих. Ямаршуухан эш үзүүлэгч болохыг нь харъя.

Ихэд уурсаж байгаагийн тэмдэг болгон тахилч дээлээ хүү татав.

Цохь наадхаа! Сүм дотор
наадах чинь миний хамаг наймааг
баллаад хаячихсан юм.

Эш
үзүүлж
чадах нь уу
харъя.

Наадхаар
чинь гайхамшиг
үйлдүүлье.





ТАС!

Дахиад цохь!




ТАС!

Хараач
ямар туниагүй
амьтан бэ!

Хэн цохисныг
хэлээдэх бидэнд.
Би чамайг эш
үзүүлэгч гэж бодож
байсан юм.

ВҮҮТТ!


Шархаа
эдгээгээч. Бидэнд
тэр гайхамшгаа
үзүүлээдэх л дээ.



Би бас чамайг
мэдэх юм байна. Чамайг тэр
Есүс гэгчтэй цуг харсан юм
байна. Чи тэрний дагалдагчдын
нэг нь мөн биз дээ?


Энэ үеэр Петр
Есүсийг даган
сүмийн гадаа
ирсэн байлаа.

Би тэр Есүсийг
чинь мэдэхгүй юм байна.
Би зүгээр юу болоод байгааг
харах гэсэн юм.




Би чамайг
тэр цэцэрлэг дотор орой
харсан юм байна шүү. Чи
тэдний нэг...

Хүн гуай та
чинь солиотой юм
уу? Би жирийн нэг муу
загасчин байна. Би энэ
Есүсийг мэдэхгүй.



Үгүй ээ, чи яахын
аргагүй тэр дагалдагч
нарынх нь нэг байна.
Би чамайг тэрэнтэй хэд
хэдэн удаа харсан юм
байна.


?!#&!
Эмэгтэй. Би
амьдралдаа энэ
хүнийг хараагүй
юм байна.



Куу -каа- рий- куу
Куу -каа- рий- куу

Энэ тахиа чинь өнөөдөр
жаахан эрт дуугарав уу даа.
Тэгсэн үү?

Тэд нөгөөдхийг
чинь гаргаад ирлээ.
Харахнээ нь гайгүй
болгож тавьсан байна
шүү.



Ял тулгуулахын тулд
иргэний хэрэг хариуцсан
эрх мэдэлтнүүдийн гарт
тушаа гэнэ ээ.

Наадхаа
ташуурд.

Хоёр нүүрлэсэн
муу тарган гахайнууд
балиар ажлаа хүнээр
хийлгээд байгаа
юм даа.

Петр тахиа
донгодохыг
сонсоод, азарган
тахиа хоёр
донгодохоос
өмнө Өөрөөс нь
гурвантаа урвана
гэсэн Есүсийн
үгийг санаж
хулчгар дорой
байдлаасаа ихэд
ичжээ.



Наадхыгаа
есөн салаа ташуураар
ураад өг!

Бурхан минь
би юу хийчих вэ? Би
яг Есүсийн хэлснээр
гурван удаа урвачихлаа
шүү дээ. Юу болох нь
энэ вэ? Эзэн минь, Есүс
яагаад ингэж зовж
байгаа юм бэ?

Хурдлаач.
Одоо шөнө
өнгөрлөө шүү.


Эцэг минь надад
хүч өгөөч.

Чи одоо юу хүсээв? Эзэнээсээ
урвахад чинь бид хангалттай мөнгө
төлөөгүйсэн биш билүү?



Би санаагаа өөрчилсөн.
Түүнийг сулла. Би мөнгийг
чинь буцааж өгье.

Наадах чинь цустай мөнгө. Бузар мөнгө учраас
бид гараа хүргэхгүй ээ. Өнөөдөр орой болохоос өмнө
Эзэн чинь цаазлагдана. Чамд айх юм байхгүй. Цаашид бид
чамайг нөгөөдүүлийг нь барихад ашиглаж болох юм шүү.



Май, энэ
мөнгөө ав. Энийг
чинь би авмааргүй
байна. Би ийм бузар
хэрэг үйлдчихээд
удаан тэсэхгүй нээ.

ЖИИИИ!

ДИИИИ!



Ээ муу
тэнэг амьтан.

A man with dark hair, wearing a blue tunic and a green cloak, is running through a rocky, wooded landscape. He is looking back over his shoulder with a determined expression. The background features large, gnarled trees and a rocky cliffside. A speech bubble is positioned above him, containing text in Mongolian.

Ийм
байдалтай
амьд явахгүй
юм байна.

Бурхан
минь, би юу
хийчих
нь энэ вэ?




Би
шуналаа яагаад
тэвчсэнгүй вэ?



Үхвэл л нэг амарч
магадгүй юм шиг байна...






Би түүнийг
харсан л даа.
Гэхдээ би түүнийг
зогсоож чадах юм
юу ч байгаагүй.

Түргэлээрэй.
Бушуухан
буулгая. Амьд
байж ч юуны
магад!

Тэднийг мод өөд авирч байхад
Иудасын сүнс хэдийнэ галтай
там уруу унаж байлаа.






Унахад нь бариад
аваарай. Тэгэхгүй бол
гүнзгий шуудуу уруу
унах гээд байна.




Хүрэхээргүй
хол байна
аа!



Ямар заваан
юм бэ! Гэдэс нь хагараад,
энүүгээр нэг болчихсон
байна шүү дээ!

Тах, огиудас
хүрчихлээ.

Энэ явдал ч
бас урьдаас эш
үзүүлэгчдээр
хэлэгдсэн юм.



Ямар юм аваад ирэв ээ? Бас нэг
буруу номтон уу? Наадахаа авч яваад
өөрсдийнхөө хууль номоор шийдэцгээ.

Энэ хүн цаазлагдах
ёстой юм. Тэгэхгүй бол бид яалаа
гэж тан дээр авчирхав дээ. Иймэрхүү
доромжлогчдыг чулуугаар шидэж алдаг
эрх мэдлийг маань та нар байхгүй
болгочихсон биз дээ. Тэгээд л бид
таны зөвшөөрлийг авах
гээд явж байна.

Ямар
хэрэг үйлдсэн
юм бэ?



Өөрийгөө
хаан гээд
байгаа юм.

Чи тэгээд
иудейчүүдийн
хаан юм уу?


Миний хаанчлал энэ
ертөнцийнх биш ээ. Тиймгүйсэн
бол миний үйлчлэгчид амийг
минь хамгаалахаар тэмцэх
байсан юм.

Тэгэхээр Чи
хаан байх
нээ?



Би энэ дэлхийд
үнэнийг гэрчлэхээр
ирсэн юм. Үнэнийг сонсох
хүсэлтэй бүхэн үгийг минь
сонсдог.





Энэ хүн үхэх
ямар ч хэрэг үйлдээгүй
юм байна. Та нар надаар
юу хийлгэх гээд байгаа
юм бэ?

Надхаа
цовдол!
Цовдол!

Авч яваад
ташуурд.



Хэдийг үү?

Цаадуул
чинь дээд талын
хэмжээ 39 гүвээд өг
гэж байна лээ.

Номлогч
гуай хэр тэсвэртэй
болохыг үзнээ хө.

Есөн салаа ташуур гэдэг нь тавин сантиметр модон бариултай, үзүүрт нь арзгар яс, чулуу, төмөр зүүсэн нэг метр шахуу урт есөн салаа суртай ташуур юм.



Хүчтэйхэн!

Аааа

Нөгөө олон нөхөд нь одоо хаа байна вэ?

Өдий болтол өршөөл гуйхгүй байгаа юм даа.

Ташуурдалт наадхыг чинь үхүүлчихэж магадгүй юм шиг байна. Тэгвэл түүний гайхамшгууд бидэнд гай тарихаа болино доо.

ТАС!

Гучин -тав


Гучин- зургаа

Гучин- долоо

Гучин - найм

Гучин - ес






Нуруу
нь ёстой аймаар
болчихлоо!

За за. Би
хаан хүнийг ташуурдах
юмсан гэж аягүй хүсдэг
байсан юм шүү.




Тэр өөрийгөө
хаан гээд байсан шүү.
Энэ ягаан нөмрөгийг
нөмрүүлчих.

Хаанд
титэм хэрэгтэй
биз дээ.




Ха ха ха!
Энэ ч ёстой сайн
титэм болно
доо.

Яая!



Май энэ таны
таяг. Агуу Хаантан.
Ха ха ха!

Титмийг нь
чанга сайн гээч
нь өмсүүлчих.



Таныг бид бүх
дэлхийн хаанаар
өргөмжилж
байна!

Ааааааа!




Одоо цэх
зогс.

Хаантан та
таягаа өргө.

Ха, ха. Хаан
та урт наслах
болтугай.

Тийм ээ, аз нь
байвал нар жаргатал
наслаарай.



Ромын хаан
хуузгүй
байдаг юм.



Одоо
харин овоо
хаан хүн шиг
болчихлоо.



Наадах чинь ямар
ч наргиангүй юм аа. Бүр
өршөөл ч гуйхгүй байгаа
юм даа. Буцаагаад
Пилатад аваачиж өгье.



Харагтун
хаан чинь энд
байна.

Бидэнд
Цезараас өөр хаан
байхгүй ээ.

Энэ хүнийг
харагтун. Надаар
энэ хүнийг яалгах
гээд байгаа
юм бэ?

Наадхыгаа
цовдол, цовдол!




Та нар өөрсдөө
авч яваад цовдол. Би
энэ хүнээс ямар ч гэм
буруу олохгүй
байна.



Ямар ч гэм
буруугүй гэдэг чинь
юу гэсэн үг вэ? Наадах
чинь өөрийгөө Бурханы
Хүү гээд байгаа юм
шүү дээ.




Бурханы
Хүү гэнэ ээ?
Наад хүнээ
аваад ир дээ.



Чи хэн юм бэ? Яагаад
надад хариулахгүй байгаа
юм бэ? Чамайг үхэлд тушаах
эрхтэй гэдгийг минь мэдэхгүй
байгаа юм уу?

Эцэг минь
гөөгүй бол танд
ямар ч эрх байхгүй ээ.



Би та нарт
хэлж байна. Энэ хүнд
ямар ч буруу алга. Би
түүнийг чөлөөллөө.

Та наад
хүнээ чөлөөлбөл
Цезарийн анд биш
байна даа.


Цовдол,
цовдол!

Наадхаа авч
яваад хүссэнээ л хий. Би энэ
хэргийн тухай бичиг хэрэг хөтөлнө.
Гэхдээ харин би энэ хүний цусныг
төлөө ямар ч буруугүй шүү.



Наад эсэргүүгээ
цовдол!

Нөгөө их
гайхамшиг энэ тэр
чинь хааччихаа вэ?



Миний бодлоор
тэр одоо хангалттай
болсон байх аа.

ТУН!


ТУК!



Бос. Босохгүй
бол чинь
ороолголоо шүү.

Хөөе. Чи!
Энэ загалмайг
нь үүрээд яв.

Яахаараа
би байдаг
юм бэ?




Энэ
яачихсан хүн
юм бэ?

Бүх
хүнийг хайрлаад
байгаа юм.




Өө Есүс ээ
биднийгээ
уучлаарай.

Иерусалимын охид
оо. Миний төлөө бүү уйл. Иерусалимынхан
айдаст автан нуугдаж, үхэхийг хүсэн хашхирах
цаг ирэх учраас өөрсдийнхөө төлөө, үр
хүүхдийнхээ төлөө л уйлцгаа.



Есүс загалмайгаа үүрэн үхлийн газар очжээ. Тэр өдөр өөр хоёр дээрэмчин загалмайгаа үүрээд очсон байлаа.

Тэнд Есүсийг хүндэлж хайрласан олон хүн байсан боловч айсандаа болоод хэн ч ярьж зүрхэлсэнгүй.



Май,
энийг уучих.
Өвчний хүчийг
сулруулна шүү.

Үгүй. Би
Эцэгийнхээ
хүслийг л
гүйцээх ёстой.

Одоо ч
гэсэн Өөрийгөө
Бурханы Хүү гэж
бодоод байгаа
юм байх даа.



Гар
хөлийг нь
сунгаадах.

Алх, хадаас
аваад өг.




Одоо сайн бариарай.
Эхний хадаасан дээр наадуул
чинь галзуу юм шиг эсэргүүцдэг
юм шүү. Хадаас ясных нь
завсраар орж мод уруу шаагдтал
сайн бариарай.

Болиоч ээ!
Миний хүү!

ТАС!

ТҮГ!






Энэ яагаад
Өөрийгөө
Бурханы Хүү
гээд байгаа гэж
бодож байна?

Хуучны
эш үзүүллэгтэй л
холбоотой юм байлгүй.
Хэн мэдэх вэ дээ.



Хөлийг нь сайн бариарай.
Хадааснуудыг яс уруу оруулах
гэж нэлээн цохих хэрэгтэй
болдог юм. Сайн барь.



Мариа минь,
би ерөөсөө тэсэхгүй юм
байна.

Би ийм
юм болно
гэж даанч
бодоогүй.

Татаач
тэнэгүүд ээ.


Надад бол жаахан
дэм хэрэгтэй байна. Муу
залхуу гахай минь.



Аав аа, юу
хийж байгаагаа
мэдэхгүй энэ
хүмүүсийг
өршөөгөөрэй.

Иохан. Чи
энд байдаг чинь
яасан сайн юм бэ.
Аймаар байна.

Бид
бүгдээрээ Түүнийг
орхичихсон юм.




Энэ хувцаснууд нь байна. Би энийг л авлаа.

Чи ганцаараа тэгэхгүй шүү. Бүгдээрээ дөрөв хуваая.

Наадхыг чинь шодож авъя.


Энийг хувааж болохгүй юм байна. Нэхмэл юм байна.

Бичээст нэг хувцсыг нь хувааж, харин нөгөөг нь шодож авна гэж бичсэн байдаг юм.



Өндрөөс
шидвэл бүгдэд
хүртдэг юм.

Лео, хараач.
Дээрээс чинь цус
дусаад байна.




Бусдыг авраад
байсан хүн өөрийгөө
аварч чаддаггүй юм
байх даа.

Хөөе Есүс ээ, чи
сүмийг нураагаад гурван өдрийн дотор
буцаагаад барина гээд байсан. Одоо
өөрийгөө авраад наад загалмайнаасаа
буугаад ирээч.

Израилийн
Хаан Христ
загалмайнаас бууж
ирэгтүн. Тэгвэл бид
хараад итгэх байх
шүү.

Муу худалч!

Бурхан Өөрийг нь
чөлөөлнө гэж найдаад байсан
хүн. Бурхан одоо Өөрийг нь
таалаад суллахыг харъя.




Май, энийг
уу. Наадах чинь
өвчнийг чинь
багасгана шүү.

Хэрэггүй



Та үнэхээр
Бурханы Хүү
юм бол өөрийгөө
буулгачих.
Бүгдээрээ энэ
муу ромчуудыг
хорооё.

Чи яагаад тэгж
хэлээд байгаа юм
бэ? Үхэх гэж байж
Бурханаас айхгүй
байна уу?




Бид үйлийнхээ
үрийг амсаж байна аа.
Харин энэ Есүс бол өөр
шүү. Ямар ч буруу юм
хийгээгүй.

Есүс ээ,
хаанчлалдаа
орохдоо намайг
санаарай.




Яг өнөөдөр
чи надтай хамт
мөнхийн улсад
орно.



Иохан аа,
чи ээжийг минь
харж хандаж
байгаарай.

За.

Ээ Есүс миний
хүү. Яагаад энэ вэ,
арай ч дээ?



Есүсийг загалмай дээр хадагдсан тэр үед тэнгэр харанхуйлан гурван цагийн турш шөнө мэт болжээ. Энэ бол харанхуйн цаг үе байсан юм. Христ Есүс гэгч тэр хүн бүх дэлхийн нүглийн төлөө амиа өргөж байлаа.

Бүх хүмүүсийн нүгэл
Есүсийн дээрээс нэгмөсөн
дарахад Есүс чанга хашхирав:



Бурхан минь,
Бурхан минь, яагаад
Намайгаа орхичхов
оо?

Бурхан Түүнийг бидний төлөө нүгэл болгожээ.

Аав аа, Таны
гарт Би сүнсээ
даатгая.

За гүйцлээ!

Иохаан.
Хүү минь үхэж
байна Тэр
минь үнэхээр
хэж байна гэж
үү дээ!


Тэгээд
амьсгалаа
хураажээ.

Гэнэт газар маш хүчтэй хөдлөв.

Юу болоод байна аа? Эхлээд тэнгэр шөнө шиг харанхуйлаад байсан. Одоо болохоор газар хөдлөөд байдаг.

Энэ бүхэн Иудейн хаан Есүсээс болоод байх шиг байна. Тэр чинь гайхамшгууд үйлддэг байсан биз дээ.

Одоо ямар гайхамшгаа үйлддэг юм бэ. Үхчихсэн юм чинь.



Одоо дахиад
гэрэлтэй болчихлоо.
Ямар хачин өдөр вэ.

Харин тийм
ээ. Яг энэ хүнийг
өнгөрсний дараа ийм
юм болоод байдаг.

Тэр үнэхээр
Бурханы Хүү
байжээ.



Эдний хөлийг хугал гэж бидэнд тушаасан юм. Нар жаргахаас өмнө эднийг үхүүлж, загалмайнаас нь буулгах гээд байгаа юм гэсэн. Маргааш энэ иудейчүүдийн ариун өдөр юм гэсэн.

Түүнийг загалмай дээр алагдана гэж урьдаас хэлэхдээ харин биеийнх нь нэг ч яс хугарахгүй гэсэн байдаг юм. Тэр зөгнөл ийнхүү биелэгджээ.


Энүүний хөлийг хугалах хэрэг алга. Үхчихсэн байна. Үхэхийнхээ өмнө юу гэж хэлснийг нь та нар мэдсэн үү? Тэр Эцэгээсээ өөрийг нь алж байгаа бид нарын нүглийг уучлаарай гэсэн шүү. Хүмүүс энэ хүнийг гайхамшгууд үйлддэг ариун хүн байсан гэлцээд байна билээ.





ТАС!

Тиймд цэргүүд Есүсийг алгасан орхиж, нөгөө хоёр дээрэмчний хөлийг хугалжээ.



Иш хөөрхий
минь ядаж
хөлийг нь
хугалсангүй нь
яамай даа.

Би яваад хүмүүс олж
ирээд оршуулахад
бэлтгэе дээ.



Нар жаргахад Шаббат эхэлдэг билээ.
Нэгэнт орой болж байсан тул шарилыг
нь хурдан оршуулах хэрэгтэй байжээ.




Саббат одоохон
эхэллээ. Шарилыг нь
миний шинэ булшинд
тавьчих.



Иосеф минь,
юун сайн юм бэ. Чи
бидний сайн нөхөр
явсаар ирсэн шүү.



Хэдий арван хоёр
дагалдагчийнх нь нэг
биш байсан ч Иосеф
хэмээх нэгэн баян
хүн өөрийнхөө хадан
булшинд Есүсийг
оршуулахаар шийджээ.




Арван
хоёрдугаар
бүлэг

ДАХИН АМИЛАЛТ,
ПЕНТЕКОСТ БА
ЭХЭН ҮЕИЙН СҮМ



За за хурдал.
Орой болчихлоо.

Ийм юм болно гэж Есүс бид нарт олон удаа хэлж байсан юмаа. Харин яагаад ийм юм болох ёстойг л би ойлгохгүй байгаа юм. Өөрөө л яг ингэж юм шиг санагдаад байх юм. Бүх юм мьг болохцаг нартай нь мэдэж байсан шүү. Дөнгөж өчигдөр шөнө л гэхэд бид нарт бас хэлж байсан юм даа.



Биед нь түрхэх
үнэрт тос бэлдээгүй
байгаа шүү дээ.

Саббат өдөр өнгөрөхөөр
буцаж ирье дээ.

Тэгэхээр чинь
бараг гурав хоночих
гээд байна шүү дээ!

Тэгэхээс
өөр арга алга
даа.


Энүүгээр яв. Доошоо
буухдаа болгоомжтой
байгаарай.

Тахилчид
Пилат уруу
буцаж ирэв.

Таны дөнгөж
сая цовдолсон тэр
худалч гурван өдрийн
дараа булшнаасаа эргэн
амилна гээд
байсан юм.


Дагалдагчид нь
булш уруу шургалж
ороод, шарилыг нь
аваад явчихвал бүр бөөн
шуугиан болно. Иймэрхүү
юмнаас сэргийлэхийн тулд
та булсных нь гадаа
цэргүүдээр мануулаад
өгөөч.

Би мануулах
цэргүүдээ явуулъя.
Та нар чадахаараа л
хамгаал.



За энэ лац тэмдэгт
ямар ч хүнийг хүргэж
болохгүй шүү.

Манай
хүмүүсийг хэн ч
давж гарж
чадахгүй ээ.

A comic book panel depicting a scene with Roman soldiers. In the foreground, a man with a red cloak and a gold helmet looks towards the right. Behind him, several soldiers in gold armor and helmets are visible. One soldier in the center-right is laughing heartily, with his hands clasped. A speech bubble from the man in the red cloak contains Mongolian text, and another speech bubble from the laughing soldier contains the sound effect 'Ха ха ха'.

Та нар үхсэн Мессиаг
гараад явчихна гэж айж
байна уу? Бид ер нь үхдэл
алдаж байгаагүй, тийм
биз дээ залуус аа?


Ха ха ха

Есүсийг оршуулснаас хойш
гурван өдрийн дараа

Анх удаагаа
л үхсэн хүн
манаж үздэг юм
байна.


Удахгүй
үүр цайх нь. Тэгээд
буух ч дөхлөө дөө.





Удахгүй гэгээ
орох нь. Хурдалъя.
Гурав хоночихлоо.

Эртхэн
амжуулсан бол
аштай вэ дээ.



Дахиад газар
хөдөлж байна!

Ээ!



Ёстой
хүчтэй хөдөлж
байна шүү.

Хүмүүс
хашхиралдахыг
дуулав уу! Хүн



Юу ...?

Aaa!




Бурхан
байна!

Чулууг
зайлуулж
байна!

Бид нарыг
алах байх даа!


Бурханы эх ээ,
биднийгээ
өршөөгөөч!



Намайг
битгий орхиоч!
Бурхан минь
өршөөгөөч!

Яаж ингэдэг
байна аа!

Амь
амиа бодоод
гүйгээрэй!



Чулуу нь ёстой
том шүү дээ. Хаанаас
эрэгтэй хүн олж
хөдөлгүүлэх вэ?

Мэдэхгүй ээ. Гурав
хоночихлоо. Түрхлэг хийж
арга хэмжээ аваагүй юм чинь
үнэр орчихсон л байхаа даа.

Тэд цэргүүдээр
мануулсан гэж

Хэдхэн хормын дараа

Чулууг хэн нэгэн
хүн аль хэдийн
зайлуулчихсан байна!



Шарил нь алга
болчихжээ. Булш нь
хоосон байна!






Ээ! Та
хэн бэ? Есүсийн
бие хаа байна?


Тэр биеийг
нь ороосон
даавуунууд байна!

Бүү гайхагтун. Та
нар цовдлогдсон Есүсийг
хайж байгаа биз дээ? Тэр
одоо энд байхгүй. Тэр
хэлж байснаараа үхлээс
амилчихсан.


Ирээд хэвтэж байсан газрыг
нь үзэгтүн. Тэгээд явж дагалдагчдад
нь очиж Есүс Галилд өөрсөдтэй нь
уулзана гэсэн гэж хэл.




Есүс амьд
байна аа! Яг
Лаазар шиг үхлээс
амилчихсан гэх
гээд байна уу, та?




Энэ
хүмүүс чинь
тэнгэр элч
нар байна!



Есүс
амьд байна!



Хурдлаарай.
Явж дагалдагчдад
хэл хүргэе.




Есүс амьд
байна! Бид нар сая
булшин дээр очоод
ирлээ.

Есүс тэнд
байхгүй, харин
тэнд тэнгэр элч
нар байсан шүү.

Тэгэхэд л
Есүс гурав дахь
өдрөө амилна гэж
хэлж байсныг нь
саналаа.

Тэр элч нар Есүсийг
та нартай Галилд
уулзана гэж хэллээ!




Петр чи хаашаа
явж байгаа юм бэ?

Булш
уруу.

Иохан Петрийн
араас гүйж,
удалгүй гүйцэж
түрүүлэв.

Иохан аа!
Хүлээгээч; Би
чам шиг хурдан
гүйж чадахгүй
юм байна.





Булш
хоосон байна!

Энэ чинь
тэгэхээр юу
гэсэн үг вэ?




Иохан, ороолтноосоо
сугарч гараад босоод явчихсан
юм шиг энэ даавуунууд нь яг
хэвтэж байсан газар нь ороолттой
хэвээрээ байж байна.

Үгүй ээ,
яаж тийм юм
байдаг юм бэ!

Тэгвэл тэр тэнгэр
элч нар хаа байна аа?
Эмэгтэйчүүд хий юм
харсан байх аа.






Та нар цагаан
хувцастай хүн
харсан уу?

Тэнд ямар ч хүмүүс,
ямар ч тэнгэр элч ер нь
юу ч байгаагүй. Бие нь
алга болчихжээ.

A man in a grey hooded robe is shown in a state of distress. He has his hands pressed against his face, with his eyes closed and a pained expression. The background features a tropical landscape with palm trees and mountains under a sunset sky. Two speech bubbles are present: one at the top left and one at the bottom left.

Ийн,
ийн.

Эмэгтэй та
яагаад уйлаав?




Тэд манай
Эзэнийг аваад явчихжээ.
Хаа тавьсныг мэдэхгүй
болохоороо л уйлж байна.

Мариа.



Эзэн минь!






Мариа одоо
надад бүү хүр. Би
Эцэг дээрээ арай
очоогүй байна. Харин
дагалдагчдад очоод
надтай уулзсанаа хэл.
Бас Намайг тэдэнтэй
Галилд уулзана
гэдгийг хэл.


Эзэн минь
Та минь амьд
байна шүү
дээ.

Есүсийг үхлээс
амилсан гэсэн мэдээнд
дагалдагчид итгэсэнгүй.



Петр, Иохан хоёр яваад
булшнаас юу ч олоогүй гэнэ
лээ. Хэн нэгэн хүн шарилыг нь
хулгайлчихсан байх л даа. Тэр
хэдэн солиотой хүүхэн яриагаа
болих хэрэгтэй. Хүмүүсийг шал
дэмий самууруулж байх юм.


Бид нар буцаад
Еммау явлаа. Одоо
бидэнд энд байх
хэрэг огт алга.



Энэ чинь
гурав дахь өдөр
нь байх аа.

Харин тийм ээ.
Гэхдээ буцаад л амилчих
байсан юм бол тэр хүмүүсээр
Өөрийгөө алуулаад яадаг
байна аа?


Тийм шүү.
Хэрвээ хаан болох
хүсэлтэй байсан юм
бол ингэж нууцаар
хиймээргүй юм даа.
Тийм биз дээ?



Би та
нартай цуг явж
болох уу?


Бололгүй яахав.
Алхахад сайхан
өдөр байна.

Ёооох!
Та намайг
айлгачихлаа.
Хаанаас гараад
ирэв ээ?




Намайг
та нарын хажууд
ирэхэд та хоёр нэг
юм ярьж явсан. Та
нар нэлээн гунигтай
харагдаад байх юм.

Назарын Есүсийн талаар
энэ өнгөрсөн хэд хоног юу ч
дуулаагүй юм уу?



Бид нар уул нь
Түүнийг Мессиа юм
байх гэж найдаж байсан
юм. Тэгтэл цовдлогдоод
алагдчихлаа.

Өнөө өглөө хэдэн хүүхэн
булшин дээр нь очтол бие нь байхгүй
байсан гэнэ! Тэд нар бас өөрсдийгөө
тэнгэр элчтэй уулзсан. Тэгээд тэр элч
нь Есүсийг амьд байгаа гэж хэлсэн
гээд байгаа юм.



Тэгээд
дагалдагчдын
хоёр нь булш уруу гүйж
очсон боловч Есүсийг
ч, тэнгэр элчийг ч олж
хараагүй байна. Харин
бие нь алга байсан
гэнэ.

Та нар Мессиагийн талаар
эш үзүүлэгчдийн бичсэн зүйлст
итгэхдээ үнэхээр хойрго юм даа.
Бичээст Есүсийг эхлээд иймэрхүү
байдлаар зовон шаналаад, дараа нь
сүр жавхланта хаанчлалаа авчирна
гэж зөгнөн хэлсэн байдаггүй биш
бил үү?

Ромчуудад
цовдлогдсон, тэр Назарын
Есүс өөрийгө Христ буюу
Бурхан Эцэгтэй адил тэнцүү
гэж байсан, тийм биз дээ? Исаиа
Христийг "Хүчит Бурхан, мөнхийн
Эцэг гэж дуудагдана" гэж хэлсэн
байдаг. Есүс бас Өөрийг нь харсан
бол Эцэгийг мөн харсантай адил
гэж хэлээгүй гэж үү? Хэлээд
байсан болгон нь ариун
Бичээстэй яг таардаг юм
даа.



Исаиа бас Христийг Израиль,
Иуда хоёрт хоёуланд нь иудей хаан
байхгүй үед ирнэ гэсэн байдаг юм.
Тэгвэл одоо яг тэр цаг мөн байна. Цааш
нь Исаиа хэлэхдээ Есүсийг хүнтэй
хавьтаж үзээгүй эмэгтэйд олдож төрнө
гэсэн байдаг. Бас эш үзүүлэгч Микагийн
хэлснээр Иудагийн Бетлехемд төрөх
ёстой бөгөөд Есүс ч тэнд л төрсөн.

Олон эш үзүүлэгч
Есүсийг Давид хааны
удмаас төрнө гэсэн байдаг.
Тэгвэл Иосеф, Мариа хоёр
хоёулаа Давидын
удмынх





Мөн эш үзүүлэгч
хэлэхдээ Христ
сохруудыг хараатай
болгож, хоригдогсдыг
суллаж, Израилийн
хоньчин буюу Сионы
Чөлөөлөгч болон
ирнэ гэсэн ажээ.


Есүс израильчуудад
гологдоно гэж Исаиа
урьдаас хэлсэн юм. Эш
үзүүлэгчид ч Есүсийн зовон
шаналахыг мэдэж байжээ. Гучхан
мөнгөн зоосны төлөө анд нөхөр
нь Есүсээс урван барьж өгөхөд
буруутгагчийнхаа өмнө Өөрийгөө
өмгөөлж хамгаалахгүйгээр
тамлуулан зодуулж, сахал үсээ
хүртэл зулгаалгуулна гэсэн
байдаг. Хүмүүс Түүнийг
нүцэглэн нүүр ам уруу нь
нулмих болно.




Эш үзүүлэгч
Зехариа Аврагчийг
мах цусаа уруулан
шархдаж, өөрсдийнхөндөө
зодуулж, гар хөлөө
хадуулан, нядлагдах хурга
мэт үхээд эцэст нь Тэр
баян хүний булшинд
оршуулагдана
гэжээ.



Гэхдээ энэ зүйл Өөрийнх нь хэрээс хэтэрсэн хэцүү асуудал байсан юм биш. Амийг нь хэн ч авч чадахгүй харин Өөрөө л Өөрийнхөө хүмүүсийн төлөө тавьж өгнө гэж Есүс хэлээгүй гэж үү? Есүс шархдаж амь сүнсээ гэм нүглийн төлөө өргөл болгон өргөх нь Бурханд тааламжтай байсан гэж Исаиа хэлсэн байдаг. Есүс түмэн олны төлөө зодуулан нүдүүлж, нүгэл хилэнцийг нь Өөртөө үүрч, үхлээрээ тэднийг Бурханы өмнө зөвт болгосон юм.



Гэхдээ үхэл бол төгсгөл биш юм. Исаиа Түүнийг үхэх боловч энэ нь Түүний төгсгөл болохгүй харин цааш үргэлжилнэ гэдгийг урьдаас харж чадсан юм. Тиймд өндөрт өргөгдөн, хүндлэгдэн магтагдаж дэлхийн өнцөг булан бүрт болох юм. Мессиа хэзээ ч алдаа гаргахгүй бөгөөд Тэр Өөрөө шинэ гэрээ юм.



Тэр шүүгч болж
шинэчлэгдсэн Израилийг шинэ хот
шинэ дэлхий дээр захирах юм. Өвдөг
бүр өмнө нь сөхөрч, хэл бүр Эзэн хэмээн
дуудах тийм өдөр цаг ирэх болно.

Гайхалтай!

Та нар чинь яагаад
ийм гунигтай байгаа билээ, Надад хэлээч.
Тэнгэр элч нар Түүнийг үхлээс амилсан гэж
хэллээ гэж эмэгтэйчүүд та нарт хэлээгүй
юм уу?

Манайх энэ дээ. Эрхэм
ээ одоо их орой болчихжээ.
Өнөө шөнөдөө манайд хонооч.
Бид хоёр Есүсийн тухай эш
үзүүллэгийн талаар илүү ихийг
сонсмоор байна.




Эрхэм ээ, та хоолны
төлөө залбирч өгвөл бид
их баярлах байна.





Хөрс шорооноос талх тариаг
ургуулдаг Бидний Эзэн, ертөнцийн
их хаан Бурхан минь ээ, Та
алдарших болтугай! Энэ талхны
төлөө Тандаа талархъя.



Аваад
идэцгээ.

Есүс! Энэ
чинь Та юу.

Эзэн минь!



Алга болчихлоо!

Явчихлаа
шүү!

Ахнаасаа л Есүс
байсан байна шүү
дээ!

Бүх эш үзүүллэгийг
мэдээд байсан нь аргагүй
юм байна л даа.




Есүс амьд байна!
Есүс амьд байна! Үхэл
Түүнийг дийлсэнгүй! Амьд
байна! Бүгдээрээ буцаж
Иерусалим уруу очоод
дагалдагчдад дуулгая.

Яг энэ үеэр
Иерусалимд

Сайн түгжээрэй.
Есүсийн бие нь алга
болчихсон болохоор тахилч нар
урьд урдынхаасаа илүү ууртай
байгаа шүү. Тэд нар биднийг л
биеийг нь хулгайлчихлаа гэж
бодож байгаа.

Бүхэл
бүтэн салаа цэрэг
манаж байхад уу?





Гурав
дахь өдрөө эргэн
амилна гэж Өөрөө
хэлж байсан шүү
дээ.

Би л лав
Өөрийнх нь амьд
байгааг нүдээрээ харж,
гарынх нь шарханд
гараа хүргэхээс нааш
итгэхгүй.




Сүнс
байна!

Туслаарай!

Энэ чинь
Есүс байна!

Бүү ай. Томас чи
намайг харахаас нааш итгэхгүй
гэсэн биз дээ. Одоо гараа нааш нь
сунгаад хадаасны ормонд хүрч үз. Хүрээд
ир Хавирганыг минь шарханд гараа
хүргээд үз.



Эзэн
минь, Бурхан минь,
Та мөн байна.


Томас чи
хараад итгэсэн
учраас ерөөгдлөө.
Гэхдээ харин Намайг
хараагүй мөртөө
итгэсэн хүмүүс
бүр илүү ихээр
ерөөгдөхб олно.



Эзэн минь!

Надад идэх юм авчраач. Та нарт зааж сургах юм их байна. Би та нартай цөөхөн хэдэн хоног л хамт байна.

Есүс!

An illustration depicting a scene from the Bible. On the left, Jesus, with long dark hair and a beard, wearing a white robe with a gold sash, holds a large fish in his hands. He is looking towards a group of men on the right. The men are dressed in simple, earth-toned robes. One man in the foreground is kneeling in prayer, with his hands clasped. Other men stand behind him, some with their hands clasped or resting their heads on their hands, appearing to be in a state of awe or listening intently. The background shows a simple interior with stone walls and a doorway.

Та нар Миний бүх дагалдагч нарт Галилд Надтай уулз гэж хэлэх хэрэгтэй. Тэнд Би та нартай ярина.

Олон жилийн тэртээ Бичээст, Христ та нарын гэм нүглийн төлөө зовон шаналж үхээд гурав дахь өдрөө эргэн амилна. Иерусалимаас эхлээд бүх үндэстэнд Түүний нэрээр нүглийн уучлалын гэмшил тунхаглагдах ёстой гэж бичигдсэн юм. Би Ариун Сүнсийг явуулж, Тэр та нарын дотор орших хүртэл Иерусалимд хүлээж бай. Ариун Сүнс та нарт сайн мэдээ тунхаглах хүч чадал өгөх болно.



Тэнгэр газар
дээрх бүх эрх мэдлийг
Надад өгсөн. Иймээс явж,
бүх үндэстнийг дагалдагч
болгогтун. Эцэг, Хүү, Ариун
Сүнсний нэрээр тэдэнд
баптисм хүртээж, Миний
та нарт тушаасан бүгдийг
сахин биелүүлэхийг тэдэнд
заа. Харагтун, үеийн төгсгөл
хүртэл Би та нартай
үргэлж хамт байх
болно.

Миний Эцэгийн
гэрт орон байр олон
бий. Би та нарт орон байр
бэлдэхээр явна. Би эргэн
ирж та нарыг Өөртөө авна.
Тэгээд Миний байх газарт
та нар бас хамт байх
болно.



Иерусалимд
очоод Ариун Сүнс
ирж Миний нэрээр
ярих хүч чадал өгөх
хүртэл хүлээгтүн.


Дээшээ
явж
байна!

Тэр Эцэг
уруугаа буцаад
явж байна.



Би үеийн
төгсгөл хүртэл та
нартай үргэлж хамт
байх болно.


Тэр
буцаад тэнгэр
өөд одчихлоо.



Та нар
яагаад тэнгэр
ширтсээр байгаа
юм бэ?


Юу гэнэ
ээ? Хэн бэ?

Булшны дэргэд
миний харсан хоёр тэнгэр
элч мөн байна.



Нэгэн өдөр
Есүс өнөөдрийн та нарын харж
байгаа шиг үүлэн дунд эргэн
ирэх болно.

Тэр
тэнгэр дэх Эцэг
уруугаа очсон.



Иерусалимд
буцаж очоод Ариун
Сүнсийг хүлээгтүн.



Есүсийн дагалдагч нар хэлснийх нь дагуу Иерусалимд очиж, дээрээс ирэх амлагдсан тэрхүү хүчийг арван өдөр залбиран хүлээж байлаа. Өөрсдөө бас үхэлд хүрч болзошгүй байсан учраас дагалдагчид нь Есүсийн амилалтын талаар чөлөөтэй ярихаас айж байсан юм.



Дагалдагчдын залбирч байсан газар доргин чичирч, өрөөн дотор их салхи үлээн, хүн бүрийн дээрээс гал мэт хэлүүд буужээ.

Тэд Ариун Сүнсээр
дүүрч өөрсдийнхөө
мэдэхгүй олон
хэлээр Бурханыг
магтаж эхлэв.




Ариун Сүнс буухад дагалдагчид хүмүүсээс айж эмээлгүй олны өмнө зоригтойгоор Бурханыг магтан хүндэлж байв.

Бидний Эзэн Есүс Христийн Эцэг Бурхан алдарших болтугай!


Эд бүгдээрээ согтуу юмуу гэтэл манай хэлээр маш цэвэрхэн ямар ч аялгагүй яриад байх юм.






Эд чинь манай ч
хэлээр бас ярьж
байна. Энэ хүмүүс яаж
ингэж олон хэлийг
ийм сайн сурдаг байна
аа? Эд боловсролтой
улс биш дээ.

Израилийн эрчүүд
ээ, та нар Есүсийн хийсэн
гайхамшгийг харлаа. Энэ
бол Бурхан Есүстэй хамт
байсны баталгаа юм. Хэдий
та нар Есүсийг цовдолсон ч
Бурхан Түүнийг үхлээс
амилуулсан билээ.




Мянган жилийн өмнө
Давид ингэж эш үзүүлжээ. "Та
миний сүнсийг тамд орхихгүй, Та
бас Өөрийнхөө Ариун Нэгэнийг
ялзрал үзүүлэхгүй."

Тиймд Израилийн гэр
баттайгаар мэдтүгэй. Бурхан
та нарын цовдолсон Есүсийг
Эзэн ба Христ болгосон юм.



Христийг
цовдолсон гэдгээ бид
ойлголоо. Одоо бид
тэгээд яах ёстой вэ?

Есүсийн тухай бодол
санаагаа өөрчилж усан баптисм
хийлгэн Түүнийг дага. Тэр та нарын
гэм нүглийг уучилж, та нар Ариун
Сүнсний бэлгийг хүлээн авах
болно.



Есүс бол
Эзэн.

Би Есүст
итгэж байна.
Надад баптисм
хүртээгээч!


Петрийн үгийг баяртайгаар хүлээн
авсан болгон баптисм хүртэв. Тэр
өдөр гурван мянга орчим хүн
тэдэн дээр нэмэгджээ.

Хэдэн сарын дараа

Дөнгөж өчигдөр л
Есүс бидэнтэй байсан юм шиг
санагдаад байх юм.

Цаг мөч тутамд
мянга мянган хүн
Есүсийг дагаж
байна шүү.


Тийм ээ, харин би одоо л
Есүсийн оршихуйг Өөртэй
нь мөр зэрэгцээд алхаж
явснаасаа илүү хүчтэйгээр
мэдрээд байна.



Эрхмүүд ээ,
ядарсан муу суумгай
надад хэдхэн зоос ч
болов хайрлаач.

Петр ээ надад
ямар ч мөнгө
байхгүй. Чамд
зоос байхгүй биз?

Байхгүй ээ. Гэхдээ
Ариун Сүнс бидэн дээр
ирснээс хойш түүнд өгөх
юм бидэнд бий шүү.



Надад ямар ч алт,
мөнгө байхгүй гэхдээ би
чамд өөрт байгаагаасаа
өгье. Есүс Христийн нэр
дээр босоод алх.

Битгий наад
хүнээрээ тогло. Наадах
чинь төрөлхийн суумгай
юм. Хөл нь ямар ч
хэрэггүй болсон.




Есүс Христ
чамайг бүтэн
болголоо.



Хөөх!

Эзэн Бурхан
агуу юм аа!


Хөл нь
уртсаж
байна!



Ёстой
итгэмээргүй
юм. Суумгай хүн
алхаж байна!

Бурхан алдарших
болтугай!
Баярлалаа Есүс!

Хөөх, бүр
үсэрч байна
гээч.




Энэ чинь нөгөө
суумгай байсан хүн
шүү дээ. Хөл нь авах
юмгүй хатчихсан
байсан юм даа.

Та нар яагаад
биднийг энэ гайхамшгийг
үйлдчихсэн юм шиг
хараад байгаа юм бэ?
Өөрийнх нь Хүү болох та
нарын цовдолсон Есүсийг
Абрахам, Исаак, Иаковын
Бурхан алдаршуулсан
ЮМ.

Хүмүүс энэ хүнийг
нөгөө цовдлогдсон
Есүсийн нэрээр
эдгэрчихсэн гээд
байгаа юм

Амьдрал бэлэглэгч хан
Хөвгүүнийг та нар цовдолсон
ч, Бурхан харин Түүнийг үхлээс
босгосныг бид харсан. Тиймд
итгэлээр Эзэн Есүсийн нэрээр энэ
хүн эдгэрсэн юм.



Та нар үл
тоомсорлосондоо Есүсийг
цовдолсон гэдгийг би мэдэж
байгаа ч ийм зүйл болно гэдгийг
эш үзүүлэгчид бидэнд эртнээс
анхааруулсан билээ.

Та бүхэн намайг мэднэ.
Зөвхөн Бурхан л намайг
дахин хөлтэй болгож чадна.
Итгэж, Есүсийг л дага.

Есүсийн тухай
бодол саналаа өөрчилж
Түүний дагалдагч нар
бологтун. Тэгвэл та нарын
гэм нүгэл арилах болно.



Есүсийг цовдолсон сүмийн
зэрэгтнүүд цэрэг явуулан Петр,
Иохан нарыг баривчлуулжээ.

Та нар
хүмүүсийг манай
шашны эсрэг
турхирах нь
зүйд нийцэхгүй
асуудал.

Эд нар ямар
ч буруу юм
хийгээгүй
шүү дээ.




Есүс энд
байхдаа Өөрөө
хийдэг байсан
шиг гайхамшиг
байлаа шүү.

Одоо бүр
суумгай хүн
явдаг боллоо гэж
баривчилж
байх шив дээ.

Манай айлын нэг хүн
Есүсийг үхлээс амилснаас
нь хойш харсан гээд байгаа
юм. Нэг удаа бүр таван
зуугаад хүн зэрэг харсан
гэсэн шүү.

Би явлаа.
Бусад дагалдагчдыг
олоод тэд нараас илүү
юм олж мэдье.




Бид уул нь буруу
номтон бүлэглэлийн
толгойлогчийг нь
цовдлоод, дараадахлаа
гэж бодож байсан юм
сан.

Эд Есүсийг
амьд гээд
байгаа юм.

Тэгвэл Есүсийг
хойноос нь хошуурагчидтай
нь цуг дахиад хороочихъял
доо.

За за, тэр хоёр
бас эд нартай одоохон
нийлэх юм байна даа.

Эд нар Есүсийг
тэнгэрт Эцэг Бурхантай
хамт байгаа гээд
байгаа юм




Бид нар энэ хүнийг
төрөлхийн суумгай байсныг
мэднэ. Та нар яаж ингэж эдгээж
чадав? Хэний нэрээр үүнийг
хийсэн бэ?

Та нар цовдолж,
Бурхан үхлээс амилуулсан
Назарын Есүс Христийн
нэрээр энэ хүн эдгэрсэн юм.
“Барилгачдын голсон чулуу
булангийн чулуу болдог” гэсэн
Бичээсийн үгийг санагтун.



Өөр ямар ч зүйл
аврал өгч чадахгүй:
газар дээр хүмүүсийг
аврахаар өгөгдсөн өөр
ямар ч нэр байхгүй.



Эд нар уул
нь хүмүүст
тоогдохооргүй
л байх ёстой
доо. Гэтэл
ямар ч сургууль
боловсролгүй
мөртөө эш
үзүүлэгчдийн
хэлснийг
чөлөөтэй иш
татаж байх
юм.

Нэгэнт үйлдэгдсэн
гайхамшийг үгүйсгэх ямар ч
арга алга. Хүн болгон тэр хүнийг
эдгэрснийг мэдээд зогсохгүй
Есүсийн дагалдагчид Түүний нэрээр
эдгээснийг ч мэднэ. Бид одоо
энэ асуудлыг шийдэхгүй бол
болохгүй дээ.


Би эднийг таньж
байна. Эд чинь үнэндээ
тэр Есүстэй цуг байдаг
байсан юм.



Эднийг
эндээс гарга!

Та нар цааш тэр үхсэн Есүсийн
нэрээр яриад эдгээгээд байвал
Тэрэнтэйгээ адилхан болно шүү.
Ойлгож байна уу, та нар? Одоо
эндээс далд орж, үхлээс амилсан
тухай утга учиргүй юмаа надад
дахин бүү дуулгаарай.

Бурханыг дагахаас
илүү өөрийг чинь дагах
нь Бурханы нүдэнд зөв байх
нь уу үгүй юу та өөрөө
шийдэх болтугай. Гэхдээ бид
өөрсдийнхөө үзэж, дуулсныг
л ярих ёстой.



Сайн мэдээ Израилийн
бүх газар нутгаар тархав.
Олон хүн Есүст итгэж
усан баптисм хүртжээ.

Чуулган хайр, амар тайвнаар
дүүрсэн нэгэн том гэр бүл болжээ.

Та Есүс
Христийн тухай
сайн мэдээг сонсож
дуулсан уу?

Есүс үхлээс амилсан.
Тэр амьд байгаа бөгөөд одоо
ч бидний дунд байна.



Чуулганд эмэгтэйчүүдийг
үнэлж хүндлэн харьцах болжээ.

Манайхан бүгдээрээ
итгэснээс хойш манай
гэрт анх удаагаа л амар
тайван тогтож байгаа
шүү.



Христэд итгэгчид дуу аялан ажилладаг байв.

Христэд итгэгчид өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж, өөр хоорондоо байгаа бүхнээ хуваалцан хэрэглэдэг байв. Тэд өдөр бүр айлаас айлд, гудам талбайд тааралдсан болгондоо Есүсийн тухай зааж сургадаг байлаа.

Израилийн эрчүүд
ээ, та нар Бурхан бидний
өвөг дээдэст үр удам нь харийн
оронд очин амьдарч 400 жил
боолчлогдсны эцэст Өөрөө тэр
үндэстнийг шүүн шийтгэж, ард
түмнээ чөлөөлөн Абрахамд өгсөн
газар нутагтаа буцаан авчирна
гэж хэлснийг мэддэг
билээ.






Стефан,
чи тэнэглэхээ
болиоч.

Чи манай
сүм дуганы эсрэг
ярьж байна!

Харин Соломон
Бурханы өргөөг барьсан
юм. Эш үзүүлэгчийн
хэлсэнчлэн Дээдийн Дээд Нэгэн
хүний гараар барьсан сүм дуганд
оршдоггүй билээ. "Тэнгэр болбоос
Миний сэнтий, Газар болбоос
Миний хөлийн гишгүүр. Надад
зориулж та нар ямар сууц барих
юм бэ? Би амрах ямар газар байна
вэ? Энэ бүх зүйл Миний мутраар
бүтээгдээгүй гэж үү?"




Та нар зөрүүд тэрслүү хүмүүс. Та нарын зүрх сэтгэл Бурханы өмнө зөв бус байна. Та нар өөрсдийнхөө эцэг өвгөдийн адил Ариун Сүнсийг эсэргүүцдэг. Эцгүүд чинь Христийн ирэхийг зөгнөн хэлсэн эш үзүүлэгчдийг хавчин доромжилж хороодог байсан бол та нар Түүнээс урван тэрсэлж амийг нь хөнөөсөн билээ.



Стефан чи
өөрийгөй иудей гэж
хэлж чадах уу?

Чи манай хууль
заншлийг үгүй
хийгээд юугаар солино
гэнэ ээ? Ромчууд
цовдолсноос хойш хэнд
ч харагдаж үзэгдээгүй
үхсэн хүнээр үү?

Харагтун, би тэнгэр
нээгдэж хүний Хүү Бурханы
баруун гар талд зогсож байхыг
харж байна. Ямар агуу
гайхамшиг вэ!



Гараараа чихээ
бөглөгтүн. Энэ их
доромжлолыг бүү сонс!

Энэ хүн
үхвэл
зохилтой!

Хотоос
гаргаад
чулуу шидээд
алчих.




Доромжлогч!

Энэ манай
шашныг үгүй
хийхээр оролдож
байна.


Бид Есүсийг
цовдолсон бол
чамайг харин
чулуу шидэж
ална даа.

Намайг чулуугаар
шидсэний дараа ч
Есүс Эзэн хэвээрээ
л байх болно.



Энэ манай шашныг доромжилж байна. Бид үүнийг үхэх ёстой гэж үзэж байна. Саул аа, дээдсээс биднийг дэмжиж байгаа биз дээ?

Би шийтгэхийг зөвшөөрсөн гарын үсгийг нь зурчихъя. Наад хүн чинь тэр үхсэн Назарын Есүсийн дагалдагч нарын нэг байгаа юм. Энэ доромжлол одоо эцэслэх болсон. Чулуугаар шидэж хороох ажлаа эхлүүлж болно.



Саул аа, миний
хувцсыг харж
байгаарай.

Эзэн Есүс минь ээ,
сүнсийг минь хүлээн авна
уу. Энэ нүглийг тэдний
эсрэг бүү тооцооч.




Энэ үеэр
Иерусалимд
чуулганы эсрэг агуу
их хавчлага эхэлжээ.
Элч нараас бусад
бүх хүн хотыг орхин
явсан юм.

Энэ бол
зөвхөн эхлэл!

Энэ Есүсийн
хүмүүсийг ингээд
дуусгая!

Доромжлогчийг ал!





Энд дахиад
өөр Христийн
дагалдагч байна уу?

Аавыг
минь битгий
зодооч!


Наад
эмэгтэйгээ
бас бариад ав.

Фарисай Паул чуулганы
эсрэг тэмцэн эрэгтэй,
эмэгтэй хүмүүсийг
гэрээс нь хөөн шоронд
хийж байлаа.

Филип гэгч христитгэлт нэгэн хүн залбирч байхад түүн дээр тэнгэр элч ирэн ярьжээ.

Филип
ээ, босоод
Иерусалимаас Газа
уруу урууддаг
замаар яв.




A man in a green robe is running away from the viewer across a desert landscape. The background shows rolling hills and a large rock formation on the right. A thought bubble is positioned above the man, containing text in Mongolian. The scene is rendered in a simple, illustrative style with bold black outlines and flat colors.


Намайг яагаад
тийшээ яв гэж байгаа
юм бол оо? Гэхдээ
Бурхан яв гэж байгаа
бол би явна аа.

Энэ өнөө
газар мөн юм шиг
байна. Одоо яах вэ
Эзээн!



A man with curly brown hair, wearing a green robe, is kneeling in a desert landscape. He is looking down and to the left. The background shows a large tree on the right and rolling hills in the distance under a blue sky. A speech bubble is positioned to the left of the man.

Эзэн
минь ээ,
Та надаас
юу хүссэн
юм бэ?

A man with a beard, wearing a green robe, is sitting on a large rock. He is looking towards a caravan of people and animals in the distance. The background shows a landscape with mountains and a large tree. A speech bubble is positioned above him, and another speech bubble is below him.

Сүйхт эрэг!
Эзэн Та намайг энд
авчирсныг учир энэ юм
уу? Тэргэн дотор Таны
өөртөө сонгосон хүн
байгаа юм уу?

Явж очоод
тэргэнд суу.




Тэргэн дотор Этиопын хатан хааны албанд хүчин зүтгэдэг эрх мэдэл бүхий нэгэн явж байлаа. Энэ хүн тэр хаанчлалын бүх баялаг болох хатан хааны эрдэнэсийн санг хариуцдаг хүн байсан юм. Мөнөөх хүн Иерусалим орж иудей заншил ёсоор мөргөл үйлдээд Этиоп уруу буцаж яваа нь энэ аж. Харин тэр замдаа Бичээсээс уншиж явав.

"Тэр нядлагдах хонь мэт хөтлөгдсөн бөгөөд хяргагчийн өмнө буй хурга дуугүй байдаг шиг Тэр амаа ч нээгээгүй юм... Учир нь Түүний амь дэлхийгээс зайлуулагдсан юм."




Би таныг эш
үзүүлэгч Исаиагийн
номыг уншиж байгааг
сонслоо. Та уншиж
байгаа юмаа ойлгож
байна уу?

Чи миний юу уншиж
байсныг ойлгосон юм уу?
Харин хүн надад
тайлбарлаж өгөхгүй бол
ойлгохгүй байна. Наашаа
гарч ирээч, цуг явъя.



Та сая
Иерусалимаас
ирэв үү?

Тэглээ. Би тэнд мөргөл
үйлдэхээр очсон юм.
Манай өөрийн шашин ер амар
тайвныг авчрахгүй
юм байна. Бурхан биднээс
алс хол бололтой.



Би амлагдсан Мессиагийн тухай уншсан юмаа. Тэгтэл сая Иерусалимд очсон чинь олон мянган хүн Мессиа ирчихсэн, бас цовдлогдоод үхлээс эргээд амилчихсан гэж яриад тунхаглаад байх юм.

Тэгээд л би эш үзүүлэгчдийн бичсэн номуудаас яг иймэрхүү юмны талаар урьдчилан хэлсэн байна уу үгүй юү гэж хайж байгаа юм. Энэ эш үзүүлэгч Исаиа өөрийнхөө тухай хэлээд байна уу аль эсвэл бүр өөр хүний тухай яриад байна уу, чи мэдэхгүй биз?

Энэ Исаиа ном чинь бараг 800-аад жилийн өмнө бичигдсэн ном. Таныг уншиж байгаа энэ 53-р бүлэг чинь Мессиагийн талаар хэлсэн маш олон эш үзүүллэгийн нэг нь л байгаа юм. Энэ дээр Есүсийг "голж доромжилно" гэсэн байгаа юм.


Та Иерусалимаас ирсэн гэлээ. Хэдий Есүс олон агуу гайхамшгийг үйлдсэн боловч манай шашны удирдагчид үл ойшоосон юм.





Ишлэл 7 бол Есүс
шүүгдэхээр зогсохдоо
өөрийгөө өмгөөлөн
хамгаалахгүй гэдгийг
хэлсэн эш үзүүллэг.

Исаиа Есүсийг
бидний гэм нүглийг
төлөхийн тулд шархдан зовлон
эдэлнэ гэсэн байдаг. Тавдугаар
ишлэл дээр нүгэлтнүүдийн
авах ёстой шийтгэл Есүст
тохогдоно гэсэн байна.




Ишлэл 8 Өөрийнхөө хүмүүсийн гэм бурууг төлөхийн тулд шоронгоос үхэлд хүргэгдсэн тухай юм.

Зургадугаар ишлэлд би бүр ч их дуртай. Ингэж хэлсэн байдаг. "Бид бүгдээрээ хонь мэт төөрч, хүн бүр өөрийн замаар явав. Харин ЭЗЭН бидний гэмийг бүгдийг нь Түүнд тохов." Энэ ишлэл хүн бүр Бурханы хүслийг орхин өөрийн нүгэлт замаар явсан ч Бурхан харин бидний нүглийг Есүст тохоон үхүүлснээр бидний дуулгаваргүй байдлын төлөөсийг төлүүлсэн гэсэн утгатай аж.




Есдүгээр ишлэл
Есүсийг баян, ядуугийн аль
алинтай нь хамт оршуулагдана
гэсэн байна.

Есүс бусад бүх хүн
гэм нүгэл үйлдсэн шиг гэм
нүгэл үйлдээгүй ч биеэрээ
тэдний нүглийн төлөөс
болсон учраас шархдаж
зовлон эдэлсэн юм.




Ишлэл 10 Есүсийн
үхлээс амилсан явдал
болоод түүнээс хойших
ажил үйлсийн талаар
өгүүлж байна.

Маш олон эш үзүүлэгч Есүс
амилсныхаа дараа хаан сэнтийд
заларч, хожим биднийг үхээд өмнө
нь очиход бидний амьдарсан
амьдралыг шүүнэ гэсэн байдаг.



Хуулийн багш нар, тахилчид
Аврагчийн тухай эш үзүүллэгүүдийг
ярьж байхыг би зөндөө сонссон. Гэтэл
яахаараа тэд чинь Есүсийг юман
чинээ боддоггүй билээ?

Хуулийн багш нар, тахилчдын зарим нь
Есүсийг хүлээж авсан ч харин зарим нь өөрсдийнх нь
хуурамч зан хоёр нүүрийг илчлэхэд уурлан хилэгнэсэн юм.
Тэд ромчуудыг үгүй хийх Мессиаг хүлээж байсан болохоос
биш гэм нүглийг нь илчлэх нэгнийг хүлээж байгаагүй юм.
Тэд хаант улсыг захирахыг хүссэн боловч Бурханаар
зүрх сэтгэлээ удирдуулахыг хүсээгүй ажээ.



Эд нараас өөр Есүс дээр биеллээ олсон эш үзүүллэгүүд байдаг уу?

Дуулал 22 бол Есүсийг цовдлуулан үхэх тухай эш үзүүллэг байгаа юм.

Дуулал ном чинь хүнийг цовдолж шийтгэдэг ёс гарахаас бүр өмнө буюу жилийн өмнө бичигдсэн гэдэг биз дээ?



Тэгэлгүй яахав. Гэхдээ Бурхан бүх зүйлийг болохоос нь өмнө мэддэг болохоор Мессиагийн тухай бараг 340 эш үзүүлэлэг хэлэгдсэн байдаг юм даа. Тэгж л бид нар зөвхөн Есүс л Бурханаа илгээгдсэн жинхэнэ нэгэн мөн байна гэж мэддэг юм.

Дуулал 22:16 дээр Есүсийн гар хөл хадаасаар хадуулснаасаа болоод цоорох тухай зөгнөсөн байдаг. Ишлэл 14-т маш ихээр цангаж мөн яснууд нь үенээсээ мултарч үхэх тухай байдаг. Харин Дуулал 34:20 Есүс цовдлуулж үхэх боловч нэг ч яс нь хугарахгүй гэсэн байдаг. Ер нь бол цовдлуулсан хүмүүсийн ясыг хугалдаг заншилтай.

Харин Есүс аль хэдийнэ амьсгал хураасан байсан болохоор ясыг нь хугалах шаардлага байгаагүй. Дуулал 22-ын 17-р ишлэл хүмүүс Түүнийг нүцэглэнэ гэсэн байдаг бол харин 18 дугаар ишлэл д хувцсыг нь хувааж нөмрөгнийх нь төлөө шодно гэсэн байдаг юм.

Түүнчлэн Зехариа номын 12:10 гарыг нь хадаж дараагаар нь иудейчүүд хадаасных нь соривыг харах болно гэсэн байдаг. Исаиа 50:6 нурууг нь ташуурдаж хацрыг нь алгадна гэж бичсэн. Дуулал 16:10 хэдийгээр хүмүүс Түүнийг оршуулах боловч бие нь тэнд ялзрахгүй гэж хэлсэн байдаг. Эш үзүүлэгчүүд бас анд нөхөр нь Түүнээс урвах бөгөөд урвагч дараа нь өөрийгөө дүүжлээд дүүжлүүрээсээ унахдаа газар унаж гэдэс нь хагаран үхнэ гэсэн байдаг. Хожим нь урвагчийн үхсэн тэр газрыг харийн хүмүүсийг оршуулдаг газар болгожээ. Саяын ярьсан зүйлүүд болон эш үзүүлэгчдийн бичсэн өөр олон зүйл биелэгдсэн юм. Назарын Есүс Христ бол дэлхийг Аврагч Мессиа мөн гэдэгт ямар ч эргэлзээ байхгүй билээ.

Би Есүсийг Мессиа гэж
итгэж байна. Тэр бол бидний
нүглийг авч хаях амлагдсан хурга
мөн. Тэгвэл одоо бид ямар ч өргөл
өргөх хэрэггүй боллоо шүү дээ.
Есүс бол Бурханд хүрэх хаалга юм
байна. Би Есүсийн дагалдагч
болно.






Энд ус
байна! Ер нь усан
баптисм хүртэж
яагаад болдоггүй
билээ?

Та бүхий л зүрх
сэтгэлээсээ Есүст
итгэж байгаа бол би
танд усан баптисм
хүртээе.


Ээ тэгэлгүй
яхвэ! Би
итгэж байна!



Би Аврагч Эзэн
Есүс Христийн нэр
дээр усан баптисм
хүртээж байна.



Бурханыг
магтъя!



Нөгөө хүн
чинь хаашаа
явчихав?

Алга болчихлоо!

Тэр хүн Бурханд хаа
нэгтээ хэрэг болсон байх аа.
Этиоп уруугаа буцаж очоод
Мессиагийн талаар сурсан
юмаа хатан хаанд дуулгая.

Тэр цагаас хойш Этиопт сүм чуулганууд
байгуулагдаж өнөөгийн лалын шашинтнуудад
ихэнх итгэгчид нь алагдах хүртлээ үргэлжилсэн юм.




Арван гурав
бүлэг
БҮХ
ДЭЛХИЙ
ДАЯАР

Амь нас нь аюул заналд өртөөд байсан учир итгэгчид Бурханы үгийг сонсож, магтаал өргөхийн тулд нууцаар цуглардаг болжээ.

Анд нөхөд
минь ээ, Эзэн маань
бидний гэм нүглийг авч
хаяхын тулд Өөрөө зовлон
эдэлсэн билээ. Бид ч бас
Түүний төлөө зовлон
туулахад гайхах хэрэг
байхгүй ээ. Тиймд эдэлж
буй хавчлага дарамтаа
хараад айж сандрах
хэрэггүй юм.

Есүс ингэж хэлсэн билээ.
"Хэрэв хэн нэг чинь миний
дагалдагч болбол тэр хүн загалмайгаа
үүрээд намайг дагах хэрэгтэй." Бид
үнэхээр Есүсийн хойноос дагахаар
дуудагдсан юм бол бас загалмайгаа
үүрээд дагах ёстой гэсэн үг ажээ.
Одоо 22-р Дуулал ингэж хэлж
байна...






Бурхан
минь ээ, бидэндээ
туслаач. Энэ нөгөө
алуурчин Саул
байна.

Бүү хөдөл! Харийн шашныг
бид зөвшөөрөхгүй. Та нар манай
өвөг дээдэс, үндэс угсааг минь
доромжилдог. Муусайн тэнэгүүд!
Нэг бол та нар итгэлээсээ урва, эс
бол үх.


Наадуулынхаа
толгойлогчийг нь
бариад ав. Бусдад
нь сайхан жишээ
болгоодохъё.



Итгэж болох бүх л
Мессиаанууд бидэнд байсан.
Гэтэл та нар яахаараа
тэр үхсэн мужаанд шүтэж
мөргөөд байдаг байна.


Бидний Эзэн Есүс
амьд байхаар зогсохгүй
Тэр бол ертөнцийг
Бүтэээгч Эзэн билээ.

Чи тэгвэл эхнэрээ
шоронд хатахын цагт
хэл яриагаа өөрчлөх
байлгүй дээ.



Болиоч
ээ! Эхнэрийг
минь
үлдээгээч!

ТҮК!



Христийг
шүтэгчид ээ, дахиад
нэг чинь ирлээ.

Бид
христитгэгчид
болохдоо ийм юм болж
магадгүй гэж мэдэж
байсан юм аа.



Харин тийм ээ,
бүгдээрээ ерөөсөө
түүний төлөө залбиръя.
Бурхан зүрх сэтгэлийг
нь зөөллөж, үнэнийг
хараасай гэж залбиръя.

Энэ нөгөө Саул
гээч Фарисай мөн биз. Тэр
бүр бидэнд хорсон, биднийг
тарчлаахаар шатаж байгаа
юм.

Тэр Саул үзэн
ядалт хорслоор
дүүрчихээд
байгаа юм.

Бид нарын зарим
ч эхлээд эргэлзэж
байсныг санаарай.



За ашгүй, Саул
чи Иерусалимыг Есүсийг
дагагч буруу номтнуудаас
овоо цэвэрлэх шиг
боллоо.

Тийм биш байна аа. Алж
устгаад, шорон гянданд хорих
тусам улам олшроод байна. Цаадуул
чинь өөр хот суурингуудаар тараад
Дамаскийн синагогиуд тэднээр
бүр дүүрчхээд байна.



Тэднийг
баривчлах
зөвшөөрлийг чамд
өгье. Чи Дамаск
уруу яв.

Би одоо
шууд
явлаа.


Шашин шүтлэг, улс үндэстнээ буруу итгэл үнэмшлээс хамгаалах нь өөрийнх нь үүрэг хэмээн Саул үзэж байлаа. Гэсэн хэдий ч өөрт нь хэзээ ч байгаагүй их амар тайван, итгэл найдвар христитгэлтнүүдэд байдаг нь түүний уурыг хүргэж байв.

Саулын өмнө гэнэт нарны
гэрлээс ч хурц гэрэл бий болов.

Саул аа,
Саул аа, юунд чи
Намайг хавчина
вэ?

Саулын унаж явсан морь
үргээд түүнийг зам уруу унагааж
орхиод давхиад явчихав.





Дагалдагчдыг
минь шийтгэснээрээ
чи Намайг хавчин
дарамталж буй хэрэг. Би
чиний мөрдөн мөшгөөд
байгаа Есүс байна.

Эзэн Та
хэн бэ, би Таныг
хавчиж байна
гэж үү?

Бос. Хотуруу оч.
Тэнд чамд юу
хийхийг чинь зааж
өгнө.

Эзэн, Та
надаар юу
хийлгэхийг
хүсээ вэ?




Та нар тэр
дууг сонсов
уу?

Тэгсэн.
Гэхдээ харин
юу хэлээд
байгааг нь
ойлгоогүй.

Би ч бас
ойлгоогүй. Яг тэнгэр
дуугарч байгаа юм
шиг сонсдож байсан.

Тэр Бурханы
дуу байсан!

Би юм
харж чадахгүй
байна! Туслаарай.
Юм харж чадахгүй
байна. Намайг хотод
аваачаад өгөөч.



Намайг Ананиа
гэдэг. Есүс надтай
үзэгдлээр яриад чам дээр
очиж хараатай болгож
өг гэсэн юм.

Би үнэхээр
хараагүй хүн.

Есүс Христийн
нэр дээр дахин
хараатай бол.



Би харж байна!
Та, Есүс эдгээлээ
гэж хэлсэн үү? Есүсийн
тухай илүү ихийг ярьж
өгөөч.



Тэгээд Ананиа Ариун бичээсийг нээж Саулд Есүсийн талаарх эш үзүүллэгүүдийг үзүүлэв.

Тиймээ. Би үнэхээр тэнэг байжээ. Бичээст эхнээсээ л бичсэн байсан байна шүү дээ. Би бүр шашинлаг зорилгодоо дөрлүүлээд сохорчихсон байсан юм байна. Би усан баталгаа хийлгэж, Есүсийн дагалдагч болмоор байна.

Бурхан Саулын нэрийг Паул болгон өөрчилжээ.




Одоо харин Паул гэгдэх болсон Саул шинэ мэдээ өвөртөлсөн шинэ хүн болсон байлаа. Цааш христитгэгчдийг хороон устгахаа бүрмөсөн больж харин ч бусдыг Есүс Христэд итгэхэд уриалан дагуулахыг хүсэх болжээ.

Би та нарын эргэлзээг ойлгож байна. Би ч бас итгэдэггүй байсан юм. Харин Назарын Есүс манай эртний эш үзүүлэгчдийн хэлсэн Мессиагийн талаарх бүх зөгнөлүүдийг биеүүлсэн юм гэдгийг би та нарт хэлэх байна.


Гайхалтай агуу баталгаа бол Бурхан Өөрөө Түүнийг үхлээс амилуулсан явдал юм.






Чи чинь юу
гээчийн тэнэг амьтан
бэ? Мессиа яаж Өөрийгөө
дайснуудад алуулж байх
юм бэ?

Тэр бол бидний
гэм нүглийг авч
хаясан Бурханы хурга
байсан юм.




Тэр үед Бурхан мөн харь үндэстнүүдэд хүрч байлаа. Бурханыг залбирлаараа эрэн хайж байсан нэгэн Ромын зуутын дарга байжээ.

Бурхан минь ээ, би Таныг бүх хүн төрөлхтнийг бүтээсэн Бүтээгч гэж мэдэх билээ. Манайхны шүтдэг шашин хүнд амар тайвныг өгч чаддаггүй хуурамч зүйл гэж би мэднэ. Харин Та надад Өөрийнхөө замыг таниулаач. Би Таны замаар явахыг хүсэж байна.



Хэн? Юу гэнэ
ээ? Та хэн бэ?
Та хаанаас ирсэн
юм бэ?

Бурхан залбирахыг чинь
сонсоод намайг илгээсэн юм.
Иоппад байдаг ширчин Симоньх
уруу хүн явуул. Тэднийх далайн
эрэг дээр байдаг юм. Тэгээд Петр
гэдэг хүнийг асуу. Петр танайд
ирж чамд Бурханы үнэнийг
хэлж өгнө.



Есүсийн
загалмайн
цусаар Бурхан
амар тайвныг
тогтоосон
билээ.

Петр ээ, манай эзэн их шүтлэгтэй
сайн хүн байгаа юм аа. Гэхдээ олон
зүйлээс болоод тайван биш байдаг. Үргэлж
залбиран мөргөж, сайн үйлс хийж, ядууст
хүртэл өглөг өгөөд байхад Бурханы амар
тайван түүнд алга байна.


Наадах чинь
юу гэсэн үг
вэ?

Би энийг эзэнд
чинь очоод
тайлбарлаж
өгье.



Зуутын дарга Петрийг
үүдэн дээрээсээ тосон
түүнд мөргөв.

Бос. Намайг бүү шүт.
Би тантай адил жирийн л
хүн. Бүх хүмүүсээ дуудаад
оруулаад ир. Би та нарт
сайн мэдээ хэлье.



Ямар агуу өдөр!
Бурхан Өөрийнх нь
дагалдагч нарын нэг болох
Петрийг бидэнд Есүсийн
тухай яриулахаар
явуулсан байна.

Тийм ээ. Би Есүсийг гурван жил хагас дагасан юм. Би
Түүнийг цовдлогдсон байхыг ч, бас үхлээс эргээд амилсан байхыг
ч харсан хүн. Үхлээс амилснаас нь хойш бид нар бүр таван зуугаараа
хүртэл цуглаад Түүний айлдахыг сонссон юм. Тэр бүр бид нартай хамт
хооллож бид Өөрт нь хүрч үзсэн юм. Есүс биднийг дайснаа хайрлаж,
биднийг хавчин дарамтлагчдын төлөө залбир гэж сургасан билээ.
Мөн Есүс Өөрийнхөө сүнсийг илгээсэн...

Тэр өдөр зуутын дарга
Корниелынхон гэр
хотлоороо бүгд Есүс
Христийн Сайн мэдээнд
итгэж усан баптисм хүртжээ.



Паул Саббат өдөр Антиох хотын синагогид иудейчүүдэд сургаал айлдав.

Та бүхэн намайг мэдэх билээ. Би христитгэгчдийг хавчин доромжилж, алж устгадаг байсан. Гэтэл Есүс надад нүд сохлом хурц гэрлээр үзэгдэж аянгын дуу хоолойгоор ярин, Өөрийнхөө үгийг зарлан тунхагла хэмээсэн юм. Би Бичээсээс Мессиагийн тухай эш үзүүллэгүүдийг уншиж судлахад Есүс үнэхээр тэр бүхнийг биелүүлсэн болохыг олж мэдлээ.






Бурхан Давидын үр удмыг
Израилийн Аврагч болгон босгох
бөгөөд Иерусалимын зэрэгтнүүд
Түүнд үхэх ял онооно гэж хэлсэн
байдаг. Дуулал 2-т ингэж бичсэн
байдаг "Чи бол Миний Хүү
өнөөдөр Би Чамайг төрүүлсэн".

Дууллын өөр нэг хэсэгт
Бурхан Өөрийн Ариун Нэгэнийг
ялзрал үзүүлэхгүй гэсэн байдаг юм. Өөр
нэг эш үзүүллэгт Есүс үхэх боловч бие
нь муудаж ялзрахгүй гэж хэлсэн байдаг.
Мосегийн огтоос өгч чадаагүй нүглийн
бүрэн уучлалыг та нар Христийн дотор
олж чадна гэдгийг мэдтүгэй.





Бурхан Есүсийг
харийнханд гэрэл,
бүх үндэстэнд
Аврагч болгон
илгээсэн юм.


Харийнхан гэнэ
ээ! Харийнхан бол
цэвэр бус хүмүүс. Тэд
хэзээ ч иудейчүүдийн
итгэлээс хуваалцах
учиргүй хүмүүс.

Чи муу
доромжлогч! Есүс
ерөөсөө хууль бус
хүүхэд байсан. Түүнийг
эх нь нөхөрт гарахаасаа
хамаагүй өмнө олсон
гэсэн яриа бий.



Наад тэрс
үзлээсээ болж чи
чулуугаар шидүүлж
үхвэл таарах юм
байна.

Та нар нэгэнт мөнхийн
амийн Сайн мэдээг
хүлээн авахгүй юм бол эш
үзүүлэгчдийн тунхаглан
хэлж байсны дагуу харь
үндэстнүүдэд бид энэ мэдээг
хүргэх болно.



Иудей үндэстэн тэр чигээрээ Христийг бүрэн эсэргүүцэх нь тодорхой болсон тул Паул Израиль бус харь үндэстнүүдэд хүч хөдөлмөрөө зориулахаар шийджээ.

Бурхан ба Түүний Хүү Есүс магтагдах болтугай. Аврал харь үндэстнүүдэд иржээ!

Паул аа, надад усан баптисм хүртээгээч!

Есүсийн тухай эш үзүүллэгүүдээс илүү ярьж өгөөч.

Маш олон харь хүн Сайн мэдээнд итгэж, Бурханы нигүүсэл дор амьдрах болжээ.

Иудейчүүд хилэгнэн уурсаж Паул, Барнаб хоёрыг хотоос гаргаж хаяад хот уруу дахин орж ирвэл амь насыг нь хөнөөхөөр заналхийлжээ. Тиймд Паул, Барнаб хоёр Ази уруу аялж тааралдсан болгондоо Сайн мэдээг тунхаглаж явав.



Барнаб аа,
намайг уначихвал
битгий зогсоорой.
Цаашаа гүйгээрэй.

Лустр хотод иудейчүүд
Паулыг үхтэл нь зодоод
хотоос гаргаж хаяжээ.

Бурхан минь ээ,
тэднийг уучлаарай.
Тэд Паулыг маань
алчихлаа.



Гэтэл харин Бурхан
гайхамшгаа үзүүлж,
Паулыг тэнхрүүлэн босгов.

Ёоох
Паул аа, би
чамайг үхчихлээ
гэж бодсон шүү!

Болоогүй ээ. Бурхан надад
зөндөө юм үзүүллээ. Би Өөрийнх нь
нэрийн төлөө нэлээн зовох бололтой.
Бид зөвхөн эхэлж л байна. Хоёулаа
буцаад хот уруу оръё.





Эзэн минь ээ
Та алдар, хүндлэл,
магтаалыг авах нь
зохилтой билээ...

Македоний Филиппой хотод Паул,
Силас нар 39 удаа ташуурдуулаад
шоронд хоригджээ. Зовон шаналж
байсан хэдий ч тэдний зүрх сэтгэл
хөөр баяраар дүүрч, шөнө дунд Бурхан
Эзэнээ магтан дуулж байсан юм.



Ааааа!

Есүс бол
Эзэн!



ТАС!

Дараах жилүүдэд нь Паул гурван ч удаа ташуурдуулан шийтгүүлсэн боловч Есүсийн тухай зарлан тунхаглахаа зогссонгүй ээ.

Паул газар газар дамжин Сайн мэдээг тунхаглаж явахад гурван удаа сууж яваа хөлөг онгоц нь живж байжээ.




Нэг удаа Паул далайн усанд унаад нэг өдөр, нэг шөнө болсны дараа л аврагджээ.

Аялж явах замдаа Паул олон удаа дээрэмдүүлж байжээ.



Хэдий тийм ч Есүсийг зарлан тунхаглахаа зогсоосон нь үгүй юм.

Ийнхүү Эзэний тухай Сайн мэдээг дэлхий даяар тараан явахдаа халуунд халж, хүйтэнд хөрч, өлсөж цанган, өвдөж зовох зэргээр бүх төрлийн хатуу хөтүүг туулсан юм.



Эзэн минь
ээ биеийг минь
эдгээгээд өгөөч.
Би дараагийн газар
очиж Сайн мэдээг
тунхаглах хэрэгтэй
байна.

Паул хотоос хотод, суурингаас сууринд очиж хуурамч шүтээнийг эсрэг зааж, Есүс Христийн сайн мэдээг хүмүүст зарлаж явлаа.



Чи хуурамч шүтээнүүдээсээ салж Бурхан уруу эргэсэн тул хуулийн ямар ч оролцоогүйгээр, итгэлээр чинь Бурхан чамайг зөвтгөлөө. Одоо чи Христийн биеийн нэг хэсэг болсон тул Бурханы гэр бүлийн гишүүн боллоо.


Бурханыг магтъя!



Энэ юмнууд
надад амар тайвныг
ердөө ч өгч
байсангүй.

Хүмүүс жинхэнэ Бурханыг танин Түүн уруу ирэхдээ тахин шүтэж байсан хуурамч шүтээнүүд мөн тэдгээртэй холбоотой бүхнийг галд шатаан гэм нүгэлт амьдралаа ардаа орхиж байсан юм. Эзэний тухай мэдээ түгж эхэлснээс хойш хориодхон жилийн дараа гэхэд тэр үеийн улс гүрнүүдэд христитгэлт хүмүүс бий болон Есүс Христээр дамжуулан Эзэн Бурханаа магтан хүндэтгэж байлаа.

Есүс дагалдагч нартаа ийн сануулжээ.
“Тэгэхэд хүмүүс та нарыг зовлон
гамшигт тушааж, та нарыг ална. Миний
нэрээс болж та нарыг бүх үндэстэн үзэн
ядах болно. Тэр үед олон хүн бүдрэх
бөгөөд нэг нэгнээ үзэн ядаж, урван
шүүхэд тушаана. Олон хуурамч эш
үзүүлэгч гарч ирж олныг төөрөлдүүлнэ.”



Эзэн Есүс
ээ, сүнсийг минь
аваарай!



Аав аа,
биднийг ингэж
байгаагийнх нь
төлөө эднийг бүү
шийтгээрэй.

Христийг дэлхийд байхад нүдээрээ үзэж харсан хүмүүс ч өтөлж, сүм чуулган ч Ромын хаант улс даяар өргөжин дэлгэрчээ. Энэ үеэс ромчууд христитгэлтнүүдийг алж хядан, хавчин дарлах үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд Христээс үл ухарсан болгоныг цэнгэлдэх хүрээлэнд олны өмнө хөгжөөн болгон гаргаж, зэрлэг бар арслангуудаар тас татуулдаг байлаа.


APPPPPP!



Aaaaaaa!

Заримдаа итгэгчдийг ромын гладиаторууд сэлэмний ирээр тасчин алдаг байсан юм. Харин итгэгчид итгэлээсээ ухрахгүй байгааг хараад хүмүүс гайхан биширдэг байлаа. Тэд Есүсийн төлөө алагдахад хэзээд бэлэн байжээ.





Загалмай дээр
үхэхээсээ өмнө Есүс
Иерусалимын сүмийн
тухай ийнхүү зөгнөжээ.

Та нар
сүмийг харж
байна уу? Би та
нарт хэлье. Энэ сүм
устаж үгүй болоход
нэг чулуу ч нөгөө
дээрээ давхарлаж
үлдэхгүй.

Түүнээс дөчин жилийн хойно буюу
МЭ 70 онд ромчууд хотыг дайран
нураахад сүм ч бас устаж үгүй болсон
юм. Сүмийн доторлогоо моднууд галд
шатахад тэнд байсан алт хайлан, чулуун
шал суурины ан цаваар орж урсжээ.
Ромчууд алтыг авах гэж оролдохдоо бүх
чулуунуудыг нурааж, тийнхүү Есүсийн
урьдаас хэлсэн ёсоор болсон ажээ.

Энэхүү дайнаас амьд үлдсэн Иерусалим болон Израилийн бусад нутагт байсан иудейчүүд харийн улс үндэстнүүдэд дүрвэн гарч, тэдний үр удам өдий үеийг хүртэл тэдгээр газар нутагтаа амьдран сууж байна.



Бид нар Сирид байдаг ахынх уруугаа явж байна.

Христигэлт иудейчүүд ч Сайн мэдээ тараасан улс үндэстнүүд уруугаа явж тэндээ суурьшин сүм чуулганууд өсөн олширчээ.


Тэдний очсон газар бүрт аль хэдийнэ христитгэлт хүмүүс байсан бөгөөд элэгсгээр угтан авч байв.

Бидэнд очих газар байхгүй ээ.




Иерусалимд тохиолдсон гай гамшгийг сонсож дуулсан. Та нар бидэнтэй байж болно шүү дээ.

Элч нар нь Есүс Христийн эргэн амилсныг үхэн үхтлээ зарлан тунхагласан юм. Тэд бүгдээрээ алагдсан бөгөөд тэнгэрийн улсад энэ дэлхийнхээс хавьгүй сайхан орон гэр бий гэсэн итгэл зоригтойгоор амиа өргөсөн байна.



Заримыг нь ромчууд цовдолжээ.


Зарим нь амьдаараа хуваагдаж, гэдэс дотроо хүртэл авахуулсан байна.



Нэг хэсэг нь
чулуугаар
шидүүлж
алагдав.

Өөр нэг хэсэг нь
зэрлэг араатны
хоол болжээ.

Зарим нь толгойгоо
авахуулжээ.



Петр уруугаа харж
цовдлогдсон юм.


Зарим нь тосонд
аажмаар чанагдаж
алагдсан юм.

Би сайхан газар
очно оо. Бурхан
та нарыг өршөөх
болтугай.

Эзэн
минь ээ, би
Тантай адилхан хэх
зохисгүй хүн.

Тэд итгэлээрээ одоогийнхоо
биетэй зүйрлэшгүй сайхан биетэй
болж тэнгэрийн оронд очно гэсэн
найдвартайгаар үхэцгээж байсан юм.

Есүсийг цовдлогдсноос хойш жаран жилийн дараа дагалдагчдаас нь үлдсэн ганц хүн бол Иохан байлаа. Түүнийг Патмос хэмээх арал уруу цөлсөн ажээ. Иоханы дээр Эзэний Сүнс оршиход Бурхан түүнд ирээдүйн талаар илчлэл өгсөн байна.



Иохан аа, Би чамд ирээдүйд болох зүйлийг харуулъя. Харсан болгоноо тэмдэглэн бичиж аваад Азийн долоон сүмд илгээгтүн.

Энэ үеийн төгсгөл ирэхэд Есүс эргэн ирж Өөртөө итгэж байгаад нас барсан болгоны булшийг онгойлгоно. Тэгээд амьд байгсдыг үхлээс амилуулагдсан хүмүүстэй нийлүүлэн тэнгэрийн мандалд уулзуулж үүрд хамтад нь байлгах юм.



Энэ дэлхийн төгсгөл ирэхэд Бурхан дэлхийд төсөөлшгүй их зовлонг авчирна. Тэр үед тэнгэрээс гал унах мэт олон төрлийн гамшгаар дэлхийн хүн амын олох нь устаж үгүй болох юм.



Хуурамч Мессиа ирж олон хүнийг хууран мэхэлнэ.
Хүмүүсийн дух юмуу баруун гарын ар дээр тэмдгээ
тавин тэднийг өөртөө итгүүлж засаглалдаа оруулах юм.



Тэрхүү тэмдгийг хүлээн аваагүй хүмүүсийг
тамлан алах юм. Тэр үед дэлхийд амьд үлдсэн
хүмүүс маш их зовлон гамшгийг туулах болно.

Эш үзүүллэгт
хэлэгдсэний дагуу Есүс
энэ дэлхийд эргэн ирнэ.

Дахин ирэхдээ Тэр
жирийн хүн шиг бус
харин сүр жавхлан,
хүч чадлаа харуулан
ирэх болно. Тэнгэр
нээгдэхэд цагаан
морь хөлөглөн
доош бууж ирэх юм.



Тэр наран мэт гэрэлтэх бөгөөд
тэргүүндээ олон титэм өмссөн байна.
Гартаа долоон од барьж, амандаа
үнэний сэлмийг зуусан байх ажээ.

Тийнхүү ирэхдээ Сатаныг мөнхөд тамаа эдэлж зовох галт нуурт хаяад, дахин хэзээ ч хүн төрөлхтнийг уруу татахааргүй болгох юм. Есүс бас Өөрийн сүүлчийн дайсан болох үхлийг галт нуурт хаяж, энэ дэлхийг цоо шинэ болгоно.



Хүүд нь итгэж байсан олон хүнийг Бурхан цуглуулан шинэ дэлхий дээр мөнх амийг өгөх болно. Бурхан тэдний нулимсыг арчихад тэд дахин хэзээ ч гуниг зовлон, үхэл хагацал, өвчин шаналал амсахгүй бөгөөд хуучны бүх юмс өнгөрөн одно. Есүс Өөрийнхөө шударга зөвт хүмүүсийн Аврагч хаан нь болж үхэл, нүглээс ангид шинэ ертөнцөд үүрд хаанчлах болно.



Есүс Христийн Сайн мэдээ өдгөө 2000 жил тунхаглагдан зарлагджээ. Есүс хаанчлалын Сайн мэдээгээ дэлхий даяар тархаж улс үндэстэн, овог аймгийн хүн бүр сонсож мэднэ хэмээн урьдчилан хэлжээ.



Ганц Бурхан байдаг
бөгөөд Тэр бас цорын
ганц Хүүтэй юм. Мөн
ганц итгэл, ганц ариун
ном байдаг бөгөөд
энэ амьдралын дараа
тэнгэрийн хаанчлалд
орох ганц л зам бий.
Дэлхийн улс үндэстэн
бүрийн олон хүний
олж мэдээд хүлээн
авсанчлан Есүс бол
зам, үнэн, амь мөн.

Христийн Сайн мэдээ бол энэ дэлхийн бусад шашин шүтлэгтэй огт адилгүй бөгөөд ямар нэгэн шахалт сүрдүүлгийн хүчээр түгээгүй юм. Есүс дагалдагч нартаа дайснаа хүртэл хайрлан, дуу хуур баяр хөөрөөр дүүрэн байхыг сургасан байна. Өнөөдөр дэлхийн бүх үндэстэн бүх хэлийн хүмүүс уучлал, мөнх амийг аваад хөөр баяраар дүүрэн байгаа билээ.



Есүс үхлээс амилснаас хойш хэдийгээр 2000 гаруй жил өнгөрсөн ч энэ дэлхий дээр Сайн мэдээг дуулж сонсоогүй хүмүүс байгаа билээ. Тэдэнд Сайн мэдээг зайлшгүй дуулгах шаардлагатай.

Ертөнцийн түүх®

Зохиогчийн эрх © 2006 Майкл Пэрл,
Дэби Пэрл

No Greater Joy Ministries байгууллагаас
эрхлэн гаргав.

Хаяг: 1000 Pearl Road

Pleasantville, TN 37033, USA

Зохиогчийн бүх эрхийг хуулиар
хамгаална. Энэхүү номын аливаа
хэсгийг АНУ-ын Зохиогчийн эрхийн
хуульд зааснаас бусад тохиолдолд
зохиогчийн зөвшөөрөлгүйгээр дахин
хэвлэх, электрон, механик, фото-
хуулбар, бусад ямар нэгэн хэлбэрт
оруулан дамжуулах, хадгалахыг
хориглоно.

Анхны хэвлэлт. 2008 оны 11 дүгээр сар.

Author: Michael Pearl

Artist: Danny Bulanadi

Coloration: Clint Cearley



<https://goodandevilbook.com/>